

**ЦАХИМ ЗАСАГЛАЛ:
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ШИЙДВЭР
ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ, МЭДЭЭЛЭЛ
ХАРИЛЦААГ ЦАХИМЖУУЛАХ
БОЛОМЖ БА СОРИЛТУУД**

СУДАЛГААНЫ ҮР ДҮН, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

ННА 66
ДАА 351
Ц-254



NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
DEPARTMENT OF
POLITICAL SCIENCE

ЦАХИМ ЗАСАГЛАЛ: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ, МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААГ ЦАХИМЖУУЛАХ БОЛОМЖ БА СОРИЛТУУД

Ерөнхий редактор

Профессор Ж.Төртогтох
МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн
Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч,
Ардчилал судлалын төвийн захирал

Төслийн зохицуулагч,
редактор

С.Ганзаяа
Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангийн
Хөтөлбөрийн менежер

Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сан болон МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхим хамтран үүсгэн байгуулсан “Төрийн Байгуулалтын Экспертийн Зөвлөл” – өөс эрхлэн гаргав.

Зохиогчийн эрх @ Монгол Улс дахь Конрад-Аденауэр-Сангийн Суурин төлөөлөгчийн газар

ISBN 979 9919-0-0079-0

КАС-ИЙН ДЭРГЭДЭХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН ЭКСПЕРТИЙН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨХ БАГ



**Профессор
Ж.ТӨРТӨГТОХ**

МУИС-ийн Шинжлэх
Ухааны Сургуулийн
Улс төр судлалын
тэнхимийн эрхлэгч,
Ардчилал судлалын
төвийн захирал



**Профессор
С.МӨНХБАТ**

Монгол Улсын
Шинжлэх ухаан,
технологийн
үндэсний
зөвлөлийн
нарийн бичгийн
дарга



**Дэд профессор
Я.ТӨГӨЛДӨР**

ШУТИС-ийн Бизнесийн
Удирдлагын
Хүмүүнлэгийн
сургуулийн Нийгмийн
ухааны тэнхимийн
эрхлэгч



С.ГАНЗАЯА

Монгол Улс дахь
Конрад-Аденауэр
Сангийн
Хөтөлбөрийн
менежер

СУДЛААЧИД



Доктор Г.ТУЯАГЭРЭЛ

МУИС-ийн Улс төр судлалын
тэнхимийн ахлах багш



Л.БЯМБАХАНД

Шинжлэх Ухааны Академийн
Олон улс судлалын
хүрээлэнгийн эрдэм
шинжилгээний ажилтан



Б.ГЭРЭЛСҮРЭН

Монголбанкны мэдээллийн
технологийн аудитор



Л.ГАЛБААТАР

Монголын Хуульчдын
холбооны гишүүн

Агуулга

Мэндчилгээ 6

Өмнөх үг 7-8

1 **ИРГЭДИЙН ЦАХИМ ОРОЛЦОО, ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, НӨЛӨӨЛӨХ ХУЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ**
Доктор Г.Туяагэрэл 9-50

2 **УЛС ТӨРИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХЭД НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ СУВГУУДЫН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ**
Л.Бямбаханд 51-107

3 **ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ШИНЖИЛГЭЭ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА**
Б.Гэрэлсүрэн 108-164

4 **ШУДАРГА ШҮҮХЭЭР ШҮҮЛГЭХ ЭРХИЙГ ЦАХИМ ШҮҮХ ХУРАЛДААНД ХАНГАХ НЬ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ**
Л.Галбаатар 165-215

Бодлогын нэгдсэн зөвлөмж 216-219

Мэндчилгээ



ХБНГУ-ын канцлер А.Меркелийг анх 2013 оны зун интернэтийг “шинэ нутаг дэвсгэр” төрөн гарч байна гэж томьёолоход олон хүмүүс гайхаж, зарим талаараа шоолж ч байлаа. Гэхдээ түүний таамаглан хэлсэн нь үнэн болохыг өнөөдрийн дэлхий ертөнц харуулж байна. 1991 оноос хойши дэлхий даяарх мэдээллийн сүлжээ, түүнтэй холбоотой техникийн шинэчлэл нь манай гарагийн эдийн засаг, шинжлэх ухаан, нийгмийг, улмаар улс төрийг ч өөрчилж байна.

Интернэтийн хувьсгалтай холбоотой эдийн засаг, нийгмийн боломжууд асар их юм. Дэлхий даяарх олон сая хүмүүс өөр хоорондоо болон улс төрийн оролцогчтой шууд харилцаж, интернэтийн харилцаа холбоогоор дамжуулан хэрэглэгчдэд урьдынхаас хэд дахин хурдан үйлчилгээ хүрснээр эдийн засгийн хувьсгал хийгдсэн билээ. Одоогийн байдлаар дэлхийн хамгийн баян таван компанийн дөрөв нь (Apple, Microsoft, Alphabet, Amazon) дижитал эдийн засагт суурилсан үйлчилгээ үзүүлж байна. Бүтээгдэхүүн, бизнесийн загвараараа тэд бидний өдөр тутмын амьдралын бүхий л түвшинг магадгүй үүрд өөрчилсөн байх. Өнөөдөр зөвхөн газрын тос төдийгүй дата өгөгдөл нь орчин үеийн дэлхийн эдийн засгийн үндэс суурийг бүрдүүлж байна.

Үүний зэрэгцээ эдийн засаг, харилцаа холбоо, цаашлаад улс төр, олон нийтийн орон зайг дижитал болгох нь асар их аюулыг дагуулж байна. Олон нийт рүү зорилготойгоор хуурамч мэдээлэл тараах нь интернэтээс үүсэн бий болсон “бүтээгдэхүүн” огтхон ч биш юм. Гэсэн хэдий ч интернэт нь урьд өмнө хэзээ ч байгаагүй өргөн цар хүрээтэй худал хуурмагийг дэлхий даяар, зардал багатай түгээх боломжийг олгосон. Дундад зууны үеэс өнөөг хүртэл тийм ч олон хүн дэлхийг хавтгай гэдэгт итгэдэггүй байсан байх. Чөлөөт, шударга сонгуулийг хууран мэхлэх, улс төрчид, компаниудын нэр хүндийг санаатайгаар унагах гэх мэт олон зүйлтэй харьцуулбал хавтгай дэлхийн онол нь илүү хор хөнөөлгүй юм.

Чухамхүү интернэт нь “шинэ нутаг дэвсгэр” мөн эсэхээс үл хамааран орчин үеийн нийгэм дижиталчлалын боломж, аюулыг даван туулж сурах ёстой болж байна. Үүнд төр чухал үүрэг гүйцэтгэдэг. Дижиталчлалын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг алдагдуулахгүйгээр эрх зүйн орчныг бүрдүүлж иргэнээ хамгаалах ёстой. Конрад-Аденауэр-Сангийн зүгээс энэ бүхэнд хувь нэмрээ оруулахыг зорин Төрийн байгуулалтын экспертийн зөвлөлийн эрдэмтэн профессор, сонгон шалгарсан судлаачдын дэмжлэгтэйгээр хамтран боловсруулсан иж бүрэн эрдэм шинжилгээний судалгааны бүтээлийг толилуулж байна. Нийт хамтран оролцсон эрдэмтэн профессор, судлаач нартаа талархлаа илэрхийлье.

ВИКТОР ФРАНК

Монгол Улс дахь Конрад-Аденауэр-
Сангийн Суурин төлөөлөгч

Өмнөх үг



ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, МУИС-ийн Шинжлэх Ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхим, Төрийн байгуулалтын экспертний зөвлөлийн арга зүйн нэгдсэн удирдлагын дор хамтран хэрэгжүүлсэн “Цахим засаглал: Төрийн үйлчилгээ, шийдвэр гаргах үйл явц, мэдээлэл харилцааг цахимжуулах боломж ба сорилтууд” сэдэвт бодлогын судалгааны агуулга, үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг нэгтгэн Уншигч Танаа толилуулж байна. Тус бодлогын

судалгаа нь дараах тодорхой сэдвүүдээр судлаач экспертүүдийн бие даан гүйцэтгэсэн дэд судалгаануудаас бүрдэж байгаа болно. Үүнд:

Нэг. Иргэдийн цахим оролцоо, төрийн цахим үйлчилгээний өнөөгийн төлөв байдал, нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ

Хоёр. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудын нөлөөллийн шинжилгээ

Гурав. Цахим засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын хэрэгжилтийн шинжилгээ, цаашдын чиг хандлага

Дөрөв. Шударга шүүхээр шүүлгэх эрхийг цахим шүүх хуралдаанд хангах нь: Олон улсын туршлага ба Монгол улсын нөхцөл байдал

Энэхүү бодлогын судалгаа нь нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгарсан судлаач экспертүүд тухайлбал, МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн ахлах багш, доктор Г.Туяагэрэл, ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Л.Бямбаханд, Монголбанкны мэдээлийн технологийн аудитор Б.Гэрэлсүрэн, Монголын хуульчдын холбооны гишүүн, хуульч Л.Галбаатар, мөн тус судалгааны зөвлөхөөр уригдан ажилласан зөвлөхүүд ШУТҮЗ-ийн нарийн бичгийн дарга, доктор С.Мөнхбат, ШУТИС-ийн БУХС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн эрхлэгч, доктор Я.Төгөлдөр, Монгол дахь Конрад-Аденауэр сангийн суурин төлөөлөгч Виктор Франк, тус сангийн төслийн менежер С.Ганзаяа нарын хамтран ажилласны үр дүнд ийнхүү уншигч олны хүртээл болж байгаа юм. Гэхдээ судалгаа бүрийн агуулга, үр дүн, зөвлөмж нь үндэсний экспертүүдийн мэдлэг, туршлага, үзэл бодол, итгэл үнэмшилд суурилсан, бие даан хийж гүйцэтгэсэн ажлын илэрхийлэл юм.

Бодлогын судалгааны үйл явцыг бүхэлд нь амжилттай зохион байгуулж, экспертүүд болон зөвлөх багийн хамтран ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж, дэмжиж ажилласан ХБНГУ-ын Конрад-Аденауэр-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын хамт олонд гүн талархал илэрхийлье. Энэ удаагийн судалгаа нь сэдвийн болон явцын нийт найман удаагийн хэлэлцүүлгийг экспертүүд болон зөвлөхүүдийн дунд зохион байгуулж,

тэдгээр хэлэлцүүлгийн үр дүн, гүйцэтгэлд үндэслэн үр дүнгээ гаргаснаараа судалгаа бүхэлдээ амжилттай болоход нөлөөлсөн болохыг онцлож байна.

Цахим засаглал, нэн ялангуяа төрийн үйлчилгээ, шийдвэр гаргах үйл явц, мэдээлэл харилцааг цахимжуулах боломж ба сорилтуудын талаарх судалгааны зарим тодорхой асуултуудыг хөндсөн уг бодлогын судалгаа нь цаашид бусад судлаач экспертүүдэд эдгээр асуудлаарх судалгаа хэлэлцүүлгийн санаа өгөх бүрэн бололцоотой гэдгийг тэмдэглэе.

МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн эрхлэгч,
Ардчилал судлалын төвийн захирал, профессор **Жанарын ТӨРТӨГТОХ**





Доктор Г.ТУЯАГЭРЭЛ

МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн ахлах багш

ИРГЭДИЙН ЦАХИМ ОРОЛЦОО, ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

УДИРТГАЛ

"Цахим засаглал: Төрийн үйлчилгээ, шийдвэр гаргах үйл явц, мэдээлэл харилцааг цахимжуулах боломж ба сорилтууд" сэдэвт төслийн хүрээнд хийж байгаа "Иргэдийн цахим оролцоо, төрийн цахим үйлчилгээний төлөв байдал, нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ" сэдэвт судалгааны ажил нь Монгол дахь иргэдийн цахим оролцооны өнөөгийн төлөв байдал, хамрах хүрээ, дижитал хуваагдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг нарийвчлан судлах зорилгоор асуулгын аргаар тоон мэдээллийг цуглуулж, түүнд өгөгдлийн шинжилгээ хийж зөвлөмж боловсруулах зорилготой юм.

Энэхүү судалгаагаар иргэдийн цахим оролцооны өнөөгийн түвшнийг судлахдаа Үндэсний статистикийн хорооноос 2018 онд хийсэн "Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулсан судалгаа"-ны үр дүнг үндэслэн Монгол Улсыг үндсэн таван кластерт хувааж кластер тус бүрээс хоёр зуун хүртэлх түүвэртэй судалгааг асуулгын аргаар цахим хэлбэрээр зохион байгуулж үр дүнд боловсруулалт хийсэн. Ингэхдээ голлох тоон үр дүнг гаргаж судалгааны арга зүйн хүрээнд математик статистикийн үндсэн дөрвөн шинжилгээг хийсэн. Үндсэн зорилгоо биелүүлэхийн тулд хийсэн судалгааны ажлынхаа үр дүнг дараах бүтэцтэйгээр танилцуулж байна.

1. Судалгааны үндэслэл
2. Судалгааны үндсэн хэсэг
3. Судалгааны үр дүн
4. Дүгнэлт
5. Зөвлөмж

Бодлогын судалгааны үндэслэл хэсэгт судалгааны ажлын үндэслэл, судалгааны зорилго, судалгааны зорилт, судалгааны арга зүй хэсгийг багтаалаа.

Судалгааны үндсэн хэсэгт иргэдийн цахим оролцооны онолын үндэслэл, сэдвийн судлагдсан байдал, судалгааны загварыг хэрхэн боловсруулсан талаар бичсэн.

Судалгааны үр дүн хэсэгт 2022 оны 6-р сарын 28-аас 2022 оны 08-р сарын 28-ны хооронд зохион байгуулсан "Иргэдийн цахим оролцооны өнөөгийн төлөв байдал" сэдэв судалгааны ажлын үр дүнг бичсэн.

1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ


XXI зуун гарсаар хүн төрөлхтний түүхэнд хөгжлийн нэгэн том үе тохиогоод байгаа нь Цахим зуун буюу Дижитал эрин юм. Технологийн хөгжлийн энэхүү боломж нь хүн төрөлхтөний өдөр тутмын амьдралын хэв маягт хувьсал өөрчлөлт авчрахаас гадна төр иргэний харилцаа, иргэдийн оролцоон дахь уламжлалт арга зүй цаашлаад иргэд өөрт хамаатай асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох оролцооны тогтолцоо, загварт ч онцгой эерэг үр дагавар авчрахын зэрэгцээгээр технологи хэрэглэгчийн чадвар, орон зайн ялгаатай байдал, дэд бүтцийн хөгжлийн түвшин гэх мэт олон хүчин зүйлсээс шалтгаалан тэгш бус байдлыг ч үүсгээд байна.

Энэхүү дижиталчлалын эрин дэх бизнесийн байгууллагуудын бэлэн байдал, эрсдлийн шинжилгээ, хөгжлийн ялгаатай боломжуудад нөлөөлж байгаа хүчний зүйлийн (фактор шинжилгээ) шинжилгээг маш идэвхтэй хийж байгаа нь ажиглагдаж байна. Цахим засаглал, төрийн үйлчилгээний дижитал шилжилтийг хийхэд мэдээллийн технологийн шийдлээс гадна хамгийн чухал хоёр зүйл бол хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, иргэдийн оролцооны тэгш байдлыг хангасан дижиталчлалын загварыг бий болгох юм. Ингэхийн тулд цахим засаглал, дижитал шилжилтийн үе дэх иргэдийн оролцооны өнөөгий төлөв байдал, дижитал хуваагдлын түвшин, нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ, төрийн дижитал үйлчилгээ нь иргэдэд ямар боломж, хүндрэлийг үүсгэж байна, цахим засаглал, дижитал үйлчилгээний платформууд нь иргэдийн оролцооны ялгаатай байдлыг харгалзан үзсэн эсэх, хөгжлийн ялгаатай боломжуудад чиглэсэн оролцоог нэмэгдүүлэх боломж зэргийг судлах зайлшгүй шаардлагатай байна.

Хүснэгт 1.

Rank	Country	EGDI Level	EGDI Rating	EGDI 2020	Online Service index	Telecomm. Infrastructure Index	Human Capital Index
1	Denmark	Very High EGDI	VH	0.9758	0.9706	0.9979	0.9588
2	Republic of Korea	Very High EGDI	VH	0.956	1	0.9684	0.8997
3	Estonia	Very High EGDI	VH	0.9473	0.9941	0.9212	0.9266
4	Finland	Very High EGDI	VH	0.9452	0.9706	0.9101	0.9549
5	Australia	Very High EGDI	VH	0.9432	0.9471	0.8825	1
92	Mongolia	High EGDI	H3	0.6497	0.5294	0.6135	0.8063
193	South Sudan	Low EGDI	L1	0.0875	0		

Зураг 1.



Эх сурвалж: НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан хэлтсээс хоёр жил тутамд гаргадаг цахим засаглалын судалгааны тайлан (2020)

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан хэлтсээс хоёр жил тутамд гаргадаг цахим засаглалын судалгааны тайлангаас харахад Монгол Улсын цахим засгийн хөгжлийн индексээр дэлхийн 193 улсаас 92, цахим оролцооны индексээр 87-рт бичигдэж байна. Мөн цахим үйлчилгээний индексийн хувьд 0.53, харилцаа холбооны дэд бүтцийн индекс 0.61 байгаа нь цахим хөгжлийн хувьд дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад дундаж түвшинд байгаа нь харагдаж байна. Гэхдээ нийгэм, улс төр, эдийн засгийн салбарт өсөлтийг бий болгож, хөгжлийг тогтворжуулах үйл явцад технологийн дэвшилд суурилсан цахим засаглалыг төлөвшүүлэх чиглэлд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Шинэ сэргэлтийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх 2020-2025 оны төлөвлөгөө гэх мэт бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох “Алсын хараа 2050”-т үндэсний оньсон тоглоомны цахим хувилбарыг хөгжүүлэхийн зэрэгцээгээр эрүүл мэндийн салбарт хиймэл оюун ухаанд суурилсан эрүүл мэндийн тогтолцоог төлөвшүүлэх талаар тусгасан байдаг. Мөн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог хангасан, хамтын ажиллагаа бэхжих нөхцөлийг бүрдүүлэхэд цахим ардчиллыг хөгжүүлж, төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих зэргээр цахимаар оролцох боломжийг бүрдүүлэх талаар үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Хүний хөгжлийг дэмжсэн, үрдүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэхийн тулд:

- Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, төгөлдөржүүлэх;
- Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгож хөгжүүлэх;
- Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээг шат дамжлагагүй, шуурхай болгох;
- Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх;
- Цахим засаглалыг хөгжүүлэх бодлого, эрх зүйн орчныг олон улсын жишигт хүргэх;
- Цахим мэдээллийн нэгдсэн санг эдийн засгийн харилцаанд бүрэн шилжүүлэх;
- Иргэн, төр, бизнесийн байгууллагууд мэдээлэл солилцооны үүлэн технологид бүрэн шилжүүлж, ил тод төрийн албаны тогтолцоог бэхжүүлэх;
- Хүний хөгжлийг дэмжсэн цахим засаглалын бодлого, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;
- Цахим засаглалын технологийг олон улсын жишигт хүргэн авлига, хүнд сурталгүй нийгмийн харилцааг төлөвшүүлэх.

Урт хугацааны хөгжлийн бодлогын үндсэн чиглэл, зорилтуудаас харахад Монгол Улсын хэмжээнд төрийн үйлчилгээг цахим хувилбараар иргэдэд хүргэх, цахим үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, технологит суурилсан иргэн төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны суурь тавигдан хөгжиж байна. Иймд төрийн цахим үйлчилгээний чанар хүртээмжид нөлөөлж буй хүчин зүйлс, иргэдийн цахим оролцооны өнөөгийн төлөв байдал, дижиталчлалын үр дагаврын талаарх судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

1.1 СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Дижитал шилжилтийн үе дэх цахим оролцооны хэлбэрүүдийг судлах, иргэдийн цахим оролцоонд нөлөөлж буй хүчин зүйлс, өнөөгийн төлөв байдал, дижитал хуваагдлын загварын талаар тоон судалгаа хийж, үр дүнг боловсруулахад судалгааны зорилго оршино. Үүнд:

- Дижитал шилжилт, төрийн цахим үйлчилгээ, цахим оролцоо, цахим мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн актууд, бодлогын баримт бичгүүдийг судалж судалгааны загвараа боловсруулах;
- Цахим засаглал, дижитал шилжилтийн үе дэх иргэдийн оролцооны бэлэн байдлын түвшинг судлах, иргэдийн цахим улс төрийн өнөөгий төлөв байдлыг судалж, нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээ хийх;

- Төрийн цахим үйлчилгээ нь иргэдэд үүсгэж буй боломж, хүндрэлийг судлах;
- Дижитал хуваагдлын түвшин, нөлөөлж буй хүчин зүйлийг судлах;
- Цахим засаглал, төрийн цахим үйлчилгээний платформууд нь иргэдийн ялгаатай байдлыг харгалзан үзсэн эсэхийг судлах зорилтуудыг дэвшүүлсэн.

1.2 СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙ

Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ дараах арга зүйг хэрэглэсэн. Үүнд:

Судалгаатай холбоотой онол, арга зүйн бүтээл, судалгааны тайлан гэх мэт хоёрдогч эх сурвалжуудаар мэдээллийн санг бүрдүүлж, баримт бичигт анализ хийх, харьцуулан судлах аргыг хэрэглэсэн.

Өнөөгийн төлөв байдлыг шинжлэхдээ Төв, Архангай, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Ховд аймаг, Увс, Дорнод аймаг, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын Хан-Уул, Сонгино-Хайрхан дүүргийг сонгон авч асуулгын аргаар судалгаа хийн, өгөгдлийг бүрдүүлж, үндсэн өгөгдөлд математик статистикийн SPSS програмын ерөнхий статистик шинжилгээ, найдварт байдлын шинжилгээ, хүчин зүйлийн шинжилгээ, корреляци хамаарлын шинжилгээ, регрессийн шинжилгээг хийсэн.

2. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

2.1 ИРГЭДИЙН ЦАХИМ ОРОЛЦООНЫ ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Цахим оролцоо гэх ойлголт нь “цахим”, “оролцоо” гэсэн үндсэн хоёр ойлголтоос тогтож байгаа юм. Иймээс иргэний цахим оролцоог тодорхойлохын тулд нэн тэргүүнд “оролцоо” хэмээх ойлголтыг тодорхойлох нь зүйтэй. Иргэдийн оролцоо нь Эртний Грек, Ромын үеэс ардчиллын гол үнэт зүйл байсаар ирсэн. Ардчилал туйлын зорилго биш харин тогтмол үйл ажиллагаа, хамтын ажиллагааны үйл явц гэж хэлж болно. Ардчиллыг иргэдийн оролцоогүй төсөөлшгүй¹ бөгөөд иргэдийн оролцоогоор ардчиллын төлөвшил, чанарыг хэмжиж болох юм.

Иргэдийн оролцоо бол хүн төрөлхтний түүхийн явцад хамтын ажиллагааны зохион байгуулалтын дээд хэлбэрт хүрэх тэмүүлэл² юм. Оролцооны ардчилал нь нийгмийн өөрчлөлтийг бий болгодог.³ Оролцоог иргэд санал бодлоо илэрхийлж шийдвэр гаргахад нөлөөлөх үйл явц гэж тодорхойлдог.⁴

Иргэдийн оролцоо бол:

1. Иргэний эрх: Ардчилсан нийгэмд иргэд улс төрд оролцох нь тэдний үүрэг биш харин иргэний эрхэд хамаардаг. Нэгэнт олгогдсон эрхээ эдлэх, хэрэгжүүлэх, хэр хэмжээ нь харилцан адилгүй байдаг.
2. Оролцоо бол арга: Оролцоо нь засгийн газрын бүрэлдэхүүнийг сонгох,

¹ Pimbert, M. & Wakeford, T. (eds) (2001) 'Deliberative democracy and citizen empowerment', Special issue of PLANotes 40 pp. 23-28. International Institute for Environment and Development, London.

² Батсүх Ш., Ганцоож Б. & Долгоржав Я. (2014). Шууд ардчилал-Иргэдийн оролцоо. УБ., х-17

³ Fung Archon (2006) Empowered Participation: Reinventing Urban Democracy. Princeton University Press

⁴ James L. Creighton (2005). The Public Participation Handbook: Making Better Decisions Through Citizen Involvement. John Wiley& Sons Inc.

засгийн газрын сонгогдсон бүрэлдэхүүнд нөлөөлөх гэсэн хоёр асуудлыг багтаасан засгийн газарт нөлөөлөх зорилго бүхий үйл ажиллагаа юм.⁵

3. Оролцоо бол зарчим: Ардчиллын хамгийн гол мөн чанарын нэг нь иргэд оролцож байх ёстой хэмээх асуудал юм.⁶

Улс төрийн шийдвэр гаргах үйл явц болон томоохон төсөл, хөтөлбөрүүдийг төлөвлөх явцад иргэдийг оролцуулахыг иргэдийн оролцоо гэж тодорхойлдог. Иргэний идэвхтэй оролцоо ардчиллын суурь үнэт зүйл, түүний мөн чанарын илэрхийлэл бөгөөд ардчиллын гол хөдөлгүүр⁷ хүч юм.

Иргэдийн оролцоо нь ардчиллын оршин тогтнох, сүүлийн тулах цэг хэмээн эрдэмтэн Густав Де Коккү тодорхойлсон. Иргэдийн оролцооны төвшин, цар хүрээ нь улс орон бүрд харилцан адилгүй төдийгүй тухайн улсын улс төрийн тогтолцоо болон соёлын илэрхийлэл.⁸

Иргэдийн оролцоо нь үзэл суртал болон хувийн эрх ашигт тулгуурладаг тул хүний үндсэн эрхийг дэмжих чухал ач холбогдолтой. Иргэдийн оролцоо нь олон нийтийн оролцоотой адилгүй. Шийдвэр гаргах үйл явц дахь олон нийтийн оролцооны нийтлэг аргачлал, арга зүй нь дээрээс доош чиглэсэн үйл явцыг тусган оролцогч талуудын хамтын ажиллагааны давуу тал болон олон нийтийн утга учиртай оролцоог бүрэн дүүрэн бүрдүүлдэггүй.⁹ Оролцоог хангах ардчилсан сонголтыг хаагдуулж, засгийн газрын зүгээс нийгмийн суурь болон аж ахуйн үйл ажиллагаанд хэт давамгайлж оролцох нь том төрийн үндсэн шинжийн нэг.¹⁰

Харин оролцоог дэмжих нь сайн засаглалын шинж бол оролцоогоо ухамсарласан ухаалаг иргэд нь ухаалаг төрийн хэмжүүр юм.¹¹ Ухаалаг төрийг хэмжих олон хэмжүүр байх бөгөөд эдгээр хэмжүүрүүд нь харилцан уялдаатай, нэгдмэл стратегийн хүрээнд бүгдийг нэгтгэж авч үзэх нь зүйтэй. Ухаалаг төрийн хэмжүүрүүдийг ухаалаг засаглал, ухаалаг журам, зохицуулалт, ухаалаг засгийн газар, ухаалаг манлайлал, ухаалаг чадавх, ухаалаг төсөв, ухаалаг иргэд хэмээн тодорхойлдог. Ухаалаг иргэд гэдэг ойлголт нь иргэдийн итгэл, боловсрол, ил тод байдал, оролцоо хүртээмжид суурилах ба эрх үүргээ ухамсарладаг, оролцоо чухал болохыг ойлгодог, боловсролтой иргэдийг ойлгоно.

Итгэлцэл, ил тод байдал, оролцоог хангасан байдал нь ухаалаг төрийн илэрхийлэл. Төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд иргэдийн төрд итгэх итгэл чухал нөлөөтэй ба иргэдийн итгэлд түшиглэн төрийн бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэдэг.¹²

5 Sidny Verba (1967). Democratic Participation. *Social Goals and Indicators for American Society*, Volume 2, 53-78

6 Ганболд Ц. (2020). Монголын улс төр уламжлал, шинэчлэл, тэмдэглэл. УБ, II боть. "МУИС-Монгол судлалын хүрээлэн" х-302

7 Мягмарцоож Н.(2012). Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо. УБ, х-8

8 МУИС хамтын бүтээл. (2018). Бурмаа Н. Иргэдийн оролцоо-Иргэний нийгэм. //Төрийн албан хаагчийн ширээний ном III. "Мөнхийн Үсэг" ХХК. УБ., х-231

9 Angelita Gregorio-medel (2014). Иргэдийн оролцоо ба чадавхын хөгжүүлэлт //NUM Leadership олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл/ УБ., х-69

10 Jan Ziekow (2014). Том төрөөс ухаалаг ухаалаг төр лүү-шаардлагатай чадавхыг хөгжүүлэх нь //NUM Leadership олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл/ УБ., х-27

11 Jan Ziekow (2014). Том төрөөс ухаалаг ухаалаг төр лүү-шаардлагатай чадавхыг хөгжүүлэх нь //NUM Leadership олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл/ УБ., х-23

12 Jan Ziekow (2014). Том төрөөс ухаалаг ухаалаг төр лүү-шаардлагатай чадавхыг хөгжүүлэх нь //NUM Leadership олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл/ УБ., х-33

Иргэдийн оролцооны талаар ардчиллын зарим сонгодог судлаачдын санаа бодлыг товчхон авч үзвэл:

Жан Жак Руссо /Rousseau/ (1712-1778, Франц): Нийгэмд шууд ардчилал-иргэдийн оролцоогоор дамжуулан нийгэм, улс төрийн үйл ажиллагааг хариуцлага, хувь хүний бие даасан байдалд тулгуурлан хөгжүүлэх нь зүйтэй. Учир нь хувь хүний хүсэл мөрөөдлийг бусад хүмүүс бүрэн төлөөлөх боломжгүй юм. Руссогийн үзэж байгаагаар хамгийн төгс улс төрийн харилцаа бол бүх иргэд нь хуулийг хэлэлцэх болон батлахад оролцох боломжоор хангагдсан бага нутаг дэвсгэртэй, жижиг бүгд найрамдах улс гэж үзэж байв.¹³

Джон Стюарт Милль /Mill/ (1806-1873, Англи): Бүх ард түмэн өөрсдийн бүрэн эрхт байдлын талаар дуу хоолойгоо илэрхийлдэг нь ард түмэнд олгогддог бүрэн эрхт байдал, төрийг хянах хэлбэр юм. Бүхий л засаглалын менежмент хэрэгжиж байсан үедээ зөв тогтолцоо гэж хүлээн зөвшөөрөгддөг ч нийгэм өөрчлөгдөхөд сул тал нь илэрдэг. Харин иргэдийн оролцоо бол нийгмийн бүхий л цаг үед хүлээн зөвшөөрөгдсөн систем юм.

Барбер /Benjamin R. Barber/ (1939-2017, Америк): Шууд ардчилал бол маш хүчтэй ардчилал. Оролцооны ардчиллын арга хэрэгсэл, төлөөллийн хэлбэр. Тиймээс ардчиллыг төгөлдөржүүлэхэд шууд, оролцооны ардчилал сайн үйлчилдэг. Энэ нь зөвхөн иргэдийн бие даах чадварт итгэх итгэлд суурилдаггүй. Цөөнх олонхын асуудлыг шийдвэрлэхэд гарах алдааг бодвол олонх өөрөө илбэн тохинуулбал гарах алдаа бага байдаг гэх үзэлд үндэслэдэг.

Эрик Фромм /Erich Fromm/ (1900-1980, Герман): Оролцоо, түүний бие даасан байдал нь сонирхолтой, чухал ажил бөгөөд санаачилга бүхий оролцооны ардчиллыг бэхжүүлэх нь эрх мэдлийг чухалчлах аюулаас зайлсхийхэд нэн шаардлагатай зүйл юм.

Жонни Волкер /Walker/ (1933-2010, Америк): Иргэд төрийн удирдлага, улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байх нь улс төрд мунхаглалыг дэвэргэдэг. Тиймээс улс төрийн төвшинд иргэд оролцохгүй байх нь улс төрчдөд боломж олгох, тэдэнд улс төрийн хуурамч тоглолт хийх боломжийг өндөрсгөдөг учраас ардчилалд туйлын аюултай гэжээ. Иргэдийн оролцоо нь Засгийн газрын хариуцлагагүй байдлын бууруулах, илчлэх, сайжруулах сайн талтай.

Ийнхүү сонгодог онолчид ардчилал болон иргэдийн оролцоо салшгүй холбоотой болохыг онцлон тэмдэглэж байжээ. Ялангуяа захиргаа судлалын эцэг В.Вильсон энэ асуудлыг товчлон тавьсан байдаг.

Тэрбээр дарангуйллын дэглэмтэй орнуудтай харьцуулахад ардчилсан нийгэмд олон нийтийн санаа бодлыг хаанд өргөмжилсөн байдгийг онцлон тэмдэглэсэн байдаг. Феодалын нийгэмд хаан бүх асуудлыг шийдвэрлэдэг бол ардчилсан нийгэмд “Ялгаатай талууд хослох, төлөвлөгөөнүүдээ цомхтгох, хэт хатуу зарчмуудыг зөөллөх замаар” шийдвэр гаргах ба ингэснээр захиргааны ажилд ахиц гарна. **Өөрөөр хэлбэл ардчилсан нийгмийн засаглал бол иргэний оролцоот засаглал юм гэдгийг**

¹³ Ганбаатар Х., Тамир Э. & Биндэръяа Д. (2004). Өрнөдийн улс төрийн сэтгэлгээний түүх. УБ., хоёрдугаар дэвтр. “ЭРДЭНЭЗҮЛ” ХХК. х-115

онцолсон байна (В.Вильсон Захиргааг судлахуй. Онол сэтгүүл, 2017, №4, 101). Энэ дашрамд ийнхүү олон нийтийн санаа бодлоор засаглах нь нэн төвөгтэй болохыг тэмдэглэжээ.(өгүүлбэрийг гүйцээсэн)

Иргэдийн байнгын үр нөлөө бүхий оролцоогүйгээр ардчилал оршин тогтнох боломжгүй юм. Зөвхөн төлөөллийн ардчиллаар хязгаарлах юм бол удирдлагын элит бүлэг буй болох, төр иргэдээс хол хөндий болох зэрэг улс төрийн талын хор уршигтайгаас гадна төрийн бодлого ард түмний ашиг сонирхлоос хөндийрөх, хэрэгжилтийн үр дүн хангалтгүй байх зэрэг сөрөг талтай. Орчин үед дэлхийн аль ч улс оронд ийм хандлага илэрч байгаа нь ард түмнээс төрд итгэх итгэл нь суларч байгаа юм. Олдсон мэдээллээс үзэхэд АНУ-ын иргэдийн төрдөө итгэх итгэл нь түүхэн доод хэмжээнд очсон байгаа бөгөөд тэдний 14 хувь нь л Засгийн газартаа итгэж байгаа аж (people-press.org /2019/4/11/public-trust-in-gov-ernment- 1958-2019/). 2012 оны судалгаанаас үзэхэд OECD орнуудын дунджаар Засгийн газарт иргэдийн итгэх байдал 40 хувь, үүнээс Грект 12 орчим Чухуд 18 орчим хувьтай байжээ. Японд мөн 18 орчим хувьтай байсан бол хамгийн өндөр нь Швейцарт 78 орчим хувьтай байсан байна.¹⁴

Манай орны судлаачид ч иргэдийн оролцооны тухай асуудлыг сөхөн судлах, түүний ач холбогдол, мөн чанарыг тодорхойлж бүтээл туурвисан байдаг. Оролцоо нь нийгмийн шинжлэх ухааны өргөн ойлголт бөгөөд улс төр судлалын хувьд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтны бодлого, шийдвэр, үйл ажиллагааг дэмжих болон тэдгээрт нөлөөлөхийн төлөө хийж байгаа аливаа үйлдлийг оролцоо хэмээн тодорхойлж болно.

Оролцоо нь улс төр, эдийн засаг, менежмент болон нийгмийн бүхий л салбарын шийдвэр гаргалтад оролцох хэлбэр, арга хэрэгслүүдийг багтаасан нийгмийн шинжлэх ухааны маш өргөн хүрээтэй ойлголт юм.¹⁵ Иргэдээс төрийн байгууллага, төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааг дэмжих, тэдгээрт нөлөөлөхийн тулд хийж байгаа аливаа үйлдлийг иргэдийн оролцоо гэж ойлгож болно.¹⁶

Иргэний оролцоо гэдэг нь иргэн сайн дураараа, албан бусаар үйлдэл хийж төрийн бодлого шийдвэрт нөлөөлөх оролдлого мөн бол иргэдийг татан оролцуулах нь төрийн байгууллагын зүгээс иргэдийг үйл ажиллагаандаа оролцуулахын тулд зохион байгуулж байгаа албан ёсны үйл ажиллагаа ажээ. Энэхүү ажилд хэрэглэж байгаа “иргэний оролцоо” хэмээх ойлголтод оролцооны эл хоёр төрлийг хоёуланг нь багтааж байгаа боловч нэгэнт захиргааны үйл ажиллагааны талаар ярьж байгаа болохоор иргэдийг татан оролцуулах арга хэлбэрт илүү анхаарч байгаа болно.

Иргэдийн оролцоо нь иргэний эрхийг хэрэгжүүлэх, ардчиллыг биелүүлэх зэрэгт чухал ач холбогдолтойгоос гадна бодлого шийдвэр зөв гарах, тэдгээрт иргэдийн болон тэдний бүлгийн ашиг сонирхлыг тусган төрийн үйлчилгээг үр дүнтэй болгодог. Иргэдийн оролцоо нь төрийн бодлого, шийдвэрийг гаргах, хэрэгжүүлэхэд төр-иргэний түншлэлийг буй болгодог.

14 КАС, МУИС (2019) Батсүх Ш. & Дэлгэржаргал Ц. Орон нутаг дахь иргэдийн оролцоо. //Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь: Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж/ "МӨНХИЙН ҮСЭГ" ХХК. УБ, х-197-198

15 Мямарцоож Н: (2012). Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо. УБ, х-11

16 Мямарцоож Н: (2012). Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо. УБ, х-12

Оролцоонд тулгуурласан менежмент, оролцоонд суурилсан эдийн засгийн шийдэл, оролцоонд тулгуурласан хөгжлийн загвар, бүх нийтийн оролцоонд суурилсан асуудал шийдвэрлэх загвар гэх мэт “оролцоо” гэх ойлголттой холбоотой ихэнх үйлдлүүдийн агуулга нь оролцогч талуудын хамтын оролцоотой шийдвэр гаргах гэсэн санааг илэрхийлж байдаг. Цахим оролцооны тухай үзэл санааг ардчиллын тэлэлт, ардчиллын бэхжилт, иргэн бүрт төрийн бодлого шийдвэрт өөрийн эрх ашигийг ямар нэгэн хэмжээгээр тусгуулах боломжийг олгох, зөвлөлдөх ардчиллын хэрэгжилттэй холбоотойгоор бий болсон нэг талаас ойлголт нөгөө талаас арга зүй гэж ойлгож болно. Энэ утгаараа цахим оролцоо гэх ойлголт нь зөвхөн улс төрийн шинжлэх ухааны судалгаанд биш эдийн засаг бизнес, харилцаа холбоо, технологийн шинжлэх ухааны судалгаанд өргөн хэрэглэгдэх болсон. Цахим оролцооны талаар судласан судалгааны ажлууд, эрдэм шинжилгээний бүтээлүүдээс судалгааны дараах хоёр чиглэлийг харж болохоор байна. Үүнд:

1. Төрийн үйлчилгээний дижитал шилжилтийн явцад бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтад иргэдийн цахим оролцооны нөлөөг судлах;
2. Цахим засгийн газрын хөгжлийн бодлого боловсруулалт ба иргэдийг оролцоог судлах;

Macintosh (2004) цахим ардчиллын тухай үзэл санаа нь цахим сонгууль, цахим оролцоо гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрддэг талаар өөрийн бүтээлдээ дурьдсан байдаг. Цахим ардчилал гэдэг нь технологийн тусламжтайгаар төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх тухай бол харин цахим оролцоо нь шийдвэр гаргах болон зөвлөлдөх үйл явцад иргэдийн дэмжлэгийг нэмэгдүүлэх тухай ойлголт юм. Энэ утгаараа цахим ардчилал бол ардчиллын үзэл санаа, илрэл бодит утгаараа нийгмийн хөрсөнд дижитал хэрэглүүрийн тусламжтайгаар бүрэлдэн бий болж байгаагийн илрэл юм¹⁷. Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээнд технологийн дэвшлийг бий болгож, дижитал хэрэгслүүдийн тусламжтайгаар Засгийн газрын үйл ажиллагааг цахимжуулж эхлэх үйл явцтай зэрэгцэн шинжлэх ухааны судалгаа шинжилгээний салбаруудад цахим хэмээх тодотголтой маш олон судлагдахуунууд шинээр болсоор байна. Эдгээрээс 2000-2020 оны хооронд хэвлэгдсэн цахим ардчилал, цахим оролцоотой холбоотой эрдэм шинжилгээний цахим өгүүлүүдийг Web of science, EBSCO-д бүртгэлтэй 8000 гаруй сэтгүүлүүдээс хайж үзэхэд давхардсан тоогоор 250 гаруй илэрц гарч ирдэг. Эдгээр эрдэм шинжилгээний өгүүлүүдийн агуулга нь дараах үндсэн 3 хэсэгт хуваагдаж болохоор байдаг. Үүнд:

1. Цахим ардчилал ба оролцоо, ардчилал ба интернет, ардчилал ба мэдээллийн технологийн хөгжил, дижитал ардчилал
2. Цахим оролцоо-Цахим Засгийн газар ба оролцоо, цахим засаглал ба оролцоо, цахим оролцоо ба зөвлөлдөх ардчилал, цахим хэлэлцүүлэг ба иргэдийн оролцоо, оролцоо ба дижитал өөрчлөлт
3. Цахим тэлэлт-дижитал хуваагдал ба оролцоо, дижитал хуваагдал ба цахим технологийн давуу, сул тал

¹⁷ Clift, S. (2000) Internet of Democracy. Communications of the ACM, 43(11), 31-32

Эндээс харахад цахим оролцоо гэдэг нь цахим ардчилал, цахим тэлэлтийн үр дүнд бий болж байгаа шийдвэр гаргах, бодлого боловсруулах үйл явцад иргэдийн идэвхжлийг дижитал технологийн тусламжтайгаар нэмэгдүүлэх тухай ойлголт болох нь харагдаж байгаа юм.

Цахим оролцоог судлахын тулд энэ судлагдахуунуудтай холбоотой дараах ойлголтуудыг судлах шаардлагатай. Үүнд:

- Цахим оролцооны онолын суурь үзэл баримтлал;
- Цахим оролцоонд оролцогч талууд;
- Цахим оролцооны хэлбэрүүд;
- Цахим оролцоонд нөлөөлөх хүчин зүйлүүд;
- Цахим оролцоог үнэлэх арга зүй;
- Цахим оролцооны үр дагавар;
- Цахим оролцоог судлах судалгааны арга зүй.

Цахим оролцооны онолын суурь үзэл баримтлал:

Цахим оролцоо нь шинжлэх ухааны олон салбарт харилцан адилгүй арга зүй, онолын үндэслэлтэйгээр судлагдсан байдаг. Үүний шалтгаан нь:

Энэ нэр томъёо нь технологийн дэвшлийн явцад бий болсон үүсмэл шинжтэй ойлголт юм. Ийм учраас цахим оролцооны талаарх нэгдмэл суурь онолын үзэл баримтлал хараахан бүрэлдэн бий болоогүй салбар дундын судлагдахуун юм.

Харьцангуй шинэ тутам хөгжиж байгаа судалгааны чиглэл учраас судалгааны нэгдмэл арга зүй, онолын тогтсон хандлагыг тодорхойлох боломж хараахан хязгаарлагдмал байгаа юм.

Гэсэн хэдий ч цахим оролцооны талаар хийгдэж байгаа эрдэм шинжилгээний өгүүллүүдийг судлаад үзэхэд дийлэнх нь улс төрийн шинжлэх ухаан, социологийн шинжлэх ухаан, төрийн захиргааны шинжлэх ухаан онолын суурь үзэл баримтлал дээр суурилсан байдаг бол цөөн тооны өгүүллүүд нь мэдээллийн технологи, компьютерийн шинжлэх ухаан, коммуникаци, хот төлөвлөлт, хүрээлэн буй орчны менежмент гэх бусад шинжлэх ухааны онолын үзэл баримтлал дээр суурилсан байдаг.

Хүснэгт 2.

Судалгааны онолын суурь үзэл баримтлал	Судалгааны чиглэл	Судалгаа хийсэн эрдэмтийн төлөөлөл
Ардчиллын тухай онол	<ul style="list-style-type: none"> Цахим ардчилал ба оролцоо Цахим оролцоо ба ардчилалын бэхжилт 	2001 он хүртэлх- Hoff, Lofgren, Torpe; 2003 он- Lourenco, Costa; 2004 он- Bingham, Nabatchi, O'Leary, Habermas; 2005- DiMaggio, Hargittai, Neuman, Robinson; 2006; Lusoli, Ward;
Төрийн захиргааны шинжлэх ухааны зарим онол	<ul style="list-style-type: none"> Хотын хөгжил, төлөвлөлтөд иргэдийн оролцоог цахим технологийн тусламжтайгаар нэмэгдүүлэх; Орон нутгийн түвшинд ардчиллын бэхжилтийг хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломж 	1991, 1997, 1999 он- Frederickson, DiMaggio; 2005 он- Bingham;
Инновацийн тэлэлтийн тухай онол	<ul style="list-style-type: none"> Технологийн дэвшил ба хөгжил Инновацийн тэлэлт ба иргэдийн оролцоо Цахим хөгжил ба иргэдийн оролцоо 	1995 он- Rogers
Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн талаарх зарим онол, мэдээллийн технологийн зарим онол сонголтын тухай онол	<ul style="list-style-type: none"> Иргэдийн оролцоонд ОНМХ-ийн хөгжлийн нөлөө Сүлжээний технологийн дэвшил ба нийгмийн хөгжил Иргэдийн сонголтын тухай онол ба орон нутгийн хөгжил 	1937-1945 он- Tocqeville; 1977- 1980 он- Castells; 1996-200 он- Putnam; 2000-2002 он- Grönlund;

Цахим оролцооны субъектүүд

Цахим оролцоо нь тухайн үйл явцад хамааралтай талуудын санаачлага дээр суурилж өрнөдөг учраас оролцогч талууд, тэдний ашиг сонирхлыг судлан үзэх шаардлагатай байдаг. Цахим оролцооны субъектүүдэд :

- **Иргэд:** Цахим оролцооны талаар хийгдэж байгаа судалгааны ихэнх хэсэг нь иргэдийн оролцоонд анхаарал хандуулж судласан байдаг. Өөрөөр хэлбэл иргэд-төрийн байгууллага, иргэд- улс төрчид, иргэд- төрийн үйлчилгээ гэх мэт иргэд болон бодлого төлөвлөх, шийдвэр гаргах үйл явцад оролцогч бусад субъектүүд гэсэн хамааралтайгаар асуудлыг авч үзэн судласан байдаг. Судлаач Chadwick, May(2003); Hudson-Smith, Evans, Batty(2005), Clift(2000), Fernández-Maldonado(2005) цахим оролцоо нь оролцогч талууд хэн байхаас ихээхэн шалтгаалдаг гэж үзээд их төлөв иргэдэд бий болж буй цахим оролцооны боломжийн талаарх судалгаануудыг хийсэн байдаг. Энэ утгаараа цахим оролцооны гол субъект нь иргэд юм.
- **Улс төрчид:** Цахим оролцооны гол субъект болох иргэдтэй хамгийн ойр оролцогч тал бол улс төрчид байдаг. Үүний учир шалтгаан нь иргэдийн оролцоогоор дамжигдан нийгэмд хүрч байгаа асуудлын шийдвэр гаргах

гол субъект нь улс төрчид байдагтай холбоотой юм. Цахим оролцооны субъектүүдийн нэг болох улс төрчид гэдэгт зөвхөн нэг бие хүнээс гадна бүлгийг ойлгодог. Цахим хэлэлцүүлэг, нэр бүхий улс төрчдөд чиглэсэн ямар нэгэн кампанит ажил гэх цахим оролцооны хэлбэрүүдэд оролцогч талуудын нэг хэсэг нь яалт ч үгүй улс төрчид байдаг. Судлаач Jensen (2003), Conhaim(2000), Howard(2005), Rushkoff(2004) нар нэр дэвшигчдийн сонгуулийн кампанит ажлын өмнө ба дараах үеийн сонгуулийн цахим оролцооны талаарх судалгаануудыг хийсэн байдаг.

- **Төрийн байгууллага:** Интернэтэд суурилсан цахим оролцооны санаачлагууд нь иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн байгууллагууд, төрийн албан хаагчид, төрийн байгууллагын бюрократ тогтолцоонд хандах хандлагад эрс шинэчлэлийг бий болгосоор байна. Тийм учраас цахим оролцооны үйл явцын гол субъект нь төрийн байгууллага юм. Цахим ардчиллын хөгжил, технологийн дэвшлийн шинэ шийдлүүд нь төрийн байгууллагын бюрократ тогтолцоонд шинэчлэл авчрахын зэрэгцээгээр төрийн үйлчилгээний цахим хувилбаруудыг олноор бий болгож улмаар Засгийн газрын үйл ажиллагааг цахимжуулах, цахим Засгийн газрыг бий болгох, зарим үйлчилгээг хариуцсан цахим төрийн албан хаагчийг бий болгосоор байна. Судлаач Bingham, Nabatchi, O'Leary(2005), Chadwick(2003), Al-Kodmany(2000), Elwood(2001), Snellen(2001) нар төрийн үйлчилгээний цахим тэлэлт, хот төлөвлөлт, орон нутгийн засаг захиргааны байгууллагын цахим бүтэц, орон нутаг дах цахим ардчиллын бэхжилт, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага дах цахим хөгжил гэсэн сэдвүүдээр судалгаа хийсэн байдаг.
- **Иргэний нийгмийн байгууллагууд:** Цахим технологид суурилсан үйлчилгээнүүд нь иргэдэд төдийгүй иргэний нийгмийн байгууллагуудад олон боломжийг бий болгож байдаг. Иргэний нийгмийн байгууллагуудын цахим санаачлага, цахим үйл ажиллагааны хувилбарууд нь иргэд төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх, улмаар үзэл бодол эрх ашигаараа нэгдэж иргэний нийгмийн байгууллагуудаас зохион байгуулж байгаа цахим хэлэлцүүлэгт орох гэх мэт олон боломжийг олгож байдаг нь иргэний нийгмийн байгууллагуудын хувьд төр иргэн хоёрыг холбох үйл явцыг технологийн дэвшлийн тусламжтай ухаалгаар шийдвэрлэх бас нэгэн гарц болсоор байна.

Цахим оролцооны хэлбэрүүд

Цахим оролцооны хэлбэрүүд гэдэгт технологийн хөгжлийн тусламжтайгаар зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаануудын хэлбэрийг багтааж ойлгоно. Дэлхийн ихэнх улсын практикаас харахад цахим оролцооны хэлбэрүүдэд улс төрийн цахим уулзалт, цахим мэтгэлцээн, цахим зөвлөгөөн, цахим санал солилцолт зэргийг авч үзсэн байдаг.

- Цахим санал хураалт:** Санал хураалтыг мэдээллийн технологийн хэрэгслүүдийн тусламжтайгаар зохион байгуулахыг цахим санал хураалт гэнэ. Санал хураалтыг цахим машины тусламжтайгаар зохион байгуулах, санал хураах газар цахим машин ашиглан саналыг хураах (сонгууль), дижитал орон зайд ямар нэгэн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж оролцогчдоос саналыг цахимаар авах гэх мэт санал хураалттай холбоотой цахим технологийн шийдлийг ашигласан бүхий л үйл явцыг багтаан ойлгож болно. Цахимаар санал хураах технологи, цахим сонгууль нь иргэдэд орон зайн ялгаатай байдлаас үл шалтгаалан сонгох үйл явцад оролцох, талуудын идэвхи оролцоог нэмэгдүүлэх, зохион байгуулалтын уламжлалт хэлбэрүүдэд үүсдэг санхүүгийн дарамтыг бууруулах олон давуу талыг үүсгэсэн практик жишээнүүдийг дэлхийн олон улс орнуудаас харж болно. Гэхдээ улс төрийн цахим сонгуулийн хувьд дээрх давуу талууд харилцан адилгүй байх тохиолдол бий. Цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа санал хураалтад хамгийн чухал асуудлуудын нэг нь оролцогчийн аюулгүй байдал, итгэлцлийн асуудал байдаг. Итгэлцэл гэдэг бол оролцогч тал технологийн шийдэл буюу санал хурааж буй тоног төхөөрөмж, үйл явцыг зохион байгуулж, дамжуулж байгаа дижитал хэрэгслүүдэд итгэхтэй холбоотой асуудал юм. Судлаач Drechsler, Madise(2002), Kenski(2005), Oostveen(2004), Prosser, Kofler, Krimmer(2003) нар ардчиллын хөгжилд цахим сонгуулийн үр нөлөө, санал хураалтын технологийн аюулгүй байдал, хэрэглэгчийн аюулгүй байдлын талаар судалгаануудыг хийсэн байна.
- Цахим улс төрийн ярилцлага, хэлэлцүүлэг:** Зөвлөлдөх ардчиллын бэхжилт, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхд цахим хэлэлцүүлгийн үүрэг маш чухлаар нөлөөлдөг байна. Оролцоонд тулгуурласан шийдвэр гаргалтыг нэмэгдүүлэхэд интернэт технологийн дэвшлийг ашиглах нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлж харилцааны орон зайг тэлж байдаг. Судлаач Best and Krueger(2005) нар онлайн болон оффлайн оролцооны ижил төстэй шинж чанар, нас сэтгэл зүйн онцлог цахим оролцооны хэлбэрүүдэд хэрхэн нөлөөлж байгаа талаарх судалгаа хийсэн байдаг. Тэрхүү судалгааны үр дүнгээс харахад өндөр настай оролцогчдын уламжлалт оффлайн оролцооны түвшин нь залуучуудынхаас илүү их байсан бол онлайн оролцооны идэвхижилт залуучуудын дунд өндөр байсан байна. Судлаач Jensen(2003) цахим оролцоо нь улс төрийн ямар нэгэн хэлбэрийн үйл ажилагаанд оролцогчдыг илүү боловсролтой болгож байдаг гэж үзсэн байдаг. Цахим хэлэлцүүлэг нь технологийн дэвшлийг хэрэглэх хэрэглэгчийн ур чадвараас ихээхэн шалтгаалдаг учраас нийгэмд дижитал хуваагдлыг бий болгодог. Иймд сүүлийн үеийн судалгаануудад цахим улс төрийн хэлэлцүүлэгт уламжлалт сувгуудаар дамжуулан хэрхэн оролцох боломжийн талаар судалгаанууд хийгдсээр байна. Үүнийг дагаад цахим хэлэлцүүлгийг уламжлалт мэдээллийн сувгуудаар дамжуулан зохион байгуулах технологийн шийдлүүдийн талаарх судалгаа ч мэдээллийн технологийн салбарт хийгдэж байна.

- **Цахим шийдвэр гаргалт:** Цахим оролцоо нь шийдвэр гаргах үйл явцад иргэдийг татан оролцуулах боломж юм. Цахим шийдвэр гаргалт гэдэг нь мэдээллийн технологийн шийдлийн тусламжтайгаар шийдвэр гаргах үйл явцыг цахимжуулахыг хэлнэ. Энэ утгаараа цахим шийдвэр гаргах үйл явц нь улс төрийн оролцооны идэвхжлийг нэмэгдүүлж байдаг байна. Орон нутгийн түвшинд хот төлөвлөлт, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны төлөвлөлтөд нутгийн иргэдийг оролцуулахад цахим шийдвэр гаргалтын технологийг түгээмэл хэрэглэдэг. Цахим Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, цахим бэлэн байдал, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хэрхэн нэмэгдүүлэх, түүнд цахим технологийн ямар шийдлийг ашиглах талаарх судалгаанууд маш чухал байдаг.
- **Цахим сайн дурын үйл ажиллагаа (хандив, тусламж):** Сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор мэдээллийн технологийн дэвшлийн тусламжтайгаар иргэний нийгмийн байгууллагуудаас зохион байгуулж байгаа цахим үйл ажиллагааг багтаан ойлгодог. Цахим сайн дурын үйл ажиллагааны гол зорилго нь улс төрийн үйл явцад нөлөөлж цаашлаад өөрсдийн ашиг сонирхлыг бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтад ямар нэг байдлаар туслуулах зорилготой байдаг.
- **Цахим зөвлөгөөн:** Цахим зөвлөгөөний гол зорилго нь оролцогч талуудын анхаарлыг шийдвэр гаргах үйл явцад чиглүүлэхэд оршдог. Цахим зөвлөгөөн нь хоёр талт харилцаан дээр суурилж оролцогч талуудын зөвлөлдөх гэж байгаа асуудлын талаар мэдээллээр хангаж уламаар талуудын байр суурийг шийдвэрт тусгах зорилгыг хэрэгжүүлдэг байна.
- **Цахим кампанит ажил:** Нэр дэвшигчид сонгуулийн кампанит ажлын зардлыг бүрдүүлэх, өөрсдийн талархан дэмжигчдийн бүлгийг байгуулах, улмаар зорилтот сонгогчдын бүлгийг бүрдүүлэхэд интернет технологийн дэвшлийг хэрэглэн хийж байгаа сонгуулийн кампанит ажлыг хэлнэ. Сүүлийн жилүүдэд сонгуулийн кампанит ажлын олон нийттэй холбоо тогтоох чиглэлд технологийн дэвшлүүдийг ашиглах нь нэмэгдсээр байна. Цахим кампанит ажил нь сонгуульд оролцож буй нэр дэвшигчдийн боломжийг нэмэгдүүлэх гэхээс илүүтэйгээр ардчиллыг бэхжилтийг хангах, сонгогчдын сонголтод нөлөөлөх хүчин зүйлийг нэмэгдүүлэх, сонголтгүй сонголтын тоог багасгах улмаар сонгогч нэг бүрийн саналыг тусгагдах боломжийг нэмэгдүүлэх чиглэлд технологийн дэвшлийг ашиглаж байгаа нэг хэлбэр юм.
- **Цахимаар санал гомдол гаргах:** Цахимаар санал, гомдол гаргах нь иргэдэд улс төрийн тогтолцоог бүрдүүлэгч төрийн институцуудын үйл ажиллагаа, улс төрийн үйл явцын талаар өөрсдийн байр сууриа технологийн дэвшлийн тусламжтайгаар илэрхийлэх, санал гомдлоо илэрхийлэх боломжийг олгодог. Цахим хэлбэрийн энэ үйл явц нь иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг нэмэгдүүлдэг

байна. Дэлхийн зарим улс орнуудад иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг технологийн шийдлийн тусламжтайгаар цахимжуулсан цахим платформууд хөгжсөөр байна.

Цахим оролцоонд нөлөөлөх хүчин зүйл

Цахим оролцоонд нөлөөлөх хүчин зүйлс гэдэгт цахим оролцооноос хүлээгдэж буй үр дүнд эерэг, сөргөөр нөлөөлөх боломжтой хүчин зүйлсийг авч үзнэ. Үүнд:

- **Мэдээллийн боломж:** Цахим оролцооны хэлбэрүүд нь нэг талаас оролцогч талууд мэдээлэл солилцож байгаа хэлбэр юм. Цахим орчинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд интернэтэд суурилсан мэдээллийн эх сурвалжуудыг нэмэгдүүлэх шаардлага зүй ёсоор тавигддаг. Бодлого боловсруулж, шийдвэр гаргах үйл явцад оролцогч талууд үнэн зөв мэдээллээр тэнцвэртэй хангах нь асуудалд бодитой хангах нөхцөлийг бүрдүүлж байдаг. Тэгэхээр мэдээлэлтэй холбоотой хүчин зүйл гэдэгт мэдээлэл олж авах боломж; мэдээллийн эх үүсвэр; мэдээллийн үнэн зөв байдлыг багтаан ойлгодог байна. Мэдээлэл олж авах боломж иргэдийн оролцоонд хэрхэн нөлөөлдөг талаар судлаач Vimber 2001 онд анх судалгаа хийсэн байдаг. Мэдээллийн хүчин зүйл нь иргэдийн оролцооны идэвхижилд нөлөөлдөг болохыг тогтоосон судалгаанаас хойш дэлхийн хэмжээнд төрийн байгууллагуудын веб сайт дээрх мэдээллүүд зөвхөн иргэд, хэрэглэгчдэд чиглэсэн нэг талт мэдээллийн урсгалын чиглэлээ олон талт болгож, хэрэглэгч-мэдээлэгч талуудын хооронд мэдээллийн эргэх холбоо сайжруулах шаардлага зүй ёсоор тавигдсаар байна.
- **Дэд бүтэц:** Иргэдийн оролцоог цахимжуулах үйл явцад хамгийн чухал хүчин зүйл бол дэд бүтцийн асуудал байдаг. Өөрөөр хэлбэл мэдээлэл, харилцаа холбооны салбарын дэд бүтцийг хөгжүүлэхгүйгээр иргэдийн оролцоог цахимжуулах, цахим арга хэмжээг зохион байгуулах боломжгүй юм. Дэд бүтцийн хүчин зүйл гэдэгт өндөр хурдны интернетийн хүртээмж, гар утасны хэрэглээ, технологийн дэвшлийн нэвтрэлт зэргийг ойлгож авч үздэг байна. Судлаач Gronlund (2002)-ын Швед Улсын жишээн дээр иргэдийн цахим оролцооны талаар хийсэн судалгаанд, Koch (2005)-ын судалгаанд интернэтэд суурилсан технологээр дамжуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй нь иргэдийн оролцоог хэт улс төржүүлж байгаа талаар дурдаад иргэдийн цахим оролцооны тэгш байдлыг хангахад дэд бүтцийн хүчин зүйл чухал байгааг судалгаандаа тэмдэглэсэн байдаг.
- **Технологийн дэвшил, инновац:** Цахим оролцоо нь технологийн дэвшил, инновацийн тодорхой шийдэл дээр суурилан явагдаж байгаа үйл явц юм. Технологийн боломжууд нь цахим оролцооны тодорхой шийдлүүд дээр харилцан адилгүй байдаг. Өөрөөр хэлбэл цахим уулзалт, зөвлөгөөний технологийн шийдэл нь бусад бүх төрлийн цахим үйл ажиллагаануудад

тохирдог гэсэн үг биш юм. Тэгэхээр иргэдийн цахим оролцооны хэлбэрүүдэд тохирох тодорхой технологийн шийдэл, дижитал платформууд олноор хөгжих нь цахим оролцоог нэмэгдүүлэх нэг чухал хүчин зүйлс хэдий ч үүнийг дагаад үүсэх хэрэглэгчийн технологийн ур чадвар, технологийн дэвшлийг хүлээж авах хурд зэргийн ялгаатай байдлаас шалтгаалан дижитал хуваагдал нэмэгдэх хандлагатай байдаг.

- **Технологи хэрэглэх чадвар:** Иргэдийн мэдээллийн технологийн ур чадварын ялгаатай байдал нь цахим оролцооны идэвхижилд шууд нөлөөлж нийгэмд тэгш бус байдлыг үүсгэдэг байна. Дижитал хуваагдлыг багасгахын тулд мэдээллийн технологийн янз бүрийн дэвшлүүд нь хэрэглэгчдийн ялгаатай байдлыг харгалзан үзсэн байх шаардлагатай бөгөөд энэ нь нийгэмд цахим тэлэлт, технологийн хөгжлөөс үүдэн бий болох тэгш бус байдлыг бууруулахад чухал үр дүнтэй юм. Орчин үед иргэдийн цахим оролцооны тэгш байдлын талаарх ойлголтод мэдээллийг олж, хүлээж авах, хэрэглэгчдийн бие физиологийн онцлогт тохирсон байх ялгаатай технологийн шийдэл, дижиталчлалын сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг багтаан авч үзэх болсон байна.
- **Хууль эрх зүйн асуудал:** Технологийн дэвшлийг иргэдийн оролцоог цахимжуулахад хэрэглэх болсоноор хууль эрх зүйн зохицуулалтын тусламжтайгаар шийдвэрлэх шаардлагатай нийгмийн харилцаанууд үүссээр байна.
- **Төрийн байгууллагын чадамж:** Иргэдийн цахим оролцоог идэвхжүүлэх, төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэх, цахим Засгийн газрыг бий болгоход төрийн байгууллагуудын чадамж маш чухлаар нөлөөлдөг. Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн чанар (веб сайтын мэдээлэл), хэрэглэгчийн хүсэлтэд хариу үйлдэл үзүүлэх хурд, мэдээллийн шинэчлэлийн асуудал энэ хүчин зүйлд багтдаг байна.

Цахим оролцооны үр нөлөө

- **Иргэдийг татан оролцуулах үр дагавар:** Мэдээллийн технологийн дэвшлийг иргэдийн оролцоог цахимжуулах үйл явцад хэрэглэснээр бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дах иргэдийн оролцоо нэмэгдэх хандагатай байдаг. Цахим оролцоо нь дижитал орчинд үзэл бодлоороо нэгдсэн кибер бүлгүүд олноор бий болж нийгэмд өрнөж байгаа асуудлын талаарх өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгосоор байна. Улс төрийн цахим оролцооны идэвхжил нь улс төрийн тогтолцооны эргэх холбоог сайжруулсанаар төрийн байгууллагуудын дотоод бүтэц, үйл ажиллагааны үр ашигтай байдалд эерэгээр нөлөөлөх боломжийг бүрдүүлдэг байна.

- **Ардчиллын бэхжилтэд үзүүлэх үр нөлөө** Ардчиллын бэхжилт нь нийгмийн хөгжилд оролцогч талуудын чөлөөт, шудрага оролцоон дээр суурилдаг. Ардчилал бол асуудалд олон талаас хандаж шийдвэр гаргах үйл явцад иргэдийг оролцуулах боломж юм. Цахим оролцооны хэлбэрүүд нь бодлого төлөвлөх, шийдвэр гаргах үйл явцад иргэдийг өргөнөөр оролцуулах, шийдвэр гаргах үйл явцад оролцогч талуудыг тухайн асуудлын талаарх үнэн зөв мэдээллээр хангаж зөвлөлдөх, санал солилцох зарчмаар бодлогын сонголтыг хийх боломжийг олгодог.

2.2 СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, СУДАЛГААНЫ ЗАГВАР

Цахим оролцоо гэдэг нь улс орны хийгээд орон нутгийн түвшинд бодлого боловсруулах, шийдвэр гаргахад бодит үр дүн гаргах мөн төлөөллийн ардчиллын зарчмыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд мэдээлэл, харилцаа холбооны технологийн тусламжтайгаар оролцогч талуудын хамтын үйл ажиллагааг өргөжүүлсэнээр иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үйл явц юм¹⁸. Энэ тодорхойлолтоос харвал цахим оролцоо гэдэг нь төрийн үйлчилгээг иргэдэд илүү ойртуулах зорилготой цахим засаглалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чухал хөшүүрэг болох нь харагдаж байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн хэмжээнд цахим оролцооны технологийн шийдлүүд хурдацтай хөгжсөөр байна. 2010 оны байдлаар дэлхийн хэмжээнд иргэдийн оролцоотойгоор төсөв батлахад цахим технологийг ашигласан 1469 тохиолдол бүртгэгдэж байсан (Sintorner, Herzberg, Allegratti, Rocke, 2010) бол 2013 оны байдлаар энэ тоо 2700 хүртэл нэмэгдсэн байдаг (Sintorner, Herzberg, Allegratti, Rocke, 2013). 2016 оны НҮБ-ын тайлангаас үзэхэд 193 гишүүн орны 183 нь боловсрол, эрүүл мэнд, санхүү төсөв, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн салбарт цахим оролцооны нэг хэлбэр болох цахим мэдээлэл, хэлэлцүүлгийг зохион байгуулсан; 62 улс нь хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр зуучлалын талаарх мэдээллийг иргэдэд цахим шуудангаар дамжуулан хүргэдэг болсон; 152 улс нь сошиал мэдээллийн сувгуудаар дамжуулан иргэдэд цахим зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэдэг; 120 улс нь шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангахад цахим технологийн шийдлийг ашиглаж байна.

“Цахим оролцоо” хэмээх ойлголт нь нэг биш олон шинжлэх ухааны уулзвар дээр судлагддаг салбар дундын судлагдахуун юм¹⁹.

“Цахим оролцоо”-ны талаар олон улсад хийгдсэн судалгаануудаас дараах чиглэлүүдийг харж болохоор байна. Үүнд:

1. Цахим оролцооны технологийн шийдлийн асуудал;
2. Цахим оролцооны төрөл хэлбэрүүдийн талаар;
3. Цахим Засгийн газар, Засгийн газрын нээлттэй мэдээллийн сан;
4. Цахим үйлчилгээний нэвтрэлт, чанар хүртээмжийн асуудлыг гол төлөв судалсан байдаг.

¹⁸ United nations, 2014, p.61

¹⁹ (Macintosh, Coleman, & Schneeberger, 2009; Medaglia, 2012; Susha & Gronlund, 2012).

Science Direct, Web of science, Google scholar дээр 2003-2017 оны хооронд цахим оролцооны талаар 779 судалгааны өгүүлэл хэвлэгдсэн байна. Тэрхүү 779 эрдэм шинжилгээний өгүүлээс судалгааны асуудал, таамаглал, судалгааны загваруудын хувьд ижил төстэй байдлаар нь ангилан үзвэл доорх 60 голлох эрдэм шинжилгээний өгүүллийг олон улсын бүтээлүүдэд их төлөв судлагдсан байдлын судалгаандаа дурьдсан байдаг.

Хүснэгт 3.

№	Судлаачийн нэр	Судалгааны загвар	Судалгааны асуудал	Түүврийн хэмжээ	Улс
1	Lee, Braynov and Rao (2003)	TAM	Цахим үйлчилгээ	158	АНУ
2	Carter and Belanger (2004)	TAM, DOI	Цахим үйлчилгээ	136	АНУ
3	Carter and Belanger (2005)	TAM, DOI	Цахим үйлчилгээ	105	АНУ
4	Carter and Belanger (2005)	TAM, DOI and web trust	Цахим сонгууль	208	АНУ
5	Scaupp and Carter (2005)	CVM, GIM	Цахим хэлэлцүүлэг	121	Сингапур
6	Yang, Li, Tan, and Teo (2007)	TRA	Цахим хэлэлцүүлэг	183	Сингапур
7	Yao and Murphy (2007)	TAM, UTAUT	Цахим сонгууль	453	АНУ
8	Belanger and Carter (2008)	trust of the internet, trust of government	Цахим үйлчилгээ	214	АНУ
9	Colesca and Dobrica (2008)	TAM	Веб хуудас, сайт	481	Румин
10	Tan, Bembar, and Cenfetelli (2008)	SERQUAL, TAM, Trust	Цахим үйлчилгээ	647	АНУ
11	Van Dijk, Peters, and Ebbers (2008)	UTAUT	Цахим үйлчилгээ	1225	Нейдерланд
12	Wang and Liao (2008)	DeLone and Mclean	Цахим үйлчилгээ	119	Тайван
13	Wangpipatwong, Chutimaskul, and Papisatorn (2008)	TAM	Веб хуудас, сайт	614	Тайланд
14	Chiang (2009)	TAM	Цахим сонгууль	281	Тайван
15	Lean, Zailani, Ramayah, and Fernando (2009)	TAM, DOI	Цахим үйлчилгээ	150	Малайз
16	Tang, Chung, and Se (2009)	TAM, TRA	Цахим үйлчилгээ	385	БНХАУ
17	Teo, Srivastava, and Jinag (2009)	DeLone and Mclean, trust	Цахим үйлчилгээ	214	Сингапур
18	Y.S. Wang and Shih (2009)	UTAUT	Мэдээллийн киоск(ТҮЦ машин)	244	Тайван
19	Kollmann and Kayser (2010)	UTAUT, CVM	Цахим ардчилал	232	ХНБГУ
20	Alathur. Ilavarasan, and Gupta (2011)	Empowerment	Цахим хэлэлцүүлэг	360	Энэтхэг
21	Al-Hujran, Al-dalahmeh, and Aloudat (2011)	TAM, Hofstredre	Цахим үйлчилгээ	197	Иордан
22	Al-Sobhi, Weerakkody, and Ei-Haddadeh (2011)	UTAUT	Цахим үйлчилгээ	624	Саудын Араб
23	Lin, Fofanah, and Liang (2011)	TAM	Цахим үйлчилгээ	167	Гамби
24	Rokhman (2011)	DOI	Цахим үйлчилгээ	751	Индонез

25	Shyu and Huang (2011)	TAM	Цахим үйлчилгээ	307	Тайван
26	Styven and Wallstrom (2011)	Trust	Цахим үйлчилгээ	422	Швед
27	Alomari, Woods, and Kuldeep (2012)	DOI, TAM	Цахим үйлчилгээ	400	Иордан
28	Alshehri, Drew, Alhussain, and Alghamdi (2012)	UTAUT, Web quality	Цахим үйлчилгээ	400	Саудын Араб
29	Belanche, Casalo, and Flavian (2012)	TAM	Цахим үйлчилгээ	416	Испани
30	Carter and Belanger (2012)	TAM, DOI, political factors	Цахим сонгууль	372	АНУ
31	Choi and Kim (2012)	TAM	Цахим сонгууль	228	АНУ
32	Lee and Kim (2012)	TAM, Social networks	Цахим хэлэлцүүлэг	1076	Өмнөд Солонгос
33	Khan, Moon, Swar, Zo, and Rho (2012)	Өөрийн судалгааны загвар	Цахим үйлчилгээ	360	Афганистан
34	Rehman, Esichaikul, and Kamal (2012)	TAM, DOI	Цахим мэдээлэл	138	Пакистан
35	Wang and Lo (2012)	TAM, TBP	Цахим үйлчилгээ	200	Тайван
36	Winkler, Hirsch, Trouvilliez, and Gunther (2012)	TAM	Гар утсанд суурилсан мэдээлэх үйлчилгээ	200	ХНБГУ
37	Alawneh, Al-Refai, and Batiha (2013)	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны загвар	Веб хуудас, сайт	206	Иордан
38	Hung, Chang, and Kuo (2013)	TBP	Цахим Засгийн газар	331	Тайван
39	Mou, Atkin, Fu, Lin, and Lau (2013)	Өөрийн судалгааны загвар	Цахим хэлэлцүүлэг	181	БНХАУ
40	Persaud and Persaud (2013)	Өөрийн судалгааны загвар	Веб хуудас, сайт	437	Канад
41	Abu- Shanab (2014)	TRA, Trust Antecedents Model	Цахим үйлчилгээ	759	Иордан
42	Al-Hujran, Al -Debei, and Al-Lozi (2014)	TAM, TPB	Цахим ардчилал	189	Иордан
43	Aloudat, Michael, Chen, and Al-Debei (2014)	TAM	Цахим Засгийн газар	290	Австрали
44	Cegarra-Navarro, Garcia-Perez, and Moreno-Cegarra (2014)	TAM	Цахим мэдээлэл	307	Испани
45	Liu et (2014)	TAM	Цахим Засгийн газар	409	БНХАУ
46	Park, Choi, and Abu Shanab (2015)	Өөрийн судалгааны загвар	Цахим мэдээллийн сүлжээ	491	Өмнөд Солонгос
47	Abu- Shanab (2015)	Өөрийн судалгааны загвар	Засгийн газрын нээлттэй дата(E-mongolia)	869	Иордан
48	Al-Quraan and Abu Shanab (2015)	Өөрийн судалгааны загвар	Веб хуудас, сайт	248	Иордан
49	Alharbi, Kang, and Hawryszkiewycz (2015)	TBP, Trust	Веб хуудас, сайт	770	Саудын Араб
50	Alrashedi, Persaudi, and Kindra (2015)	Өөрийн судалгааны загвар	Цахим мэдээлэл	200	Саудын Араб
51	Dahi and Ezziane (2015)	TAM	Цахим үйлчилгээ	845	Абу Даби

52	Rabaa'l (2015)	TAM	Цахим үйлчилгээ	853	Иордан
53	Rana and Dwivedi (2015)	SCT	Цахим санал гомдол, шийдвэрлэлт	419	Энэтхэг
54	Zuiderwijk, Janssen, and Dwivedi (2015)	UTAUT	Засгийн газрын нээлттэй дата(E-mongolia)	111	Зарим улс орнууд
55	Cai Shuqin, Mastoi, Gul, and Gul (2016)	Өөрийн судалгааны загвар	Цахим үйлчилгээ	200	Пакистан
56	Piehler, Wirtz, and Daiser (2016)	ECT	Веб хуудас, сайт	477	Нигер
57	Rodrigues, Sarabdeen, and Balasubramanian (2016)	UTAUT	Цахим үйлчилгээ	380	Арабын нэгдсэн Эмират улс
58	Seo and Bernsen (2016)	SCT, UTAUT, Trust	Хотын цахим үйлчилгээ	111	Нейдерланд
			Хотын цахим үйлчилгээ	73	
			Хотын цахим үйлчилгээ	70	
			Хотын цахим үйлчилгээ	83	
59	Oni, Mbarika, and Ayo (2017)	CVM, TRA	Цахим ардчилал	327	Нигер
60	Schmidhuber, Hilgers and Gegenhuber (2017)	TAM	Нээлттэй Засгийн газар	466	Австри
CVM-civic voluntarism model, DOI-diffusion of innovation, GIM-general incentives model, SCT- social cognitive theory, SERQUAL- service quality, TAM-technology acceptance model, TPB- theory of planned behaviour, TRA-theory of reasoned action, UTAUT-unified theory of acceptance and use of technology, ECT- Expectation confirmathion theory					

(Mijal Naranzo Zolotov²⁰, Sven Casteleyen²¹, E-participation adoption models research in the last 17 years, Science Direct)

Энд дурьдагдсан 60 судалгааны ажил нь цахим оролцоо, цахим Засгийн газар гэх ерөнхий ойлголтын хүрээнд цахим ардчилал, цахим сонгууль, цахим санал хураалт, цахим шийдвэр гаргалт (шүүх болон бусад), цахим хэлэлцүүлэг, цахим мэдээллийн талаар тоон судалгаа хийсэн байна. Судалгааны өгөгдлийг асуулгын аргаар бүрдүүлж, SPSS болон Smart PLS программ ашиглан, корреляци, регресс болон замын шинжилгээ хийсэн байна. Судалгаанд оролцогчдыг ажил эрхлэлтийн байдлын хувьд, оршин байгаа газар нутгийн хувьд, насны хувьд ялгаатай байхаар сонгосон байсан. Цахим оролцооны талаар хийгдсэн судалгаануудад хувьсагчуудыг дараах байдлаар авч үзсэн байсан. Үүнд:

- Цахим оролцооноос хүртэж буй ашиг тус
- Хэрэглэгдэх байдал (хялбар, үр ашигтай байх)
- Хандлага
- Нийгмийн нөлөөлөл
- Цахим сүлжээнд итгэх итгэл
- Хэрэглэх хүсэл, эрмэлзэл
- Засгийн газарт итгэх итгэл

20 Information management school, Universidade Nova de Lisboa, Lisbon, Portugal

21 Universidad Jaime I, Institute of New Imaging Technologies, Geospatial technologies lab

- Өрсөлдөх чадвар
- Цахим оролцооноос бий болж буй дижитал ялгаатай байдал
- Үүсч болох эрсдэл
- Технологийн хэрэглэх чадвар
- Технологийн нөхцөл

Цахим оролцооны талаар хийсэн дээрх судалгаануудын өгөдлийн шинжилгээний агуулгыг судлан үзэхэд дээр дурьдсан үндсэн хувьсагчуудын хүрээнд асуулгаа томъёолсон байсан.

Хүснэгт 4.

Хувьсагчууд	Судалгааны асуулгын чиглэл
Хандлага	Хэрэглээг дэмжсэн хандлага
	Цахим санал өгөхийг дэмжсэн хандлага
	Цахим ардчиллыг дэмжих хандлага
Хэрэглээ	Цахим оролцоог дэмжсэн хэрэглээ
	Цахим Засгийн газрын үйл ажиллагааг дэмжсэн
Чанар, ашигтай байх	Мэдээллийн тогтолцооны чанар
	Цахим үйлчилгээний чанар
	Веб сайтын чанар
Улс төрийн үр ашиг	Улс төрийн тогтолцоо, улс төрийн үйл явцын үр ашигтай байдал
Сэтгэл ханамж	Хэрэглэгчийн сэтгэл ханамж
	Цахим оролцоог дэмжсэн аппликейшины талаарх сэтгэл ханамж
	Иргэдийн сэтгэл ханамж
Итгэл	Цахим оролцоонд итгэх итгэл
	Хэрэглэгчийн итгэл үнэмшил
	Төрийн байгууллагуудын веб сайтад итгэх итгэл
	Цахим санал хураалтын тогтолцоонд итгэх итгэл
	Орон нутгийн засаг захиргаанд итгэх итгэл(цахим үйлчилгээ)
Технологийн үр чадвар, Цахим үйлчилгээг хэрэглэх үр чадвар	Цахим платформын хэрэглээ
	Цахим хэлэлцүүлгийн хэрэглээ, оролцогчдын тоо
	Хэрэглэгчийн зан төлөв (хэрэглэх явцад үүсэх бэрхшээл, төвөгтэй байдал)


Энэ удаагийн бодлогын судалгаагаар иргэдийн цахим оролцооны өнөөгийн төлөв байдлыг судлахдаа аймаг, нийслэлийн иргэдийн төлөөллийг судалгааны түүвэртээ багтаахын тулд 2018 онд Үндэсний статистикийн газраас хийсэн “Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулсан судалгаа”-г

үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэрийг үндсэн 5 кластерт хуваан авч үзэж, кластер тус бүрээс 1-2 аймгийг сонгон авч санамсаргүй түүврийн аргаар судалгааг хийсэн. “Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулсан судалгаа” нь эдийн засгийн бүсээр нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг харьцуулан судласан байна. Түүврийн хэмжээ, судалгааг зохион байгуулах аймгийг сонгохдоо дээрх судалгааг сонгон авах болсон шалтгаан нь:


1. Судалгаанд эдийн засгийн өсөлт, инфляц, төсөв, хөрөнгө оруулалт, түүнчлэн эдийн засгийн зарим бодит салбарын үндсэн үзүүлэлт, хүн амын тоо, нягтрал, хүний хөгжлийн индекс зэрэг үзүүлэлтийг эдийн засгийн бүсүүдээр судласан.
2. Уг судалгааны өгөгдөл нь ҮСХ-ноос гаргаж байгаа албан ёсны статистикийн мэдээлэлд суурилсан байсан.
3. Кластер шинжилгээ нь аймгуудыг нийгэм эдийн засгийн үзүүлэлтийн ойролцоо түвшингээр нь бүлэглэж харуулдаг.

Энэ шинжилгээгээр I кластерт: Архангай, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Төв, Хөвсгөл гэсэн 6 аймаг; II кластерт: Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хэнтий, Дархан-Уул гэсэн 7 аймаг; III кластерт: Булган, Дорноговь, Дорнод, Дундговь, Увс, Орхон, Говьсүмбэр гэсэн 7 аймаг; IV кластерт: Сэлэнгэ аймаг; V кластерт: Улаанбаатар хот багтаж байна. Кластер тус бүрээс сонгон авсан аймгуудын хувьд үүрэн холбооны хэрэглэгч болон интернэт хэрэглэгчийн тоог авч үзэхэд харьцангуй ойролцоо байсан.

Зураг 2. Гар утас идэвхтэй хэрэглэгчдийн тоо



Зураг 3. Интернет хэрэглэгчийн тоо



Эх сурвалж: <https://www.1212.mn>

“Иргэдийн цахим оролцооны өнөөгийн төлөв байдал” судалгааны хүрээнд нийт 940 түүвэртэй байхаар төлөвлөж I кластераас Өвөрхангай, Төв, Завхан, II кластераас Ховд, Говь-Алтай, III кластераас Увс, IV кластераас Сэлэнгэ, V кластераас Улаанбаатар хотыг тус тус төлөөлүүлэн судласан болно.

Судалгааны анкет нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Оролцогчийн ерөнхий мэдээлэл;
- Нэгдүгээр бүлэг нь Монгол улсын хэмжээнд иргэдийн цахим оролцооны түвшинийг тодруулах зорилготой 57 асуулгатай;
- Хоёрдугаар бүлгийн хувьд Засгийн газрын цахим үйлчилгээний чанар, иргэдийн цахим оролцоонд нөлөөлөх хүчин зүйлийг тодруулах, дижитал ялгарлыг тодруулах гэсэн үндсэн хоёр зорилготой 61 асуулгатай.

Судалгааг 2022 оны 6-р сарын 28-аас 8-р сарын 28-ны хооронд цахим болон цаасан хосолмол хэлбэрээр зохион байгуулсан. Судалгааны өгөгдлийн дүн шинжилгээг статистикийн SPSS.24 программ ашигласан боловсрууллаа. Оролцогчдоос авсан нээлттэй асуултын хариултад дүн шинжилгээ хийхдээ өгсөн санал тус бүрийг нэг бүрчлэн тусгаж, хамгийн олон давтамжтайгаар илэрхийлэгдсэн эхний хариултаудад дүгнэлт хийсэн.

3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Судалгаанд оролцогчдын мэдээлэл хэсэгт оролцогчдын харьяалагдах аймаг, нийслэл (кластер), нас, хүйс, боловсрол ажил эрхлэлтийн байдлыг тодруулах асуулгууд оруулсан. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийг дараах хүснэгт 1-т харууллаа.

Хүснэгт 5. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл (харъяалал, нас, хүйс, боловсролын байдал, ажил эрхлэлтийн байдал)

Судалгаанд оролцогч (аймаг, нийслэлээр)

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	1-р кластер: Төв, Архангай, Өвөрхангай, Завхан аймаг	196	20.6	20.8	20.8
	2-р кластер: Говь-Алтай, Ховд аймаг	311	32.7	33.0	53.8
	3-р кластер: Увс, Дорнод аймаг	97	10.2	10.3	64.1
	4-р кластер: Сэлэнгэ аймаг	113	11.9	12.0	76.1
	5-р кластер: Улаанбаатар хот	225	23.7	23.9	100.0
	Total	942	99.2	100.0	
Missing	System	8	0.8		
Total		950	100.0		

Судалгаанд оролцогчдын нас

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	18-25	263	27.7	28.5	28.5
	26-35	285	30.0	30.9	59.4
	36-45	192	20.2	20.8	80.3
	46-55	130	13.7	14.1	94.4
	56-65	44	4.6	4.8	99.1
	66-аас дээш	8	0.8	0.9	100.0
	Total	922	97.1	100.0	
Missing	System	28	2.9		
Total		950	100.0		

Судалгаанд оролцогчдын хүйс

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Эрэгтэй	329	34.6	35.4	35.4
	Эмэгтэй	601	63.3	64.6	100.0
	Total	930	97.9	100.0	
Missing	System	20	2.1		
Total		950	100.0		

Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Бүрэн бус дунд	80	8.4	8.4	8.4
	Бүрэн дунд	206	21.7	21.7	30.1
	Техник болон мэргэжлийн	45	4.7	4.7	34.8
	Дээд	619	65.2	65.2	100.0
	Total	950	100.0	100.0	

Судалгаанд оролцогчдын ажил эрхлэлтийн байдал

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Төрийн байгууллагат ажилдаг	410	43.2	43.3	43.3
	Хувийн байгууллагат ажилладаг	210	22.1	22.2	65.5
	Оюутан	158	16.6	16.7	82.2
	Тэтгэвэрт	32	3.4	3.4	85.6
	Ажил хийдэггүй	88	9.3	9.3	94.9
	Малчин	48	5.1	5.1	100.0
	Total	946	99.6	100.0	
Missing	System	4	0.4		
Total		950	100.0		

Судалгаанд оролцогчдын 20.6 хувь нь Төв, Архангай, Өвөрхангай, Завхан аймаг, 32.7 хувь нь Говь-Алтай, Ховд аймаг, 10.2 хувь нь Увс, Дорнод аймаг, 11.9 хувь нь Сэлэнгэ аймаг, 23.7 нь Улаанбаатар хотын иргэд байна. Хүйсийн хувьд авч үзвэл 63.3 хувь нь эмэгтэй, 34.6 хувь нь эрэгтэй оролцогчид байна. Судалгаанд оролцсон иргэдийг насны байдлаар нь ангилан үзвэл 18-25 насны оролцогчид 27.7 хувь, 26-35 насны оролцогчид 30 хувь, 36-45 насны оролцогчид 20.2 хувь, 46-55 насны оролцогчид 13.7 хувь, 56-65 насны 4.6 хувь, 66-аас дээш насны оролцогчид 0.8 хувийг тус тус эзэлсэн байна.

Судалгаанд оролцогчдыг боловсролын түвшингээр нь авч үзвэл бүрэн бус дунд боловсролтой оролцогчид 8.4 хувь, бүрэн дунд боловсролтой оролцогчид 21.7 хувь, техник, мэргэжлийн болон тусгай дунд боловсролтой оролцогчид 4.7 хувь, дээд боловсролтой оролцогчид 65.2 хувийг эзэлж байна.

Судалгаанд оролцогчдын 43.2 хувь төрийн байгууллагат, 22.1 хувь нь хувийн хэвшлийн байгууллагат ажилладаг, 16.6 хувь нь оюутан, 3.4 хувь нь тэтгэвэрт, 5.1 хувь нь малчин, бол 5.3 хувь ямар нэгэн хөдөлмөр эрхэлдэггүй байна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН 1

Судалгааны анкетын 1-р хэсэг нь 56 асуулгатай бөгөөд асуулгуудыг дараах зорилтуудыг шийдвэрлэх байдлаар сонгосон. Үүнд:

1. Судалгаанд оролцогчдын интернэт орчинд идэвхтэй байх дундаж цагийг тогтоох;
2. Иргэдийн цахим оролцооны түгээмэл хэрэглэгдэж байгаа хэлбэрүүдийг тодруулах;
3. Иргэдийн мэдээлэл олж авах уламжлат болон орчин үеийн эх сурвалжуудыг тодруулах;
4. Иргэдийн цахим оролцооны үндсэн дижитал хэрэгслүүдийг тодруулах;
5. Цахим оролцоог дэмжсэн технологийн шийдлүүдийн талаарх иргэдийн хүлээлтийг тодруулах;
6. Иргэдийн дижитал хэрэглээний зардлын төлөв байдлыг шинжлэх.

Судалгааны асуулгын найдварт байдалд шинжилгээ хийж үзэхэд нийт асуулгын 52 нь үндсэн зорилтуудыг хангахад найдвартай байгаа нь харагдаж байна.


Хүснэгт 6.

Reliability Statistics		
Cronbach`s Alpha	Cronbach`s Alpha Based on Standardized items	N of items
0.897	0.915	52


Интернэт орчинд идэвхитэй байх дундаж цагийг тогтооход 1-р кластер багтаж байгаа оролцогчдын хувьд 41.7 хувь нь хоногт дунджаар 1 хүртэлх цагаар тогтмол онлайн; 2-р кластерын оролцогчид болон 5-р кластерын оролцогчдын 31.7 хувь нь 2 цаг хүртэлх хугацаагаар онлайн; 1-р кластерын оролцогчдын 21.9 хувь, 2-р кластерын оролцогчдын 39.2 хувь нь 3 хүртэлх цагаар тогтмол онлайн; 2-р кластерын оролцогчдын 31.6 хувь нь, 5-р кластерын оролцогчдын 23.8 хувь нь 3-аас дээш цагаар тогтмол онлайн байдаг гэсэн үр дүнг доорх диаграммаас харж болно. Харин хоногт 24 цагаар онлайн байдаг оролцогчдын хувь хэмжээг харахад хамгийн өндөр нь 2-р кластерын оролцогчдын 33.3 хувь, хамгийн бага нь 1-р кластер болон 3-р кластерын оролцогчдын 8.3 хувь нь байгаа нь харагдаж байна. Судалгааны нэгдсэн дүнгээс харахад 1, 2-р кластерын оролцогчдын онлайн байх хугацаа нь бусдаасаа харьцангуй урт байгаа нь харагдаж байна.

Судалгаанд оролцогчдын 1-3 хүртэлх цагаар онлайн байх хугацааг хүйсийн харьцаагаар авч үзвэл эмэгтэй оролцогчдын хувьд эрэгтэй оролцогчдынхоос өндөр байгаа нь харагдаж байна. Харин 24 цагаар тогтмол онлайн байдаг оролцогчдын 58.3 хувь эрэгтэй оролцогчид, 41.7 хувь эмэгтэй оролцогчид байгаа нь харагдаж байна. Эндээс үзэхэд эмэгтэйчүүд богино хугацаагаар буюу хоногт 1-3 хүртэлх цагаар тасралтгүй онлайн байдаг байхад эрэгтэйчүүдийн хувьд 24 цагаар тогтмол онлайн байх нь элбэг байдаг байна.

Зураг 4. Судалгаанд оролцогчдын онлайн байх хугацаа




Зураг 5. Онлайн байх хугацаа (хүйсээр)



Судалгаанд оролцогчдын онлайн байх хугацааг ажил эрхлэлтийн ялгаатай байдлаар авч үзэхэд тэтгэвэрт сууж буй оролцогчдын онлайн байх хугацаа хамгийн бага буюу тэдний 5 хувь нь 1-3 хүртэлх цагаар онлайн байдаг байхад малчдын 18.5 хувь хоногт 1-2 цагаар тогтмол онлайн байдаг. Харин төрийн албан хаагчдын 49.5 хувь нь 3-аас дээш цагаар онлайн байдаг. Хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг оролцогчдын 41.7 хувь нь, оюутан сурагчдын 25 хувь нь хоногт 24 цагаар тогтмол онлайн байдаг гэсэн үр дүнг дээрх графикаас харж болохоор байна. Өөрөөр хэлбэл онлайн байх нь хэрэглэгчийн төсөв, ажил мэргэжлийн онцлогтоос хамаарч байгаа дүр зураг эндээс харагдаж байна

Зураг 6. Онлайн байх хугацаа (ажил эрхлэлтийн байдлаар)



Иргэдийн мэдээлэл олж авах уламжлалт болон орчин үеийн эх сурвалжуудыг тодруулахад оролцогчдын 24.6 хувь нь олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан мэдээлэл олж авдаг байна. Харин оролцогчдын 34.8 хувь мэдээллийг олж авах эх сурвалжуудад хэвлэмэл сонин, радио (Фм радио багтаж байгаа)-г тооцохгүй байгаа нь харагдаж байна. Мөн нөгөө талаас мэдээлэл олж авах үйл явцад цахим сүлжээ давамгайлж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 7.

	Сонин хэвлэл	Цахим сүлжээ	Радио, Фм	Бусадтай нүүр тулж ярилцах	телевиз
Огт санал нийлэхгүй байна	32.5	12.3	34.8	22.4	18.3
Санал нийлэхгүй байна	15.9	9.3	14.9	18.8	15.4
Санал нийлж байгаа болон нийлэхгүй байгаа аль нь болохыг хэлж мэдэхгүй байна	18.2	19.7	15.6	23.7	22.5
Санал нийлж байна	8.4	26.5	5.2	8.0	16.0
Маш их санал нийлж байгаа	3.4	24.6	2.9	2.9	18.1

Судалгаанд оролцогчдын 84.4 хувь нь гар утас хэрэглэдэг, 63.8 хувь тогтмол хэрэглэдэг фэйсбүүк хаягтай, 25.3 хувь youtube хаягтай, 26.4 хувь нь өдөр тутмын харилцаандаа хувийн мэйл хаяг ашигладаг байхад оролцогчдын 3.5 хувь нь л твиттер хаягтай байна. Судалгааны энэ дүн нь оролцогчдын мэдээллийн эх сурвалжид олон нийтийн цахим сүлжээ давамгайлах шинжтэй байгаа дээрх үр дүнг давхар баталж байгаа юм.

Хүснэгт 8.

	Гар утас	Хувийн мэйл	Фэйсбүүк хаяг	Инстаграм хаяг	Твиттер хаяг	Youtube хаяг
Огт санал нийлэхгүй байна		3.8	0.4	1.3	5.5	2.5
санал нийлэхгүй байна	0.4	5.1	1.3	1.7	5.5	6.7
Сайн мэдэхгүй байна	0.4	8.8	1.7	24.4	4.3	7.2
Санал нийлж байна	10.9	34.3	24.4	63.8	12.2	29.2
Маш их санал нийлж байна	84.4	26.4	63.8		3.5	25.3

Судалгаанд оролцогчдын 45.9 хувь нь сошиал сувгуудаар зочлох, 29.1 хувь нь бичлэг, контент үзэх, 20.8 хувь цахим эрүүл мэндийн зөвлөгөө авах зорилгоор онлайн байдаг гэж хариулсан байхад нийт оролцогчдын 7.7 хувь нь л янз бүрийн цахим хэлэлцүүлэгт орох, 12.9 хувь нь хот, хөдөө орон нутгийн хөгжилд тулгамдаж буй асуудлын талаар санал бодлоо илэрхийлэх зорилгоор онлайн байдаг гэсэн хариултыг өгсөн байгаагаас харахад олон нийтийн сошиал мэдээллийн хэрэгсэлд суурилсан цахим үйлдлүүд давамгайлдаг ба харин цахимаар өргөдөл гомдол гаргах, цахим хэлэлцүүлэг, хот төлөвлөлт орон нутгийн хөгжлийн талаар шийдвэр гаргалтад цахимаар оролцох гэх мэт хэлбэрүүд маш бага хувийг эзэлж байна. Эндээс үзэхэд судалгаанд оролцогчдын цахим оролцооны хэлбэр дижитал хэрэглүүрийн хувьд зөвхөн сошиал медиагаар хязгаарлагдсан, бодлого төлөвлөлт, шийдвэр гаргах үйл явцад оролцох цахим оролцооны хэлбэр харьцангуй хязгаарлагдмал шинжтэй байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 9.

	Сошиал сувгуудаар зочлох	Цахимаар сайн дурын үйл ажиллагаанд нэгдэх	Цахимаар өргөдөл гомдол гаргах	Хүмүүстэй харилцах	Цахим шуудан илгээх	Цахим худалдан авалт	Цахим хэлэлцүүлэгт оролцох
Огт хэрэглэдэггүй	3.8	19.4	18.5	3.8	8.0	15.6	18.1
Хэрэглэдэггүй	2.1	14.4	15.7	8.0	9.7	11.4	13.1
Сайн мэдэхгүй байна	9.3	23.4	22.4	17.8	17.1	21.3	19.2
Хэрэглэдэг	29.2	9.4	10.2	28.6	24.1	18.2	15.3
Байнга хэрэглэдэг	45.9	8.1	4.3	23.5	18.6	10.3	7.7
Total	90.2	74.6	71.2	81.7	77.5	76.7	73.3
System	9.8	25.4	28.8	18.3	22.5	23.3	26.7
Total		100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Хүснэгт 10.

	Веб сайтуудаар зочлох	Бичлэг контент үзэх	Сонин содон зүйл үзэж сонсох	Сенсацн бүхий мэдээллийн үйл явцтай танилцах	Цахим эрүүл мэндийн зөвлөгөө	Хот, хөдөө, Орон нутгийн хөгжилд тулгамдаад байгаа асуудлын талаар санал бодлоо илэрхийлэх
Огт хэрэглэдэггүй	9.7	3.8	8.4	6.7	6.3	9.3
Хэрэглэдэггүй	10.6	4.6	6.7	9.3	10.5	14.8
Сайн мэдэхгүй байна	22.7	14.8	21.2	23.8	20.8	24.8
Хэрэглэдэг	17.1	27.8	20.7	18.1	22.5	16.4
Байнга хэрэглэдэг	15.4	29.1	18.8	18.3	20.8	12.9
Total	75.5	80.1	75.9	76.2	81.1	78.3
System	24.5	19.9	24.1	23.8	18.9	21.7
Total	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа цахим технологийн шийдлүүдийн талаарх иргэдийн хүлээлтийг тодруулахад оролцогчдын 52.9 хувь нь хэрэглэхэд хялбар байх, 43.6-44.5 хувь нь төрийн байгууллагуудын веб хуудас, цахим үйлчилгээний платформууд нь бүртгүүлэхэд хялбар байх мэдээлэл нь шинэчлэгдэг байх, тухайн сайтад хандсан иргэдийн хүсэлтэд богино хугацаанд хариулт өгдөг байх, мэдээлэл нь үнэн зөв байх талаар саналаа өгсөн байхад оролцогчдын 43.3 хувь нь эрх зүйн зохицуулалт чухал байгаа талаар саналаа өгсөн байна.

Хүснэгт 11.

	Хэрэглэхэд хялбар байх	Богино хугацаанд хариу өгдөг	Мэдээлэл нь шинэчлэгддэг байх	Мэдээллийн үнэн байдал	Хэрэглэгчдийн эрх ашиг хангагддаг байх	Эрх зүйн зохицуулалтыг сайжруулах	Сайтуудын хувьд бүртгүүлэх хялбар байх
Огт санал нийлэхгүй байна	0.4	0.8	2.1	1.7	1.3	1.3	2.5
Санал нийлэхгүй байна	0.8	2.9	1.3	0.8	3.1	2.5	2.9
Санал нийлж байгаа болон нийлэхгүй байгаа аль нь болохыг хэлж мэдэхгүй байна	8.0	8.4	9.3	15.4	10.9	11.1	17.4
Санал нийлж байна	31.1	32.3	27.1	25.9	29.4	25.9	26.4
Маш их санал нийлж байгаа	52.9	44.5	43.4	43.6	38.5	43.3	31.4
Total	93.3	89.1	83.1	87.4	83.2	84.0	80.6
System	6.7	10.9	16.9	12.6	16.8	16.0	19.4
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Судалгаанд оролцогчдын цахим хэрэглэгдэхүүний зардлыг авч үзэхэд оролцогчдын 27.5 хувь нь 10 000-40 000 төгрөгийг зарцуулдаг бол түүнтэй ойролцоо хувийн хэрэглэгчид буюу оролцогчдын 22.1 хувь нь 120 000- 150 000, харин өндөр хэрэглээтэй буюу 160 000 төгрөгнөөс дээш зардалтай оролцогчдын тоо 0.4 хувийг эзэлж байна.

Хүснэгт 12.

Цахим хэрэглэгдэхүүний зардал					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	10 000-40 000 төгрөг	261	27.5	27.6	27.6
	45 000 -80 000 төгрөг	130	13.7	13.7	41.3
	90 000- 110 000 төгрөг	181	19.1	19.1	60.5
	120 000 -150 000 төгрөг	210	22.1	22.2	82.7
	160 000 төгрөгнөөс дээш	4	0.4	0.4	100.0
	Total	946	99.6	100.0	
Missing	System	4	0.4		
Total		950	100.0		

СУДАЛГААНЫ ҮР ДҮН 2

Судалгааны анкетын 2-р хэсэг нь нийт 64 асуулгаас бүрдэж байгаа бөгөөд энэхүү асуулгуудыг дараах зорилтуудыг шийдвэрлэх зорилгоор асуусан.

1. Төрийн цахим үйлчилгээний чанарт нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох
2. Иргэдийн цахим оролцоонд нөлөөлж байгаа хүчин зүйлүүд хоорондын хамаарлыг шинжлэх

Судалгааны асуулгын найдвартай байдалд шинжилгээ хийж үзэхэд 2-р бүлгийн 64 асуулгын Cronbach's Alpha нь 0,974 байгаа нь найдвартай байгааг илтгэж байна.

Хүснэгт 13.

Reliability Statistics		
Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized items	N of items
0.974	0.975	64

Хүснэгт 14.

КОРРЕЛЯЦИ ШИНЖИЛГЭЭ			
Descriptive Statistics			
	Mean	Std. Deviation	N
Дижитал хэрэглүүрийн чанар хүчин зүйл	3.3796	1.09962	896
Улс төрийн хүчин зүйл	3.4240	1.12362	892
Технологийн шийдлийн хүчин зүйл	3.7107	0.99520	888
Нийгэмд үзүүлэх нөлөөллийн хүчин зүйл	3.4487	1.05177	884
Төрийн цахим үйлчилгээнээс хүлээгдэж буй ашигийн хүчин зүйл	3.3931	1.10018	864
Төрийн цахим үйлчилгээнд итгэх иргэдийн итгэлийн хүчин зүйл	3.4720	1.00601	864
Цахим үйлчилгээг дэмжлэгийн төрийн тогтолцооны хүчин зүйл	3.8048	0.90490	860

Судалгааны асуулгын 2-р бүлгийн 64 асуулгын эхний 31 асуулга нь төрийн цахим үйлчилгээний чанарт нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодруулах зорилгын хүрээнд тавигдсан асуултууд юм. Эдгээр 31 хүчин зүйлийг 7 бүлэг болгон авч үзэж корреляци шинжилгээг хийсэн. Дараах хүснэгтээс харвал улаанаар тодруулсан төрийн цахим үйлчилгээнд итгэх иргэдийн итгэл нь бусад 6 хүчин зүйлээс ихээр хамаарч байна. Хамгийн бага хамаарч байгаа нь дижитал хэрэглүүрийн чанар ба цахим үйлчилгээг дэмжсэн төрийн бодлого, дэмжлэг гэсэн хүчин зүйлүүдийн хооронд 0.429 хүчтэй хамаарч, хамгийн их хамаарал нь цахим үйлчилгээнээс хүлээгдэж буй ашиг ба цахим үйлчилгээнд итгэх иргэдийн итгэл гэсэн хүчин зүйлүүдийн хооронд 0.788 хүчтэй хамаарч байна. Эндээс цахим оролцоонд иргэдийн цахим оролцоонд итгэх итгэл болон бусад 6 хүчин зүйлээс хамааруулан регрессийн шинжилгээ хийх боломжтой байна.

Хүснэгт 15.

Correlations									
	Дижитал хэрэглүүрийн чанар хүчин зүйл	Улс төрийн хүчин зүйл	Технологийн шийдлийн хүчин зүйл	Нийгэмд үзүүлэх нөлөөлөл	Цахим үйлчилгээнээс хүлээгдэж буй ашиг	Цахим үйлчилгээнд итгэх иргэдийн итгэл	Цахим үйлчилгээг дэмжсэн төрийн бодлого		
Дижитал хэрэглүүрийн чанар хүчин зүйл	Pearson Cor-relation	1	.480**	.446**	.506**	.583**	.429**		
	Sig. (2-tailed)		0.000	0.000	0.000	0.000	0.000		
	N	896	892	888	884	864	856		
Улс төрийн хүчин зүйл	Pearson Cor-relation	.480**	1	.526**	.576**	.601**	.500**		
	Sig. (2-tailed)	0.000		0.000	0.000	0.000	0.000		
	N	892	892	888	884	864	856		
Технологийн шийдлийн хүчин зүйл	Pearson Cor-relation	.446**	.526**	1	.690**	.671**	.625**		
	Sig. (2-tailed)	0.000	0.000		0.000	0.000	0.000		
	N	888	888	888	884	864	856		
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл	Pearson Cor-relation	.506**	.576**	.690**	1	.663**	.549**		
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000		0.000	0.000		
	N	884	884	884	884	864	856		
Цахим үйлчилгээнээс хүлээгдэж буй ашиг	Pearson Cor-relation	.522**	.601**	.671**	.681**	1	.588**		
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000		0.000		
	N	864	864	864	864	864	852		
Цахим үйлчилгээнд итгэх иргэдийн итгэл	Pearson Cor-relation	.583**	.570**	.712**	.663**	1	.661**		
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000		
	N	864	864	864	864	864	852		
Цахим үйлчилгээг дэмжсэн төрийн бодлого	Pearson Cor-relation	.429**	.500**	.625**	.549**	.588**	1		
	Sig. (2-tailed)	0.000	0.000	0.000	0.000	0.000			
	N	856	856	856	856	852	860		

Регрессийн шинжилгээ

Регрессийн тэгшитгэлийн корреляцийн коэффициент нь 0.861 байгаа нь хүчин зүйлүүдийн хооронд хүчтэй хамааралтай ба детерминацын коэффициент нь 0.724 нь Цахим үйлчилгээнд итгэх иргэдийн итгэл хүчин зүйлд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг 100% гэж үзвэл 6 хүчин зүйлээс 72.4% хамаарч , авч үзээгүй хүчин зүйлээс 27.6% хамаарч байгаа болохыг харуулж байна.

Хүснэгт 16.

b. All requested variables entered.

Model Summary									
Model	R	R Square	Adjusted R Square	Std. Error of the Estimate	Change Statistics				
					R Square Change	F Change	df1	df2	Sig. F Change
1	.851^a	0.724	0.722	0.52558	0.724	368.277	6	841	0.000

a. Predictors: (Constant), Цахим үйлчилгээг дэмжсэн төрийн бодлого, дэмжлэгийн тогтолцоо, Дижитал хэрэглүүрийн чанар , Улс төрийн хүчин зүйл, Нийгэмд үзүүлэх нөлөөлөл, Цахим үйлчилгээнээс хүлээгдэж буй ашиг, Технологийн шийдлийн хүчин зүйл

Хүснэгт 17.

ANOVA ^a						
Model		Sum of Squares	Df	Mean Square	F	Sig.
1	Regression	610.382	6	101.730	368.277	.000^b
	Residual	232.312	841	0.276		
	Total	842.694	847			

a. Dependent Variable: Цахим үйлчилгээнд итгэх иргэдийн итгэл

b. Predictors: (Constant), Цахим үйлчилгээг дэмжсэн төрийн тогтолцоо, бодлого Дижитал хэрэглүүрийн чанар хүчин зүйл, Улс төрийн хүчин зүйл, Нийгэмд үзүүлэх нөлөөлөл, Цахим үйлчилгээнээс хүлээгдэж буй ашиг, Технологийн шийдэл

Хүснэгт 18.

Coefficients ^a										
Model	Unstandardized Coefficients		Standardized Coefficients	T	Sig.	95.0% Confidence Interval for B		Collinearity Statistics		
	B	Std. Error	Beta			Lower Bound	Upper Bound	Tolerance	VIF	
1	(Constant)	-0.081	0.086		-0.946	0.344	-0.250	0.087		
	Дижитал хэрэглүүрийн чанар хүчин зүйл	0.159	0.021	0.172	7.758	0.000	0.119	0.199	0.666	1.502
	Улс төрийн хүчин зүйл	0.008	0.022	0.008	0.352	0.725	-0.035	0.050	0.570	1.754
	Технологийн шийдлийн хүчин зүйл	0.198	0.029	0.192	6.732	0.000	0.140	0.256	0.403	2.484
	Нийгэмд үзүүлэх нөлөөллийн хүчин зүйл	0.043	0.027	0.044	1.584	0.113	-0.010	0.096	0.417	2.401
	Цахим үйлчилгээнээс хүлээгдэж буй ашиг	0.382	0.026	0.418	14.697	0.000	0.331	0.433	0.406	2.464
	Цахим үйлчилгээг дэмжсэн төрийн бодлого, зохицуулалт	0.217	0.027	0.196	7.951	0.000	0.163	0.270	0.539	1.854


a. Dependent Variable: Цахим үйлчилгээнд итгэх иргэдийн итгэл

Цахим үйлчилгээнд итгэх иргэдийн итгэл нь 0.172-аар *дижитал хэрэглүүрийн чанараас, 0.008*-аар улс төрийн хүчин зүйлээс, 0.192*-аар технологийн шийдэлээс 0.044*-аар нийгэмд үзүүлэх нөлөөнөөс, 0.418*-аар төрийн цахим үйлчилгээнээс хүлээгдэж буй ашигаас, 0.196 *-аар цахим үйлчилгээг дэмжсэн төрийн бодлого, тогтолцооноос тус тус хамаарч байна. Эндээс авч үзвэл төрийн цахим үйлчилгээнээс хүлээгдэж буй ашигаас хамгийн ихээр, хамгийн багаар улс төрийн хүчин зүйлээс эерэгээр хамаарч байгаа нь харагдаж байна.

Судалгааны асуулгын 2-р бүлгийн асуулгын 33 нь иргэдийн цахим оролцоонд нөлөөлөх хүчин зүйл хоорондын хамааралд замын шинжилгээ хийх зорилтын хүрээнд томъёологдсон асуулгууд юм. Иргэдийн оролцоонд нөлөөлөх эдийн засгийн хөгжил, харилцаа холбооны дэд бүтэц, боловсрол, ардчиллын бэхжилт гэсэн 4 хүчин зүйлийг сонгон авч хүчин зүйл хоорондын хамаарлын шинжилгээг хийсэн. Иргэдийн цахим оролцоонд хамгийн их нөлөөтэй нь эдийн засаг болон дэд бүтцийн хөгжил байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа юм.

Иргэдийн оролцоонд нөлөөлөх хүчин зүйл хоорондын хамаарлыг дүрслэн харуулбал ийм байна.

Зураг 7.



СУДАЛГААНЫ ҮР ДҮН 3

Судалгааны асуулгын 16 асуулга нь төрийн цахим үйлчилгээний хэрэглээнд дижитал хуваагдалд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодруулах зорилготой байсан. Судалгааны асуулгын найдварт байдалд шинжилгээ хийж үзэхэд 2-р бүлгийн 16 асуулгын Cronbach’s Alpha нь 0,867 байгаа нь найдвартай байгааг илтгэж байна.

Хүснэгт 19.

Reliability Statistics		
Cronbach’s Alpha	Cronbach’s Alpha Based on Standardized items	N of items
0.866	0.867	16

Дижитал хуваагдлын түвшинг тодорхойлох үндсэн 4 хүчин зүйлийг энэ судалгааны хүрээнд авч үзсэн. Үүнд:

1. Төрийн цахим үйлчилгээг хүлээж авах боломж
2. Хэрэглэгчийн технологийн мэдлэг, ур чадвар
3. Технологийн дэвшил инновац
4. Хэрэглэгчийн эдийн засгийн байдал

Дээрх 4 хүчин зүйлийн хүрээнд корреляци шинжилгээг хийсэн. Хүснэгтээс харвал улаанаар тодруулсан дижитал хуваагдал нь дээрх 4 хүчин зүйлээс хамаарч байгаа нь харагдаж байна. Хамгийн бага хамаарч байгаа нь технологийн дэвшил, инноваци ба хэрэглэгчийн эдийн засгийн байдал хүчин зүйлүүдын хооронд 0.228 хүчтэй хамаарч, хамгийн их хамаарал нь хэрэглэгчийн технологийн мэдлэг, ур чадвар ба төрийн цахим үйлчилгээг хүлээж авах боломж хүчин зүйлүүдийн хооронд 0.788 хүчтэй хамаарч байна.

Хүснэгт 20.

Correlations						
		Дижитал хуваагдлын түвшин	Төрийн цахим үйлчилгээг хүлээж авах боломж	Хэрэглэгчийн технологийн мэдлэг ур чадвар	Технологийн дэвшил инноваци	Хэрэглэгчийн эдийн засгийн байдал
Pearson Correlation	Дижитал хуваагдлын түвшин	1.000	0.312	0.410	0.371	0.257
	Төрийн цахим үйлчилгээг хүлээж авах боломж	0.312	1.000	0.708	0.484	0.401
	Хэрэглэгчийн технологийн мэдлэг ур чадвар	0.410	0.708	1.000	0.424	0.482
	Технологийн дэвшил инноваци	0.371	0.484	0.424	1.000	0.228
	Хэрэглэгчийн эдийн засгийн байдал	0.257	0.401	0.482	0.228	1.000

ДҮГНЭЛТ

“Иргэдийн цахим оролцооны өнөөгийн төлөв байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ” сэдэвт бодлогын судалгааны хүрээнд дэвшүүлсэн зорилтоо шийдвэрлэхээр 950 түүвэртэй асуулгын судалгааг цахим, цаасан хэлбэрээр зохион байгуулсаны үр дүнд дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

- Дунджаар судалгаанд оролцогчдын 40 орчим хувь нь интернэт орчинд хоногт 3 хүртэл цагаар тогтмол онлайн байдаг. Ажил мэргэжлийн онцлог, нас хүйсийн ялгаатай байдлаас шалтгаалж интернэт орчинд байх хугацаа харилцан адилгүй байна. Эмэгтэй оролцогчдын хувьд хоногт 3 хүртэлх цагаар интернэт орчинд байх нь давамгайл байгаа бол харин эрэгтэй оролцогчдын хувьд хоногт 24 цагаар онлайн байх хугацаа нь эмэгтэй оролцогчдынхоос хавьгүй илүү байна;
- Судалгаанд оролцогчдын цахим орчинд идэвхитэй хийдэг үйлдлүүдийн тоонд олон нийтийн мэдээллийн сүлжээгээр зочлох, нийгэм улс төрд өрнөж байгаа үйл явцын талаар мэдээлэл авах, эрүүл мэндийн зөвлөгөө авах, цахим худалдан авалт хийх гэж нэрлэсэн байна. Харин судалгаанд оролцогчдын маш цөөхөн хувь нь буюу 7.7 хувь нь цахим хэлэлцүүлэгт оролцож өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, аймаг, нийслэл, сум орон нутгийн хөгжилтэй холбоотой асуудлаар шийдвэр гаргах үйл явцад цахимаар оролцох гэж нэрлэсэн байна. Эндээс харахад иргэдийн цахим оролцооны боломжийн талаарх ойлголт бага, төрийн цахим үйлчилгээний хэрэглээ хязгаарлагдмал байгаа нь харагдаж байна;
- Төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээг цахимаар авах боломж харьцангуй ихэсч байгаа хэдий ч бодлого боловсруулах, шийдвэр гаргах шатанд

- иргэдийн цахим оролцооны идэвхи хязгаарлагдмал хэвээр байна;
- Судалгаанд оролцсон иргэд төрийн байгууллагуудын вебсайт дээрх мэдээлэл шинэчлэгддэггүй, бүртгүүлэхэд бэрхшээлтэй, төрийн байгууллага хоорондын цахим мэдээллийн нэгдмэл байдал алдагдсан, цахим орчин дахь хувь хүний мэдээллийн аюулгүй байдал бүрэн хангагдаагүй байна гэж үзэж байна;
 - Төрийн цахим үйлчилгээний платформуос үйлчилгээ авахад иргэдийн ялгаатай байдлыг харгалзан үзсэн технологийн шийдэл байдаггүй гэж үзсэн байна;
 - Судалгааны үр дүнгээс харахад иргэдийн цахим оролцоонд хамгийн ихээр нөлөөлж байгаа хүчин зүйл нь тухайн цахим платформын хэрэглэгчийн ямар нэгэн эрх ашигийг хангасан байхаас гадна түүнд итгэх иргэдийн итгэл байна;
 - Төрийн цахим үйлчилгээний хэрэглээнд одоогоор дижитал хуваагдал төдийлөн гүн гүнзгий үүсээгүй байгаа хэдий ч хэрэглэгчийн технологи ашиглах чадвар, тухайн цахим үйлчилгээг хүлээж авах боломжаас шалтгаалан дижитал хуваагдал цаашид гүнзгийрэх магадлал байгааг судалгааны үр дүн харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

- Цахимаар өргөдөл гомдол гаргах, цахим хэлэлцүүлэг, хот төлөвлөлт орон нутгийн хөгжлийн талаар шийдвэр гаргалтад цахимаар оролцох гэх мэт иргэдийн цахим оролцооны үр ашигтай хэлбэрүүдийг идэвхжүүлэх;
- Иргэд цахим хэрэглэгдэхүүний зардалд 10 000-120 000 хүртэлх төгрөгийг тогтмол зарцуулж байгаа боловч энэхүү зардлаараа зөвхөн социал медиагаар хязгаарлагдсан цахим үйлдлийг хийж байна. Иймд дээрх байдлыг өөрчлөн зардлыг үр ашигтай цахим оролцооны хэлбэрт хувиргах идэвхитэй цахим оролцооны соёлыг иргэдэд төлөвшүүлэх;
- Төрөөс иргэдэд чиглэсэн цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд үйлчилгээний платформын найдварт байдлыг хангах, иргэдийн хүлээлтэд нийцсэн цахим бүтээгдэхүүнийг санал болгох;
- Төрийн байгууллагуудын веб хуудасны мэдээллийн нэгдмэл байдал, албан ёсны мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох;
- Хэрэглэгчийн ялгаатай байдалд нийцсэн цахим үйлчилгээний стандарт загварыг бий болгох
- Эдийн засгийн нөөцийг иргэдийн цахим оролцоог дэмжсэн дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглүүлэх;

- Иргэдийн цахим технологи хэрэглэх ур чадварыг хөгжүүлэх, бүх шатны боловсролын байгууллагат компьютер, мэдээлэл зүйн чиглэлийн хичээлийн хөтөлбөрт инновац хийх, нийгмийн бүхий л салбарт ардчиллыг бэхжүүлэх, цахим ардчиллыг хөгжүүлэх;
- Цахим үйлчилгээг хүлээж авах боломж, хэрэглэгчийн технологийн мэдлэг, ур чадвар, хэрэглэгчийн эдийн засгийн байдлаас шалтгаалан төрийн цахим үйлчилгээний хүртээмжид дижитал хуваагдал үүсэх эрсдэл байгааг анхаарч дижиталчлалын сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлэх, шаардлагатай тохиолдолд цахим засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн дэмжлэгийг үзүүлэх хэрэгтэй байна.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээр

- Батсүх Ш., Ганцоож Б. & Долгоржав Я. (2014). Шууд ардчилал-Иргэдийн оролцоо. УБ.,
- Ганболд Ц. (2020). Монголын улс төр уламжлал, шинэчлэл, тэмдэглэл. УБ., II боть. “МУИС-Монгол судлалын хүрээлэн”
- Ганбаатар Х., Тамир Э. & Биндэръяа Д. (2004). Өрнөдийн улс төрийн сэтгэлгээний түүх. УБ., хоёрдугаар дэвтэр. “ЭРДЭНЭЗУЛ” ХХК.
- Мягмарцоож Н.(2012). Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо. УБ
- МУИС хамтын бүтээл. (2018). Бурмаа Н. Иргэдийн оролцоо-Иргэний нийгэм. //Төрийн албан хаагчийн ширээний ном III. “Мөнхийн Үсэг” ХХК. УБ
- КАС, МУИС (2019) Батсүх Ш. & Дэлгэржаргал Ц. Орон нутаг дахь иргэдийн оролцоо. //Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь: Судалгааны үр дүн, бодлогын зөвлөмж/ "МӨНХИЙН ҮСЭГ" ХХК. УБ

Гадаад хэл дээр

- Aikens, G. S. (1998). A personal history of Minnesota Electronic Democracy, 1994. Journal of Government Information,
- Ainsworth, S., Hardy, C., & Harley, B. (2005). Online Consultation: E-Democracy and E-Resistance in the Case of the Development Gateway. Management Communication Quarterly, 19(1)
- Berelson, B. (1952). Content Analysis In Communicative Research. New York: Free Press.
- Berman, J., & Witzner, D. J. (1997). Technology and Democracy. Social Research, 64(3)
- Best, S. J., & Krueger, B. S. (2005). Analyzing the representativeness of Internet political participation. Political Behavior, 27(2), 183-216. Beynon-Davies, P., Williams, M. D., Owens, I., & Hill, R. (2004). The electronic procurement of ideas. International Journal of Electronic Business, 2(1), 3-19.
- Clift, S. (2000). An Internet of Democracy. Communications of the ACM, 43(11)
- Coleman, S. (2007). Personal communication, Demo-net web-site (www.demo-net.org).
- Conhaim, W. W. (2000). The Internet. Link-Up, 17

- Gimmler, A. (2001). Deliberative democracy, the public sphere and the internet. *Philosophy & Social Criticism*, 27(4)
- Gross, T. (2000). Technological support for e-democracy: history and perspectives, *Proceedings 11th International Workshop on Database and Expert Systems Applications*. Greenwich, UK.
- Grönlund, Ä. (2002). Introduction to the Special Issue on E-democracy in Practice. *e-Service Journal*, 2(1)
- Grönlund, Ä. (2003). Emerging electronic infrastructures - Exploring democratic components. *Social Science Computer Review*, 21(1)
- Macintosh, A. (2004). Characterizing e-participation in policy-making. *Proceedings of the 37th Annual Hawaii International Conference on System Sciences*, Computer Society Press.
- Macintosh, A., Robson, E., Smith, E., & Whyte, A. (2003). Electronic Democracy and Young People. *Social Science Computer Review*, 21(1)



Л.Бямбаханд
ШУА-ийн ОУСХ-ийн ЭША

УЛС ТӨРИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХЭД НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ СУВГУУДЫН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

ОРШИЛ

Эмэгтэйчүүдийн бүрэн дүүрэн, эрх тэгш оролцоо хангах нь ардчилсан нийгмийн үндэс билээ. Хэдийгээр эмэгтэйчүүд боловсрол эзэмших хувь хэмжээ өндөр байгаа боловч энэ нь хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсний тэгш бус байдлыг арилгахад төдийлөн нөлөө үзүүлэхгүй байгаа нь Монгол Улсын жишээнээс харагддаг.

Нийгмийн амьдралын бүхий л хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн оролцоо, манлайллын эрх тэгш байдлыг хангах нь дэлхий нийтийн өмнө тулгамдсан асуудлуудын нэг болж байна. Энэ асуудлыг шийдвэрлэх явдал НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар тодорхойлсон “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-д чухал байр суурь эзэлдэг. “Тогтвортой хөгжлийн зорилт-2030”-ийн хүрээнд улс орнууд үндэсний хэмжээнд эрх тэгш байдлыг хангахад ихээхэн анхаарал хандуулж байгаа юм.

Дэлхийн улс орнууд жендэрийн эрх тэгш байдлыг хангахыг зорьж тодорхой хүчин чармайлт гаргаж байгаа боловч нийгмийн амьдралын хүрээнд жендэрийн тэгш бус байдал арилахгүй хэвээр байна. Монгол Улсын тухайд, Үндэсний статистикийн хорооны мэдээллээр манай улсын нийт хүн амын 50.85 хувь нь эмэгтэй байна.¹ Манай эмэгтэйчүүдийн боловсролын түвшин харьцангуй өндөрболовч эзэмшсэн мэргэжил, боловсролоо ашиглан хөдөлмөрийн зах зээлд оролцох, улс төрийн шийдвэр гаргах түвшинд идэвхтэй, эрх тэгш оролцох боломж хязгаарлагдмал байна. Үүний зэрэгцээ дэлхий дахинд дэгдсэн цар тахлын улмаас энэ чиглэлд олсон ололт амжилт алдагдан, ухралтанд орж байгааг статистик, тоо баримт илтгэж байгаа юм. Ялангуяа, улс төрд жендэрийн тэгш байдал хангагдахад дахиад 100 гаруй жил шаардлагатай болоод байна.

Цар тахал нь дэлхийн улс орнуудад олон төрлийн сорилт бэрхшээлийг авчирч, эдийн засгийн болон бусад хохирлыг учруулж байгаа боловч энэхүү эрүүл мэндийн хямрал нь дэлхий нийтээрээ цахим шилжилт хийх явцыг түргэссэн билээ. Цахим шилжилтийн ачаар уламжлалт мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан дуу хоолойгоо хүргэхэд бэрхшээлтэй тулгардаг байсан бүлгүүдийн нэг болох эмэгтэйчүүд үзэл бодлоо илэрхийлэх, улс төрд оролцох оролцоо, манлайллаа бэхжүүлэх боломжоор хангагдаж эхэлсэн. Ялангуяа, үүнд нийгмийн сүлжээний сувгууд чухал үүрэг гүйцэтгэх боллоо. Иймээс энэ байдалд дүн шинжилгээ хийх, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, манлайллыг дэмжихэд нийгмийн сүлжээний сувгуудыг үзүүлэх нөлөөллийг судлах шаардлагатай юм.

¹ Жендэрийн Үндэсний хороо “Суурь судалгааны тайлан” (2020 он)

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар 2015 онд батласан “Тогтвортой хөгжлийн зорилго-2030”-д заасан 17 зорилтын 5 дугаар зорилт нь “жендэрийн эрх тэгш байдлыг хангах”-д чиглэсэн билээ. Энэхүү зорилтын хүрээнд нийт 9 дэд зорилт, хэрэгжилтийг үнэлэх 14 шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон.

Тус зорилгын 5 дугаар зорилт нь “улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хүрээнд шийдвэр гаргах бүх шатанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор эмэгтэйчүүдийг хангах”-д чиглэсэн.

Хэдийгээр эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд зарим нэг ахиц дэвшил гарч байгаа боловч дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр ТХЗ-д заасан “жендэрийн эрх тэгш байдлыг хангах” зорилтыг хэрэгжүүлэхэд ихээхэн саад бэрхшээл тулгарч болзошгүй байна.

Дэлхийн эдийн засгийн форумас цар тахал дэгдэхээс өмнө дэлхийн хэмжээнд жендэрийн ялгаатай байдлыг арилгахад 99.6 жил шаардлагатай хэмээн тооцож байсан бол тус байгууллагын 2021 оны 3 дугаар сарын тайланд дурдснаар цар тахлын улмаас энэ хугацаа 36 жилээр хойшилж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн хоорондох эдийн засаг, улс төрийн эрх мэдэл, боловсрол, эрүүл мэндийн тэгш байдлыг хангахад дунджаар **135.6 жил** шаардлагатай болоод байна.

2021 он хүртэл хугацаанд “улс төрийн эрх мэдэл”-ийн хүрээнд жендэрийн зөрүүтэй байдлыг арилгахад 22 хувийн ахиц дэвшил гарсан боловч цар тахалтай холбоотой энэ чиглэлд олсон ахиц дэвшил алдагдах, улмаар ухралтанд орох нөхцөл үүсээд байна. Тухайлбал, тус индекст хамрагдсан 156 улсын парламентын 35,500 суудлын 26.1 хувийг, засгийн газруудын 3,400 гаруй сайдын ердөө 22.6 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. 2021 оны 1 дүгээр сарын 15-ны байдлаар дэлхийн 81 улсад эмэгтэй төрийн тэргүүн огт ажиллаж байгаагүй байна. Өнөөгийн хурдаар явах юм бол улс төрд жендэрийн тэгш байдлыг бий болгоход **145.5 жил** шаардлагатай.

Цар тахал улс төрд жендэрийн тэгш бус байдлыг бууруулахад гарсан ахиц дэвшлийг хойш чангааж, ухралт авчирсан боловч нөгөө талаар дэлхий нийтийг хамарсан энэхүү үзэгдэл нь цахим шилжилтийг түргэсгэж өгсөн. Цахим шилжилт урьд өмнөхөөс илүү хурдтай явагдаж байгаа нь улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг халахад эерэг нөлөөлж болох юм. Иймд энэхүү судалгаа нь цар тахлын нөлөөгөөр эрчимжсэн цахим шилжилт, ялангуяа нийгмийн сүлжээний сувгуудын хэрэглээ нэмэгдсэн явдал улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг халахад хэрхэн нөлөөлж болохыг судлахад чиглэх юм.

Энэхүү судалгааны ажил нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглах нөлөөллийг судлах юм.

Судалгааны зорилго, зорилтууд

Судалгааны хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны өнөөгийн нөхцөлд дүн шинжилгээ хийх;
- Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш бус байдал үүсэх болсон шалтгааныг тодруулах;
- Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний үзүүлэх нөлөөлөлд дүн шинжилгээ хийх.

БҮЛЭГ 1. ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дэлхийд болон Монгол Улсад эмэгтэйчүүдийн оролцоо ямар байдалтай байгааг судалгааны энэ бүлэгт авч үзлээ. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны өнөөгийн байдлыг авч үзэхийн өмнө улс төрийн оролцооны тодорхойлолтыг авч үзнэ. Мөн судалгааны гол зорилго нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудын үзүүлэх нөлөөллийг судлах зорилготой учраас шийдвэр гаргах түвшинг тодорхойлсон онолын тодорхойлолтыг товч дурдах юм.

1.1 ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Улс төрийн оролцоо нь сонгуулийн оролцоогоор хязгаарлагддаггүй оролцооны олон хэлбэр, оролцох түвшин, оролцоонд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарлаар илэрхийлэгддэг улс төрийн ойлголт юм.² Роберт Далийн тодорхойлсноор “энгийн иргэдэд төр засагтайгаа хариулцлага тооцох боломж олгодог ардчиллын амин чухал, салшгүй нэг хэсэг нь иргэдийн улс төрийн оролцоо юм”.³ Өмнө нь судлаачид төртэй хариуцлага тооцох гэдгийг гол төлөв сонгуулиар төсөөлдөг байсан учраас сонгуульд санал өгөх, өөрөө нэр дэвших эсвэл сонгуулийн кампанит ажилд сайн дураар ажиллах, намд гишүүнээр элсэх гэх мэт цөөн тооны нийгмийн хэв хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг иргэдийн улс төрийн хэмээн тодорхойлдог байв.

Улс төрийн оролцоонд голчлон улс төрд нөлөөлөх үйл ажиллагаануудыг хамруулан авч үздэг. Улс төрийн оролцоо нь 4 тодорхой, нийтлэг хэв шинжтэй.⁴ Үүнд:

1. Улс төрийн оролцоо гэдэг нь телевизээр улс төрийн мэтгэлцээн үзэх зэрэг идэвхгүй бус үйл ажиллагаа биш харин санал өгөх, сонгосон улс төрийн төлөөлөлдөө хандах зэрэг идэвхтэй үйл ажиллагааг хэлнэ.

2 Я.Төгөлдөр “Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хөгжил, чиг хандлага”, 2013 он, Докторын зэрэг горилсон диссертацийн ажил, 63 х

3 Robert Dahl “Polyarchy: Participation and Opposition” (Yale University Press, 1971)

4 Verba S, Nie NH (1972) Political participation in America: political democracy and social equality. The University of Chicago Press, Chicago/London

2. Улс төрийн оролцоо нь улс төрчид, лобби бүлгүүд бус буюу хувь иргэдийн зохион байгуулж буй үйл ажиллагаанаас бүрдэнэ.
3. Улс төрийн оролцоо нь хуулиар албадан хэрэгжүүлдэг биш бөгөөд харин сайн дурын үйл ажиллагаа юм.
4. (Төрийн) албан тушаалтнуудыг сонгох буюу тэдний үйл ажиллагаа, шийдвэрт нөлөөлөх замаар улс төрийн тогтолцоонд чиглэсэн байдаг.

Ерөнхийд нь авч үзвэл, улс төрийн оролцоо гэдэг нь төрийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх юмуу эсвэл төрийн бодлогыг боловсруулах хүмүүсийг сонгоход шууд болон шууд бус байдлаар нөлөөлөх замаар төрийн шийдвэрт нөлөөлөх зорилгоор тодорхойлогдоно.⁵

Иргэдийн улс төрийн оролцоо нь ардчиллын онолын хүрээнд судлагдаж, ардчиллын мөн чанар, үр дүнг хэмжих нэгэн үзүүлэлт болохын хувьд судалгааны онол, практикийн ач холбогдлыг илэрхийлдэг. Тэр дундаа нийгмийн тэн хагасын төлөөлөл болох эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог авч үзэх нь иргэдийн улс төрийн оролцоонд тулгуурласан улс төрийн шинжлэх ухааны парадигмын судлагдахуун юм.⁶

Судлаач Вики Рендал үзэхдээ “улс төрийн шинжлэх ухаанд улс төр дэх эмэгтэйчүүдийн байр суурь, оролцооны талаарх судалгааг ардчиллын онол, улс төрийн оролцооны онолын загваруудтай холбон судлах шаардлагатай юм. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжсэн бодлого, үйл ажиллагааг нийгмийн бүхий л түвшинд гүн гүнзгий ухуулан таниулах хэрэгтэй. Мөн уг асуудлыг улс төрийн парадигм доор судлан үзэхгүйгээр тэдний оролцооны хэлбэрүүдийг ярьж болохгүй юм. Иймд эмэгтэй хүн хөгжлөөс хуваалцах эрхтэй хүний хувьд улс төрийн тэгш байдал гэсэн ойлголтыг тодорхойлох нь улс төрийн оролцооны чухал эх үндэс”⁷ гэж тодорхойлжээ.⁸

Судлаач Н.Коннелийн феминизмийн онол улс төрийн шинжлэх ухаан дахь хамгийн цэгцтэй, тогтолцоотой бөгөөд өргөн хэрэглэгдэх онол юм. Н.Коннелийн дэвшүүлсэн “хүйсийн тэгш эрхийн дэглэм” гэсэн томъёоллоор төр нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн эрх мэдлийн хуваарилалтыг хэр хангаж, тэдний зохицол, нийцлийг бий болгож чадсанаар тодорхойлогддог. Хүйсийн тэгш эрхийн дэглэм нь үе залгамжлал, хөдөлмөрийн харилцаа, хуваарилалт, хүмүүсийн сэтгэл зүйн хандлагаар дамжин илэрч байдаг. Энэ бүхэнд төр оролцох, зохицуулах үүрэгтэй бөгөөд зохицуулж болох зүйлсүүд дээр шаардлагатай арга хэмжээг авч түүхэн хугацаанд бий болсон ойлголт хандлагуудад зохицуулалт хийх нь зүйтэй гэж Коннел үзсэн⁹.

5 Himelboim, I., Lariscy, R. W., Tinkham, S. F., & Sweetser, K. D. (2012). Social media and online political communication: The role of interpersonal informational trust and openness. *Journal of Broadcasting & Electronic Media*, 56(1), 92-115

6 Я.Төгөлдөр “Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хөгжил, чиг хандлага”, 2013 он, Докторын зэрэг горилсон диссертацийн ажил, 63 х

7 Frazana Bari. 2005. *Women's Political Participation: Issues and Challenges*. Report. New York. page 38

8 Я.Төгөлдөр “Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хөгжил, чиг хандлага”, 2013 он, Докторын зэрэг горилсон диссертацийн ажил, 58 х

9 Мөн тэнд

Улс төрийн шинжлэх ухаанд улс төрийн сонгох эрхээс, улс төрийн эрх мэдлийг хуваалцах сонгогдох эрхээ эдлэх хөгжлийн шинэ давалгааг дэлхийн бүхий л орны эмэгтэйчүүдийн дунд түгээх нь улс төрийн оролцооны феминист үзэл баримтлалын гол зарчим болжээ. Тодруулбал, улс төрд эмэгтэйчүүдийн манлайлал, улс төрийн элитийн түвшний оролцоог илүү чухалчилж байна. Иймд феминизмийн онолчид сонгодог реалист онолоос татгалзаж уламжлалт арга замыг засаж өөрчлөхийн тулд дэлхийн улс төрд байгаа хэт хэлбийсэн имижийг неофеминизмийн шинэ урсгал болох конструктивизмийн онол үзэл баримтлалд чиглүүлэн улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоог бүх талаас нь хөгжүүлэх хэрэгтэй гэж үзэж байна¹⁰

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны нэг бүрэлдэхүүн хэсэг гэдгийг Комиссоос гаргасан “Европын улс төрд эмэгтэйчүүд: Арга хэмжээ авах цаг нь боллоо” тайланд тодорхойлсон бөгөөд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог авч үзэхдээ Европын орнууд эмэгтэйчүүд хэзээнээс эхлэн сонгуульд оролцон, санал өгөх эрхтэй болсон тухай дурдсан байна.¹¹

Олон улсын ардчилал, сонгуулийн туслалцааны хүрээлэнгээс гаргадаг “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо-Африкийн барометр 2021” судалгаанд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хэмжихдээ дараах шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурласан байна. Үүнд:

- Парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Орон нутгийн засаг захиргаанд эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Улс төрийн намуудын удирдлагад эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Сонгуульд хяналт тавих байгууллагад эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Эмэгтэй спикерийн эзлэх хувь
- Нийслэлийн хотын захирагчдад эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Улс төрийн гүйцэтгэх албан тушаалууд (ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, ерөнхий сайд, шадар сайд)-ад эмэгтэйчүүдийн эзлэх хувь
- Засгийн газрын гишүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь¹²

Эндээс үзэхэд, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны нэг бүрэлдэхүүн хэсэг болох сонгогдох эрхийн хэрэгжилтийг дээр дурдсан шалгуур үзүүлэлтээр тодорхойлж болохоор байна.

Дээр дурдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд, эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийн хэрэгжилтийг авч үзэж болохыг бусад судалгаанууд нотолж байна. Тухайлбал, Дублины Технологийн Их сургуулийн бодлогын судалгаанд, Европын Холбоон дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог үнэлэхдээ *парламентад эмэгтэйчүүдийн*

10 Я.Төгөлдөр “Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хөгжил, чиг хандлага”, 2013 он, Докторын зэрэг горилсон диссертацийн ажил, 58 х

11 European Commission “Women in European Politics: Time for action”, January 2009 http://ibdigital.uib.es/greenstone/sites/localsite/collect/porta_social/index/assoc/coeuro00/37.dir/coeuro0037.pdf

12 IDEA “Women’s political participation: Africa Barometer 2021” <https://www.idea.int/sites/default/files/publications/womens-political-participation-africa-barometer-2021.pdf>

эзлэх хувь, засгийн газрын сайд нарын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, орон нутгийн засаг захиргаанд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, улс төрийн намын удирдлагад эмэгтэйчүүдийн эзлэх хувь, ерөнхий сайд/гүйцэтгэх засаглалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь, мужийн захирагч/орон нутгийн гүйцэтгэх засаглалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь зэрэг шалгуур үзүүлэлтийг баримталсан байна.¹³ Энэ нь өмнө дурдсан судалгааны шалгуур үзүүлэлтүүдтэй үндсэндээ дүйж байгаа юм.

Олон улсын парламентын холбооноос жил бүр гаргадаг “Парламент дахь эмэгтэйчүүд” судалгааны тайланд, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог авч үзэхдээ, парламентын гишүүдэд эзлэх эмэгтэйчүүдийн хувиар тодорхойлсон байна.¹⁴ Эндээс үзэхэд, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог тодорхойлохдоо тэдний сонгогдох эрхээ хэрхэн эдэлж байгаад анхаарал хандуулах шаардлагатай юм. Түүнчлэн, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хүрээнд парламентад ажиллаж байгаа эмэгтэй гишүүдийн тоог авч үзэхийн зэрэгцээ дэлхий даяар парламентын спикеруудын хэдэн хувь нь эмэгтэй болохыг тайланд авч үзсэн байна.

НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн зөвлөлөөс 2019 онд гаргасан “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, манлайлал” бодлогын судалгааны зөвлөмжид, 1995 онд Бээжингийн үйл ажиллагааны хөтөлбөр батлагдснаас хойш Ази, номхон далайн бүс нутагт эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо нэмэгдсэн хэмээн дүгнэсэн бөгөөд ингэхдээ парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувийг гол шалгуур үзүүлэлтээ болгожээ.¹⁵

Их Британийн Хамтын нөхөрлөлийн орнуудын байгууллагын нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан “Хамтын нөхөрлөлд харьяалагддаг Африкын орнууд дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо ба улс төрийн намууд” судалгаанд, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог улс төрийн намуудтай холбон авч үзсэн бөгөөд эмэгтэйчүүдийн оролцоог хангагдсан эсэхийг үнэлэхдээ улс төрийн намуудын удирдах байгууллагуудад эмэгтэйчүүдийн оролцоо хэр байгааг авч үзжээ.¹⁶

Дээр дурдсанд үндэслэн, судалгааны энэ хэсэгт эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог сонгох болон сонгогдох эрхийн хүрээнд авч үзэж, дэлхий дахинд болон Монгол Улсад эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт, дүгнэлт өгөхийг зорьсон болно.

Улс төрийн шийдвэр гаргах түвшин:

“Төрийн эрх мэдлийг хуваарилах” онолын дагуу, төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх хэмээн хуваадаг.¹⁷ Дээр дурдсан засаглалын салаа

13 Dublin Technical University “Promoting the political participation of women in the European Union” Policy Brief https://eurosocial.eu/wp-content/uploads/2021/03/GALLIGAN-Yvonne_Promoting-the-political-participation-of-women-in-the-European-Union-ENGLISH.pdf

14 Inter-Parliamentary Union “Women in parliament in 2021” file:///C:/Users/PC1/Downloads/2021-women%20in%20parliament_EN-LR_0%20(1).pdf

15 UN ESCAP “Women’s Political Participation and Leadership” Social Development Policy Briefs No. 2019/3: 1

16 The Common Wealth “Political Parties and Women’s Political Participation in Commonwealth Africa” https://production-new-commonwealth-files.s3.eu-west-2.amazonaws.com/migrated/inline/P15741_GDP_POL_Parties_Womens_Participation_Africa_Y_A_Mensah_V3_LoRes%20%28003%29.pdf?fbclid=IwAR1-zQg485_NCMXLC0Het5a0UvWweevyLKygTpxeX808i_UhYZJGyqACz4

17 Хууль зүй, дотоод хэргийн яам “Төрийн онол” гарын авлага, УБ, 2007

мөчрүүдээс хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын хүрээнд улс төрийн шийдвэр гардаг. Тодруулбал, парламент, засгийн газар, орон нутгийн засаг захиргаа зэрэг нь үндэсний болон орон нутгийн хэмжээнд бодлого тодорхойлж, **шийдвэр гаргах** улс төрийн мэргэшсэн тодорхой чиг үүрэг, эрх үүрэг бүхий институцууд юм.¹⁸

Зураг 1.



Улс төрийн шийдвэр гаргадаг өөр нэг субъект нь улс төрийн намууд юм. Учир нь улс төрийн намаар дамжин иргэд (эрэгтэй, эмэгтэй хүмүүс) улс төрийн шийдвэр гаргах түвшинд төлөөлөгч болж сонгогддог.¹⁹

1.2 ОЛОН УЛСЫН БОЛОН ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦООГ ХАНГАСАН БАЙДАЛ

Хүний эрхийн талаар олон улсын суурь конвенцуудад жендэр тэгш бус байдлыг арилгах, эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай заасан байдаг. Мөн эрх мэдэл бүхий албан тушаал, шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, төлөөллийг хангах тухай тусгасан байдаг. Жендэрийн тэгш байдал, улс төр болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөллийн үндэс болох тэгш эрхийн зарчим, ялгаварлан гадуурхах явдлыг хориглох нь НҮБ-ын Дүрэмд тусгалаа олсон билээ. НҮБ-ын Дүрмийн оршил хэсэгт “хүний үндсэн эрх, хувь хүний нэр төр, үнэ цэнэд итгэх итгэл болон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд түүнчлэн том, жижиг үндэстэн адил тэгш эрхтэй хэмээх итгэлийг дахин нотлох” хэмээн дурдсан байдаг.²⁰

Олон улс орнуудын Үндсэн хуулинд тусгалаа олж, бүх хүнийг хүйсээр нь ялгаварлан гадуурхахгүй байх эрхийг баталгаажуулж өгсөн олон улсын эрх зүйн баримт бичиг нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал юм. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, төлөөллийг хангах нь хүний үндсэн эрх төдийгүй тогтвортой хөгжлийг

¹⁸ Фридрих Эбэртийн сан “Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгэм: Тогтолцоо ба бодлого”

¹⁹ ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн алба “Улс төрийн намд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” гарын авлага, Варшав, 2014

²⁰ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм, 1945 он

цогцлоох, ардчиллыг түгээн дэлгэрүүлэх үндэс болно. Эмэгтэйчүүд өөрийн амьдралд нөлөөлөхүйц шийдвэр гаргах үйл явц болон институциудад оролцох, өөрийгөө төлөөлөх эрхтэй.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт нь олон нийтийн болон улс төрийн амьдралд эрэгтэй, эмэгтэй хүмүүс эрх тэгш байх тухай тодорхой заалтуудыг агуулсан байдаг. Тодруулбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактад дараах байдлаар тэгш эрхийн зарчмыг баталгаажуулжээ.²¹ Үүнд:

Иргэн бүр тус пактын 2 дугаар зүйлд дурдсан аливаа алагчилалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр дараах эрх, боломжийг эдэлнэ. Үүнд:

(a) төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох;

(b) сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох;

Эмэгтэйчүүдийн алагчлах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенц нь эмэгтэйчүүдийн хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх цогц хэрэгсэл юм. Эмэгтэйчүүдийн алагчлах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенцийг соёрхон баталснаар улс орнууд тус конвенцид тусгагдсан бүх эрхийг үндэсний хэмжээнд хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх арга хэмжээг авч, эмэгтэйчүүдийн алагчлах бүх хэлбэрийг арилгах үүрэгтэй. Тус конвенцийн 7 дугаар зүйл нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, түүний дотор нийтийн албанд сонгогдох, төрийн үйл ажиллагаанд бүрэн дүүрэн оролцох, алба хаших, санал өгөх зэрэг эрхийг баталгаажуулсан.

Монгол Улс эмэгтэй, эрэгтэй хүнд тэгш шударга хандах үзэл санааг 1924, 1940, 1960, 1992 онд баталсан дөрвөн удаагийн Үндсэн хуулиндаа тусгаж, НҮБ-ын болон бусад олон улсын байгууллагаас гаргасан дараах гэрээ, конвенцуудад нэгдэн ороод байна. Үүнд:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц
- Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц
- Хөдөөгийн эмэгтэйчүүдийн орчин нөхцөлийг дээшлүүлэх тухай конвенц
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай конвенц
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц
- Хүн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх,

21 НҮБ, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт <https://legalinfo.mn/mn/detail/1257>

таслан зогсоох, шийтгэх тухай нэмэлт протокол

- Ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд алагчлахгүй байх тухай ОУХБ-ын конвенц
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц
- Боловсролын салбар дахь алагчлах үзлийн эсрэг конвенц
- Амаржсан эхийн эрхийг хамгаалах ОУХБ-ын 103 дугаар конвенц
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай ОУХБ-ын 182 дугаар конвенц, 190 дүгээр зөвлөмж
- Тэгш шан, хөлс олгох тухай ОУХБ-ын конвенц

Манай улс эмэгтэйчүүдийн эрхийг хангах, жендэрийн эрх тэгш байдлыг тогтоох, түүний дотор улс төрд эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах зорилгоор үндэсний хэмжээнд дараах хууль тогтоомжийг батлан гаргаж, хэрэгжүүлж ажиллаж байна. (Хүснэгт 1-ыг үзнэ үү).²²

Хүснэгт 1. Жендэр эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн Монгол Улсын хууль тогтоомжууд

№	Хууль, тогтоомжийн нэр	Жендэрийн тэгш эрхийг хангахад чиглэсэн заалтууд
1	Монгол улсын Үндсэн хууль (1992 он)	<ul style="list-style-type: none"> • 1990 оноос хийгдсэн нийгмийн шинчлэлтэй холбогдуулан эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах талаар илүүтэй анхаарах болсон бөгөөд 1992 оны Монгол улсын Үндсэн хууль хүйсийн тэгш байдлыг хангах тухай заасан байдаг. • ҮХ-ийн 16-р зүйлд: “Эрэгтэй эмэгтэй хүмүүс нь гэр бүлийн дотор ба соёл, нийгэм, эдийн засгийн болон улс төрийн хувьд ижил тэгш эрхтэй байна хэмээн заасан. • ҮХ-ийн 16-р зүйлд: “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж заажээ.
2	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011 он)	<ul style="list-style-type: none"> • Энэхүү хуулиар улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн үндэс бүрдэж байгаа бөгөөд жендэрийн тэгш байдлыг хангах, энэхүү хуулийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хүлээх хариуцлагыг тодорхойлжээ.

²² IRIM судалгааны хүрээлэн. (2015). Монгол Улс дахь Жендерийн эрх тэгш байдал (Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа). Улаанбаатар : Швейцарийн Хөгжлийн Агентлаг.

3	Иргэний хууль (2002 он)	<ul style="list-style-type: none"> Иргэний хуулинд иргэд хоорондын харилцааг зохицуулах хууль эрхзүйн үндсэн зарчмуудыг тодорхойлсон байдаг ба хувь хүн болон төрийн байгууллага хоорондын харилцааг мөн энэ хуулиар зохицуулдаг. Иргэний хуульд Монгол Улсын иргэн бүр иргэний эрх зүйн харилцаанд эрх тэгш, оролцож, эрх үүргээ эдэлнэ гэж заасан байдаг. Тус хуулийн 520-р зүйлд зааснаар хүү, охины аль аль нь хуулийн дагуу гэр бүлийн өмчийг өвлөн авах эрхтэй нас барагчийн нөхөр эхнэр мөн гэр бүлийн өмчийг өвлөх адил тэгш эрх эдэлнэ. Гэр бүл болоогүй эмэгтэй, эрэгтэй өмч хөрөнгө эзэмшихдээ тэгш эрх эдэлнэ. Гэр бүл болсон эхнэр, нөхөр өмч хөрөнгө эзэмшихдээ тэгш эрх эдэлнэ. Мөн энэ хуулиар гэр бүлийн харилцаанд оруулсан мөнгөн бус оролцоо, хувьтай холбоотой асуудлыг зохицуулдаг байна.
4	Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль (1999 он)	<ul style="list-style-type: none"> Энэ хуулиар хөдөлмөрийн харилцаанд жендэрт суурилсан алагчлах үзлийг хориглосон байдаг бөгөөд хуулийн зарим бүлэгт жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалсан зүйл заалт орсон байна. Жишээлбэл: 7 дугаар бүлгийн 7.4 болон 7.5-д ажилд авах ярилцлагын үеэр ажил олгогч этгээд ажилд орохоор өргөдөл гаргагчийн гэр бүлийн байдлын талаар асуух нь хууль бус үйлдэл болно. Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил хэмжээний цалин хөлс тогтооно.
5	Боловсролын тухай хууль (2002 оны нэмэлт, өөрчлөлт 2006 он)	<ul style="list-style-type: none"> Энэ хуулинд боловсролын салбар дахь эрх тэгш байдлыг хангах суурь зарчмыг тусгасан байдаг. Иргэн бүр арьс өнгө, үндэс угсаа, иргэншил, хүйс, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, нийгэмд эзлэх байр суурь, эдийн засгийн чадавх зэргээс үл хамааран боловсрол эзэмших тэгш эрхтэй.
6	УИХ-ын сонгуулийн тухай хууль	<ul style="list-style-type: none"> УИХ-ын сонгуулийн тухай хуулийг 2011 онд батлагдсан бөгөөд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 7.2.2 -т: "... улс төрийн ба удирдах албан тушаалд эрэгтэй, эмэгтэй хүний тэнцвэртэй төлөөллийг хангах зорилгоор суудал хадгалах зэргээр квотын хэлбэрийг хэрэгжүүлэх" гэсэн заалт байдаг.
7	Улс төрийн намын тухай хууль (2005 он)	<ul style="list-style-type: none"> Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хангах зорилгоор улс төрийн нам байгуулах, үйл ажиллагааг нь зогсоох, тараах, улсын бүртгэлд бүртгэх, намын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, үүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино. Тус хуулинд намын нийт гишүүдийн 30%-ийг эмэгтэй гишүүд бүрдүүлнэ гэсэн заалт байсан боловч хуулийн шинэчилсэн найруулгаас энэ заалтыг хассан байдаг.

1.3 ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН СОНГОХ БОЛОН СОНГОГДОХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Сонгох эрх нь төрөөс гаргадаг улс төрийн шийдвэрт ард иргэдийг татан оролцуулахын үндэс болдог. Олон улс оронд сонгуулийн эрхийг зөвхөн өмч хөрөнгөтэй насанд хүрсэн эрэгтэйчүүдэд олгож байсан бол яваандаа өмчтэй байхаас үл хамааран насанд хүрсэн бүх эрэгтэйчүүд энэ эрхийг эдлэх болж, дараагаар нь эмэгтэйчүүд зэрэг улс төрд хангалттай төлөөлөлгүй бусад бүлэгт санал өгөх эрхтэй болсон.

“Иргэн” гэх тодорхойлолт цаг хугацааны явцад өөрчлөгдөж, цөөнх болон уугуул иргэдийг энэ тодорхойлолтод хамруулан үзэх болсноор тэдгээр хүмүүст сонгуульд санал өгөх эрхийг олгож иржээ. Гэтэл зарим орнууд улс орноо эмхлэн байгуулсан тэр цагаасаа эхлэн үндэс угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн байдал болон бусад шалгуур үзүүлэлтээс үл хамааран бүх насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүнийг сонгох эрхээр хангасан.

Эмэгтэйчүүд олон жилийн тэмцлийн үр дүнд сонгох эрхээ олж авсан бөгөөд энэ тэмцэл 100 жилийн түүхтэй. Хамгийн анх Европын цөөн орнууд, Австрали, Шинэ Зеландад эхлээд эмэгтэйчүүдийн сонгох эрхийг олгосон бол 1920 онд АНУ-д үндсэн хуулийн өөрчлөлтөөр эмэгтэйчүүд улс төрийн эрхээ олжээ. Манай улсын тухайд 1924 оны Үндсэн хуулиар эмэгтэйчүүд сонгуульд санал өгөх эрхийг олгож, баталгаажуулсан. Франц, Итали, Япон зэрэг орнууд бүр 1940-өөд он хүртэл ийм эрхийг баталгаажуулаагүй юм.

Доор дурдсан хүснэгтэн мэдээлэлд эмэгтэйчүүдэд сонгох эрхийг хамгийн түрүүнд болон сүүлд олгосон улс орнуудыг авч үзье (Хүснэгт 2, 3). Эдгээр хүснэгтэнд мэдээлэлд дурдсан орнуудын зарим нь орон нутгийн түвшинд (тодруулбал, муж, аймгийн түвшинд) эмэгтэйчүүдийн сонгох эрхээр хангасан боловч үндэсний түвшинд хангасан нь хожуу байсан учраас энд үндэсний хэмжээнд эмэгтэйчүүдэд сонгох эрхийг олгосон оныг авч үзсэн болно.

Хүснэгт 2. Эмэгтэйчүүдэд сонгох эрх хамгийн түрүүнд олгосон орнууд

Он	Улсын нэр	Он	Улсын нэр
1893	Шинэ Зеланд	1917	Канад*
1902	Австрали*	1918	Австри, Эстони, Гүрж, Герман, Унгар, Ирланд*, Бүгд найрамдах Кыргызстан Улс, Латив, Литва, Польш, Орос, Их Британи
1906	Финланд	1919	Беларус, Бельги*, Люксембург, Нидерланд, Швед*, Украин
1913	Норвеги	1920	Албани, Чех, Исланд**, Словак, АНУ
1915	Дани, Исланд*	1921	Армени, Азербайжан, Швед**

Эх сурвалж: Олон улсын Парламентын хороо²³

23 Тайлбар: *Тодорхой хязгаарлалттай үндэсний түвшинд эмэгтэйчүүдэд сонгох эрх олгосон огноо

** Тэрхүү хязгаарлалтыг үгүй болгосон огноо

Хүснэгт 3.Эмэгтэйчүүдэд сонгох эрхийг хамгийн сүүлд олгосон орнууд

Он	Улс орны нэр
2003	Индонез, Катар
2005	Кувейт
2006	Монтенегро, Арабын Нэгдсэн Эмират Улс
2008	Бутан
2011	Саудын Араб

Эх сурвалж: Олон улсын Парламентын хороо ²⁴

Олон улсын Парламентын холбооноос 2021 онд гаргасан “Парламент дахь эмэгтэйчүүд” тайланд дурдснаар дэлхийн хэмжээнд эмэгтэй парламентчдын эзлэх хувь 0.6 пунктээр нэмэгдэж 26.1 хувьд хүрсэн байна. Энэ нь сүүлийн хоёр жилд гарсан ахиц дэвшлийг харуулж байгаа юм.

2021 онд парламентын сонгууль болсон 48 оронд эмэгтэй нэр дэвшигчид шинээр нийт суудлын 28.6 хувийг эзлэх болсон нь өмнө болсон сонгуулиас 2.1 пунктээр ахисан байна. 2020 онд шинээр гурван улсад парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдээс давж, улмаар дэлхий хэмжээнд таван улс (Мексик, Никарагуа болон тэдэн дээр нэмэгдээд Куба, Руанда, Арабын Нэгдсэн Эмират улс) эмэгтэй гишүүн олонхи болсон парламентыг бүрдүүлээд байна.

Гэсэн хэдий ч дэлхий даяар ахиц дэвшил жигд байсангүй. Кабо Верде, Перу зэрэг олон улс ахиц дэвшил гаргасан бол Алжир зэрэг улсад ухралт ажиглагдаад байна. Япон, Тонга зэрэг улсад парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл цөөн хэвээр байна. Нийт зургаан бүс тутмын хоёрт нь 2021 онд сонгууль явагдахад жендэрийн тэгш байдлыг хангахад улс орнууд өмнөх сонгуультай харьцуулахад ухралтанд оржээ.²⁵

2021 онд дэлхий даяар 73 спикер шинээр сонгогдсон. Тэдний дөнгөж 18 нь буюу 24.7 хувь нь эмэгтэйчүүд байв. Нийтэд нь авч үзвэл, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар парламентын спикерүүдийн 22 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байсан бол жилийн өмнө энэ нь 20.9 хувь байсан юм.²⁶


ОУПХ-ны тайланд дурдсанчлан, дэлхийн бүх бүс нутаг эмэгтэй спикертэй болоод байгаа боловч тэдний эзлэх хувь бүс нутгаасаа хамаарч ихээхэн ялгаатай байна. Америк тивд эмэгтэй спикерийн эзлэх хувь хамгийн өндөр буюу 35.2 байгаа бол Европ 28.6 хувьтайгаар удаалж байна. Харин Ойрхи Дорнод, Хойд Африк болон Номхон далайн бүс нутагт эмэгтэй спикерийн эзлэх хувь тус бүр 4.2 болон 6.3 байна.

²⁴ Тайлбар: Шинээр тусгаар тогтносон орнууд (Косова, Өмнөд Судан гэх мэт)-ын тухайд салж тусгаарласан улс нь өмнө нь эмэгтэйчүүдэд сонгох эрхийг олгоогүй байсан тохиолдолд энэ жагсаалтад бичигдэж байгаа юм. Тухайлбал, Судан улс нь 1964 онд эмэгтэйчүүдэд сонгох эрхийг олгосон байсан учраас Өмнөд Судан нь хэдийгээр 2011 онд тусгаар тогтносон боловч энэ жагсаалтад ороогүй болно.

²⁵ IPU “New IPU report: more women in parliament and more countries with gender parity”(03 March 2022) <https://www.ipu.org/news/press-releases/2022-03/new-ipu-report-more-women-in-parliament-and-more-countries-with-gender-parity>

²⁶ Мөн тэнд

Зураг 2. Үндэсний хууль тогтоох байгууллагад сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо (дэлхийн хэмжээнд, 2002-2022 он)



1960 онд Шри-Ланка Улсад Сирима Бандаранаике дэлхийн анхны эмэгтэй ерөнхий сайдаар сонгогдсоноос хойш дэлхийн 70 гаруй улсын сонгогчид эмэгтэй хүнийг гүйцэтгэх засаглалын тэргүүний албан тушаалд сонгосон байна. Гүйцэтгэх засаглалын тэргүүнийг олон янзын байдлаар сонгож байна. Зарим улсад (тухайлбал, АНУ-ын гүйцэтгэх засаглалын тэргүүн нь ерөнхийлөгч байдаг) гүйцэтгэх засаглалын тэргүүнийг шууд сонгуулиар сонгодог бол заримд нь хууль тогтоох байгууллагаас шууд бусаар сонгодог байна. Бусад улсад хууль тогтоох сонгуулийн дараа олонх болсон улс төрийн нам, олонхийн эвслийн даргыг гүйцэтгэх засаглалын тэргүүнээр томилдог байх жишээтэй.

Хоёр улс түүхэндээ анх удаа эмэгтэй ерөнхийлөгчийг сонгосон нь Гондурас Улсын Шиомара Кастро де Зелая, Танзанийн Самиха Сулуку нар юм. Мөн Самоа Наоми Матаафаг анхны эмэгтэй Ерөнхий сайдаар сонгосон нь зөвхөн Самоа төдийгүй Номхон далайн нийтийн бүс нутгийн хувьд чухал ач холбогдолтой юм. (Хүснэгт 4-ыг үзнэ үү).

Хүснэгт 4. Гүйцэтгэх засаглалын тэргүүнээр ажиллаж буй эмэгтэйчүүд (2022 оны 3 дугаар сарын 25-ны байдлаар)

Улс	Нэр	Албан тушаал	Томилогдсон огноо
Аруба	Эвелин Вевер-Кроес	Ерөнхий сайд	2017 оны 11 дүгээр 17-ний өдрөөс өнөөг хүртэл
Бангладеш	Шейх Хасина	Ерөнхий сайд	1996-2001, 2009 оны 1 дүгээр сарын 6-наас хойш
Барбодас	Миа Моттлей	Ерөнхий сайд	2018 оны 5 дугаар сарын 25-наас өдрөөс хойш
Барбодас	Сандра Мэсон	Ерөнхийлөгч	2021 оны 11 дүгээр 30-ны өдрөөс хойш

Дани	Метте Фредериксон	Ерөнхий сайд	2019 оны 6 дугаар сарын 26-наас хойш
Эстони	Каяа Каллас	Ерөнхий сайд	2021 оны 1 дүгээр сараас хойш
Этиоф	Сахле-Ворк Зевде	Ерөнхийлөгч	2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс хойш
Финланд	Санна Мирелла Марин	Ерөнхий сайд	2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс хойш
Габон	Розе Кристиане Оссоуза Рапонда	Ерөнхий сайд	2020 оны 7 дугаар сараас хойш
Гүрж	Саломе Зоурабишвили	Ерөнхийлөгч	2018 оны 12 дугаар сарын 16-ны өдрөөс хойш
Грек	Экатерина Сакелларопоулоу	Ерөнхийлөгч	2020 оны 3 дугаар сараас хойш
Гондурас	Хиомара Кастро	Ерөнхийлөгч	2022 оны 1 дүгээр сараас хойш
Исланд	Катрин Жаковсдоттир	Ерөнхий сайд	2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс хойш
Косова	Вяоса Османи-Садриу	Ерөнхийлөгч	2021 оны 4 дүгээр сараас хойш
Литва	Ингрида Симоните	Ерөнхий сайд	2020 оны 11 дүгээр сараас хойш
Молдав	Маиа Санду	Ерөнхийлөгч	2020 оны 12 дугаар сараас хойш
Молдав	Наталиа Гаврилита	Ерөнхий сайд	2021 оны 8 дугаар сараас хойш
Намибиа	Саара Куугонгелва Амадхила	Ерөнхий сайд	2015 оны 3 дугаар сарын 21-ний хойш
Балба	Бидхиа Деви Бандхари	Ерөнхийлөгч	2015 оны 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс хойш
Шинэ Зеланд	Жасинда Ардерн	Ерөнхий сайд	2017 оны 10 дугаар 27-ны өдрөөс хойш
Синт Маартен	Силвериа Жаковс	Ерөнхий сайд	2020 оны 1 дүгээр сарын 26-ны өдрөөс хойш
Самоа	Фиаме Наоми Матафа	Ерөнхий сайд	2021 оны 7 дугаар сараас хойш
Серби	Ана Брнавик	Ерөнхий сайд	2017 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс хойш
Сингапур	Халимах Яков	Ерөнхийлөгч	2017 оны 9 дүгээр 14-ний өдрөөс хойш
Словак	Сузана Капутова	Ерөнхийлөгч	2019 оны 6 дугаар 15-ны өдрөөс хойш
Швед	Магделана Андерссон	Ерөнхий сайд	2021 оны 11 дүгээр сараас хойш
Тайвань	Цай Инвен	Ерөнхийлөгч	2016 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс хойш
Танзания	Самиа Сухулу Хассан	Ерөнхийлөгч	2021 оны 3 дугаар сарын 19-ний өдрөөс хойш
Того	Виктоир Томега Догве	Ерөнхий сайд	2020 оны 9 дүгээр сараас хойш
Тунис	Найла Боуден Ромдхане	Ерөнхий сайд	2021 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс хойш
Уганда	Робинах Наббануе	Ерөнхий сайд	2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс хойш

Монгол Улсын тухайд, Дэлхийн эдийн засгийн форумаас жил бүр гаргадаг Дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын индексээр ахиц гаргаад байгаа нь сайшаалтай юм. Тухайлбал, энэ индексээр 149 орноос 2018 онд 58 дугаар байранд орсон²⁷ бол 2020 онд 153 орноос 79 дүгээр байранд орж, ухарсан үзүүлэлттэй байсан.²⁸ Харин 2021 онд 156 улсаас 69 дүгээр байранд орж, эмэгтэйчүүд тэгш эрх эдлэхэд ахиц дэвшил гаргаад байна. Манай улс нь Зүүн Ази болон Номхон далайн бүс нутагтаа 7 дугаар байранд орж байна.²⁹

Хэдийгээр Монгол Улс жендэрийн зөрүүтэй байдлыг арилгахад амжилт олж байгаа боловч улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтээр 2006 онтой харьцуулахад ухарсан байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтээр 156 орноос 116-д бичигдэж байгаа нь энэ чиглэлд ажиллах шаардлагатай байгааг харуулж байгаа юм (Хүснэгт 5-ийг үзнэ үү).

Хүснэгт 5. Жендэрийн зөрүүтэй байдлын индекс, Монгол Улс

	2006 он	Оноо	2021 он	Оноо
Жендэрийн зөрүүтэй байдлын индекс	42	0.682	69	0.716
Эдийн засгийн оролцоо, боломж	21	0.704	23	0.769
Боловсрол эзэмшилт	20	0.999	73	0.993
Эрүүл мэнд	1	0.980	1	0.980
Улс төрийн эрх мэдэл	101	0.046	116	0.122

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум

Дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын индексийн дэд үзүүлэлт болох улс төрийн эрх мэдлийн индексийг дотор нь задалж авч үзвэл, сүүлийн 50 жилийн хугацаанд эмэгтэй төрийн тэргүүнтэй байсан хугацаа гэсэн үзүүлэлтээр Монгол Улс огт оноо аваагүй байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн эрх мэдлийн үзүүлэлтээр чамлалттай оноо авахад энэ үзүүлэлт хамгийн их хойш нь татжээ (Хүснэгт 6-ыг үзнэ үү). Манай улсад эмэгтэй төрийн тэргүүнтэй байсан туршлагагүй боловч Монгол Улсын Ерөнхийлөгчийн 7 удаагийн сонгуульд 16 хүн нэр дэвшсэнээс 1 нь эмэгтэй (2013 оны сонгууль) байсан³⁰ нь энэ чиглэлд чамлахааргүй дэвшил юм.

Хүснэгт 6. Жендэрийн зөрүүтэй байдлын индексийн улс төрийн эрх мэдэл дэд үзүүлэлт, Монгол Улс (2021 он)

Улс төрийн эрх мэдэл	Монгол Улс		Дэлхийн дундаж оноо
	Байр	Оноо	
Парламент дахь эмэгтэйчүүд, %	113	0.209	0.312
Сайд нарын түвшин дэх эмэгтэйчүүд, %	85	0.232	0.235
Эмэгтэй төрийн тэргүүнтэй байсан хугацаа (сүүлийн 50 жилд)	72	0.000	0.144

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн форум

27 World Economic Forum "The Global Gender Gap Index 2018"

28 World Economic Forum "The Global Gender Gap Index 2020"

29 World Economic Forum "The Global Gender Gap Index 2021" https://www3.weforum.org/docs/WEF_GGGR_2021.pdf

30 УЦХ "Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо", 2019 он

Парламентын гишүүдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувиар Монгол Улс дэлхийд 156 орноос 113 байранд орж дэлхий дунджаас доогуур байгаа нь анхаарал татаж байна. УИХ-ын 2020 оны сонгуулийн үр дүнд 13 эмэгтэй гишүүн сонгогдсон өмнөх амжилтаа бататгасан явдал болов.³¹ Өмнөх парламентын сонгуулиудын үр дүнг авч үзвэл, Монгол Улсын шинэ Үндсэн хуулиа батлан, парламентын тогтолцоонд шилжин, Монгол Улсын Их Хурлын анхны сонгуульд 1992 онд 293 хүн нэр дэвшиж, 76 гишүүн сонгогдсоноос 4 нь буюу 5.3 хувь нь эмэгтэй гишүүн сонгогдсон байна.

УИХ-ын сонгууль явагдсан дараагийн жилүүдэд эмэгтэйчүүд нэр дэвшсэн байдлыг авч үзвэл, 1996, 2000 онд нийт нэр дэвшигчдийн 1.5-2.6 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол 2004 оны сонгуулиас хойш нэр дэвшигчдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэж 2012 онд хамгийн өндөр 32.0 хувьд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, 2004 оноос өмнөх сонгуулиудад нэр дэвшигч 100 хүн тутмын 2-3 нь эмэгтэй байсан бол түүнээс хойш 14-32 болж нэмэгджээ. (Хүснэгт 7-ыг үзнэ үү).³²

Хүснэгт 7. УИХ-ын сонгуульд нэр дэвшиж, сонгогдсон гишүүдийн тоо (1992-2020 он)

Сонгуулийн жил	Нэр дэвшигчдийн тоо	Нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн тоо		Сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо	
1992	293	*		3	3.9%
1996	302	*		8	10.5%
2000	602	*		9	11.8%
2004	244	40	16.3%	5	6.6%
2008	356	66	18.5%	3	3.9%
2012	544	174	32%	11	14.5%
2016	498	129	26%	13	17.1%
2020	606	151	25%	13	17.6%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2016 оны сонгуулийн үр дүнд 13 гишүүн сонгогдон ажиллахаар болсон нь 2012 оны парламентын сонгуультай харьцуулахад өссөн үзүүлэлт юм. 2012 оны сонгуулийн үр дүнгээр УИХ-ын нийт гишүүдийн 14.5 хувь нь эмэгтэй гишүүд байсан. Харин 2016 онд энэ тоо 17.1 хувьд хүрчээ.³³

Монгол Улсад УИХ-ын даргаар ажилласан эмэгтэй гишүүн байхгүй боловч УИХ-ын 2020 оны сонгуулийн үр дүнд байгуулагдсан парламентын дэд даргаар эмэгтэй гишүүн ажиллах болсон нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэхэд нэг бодитой алхам бөгөөд энэ нь Монгол Улсын парламентын түүхэн дэх хоёр дахь

31 Монцамэ “УИХ-ын эмэгтэй гишүүд бүлэг байгуулав” (2020.08.20)<https://montsame.mn/mn/read/234160>

32 Мөн тэнд

33 Азийн барометр судалгаанд хамрагдсан 13 улс (Камбож, Хятад, Хонг Конг, Индонез, Япон, Малайз, Филиппин, Сингапур, Өмнөд Солонгос, Тайвань, Тайланд, Вьетнам зэрэг)-ын хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөлөл эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо нэмэгдэх бус, харин ч ухралтад оруулсан хэмээн дүгнэсэн нь үүнийг нотолж байна.

удаагийн тохиолдол болж байна.³⁴ Мөн УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар анх удаа эмэгтэй хүн томилогдож, өнөөг хүртэл албан үүргээ гүйцэтгэж байгааг энд дурдах шаардлагатай.³⁵

2021 онд байгуулагдсан шинэ Засгийн газрын 14 сайдын 4 нь эмэгтэй сайд ажиллаж байсан. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн 39.1-т заасан “Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно” гэснийг 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр 2022 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсонтой³⁶ холбогдуулан Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, ерөнхий чиг үүргийн 4 яам, чиглэлийн 12 сайд, яамгүй 5 нийт 21 сайдтайгаар үйл ажиллагаа явуулахаар тогтосны 3 нь эмэгтэй байна.³⁷

2020 оны байдлаар Засгийн газар 14 сайдтайгаар үйл ажиллагаа явуулж байхад сайд нарын 2 нь буюу 14.2 хувь нь эмэгтэй сайд байна. Засгийн газрын агентлагийн дарга нарын 29 нь эрэгтэй байхад 1 эмэгтэй энэ албан тушаалд ажиллаж байв.

Аймаг, нийслэлийн засаг даргаар 2022 он хүртэл нэг ч эмэгтэй ажиллаагүй байж байгаад 2022 оны 8 дугаар сард Ховд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын гишүүдийн 73.1 хувийн саналаар Э.Болормааг тус аймгийн засаг даргаар сонгосон байна. Монгол Улс 1931 онд засаг захиргааны өөрчлөлт хийж, орчин үеийн аймгуудыг байгуулснаас 91 жилийн хугацаанд анх удаа эмэгтэй хүн засаг даргаар томилогдсон нь энэ болж байгаа юм.³⁸ 2019 оны байдлаар нийслэлийн 9 дүүргийн ИТХ-ын дарга нарын 4 нь эмэгтэй байсан нь “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-д заасан квотыг хангасан бол Монгол Улсын 330 сумын ИТХ-ын дарга нарын 59 нь буюу 17.8 хувь нь эмэгтэй байна.³⁹

Төрийн албан хаагчийн 2020 оны тоо бүртгэлээс үзвэл, төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудад эмэгтэйчүүдийн эзлэх хувь яамдын төрийн түвшинд байхгүй, агентлагийн даргын түвшинд 8.3 хувь, аймаг, нийслэлийн ЗДТГ-ын даргын түвшинд 18.2 хувь байгаа бол аймаг, нийслэлийн ИТХ-ын нарийн бичгийн даргын түвшинд 22.7 хувь байна (Хүснэгт 8-ыг үзнэ үү).⁴⁰

34 А.Төгөлдөр “УИХ эмэгтэй даргатай боллоо” (2020.06.30) <https://ikon.mn/n/1xdl>

35 Монцамэ “Л.Өлзийсайханыг УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилохыг дэмжив” (2019.05.08) <https://montsame.mn/mn/read/188770>

36 Монгол Улсын Үндсэн хууль <https://legalinfo.mn/mn/detail/367>

37 Г.Тэгшсүрэн “Шинэ сайд нар мэдээлэл өгч байна” <https://gogo.mn/r/ojn6d>

38 А.Цээсүрэн “Ховд аймгийн Засаг даргаар Э.Болормааг сонгожээ” (2022.08.29) <https://news.mn/r/2583939/>

39 Жендэрийн үндэсний хороо “Монгол Улс: Жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин (Сүүлийн үеийн тоо баримтаар)” 2020 он

40 Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан: Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн бүртгэлийн тайлан <https://csc.gov.mn/s/52/914>

Хүснэгт 8. Төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын тоо, хүйсээр, 2020 он

Албан тушаал	Нийт	Хүйс			
		Эрэгтэй		Эмэгтэй	
		тоо	хувь	тоо	хувь
Яамдын ТНБД	14	14	100%	0	0.0%
Агентлагийн дарга	36	33	91.7%	3	8.3%
Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга	22	18	81.8%	4	18.2%
Аймаг, нийслэлийн ИТХ-ын нарийн бичгийн дарга	22	17	77.3%	5	22.7%
Дүүргийн ИТХ-ын нарийн бичгийн дарга	9	7	77.8%	2	22.2%
Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга	330	130	39.4%	200	60.6%
Дүүргийн ЗДТГ-ын дарга	9	8	88.9%	1	11.1%
Сумын ЗДТГ-ын дарга	330	173	52.4%	157	47.6%
Нийт	772	400	51.8%	372	48.2%

Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ:

Дэлхий дахинд эмэгтэйчүүдийн сонгох эрх үндсэндээ хангагдсан бөгөөд Монгол Улсад эмэгтэйчүүд сонгуульд санал өгөхөд ямар нэгэн хязгаарлалт байхгүй, чөлөөтэй эрхээ эдлэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдийн сонгох эрхтэй холбоотой ноцтой, шийдвэрлэх асуудлууд цөөн байна.

Харин сонгогдох эрхийн хэрэгжилт чамлалттай байна. Дэлхийн ардчилсан улс орнуудын хувьд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг сонгож ажиллуулах туршлага тогтсон боловч Скандинавын орнуудыг эс тооцвол дийлэнх улс оронд эмэгтэйчүүдийн төлөөлөл парламентын 20 хүрэхгүй хувьтай байгаагаас үзэхэд улс төрийн талбарт эрэгтэйчүүдийн ноёрхол хэвээр байгааг харуулж байгаа юм. Мөн цар тахалтай холбоотойгоор бүх салбарт, ялангуяа улс төрд жендэрийн тэгш бус арилгахад олсон ололт амжилт алдагдан, ухралтанд орсон явдал юм.

Гэвч удаан боловч зарим өөрчлөлт гарч байгааг үгүйсгэж болохгүй. Жишээлэхэд, Монгол Улсын УИХ-ын 8 дахь удаагийн сонгуулийн үр дүнд сонгогдсон нийт гишүүдийн 13 нь буюу 17.1 хувь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх 7 удаагийн парламентуудаас хамгийн өндөр үзүүлэлт юм. Мөн Монгол Улс аймаг, нийслэлийн түвшинд түүхэндээ анх удаа эмэгтэй засаг даргатай боллоо.

БҮЛЭГ 2. ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООНД ТУЛГАМДАЖ БУЙ СААД БЭРХШЭЭЛ, ШАЛТГААН

Парламентад эзлэх эмэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэхэд квотыг амжилттай хэрэгжүүлсэн нь нөлөөлжээ. Тодруулбал, өмнөх жилүүдэд ажиглагдсанчлан, квот бол эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд амжилт гаргахад хамгийн шийдвэрлэх хүчин зүйлүүдийн нэг юм. 2021 онд нэг буюу доод танхимд ямар нэгэн хэлбэрээр квот тогтоосон 30 улсад парламентад сонгогдсон гишүүдийн 31.9 хувь нь эмэгтэйчүүд байсан бол квотгүй орнуудад эмэгтэйчүүд парламентын гишүүдийн 19.5 хувийг бүрдүүлж байна. Харин парламентынхаа дээд танхимд ямар нэг хэлбэрээр квот тогтоосон дөрвөн улсад сонгогдсон парламентын гишүүдийн 29.1 хувь нь эмэгтэйчүүд байсан бол эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог дэмжих ийм арга хэмжээг аваагүй орнуудад 23.9 хувь нь эмэгтэйчүүд байжээ.

Квотыг нэвтрүүлсэн нь Монгол Улсад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоонд эерэгээр нөлөөлсөн юм. УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн болон сонгогдсон эмэгтэй гишүүдийн тоо аажмаар өсөхөд Монгол Улсын сонгуулийн тухай хуульд нам эвслээс нэр дэвшүүлэх тооны доод хязгаар 20 хувь байх заалтыг оруулсан явдал чухал нөлөө үзүүлсэн. Монгол Улс парламентын гишүүдийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувиар дэлхий дунджаас доогуур байгааг квотыг нэмэгдүүлэх замаар богино хугацаанд өөрчлөх боломжтой. Гэвч 2020 онд Сонгуулийн тухай хуулийг хэлэлцэх явцад эмэгтэйчүүдийн оролцооны доод түвшнийг 30 хувьд хүргэх санал гарсан ч дэмжигдэлгүй 20 хувь чигээрээ үлдсэнээс⁴¹ харахад энэ чиглэлд Монгол Улс ахиц дэвшил гаргаж чадах эсэх нь улс төрийн намуудын хүсэл зоригоос хамаарахаар байна.

Гэсэн хэдий ч квот нь дангаараа шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэхэд хангалтгүй юм. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангахад сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлүүдийг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх шийдлүүдийг санал болгох нь улс төрийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангахад чухал юм.

Иймд дор дурдсан бүлэгт шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоонд сөргөөр нөлөөлдөг байж болох хүчин зүйлсийн талаар онолын судалгаа болон Монгол Улсад хийгдсэн судалгаануудыг авч үзлээ.

2.1. ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Эмэгтэйчүүд шийдвэр гаргах түвшинд ажиллахад саад болдог олон хүчин зүйлс бий гэдгийг судлаачид тогтоосон бөгөөд онолын судалгааг хийхдээ тодорхойлсон хүчин зүйлсүүдийг бүлэглэн авч үзсэн болно.

Ө

41 Р.Оюунцэцэг “Монголэмэгтэйчүүдтөртүшилцэхэдюусаадболдогвэ?” <https://ikon.mn/n/1lr>


өртөө итгэх итгэлийн ялгаатай байдал

Америкийн Корнелийн их сургуулийн 2003 онд хийсэн судалгаанаас үзэхэд, эрэгтэйчүүд өөрийн чадвар, гүйцэтгэлээ хэт өндөр үнэлдэг бол эмэгтэйчүүд эсрэгээрээ доогуур үнэлдэг. Бодит байдал дээр тэдний гүйцэтгэлийн түвшин тоо, чанарын хувьд төдийлөн ялгаагүй байдаг байна (Katty Kay, 2014). Эмэгтэйчүүдийн өөртөө итгэх байдал сул байдаг үзэгдлийг Паулин Клаунс, Сюзен Имес нар “луйварчны синдром” хэмээн тодорхойлжээ. Ихэвчлэн эмэгтэйчүүд эрхэлж байгаа ажилдаа тэнцэхгүй гэдгээ байнга илэрхийлэн ярьдаг бөгөөд энэ утгаар тэд “луйварчид” юм. Эмэгтэйчүүд бусдад таалагдахгүй байх, сэтгэл татам харагдахгүй байх, бусдаас илүү тодорч харагдах буюу хэт анхаарал татахад эмзэг ханддаг болох нь судалгаагаар тогтоогджээ (Gordon, 2014).

Мэдээжийн хэрэг, эрэгтэйчүүд өөртөө эргэлзэх нь бий боловч тэдний хувьд эргэлзээ нь эмэгтэйчүүдтэй адил нөлөө үзүүлдэггүй байна. Хевлетт Пакард компанийн дотоод тайлангаас үзэхэд, эрэгтэйчүүд тухайн ажилд шаардагдах ур чадварын 60 хувийг бий болгосон байгаа атлаа тухайн ажилд орох эсвэл тушаал дэвших өргөдөл гаргадаг байна. Харин эмэгтэйчүүд тухайн ажилд шаардагдах чадварын 100 хувь хангасан тохиолдолд л тухайн ажилд ажиллах өргөдөл гаргадаг байна. Үүнээс дүгнэхэд, эмэгтэйчүүдийг хойш нь татаж байгаа зүйл нь тэдний бодит чадвар бус, харин тухайн зүйлийг хийхгүй байх шийдвэр юм.

Зенгер Фолкманы судалгаанаас үзэхэд, эмэгтэйчүүдийн туршлага нэмэгдэхийн хэрээр тэдний өөртөө итгэх итгэл нэмэгддэг болохыг судалгаа харуулдаг (Zenger, 2018).

Зураг 1. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өөртөө итгэл байдал (насаар, хувь)



Зураг 1-ээс үзэхэд эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд нас ахихын хэрээр өөртөө итгэх итгэл нь нэмэгддэг байна. Гэхдээ айдас, өөртөө итгэх итгэл дутагдснаас эмэгтэйчүүд карьерынхаа эхний жилүүдэд маш олон боломжийг алддаг гэдгийг энд дурдах хэрэгтэй.

Жендэрийн хэвшмэл хандлага

Вальтер Липпман “хэвшмэл ойлголт” хэмээх нэр томъёог анх гаргаж ирсэн бөгөөд тодорхой нийгмийн бүлгийн талаар бодоход санаанд орж ирдэг нийтлэг дүр төрхийг илэрхийлдэг (Lippmann, 1922). Жендэрийн хэвшмэл ойлголт нь эмэгтэйчүүдийн ур чадварын талаар сөрөг ялгаварласан үзэл бодол хэмээн тодорхойлдог (Wood, 2008). Төр засгаас хууль тогтоомж баталж, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин ихээхэн ахисан боловч эмэгтэйчүүд шийдвэр гаргах албан тушаалд тохирохгүй, илүү дэмжлэг, тусламж үзүүлэх үүрэг роль гүйцэтгэхэд тохиромжтой гэх хэвшмэл хандлагад тулгарсан байр сууринаас үүдэн дээд түвшний менежерийн албан тушаалд ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэхгүй байна (Heilman, 2006). Эхнэр, эх хүн, охины хувиар эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийг дэмжиж, тэдний удирдлаганд байх ёстой гэх хэвшмэл ойлголт нь эмэгтэйчүүдэд сөргөөр нөлөөлдөг (Tomppkins, 1988).

Эмэгтэйчүүдийн уламжлалт онцлог шинж чанарууд болох харилцаанд чиглэсэн хандлага, даруу төлөв байдал, идэвхгүй байдал, сэтгэл хөдлөл зэрэг нь амжилтанд хүрэхийн төлөөх хандлага, эрсдэл хүлээх, шийдвэр төгс байдал, бие физилогийн хүч чадавхи, харизм зэрэг манлайлагчийн шинж чанартай барагтай бол давхцадаггүй (Hansen, 2009)(Wood, 2008). Ийм хэвшмэл ойлголтоос үүдэн эмэгтэйчүүдийг удирдах албан тушаалд тэнцэхгүй хэмээн үзэж дээд түвшний менежерийн албан тушаалд дэвшүүлэх нэр дэвшигчдээс эмэгтэйчүүдийг хасах нь байдаг.

Менежерийн албан тушаалд ажиллаж байгаа эмэгтэйчүүд нь туслах үүрэг гүйцэтгэж байгаа эмэгтэйчүүд болон ижил албан тушаалд ажиллаж байгаа эрэгтэйчүүдээс гүйцэтгэл муутай байгаа нь эмэгтэйчүүдээс илүү эрэгтэйчүүдэд менежментийн үүрэг роль гүйцэтгэх нь зохимжтой хэмээх үзэл нь арилахгүй байна (Heilman, 2006).

Жендэрийн хэвшмэл ойлголтыг даван туулахын тулд эмэгтэйчүүд өөрсдийгөө чадвартай, найдвартай гэдгээ батлан харуулах хэрэгтэй. Тухайлбал, АНУ-ын Холбооны засгийн газарт ажиллаж байгаа хүмүүсээс авсан судалгаанаас үзэхэд, судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 55 хувь нь тушаал дэвшихийн тулд эрэгтэйчүүдээс илүү сайн ажиллах хэрэгтэй хэмээн үзсэн бол ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн ачаар эмэгтэйчүүд тушаал дэвших боломжтой болсон хэмээн судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн 41 хувь, эмэгтэйчүүдийн 20 хувь үзжээ (Naff K. C., 2001).

“Шилэн тааз”-ны нөлөө

Эмэгтэйчүүд болон нийгмийн цөөнх нь байгууллагууд, ялангуяа төрийн албанд ажиллах үед тэдний карьер ахих үйл явц нь менежментийн дунд түвшинд хүрээд зогсдог. Тэд тушаал дэвшихийн тулд “шилэн тааз”-ыг нэвтрэх хэрэгтэй болдог (Naff K. C., 1994)(Guo, 1992). Ойлголтын хувьд, “шилэн тааз” нь карьер ахихад нөлөөлдөг бусад жендэр болон үндэсний цөөнхтэй холбоотой хориг саадуудыг өөртөө багтаадаг. Түүнчлэн, эмэгтэйчүүд, үндэсний цөөнхүүд нь “шилэн хана”, “наалдамхай шал”, “хавхтай хаалга” зэргийг даван гарч карьер ахих боломжтой болдог (Naff K. C., 1994).

Моррисон, Вон Глинов нарын судлаачид “шилэн тааз”-ыг ярвигтай боловч илэрхий хүчтэй бөгөөд менежерийн шатаар дээш өгсөхөд нь эмэгтэйчүүд, цөөнхүүдэд саад болдогийг тодорхойлжээ (Morrison & Von Glinow, 1990). Шилэн таазны нөлөөнөөс болоод байгууллагын топ түвшинд цөөн тооны эмэгтэй ажилладаг. Эмэгтэйчүүд “шилэн тааз”-аар дамжин, эрэгтэйчүүдээс илүү их нийгмийн төлөөсийг төлж топ түвшинд хүрсэн байлаа ч гэсэн эмэгтэйчүүдийн эрх мэдлийг ихээхэн хязгаарладаг дахиад өөр нэг “шилэн тааз”-тай тулгарах магадлалтай. Мөн эмэгтэйчүүд ижил албан тушаалд байгаа эрэгтэйчүүдээс илүү бага эрх мэдэлтэй учраас цалин багатай байдаг (Alkadry & Tower, 2011).

Амбицын ялгаатай байдал

Бостоны консалтинг группын 189 орны 200 мянга ажилтан, түүний дотор 141 мянган эмэгтэй ажилтанг хамруулсан судалгаанаас үзэхэд карьерын эхэн үед эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүд адилхан амбицтай байсан боловч энэ нь аамжаар буурдаг аж. Тухайлбал, 30-аас доош насны ажилтнуудын дунд амбицын ялгаа ажиглагдахгүй байсан бол жендэрийн олон талт байдлыг бий болгоход бусдаас хоцорч байгаа компаниудын хувьд эмэгтэйчүүдийн амбиц эрэгтэйчүүдтэй харьцуулахад хурдан буурдаг байна. 30-40 насны эмэгтэй, эрэгтэйчүүдийн хооронд 17 хувь байхад эмэгтэйчүүдийн тушаал дэвшүүлэх хувь 66 хувь байсан бол эрэгтэйчүүдийг тушаал дэвшүүлэх магадлал 83 хувь байна.

Гэтэл жендэрийн олон талт байдал сайжирч байгаа гэж үзэж байгаа хүмүүс нийт ажилтнуудын 85 хувийг эзэлж, эмэгтэйчүүдийн тушаал дэвших магадлал 87 хувь байхад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд амбицын зөрүү бараг байхгүй байсан. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн үүрэг хариуцлага гэхээс илүү байгууллага жендэрийн олон талт байдлыг хангаж байгаа эсэхээс шалтгаалан эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн амбиц ялгаа бий болдог гэж судалгаанд дурдсан байна (Joya, 2017).


Түүнчлэн, Америкийн их сургуулийн судлаачид оюутнуудын улс төрийн амбицыг үнэлэх зорилгоор 18-аас 25 насны 2100 орчим коллежийн оюутнуудаас судалгаа авсан. Эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2 дахин олон эрэгтэй улс төрийн карьер хийх сонирхолтой байсан. Насаар ахимаг эмэгтэйчүүдээс судалгаа авахад тэдний улс төрийн амбиц нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад сул байна. Учир нь гэр бүлийн үүрэг хариуцлага, ажил, амьдралынхаа тэнцвэрээ хадгалахтай холбоотой асуудлуудын улмаас эмэгтэйчүүд улс төрийн сонгуульт ажилд өрсөлдөх сонирхолгүй байдаг байна.

2.2. ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ОРОЛЦОХОД МОНГОЛ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ТУЛГАМДАЖ БУЙ СААД БЭРХШЭЭЛ, ШАЛТГААН

Улс төрийн сонгуульт албан тушаалуудад эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгаа нь олон шалтгаантай. Тухайлбал, АНУ-ын Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн удирдлаган дор, Нийгмийн бодлого хөгжил судалгааны хүрээнд Улаанбаатар хот, 13 аймгийн 18-аас дээш насны 2,492 иргэнээс 2020 оны 5 дугаар

14-нөөс 6 дугаар 15-ны өдөр авсан судалгаанаас үзэхэд улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангагдахгүй байгаагийн хамгийн гол саад бэрхшээлийг дараах байдлаар тодорхойлсон байна.⁴²

Зураг 2. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангагдахгүй байгаагийн хамгийн гол саад бэрхшээл



Эх сурвалж: БНОУХ

Дээрх судалгаанаас үзэхэд, улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангагдахгүй байгаа гол шалтгаан нь *нэгдүгээрт, эмэгтэйчүүд ар гарын ажил, хүүхдээ асрах ажилд дарагдсан байдал (75 хувь), хоёрдугаарт, эмэгтэйчүүдэд дэмжих танилын хүрээ дутмаг (63 хувь), эмэгтэйчүүд нэр дэвшсэн ч тэднийг сонгодоггүй (64 хувь)* зэрэг болж байна.⁴³

2020 онд энэ талаар хийсэн чанарын судалгааны үр дүнгээс үзэхэд, нийгмийн шинжтэй хүчин зүйлүүд болох гэр бүлийн үүрэг хариуцлага, жендерийн хэвшмэл хандлага зэрэг улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарладаг хүчин зүйлээр тодорхойлогдсон.⁴⁴Тодруулбал, судалгааны ярилцлагад

⁴² Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн “Залуучуудын санал бодлын судалгаа” УБ хот, 2020

⁴³ Мөн тэнд

⁴⁴ Л.Бямбаханд “Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлүүд” Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа, УБ 2020 он

оролцсон бүлэг тус бүрээр нь авч үзвэл, жендэрийн экспертүүд нийгэмд оршиж буй жендэрийн хэвшмэл хандлагыг эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хязгаарлагч суурь хүчин зүйлээр нэрлэсэн бол эмэгтэй улс төрчдийн зүгээс гэр бүлийн үүрэг хариуцлага, ажил-амьдралын тэнцвэрийг хадгалахад тулгардаг бэрхшээлүүд нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагчаар нэрлэсэн.⁴⁵

Иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшээд ялагдсан эмэгтэйчүүдээс амжилтгүй болсон шалтгааныг тодруулахад, *нэгдүгээрт* нэр дэвшиж өрсөлдсөн намын нэр хүнд (55 хувь), *хоёрдугаарт* сонгуулийн кампанит ажил муу байсан гэх хоёр үндсэн шалтгааныг нэрлэсэн байна.⁴⁶

Улс төр судлаач Э.Гэрэлт-Одын дүгнэснээр, Монгол Улсад хэрэгжиж байгаа сонгуулийн мажоритар тогтолцоо эмэгтэйчүүд, залуучуудын улс төрийн манлайлалд ээлтэй бус байна. Мажоритар тогтолцоо нь тойрогтоо хамгийн олон санал авсан нэр дэвшигч ялах боломжтой учраас нөлөө бүхий, олны тал хүмүүст илүү боломж олгож, хөрөнгө мөнгө багатай залуу, эмэгтэй улс төрчийн сонгогдох боломжийг хязгаарладаг.⁴⁷ Нөгөөтэйгүүр, сонгуулийн мажоритор тогтолцоонд нэр дэвшигч гол үүрэгтэй байдгаас санхүүгийн нөөц сайтай нэр дэвшигчийн сонгуульд ялах магадлал нь нэмэгддэг.

Монгол Улсад эмэгтэй нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаа явуулахад шаардлагатай хөрөнгө босгоход ихээхэн хүндрэлтэй тулгардаг. Өнөөдөр хэрэгжиж буй хууль тогтоомжинд сонгуулийн кампанит ажлын зардлыг хязгаарлах заалт сул байгаа явдал хөрөнгөтэй нэр дэвшигч, улс төрийн намуудад илүү боломж олгож байна. Хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага сул байгаагаас намууд, нэр дэвшигчид сонгогдсоныхоо дараа бизнесийн ашиг сонирхолд автах эрсдэлтэй юм.

“Манай улсад одоог хүртэл эрэгтэйчүүд давамгайлсан парламентын гишүүдийн дунд бизнес эрхэлдэг гишүүд олон бий. Тиймээс улс төрд бизнесийн ашиг сонирхлын нөлөө их, томоохон компаниуд сонгуулийг санхүүжүүлж байгаа нь улс төрд байгаа эмэгтэйчүүд болон бага орлоготой эрэгтэй нэр дэвшигч сонгогдоход саад бэрхшээл болсоор байна”.⁴⁸ Энэ нь улс төрийн гараа тэгш бус байгааг, мөн нэгэнт парламентад эрэгтэйчүүд давамгайл байгаа тул дахин сонгогдох боломж, мөн эрэгтэйчүүдэд илүү байгааг харуулж байна. Түүнчлэн нам дотроо нэр дэвших эрх авах “нэр дэвшигчийн татвар” гэх өндөр босго тавьдаг. Энэ нь эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд ялгаварлал, бэрхшээл учруулж байна.⁴⁹

Сонгуулийн кампанит ажил явуулахад ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө шаардлагатай болох нь судалгаанаас харагдаж байна. Жишээ дурдахад, 2016 оны УИХ-ын сонгуульд ажиглалт хийсэн Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны

45 Мөн тэнд

46 Монголын Эмэгтэйчүүдийн Сан, “Орон нутгийн ИТХ-д нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийн чадавхийг үнэлэх нь” судалгааны тайлан”, 2012 он

47 Мэдээ. Мн “Э.Гэрэлт-од: Монгол Улсад нэг нам давамгайлсан улс төрийн тогтолцоо бүрдэж байна” (2021.03.25) <https://medee.mn/p/157682>

48 Р.Бурмаа, “Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо: Туршлага ба сургамж. Монгол Улс”, УБ хот, 2013 он

49 НҮБХХ, “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх нь” УБ хот, 2014 он

байгууллагын тайланд нэгэн жижиг намын даргын дурдсанаар нам нь нэр дэвшигч бүртээ 40 орчим сая төгрөг зарцуулсан гэжээ. Бусад намуудад илүү өндөр тооцоо гарсан мэдээлэл ирсэн бол зарим нэр дэвшигчид санхүүжилт байхгүйгээс сонгуулийн сурталчилгааг идэвхтэй явуулахгүй буйгаа хэлж байв.⁵⁰

2020 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшиж сонгогдсон гишүүдийн сонгуулийн зардлын тайланг нэг бүрчлэн гаргаж үзэхэд, УИХ-ын гишүүн Б.Саранчимэг, Н.Учрал, Б.Энхбаяр, Х.Булгантуяа нарынх 500 саяас дээш буюу хамгийн өндөр байсан бол Ж.Батсуурь, Н.Ганибал, С.Одонтуяа нар 100 гаруй сая төгрөг буюу хамгийн бага зардал гаргасан байна.⁵¹ Дээрхээс үзэхэд, жил ирэх тусам сонгуулийн зардал нэмэгдэж байгаа нь харагдаж байна. 2016 онд УИХ-ын сонгуульд нэр дэвшигч хамгийн багадаа 40 орчим сая төгрөгийн зардал гаргаж байсан бол 2020 оны УИХ-ын сонгуульд энэ хэмжээ 100 сая төгрөг болж, бараг 3 дахин нэмэгдсэн байна.

Мажоритар тогтолцоогоор зохион байгуулсан 2008 оны сонгуульд нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулахад 3.4 тэрбум, нэр дэвшигчийг сурталчлахад 1.8 тэрбум төгрөг зарцуулсан хэмээн мэдээлсэн. Харин холимог тогтолцоогоор зохион байгуулсан 2012 оны сонгуульд нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулахад 7.6 тэрбум, нэр дэвшигчийг сурталчлахад 15 тэрбум төгрөг тус тус зарцуулжээ. Энэхүү зардлын задаргаанаас харахад сонгуулийн мөрийн хөтөлбөрийг таниулах нэр дэвшигчийг сурталчлах, уулзалт, хурал цуглаан зохион байгуулахад 2008 онд 7.8 тэрбум зардлын ойролцоогоор 74.3 хувь нь, 2012 онд нийт 35.6 тэрбум зардлын 70.2 хувь нь тус тус зарцуулагджээ.⁵² Өөрөөр хэлбэл, сонгуулийн зардлын дийлэнх хэсэг нь иргэд, сонгогчдод мөрийн хөтөлбөрөө тайлбарлан таниулах, нэр дэвшигчийг сурталчлахад зарцуулагдаж байна гэсэн үг юм.

Хандив цуглуулах замаар мөнгө босгох нь эмэгтэйчүүдийн хувьд ярвигтай асуудал байдаг. Эрэгтэй улс төрчид бизнесийн хүрээнийхэнтэй нягт холбоотой байдаг учраас сонгуулийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх боломж нь өргөн байдаг. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бизнесийн томоохон байгууллагад эрэгтэйчүүд давамгайлж, харин жижиг, дунд үйлдвэрлэлийн 64 хувийг эмэгтэйчүүд эзэмшиж байна. Хувийн салбарт дунд түвшний менежерүүдийн 30 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байгаа бол дээд түвшний менежерүүдийн 15 хувь нь эмэгтэйчүүд байна.⁵³ МҮХАҮТ-аас шалгаруулсан ТОП 100 аж ахуйн нэгжийн 26 нь эмэгтэй удирдлагатай төдийгүй МҮХАҮТ-д бүртгэлтэй нийт компаниудын 10 хувь нь эмэгтэй захиралтай байна.⁵⁴ Энэ дурдагдсан тоо баримтаас үзэхэд, Монгол Улсын хувьд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн орлого, санхүүгийн чадамж тэгш бус байгаа нь улс төрд жендэрийн тэгш бус байдлыг арилгах буюу эмэгтэйчүүдийн оролцоо, манлайлал нэмэгдэхэд тээг болж байна.

50 ЕАБХАБ, “ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгуулийн ажиглах хорооны тайлан”, 2016 он

51 News Press “Д.Энхцэцэг: УИХ-ын 2020 оны сонгуулийн зардал хоёр дахин өссөн ч зарцуулалт нь тодорхойгүй байна” <https://newspress.mn/v1/%D0%AF%D1%80%D0%B8%D0%BB%D1%86%D0%BB%D0%B0%D0%B3%D0%B0/news/26022>

52 Мөн тэнд

53 IRIM “Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдал: (Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаа), УБ, 2014 он

54 Г.Батмандах “Залуу захирлууд ярьж байна” (2017.04.20) <https://news.mn/r/763325/>

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Монгол Улсад сонгосон сэдвийн хүрээнд хийсэн судалгаануудыг авч үзвэл, тоон болон чанарын судалгааны аргуудыг аль алиныг нь ашигласан байна. Судалгаанд хамрагдагсдын хувьд улс төрч эмэгтэйчүүдээс авсан ярилцлагын судалгаа зонхилж байгаа бол энд дурдагдсан тоон судалгаа нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлсийг сонгогчдоос буюу иргэдээс асууж тодорхойлсноороо онцлогтой.

Судлагдсан байдлын судалгаанаас үзэхэд *эрэгтэйчүүд давамгайлсан улс төрийн бүтэц, нэр дэвшиж өрсөлдсөн намын нэр хүнд, сонгуулийн сурталчилгаа явуулахад шаардлагатай хөрөнгө босгоход тулгардаг хүндрэл* зэрэг нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарладаг зүйлсээр нэрлэгджээ. Эндээс шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоонд хамгийн сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл нь улс төрийн санхүүжилт босгох явдал болж байна.

БҮЛЭГ 3. ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХЭД НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ СУВГУУДЫГ АШИГЛАХ НЬ

Нийгмийн сүлжээний сувгууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэх, нийгмийн амьдралд оролцох шинэ орон зайг бий болгож өгч байна. Тэдгээрээр дамжуулан улс төрчид өөрсдийгөө иргэдэд таниулах, улс төрийн хөтөлбөрөө сурталчлан мэдээлэх шинэ боломжтой болоод байгаа билээ. Эдгээр нь нийгмийн сүлжээний сувгуудын улс төрд авчирч буй эерэг талууд болж байна. Эерэг талуудын зэрэгцээ нийгмийн сүлжээний сувгуудтай холбоотой үүсдэг сул талууд бий.

Доор дурдах бүлэгт нийгмийн сүлжээний сувгуудын улс төрд үзүүлэх эерэг болон сөрөг нөлөөг тухай авч үзэхийн зэрэгцээ энэхүү мэдээллийн шинэ хэрэгсэл нь эмэгтэйчүүдийн оролцоог шийдвэр гаргах түвшин нэмэгдүүлэхэд хэрхэн нөлөөлж болоход дүн шинжилгээ хийж, асуулга судалгаанд тулгуурлан энэ чиглэлд Монгол Улсад бий болох боломжийг гаргаж ирэхийг эрмэлзлээ.

3.1. ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Нийгмийн сүлжээний сувгуудын ач холбогдол, гүйцэтгэх үүрэг цаг хугацаа өнгөрөхийн хэрээр өөрчлөгдөж, улс төрийн дискурс, мэдээлэл, оролцоонд нөлөөлөх чухал хэрэгсэл болоод байна.⁵⁵ Улс төрийн хэлэлцүүлэгт тогтмол оролцдог нийгмийн сүлжээ хэрэглэгчид нь улс төрийн зорилгоор нийгмийн сүлжээг тогтмол хэрэглэдэг байх нь түгээмэл байдаг.⁵⁶ Нийгмийн сүлжээний хэрэглээ нь хэрэглэгчийн санаа бодолд нөлөөлдөг болохыг өмнө нь хийгдсэн судалгаа нотолдог байна.⁵⁷ Нийгмийн сүлжээний үзүүлэх нөлөө нь зөвхөн сонгогчийн санал бодолд нөлөөлөхөөр хязгаарлагдахгүй, зарим тохиолдолд улс төрийн оролцоо, санал өгөхөд нь хүртэл нөлөөлөх нь бий.⁵⁸ Эсрэгээрээ, сонгогчдын тодорхой нэр дэвшигчдэд санал өгөхөд нөлөөлдөг цорын ганц хүчин зүйл нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл биш бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрэглэгчийн улс төрийн үзэл баримтлал, оролцоог өөрчлөхүйц хэмжээнд хүчтэй нөлөө үзүүлдэггүй хэмээн үзсэн судалгаанууд цөөнгүй бий.⁵⁹

Нийгмийн сүлжээний сувгууд нь үзэл бодлоо илэрхийлэх чухал хэрэгсэл төдийгүй ашиглахад хүртээмжтэй байдгаас ач холбогдол улам бүр өсч байна. Мэдээлэл авах, үзэл бодлоо илэрхийлэх, хэлэлцүүлэг өрнүүлэх талбараар хангадаг нь нийгмийн сүлжээний сувгуудын хамгийн гол давуу тал юм. Нийгмийн сүлжээний сувгууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг дэмждэг чухал хэрэгсэл гэдэгтэй маргахын аргагүй болоод байна. Уламжлалт мэдээллийн хэрэгслүүдээр үзэл бодлоо илэрхийлэхэд хүндрэлтэй тулгардаг байсан иргэд нийгмийн сүлжээний сувгуудуудаар дамжуулан үзэл бодол, итгэл үнэмшлээ илэрхийлэхийн зэрэгцээ

55 Bronstein, J., & Aharony, N. (2015). Personal and political elements of the use of social networking sites. *Information Research*, 20(1)

56 Rainie, L., Smith, A., Schlozman, L. K., Brady, H., & Verba, S. (2012). *Social Media and Political Engagement*. Pew Research Center's Internet & American Life Project. Washington, D.C. 20036

57 Gionis, A., Terzi, E., & Tsaparas, P. (2013). Opinion Maximization in Social Networks. In *SDM* (pp. 387-395)

58 Anwar, M., & Jan, M. (2010). Role of Media in Political Socialization: The Case of Pakistan. *Dialogue*, 5(3), 212- 27

59 Payne, A. (2009). *The New Campaign: Social Networking Sites in the 2008 Presidential Election*

фэйсбүүк, твиттер зэргээр улс төрд өөрийг нь төлөөлж буй хүмүүсийн талаарх байр сууриа чөлөөтэй хуваалцах боломжоор хангагдаж эхэлсэн. Ийнхүү үзэл бодлоо илэрхийлэх нь иргэдийн улс төрд оролцох оролцоонд эерэг нөлөө авчирч байна. Улс төрийн үзэл бодлоо илэрхийлэхэд нийгмийн сүлжээний хэрэгслүүдийг ашиглах нь улс төрийн оролцоог нэмэгдүүлдэг болохыг судалгаанууд⁶⁰ харуулаад байна.⁶¹

Нийгмийн сүлжээний сувгууд бий болсонтой холбогдуулан иргэдийн улс төрийн оролцоог цахим болон цахим бус хэлбэртэй байж болно хэмээн үзэх болсон. Цахимаар улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх хийгээд улс төрийн оролцооны хоорондын хамаарлын талаар хийгдсэн судалгаануудаас^{62,63} үзэхэд энэ хоёрын хооронд эерэг хамаарал байгаа нь тогтоогдсон. Түүнчлэн, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэхэд нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглах нь цахим болон цахим бус улс төрийн оролцоо аль аль нь нэмэгдэхэд нөлөөлдөг нь судалгаанаас харагдсан.^{64,65}

Зарим орнуудын жишээг дурдвал, Сингапурт уламжлалт хэвлэл мэдээллийн орчин хязгаарлалттай байдгаас олон нийт болон идэвхтнүүд цахим болон цахим бус байдлаар улс төрийн оролцоогоо илэрхийлэх нь түгээмэл болсон.⁶⁶ Малайзид хэвлэл мэдээллийн хэрэгслүүд тэгш хүртээмжтэй бус байдгаас үзэл бодлоо илэрхийлэх боломж хязгаарлагдмал учраас сөрөг хүчний намууд нийгмийн сүлжээний сувгуудаар дамжуулан олон нийтийн дэмжлэгийг цуглуулж байгаа⁶⁷ төдийгүй нийгмийн сүлжээ нь сонгогчдод нөлөөлж байгааг судалгаанууд харуулж байна.⁶⁸

Нөгөө талаар, сошиал медиа хэрэглээ нь цахим бус буюу уламжлалт улс төрийн оролцоонд нөлөөлдөг эсэх талаар судлаачдын дунд хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнөсөөр байна.⁶⁹ АНУ-ын судалгааны байгууллага Пью судалгааны төвийн судалгаанаас үзэхэд, фэйсбүүкийг тогтмол бус хэрэглэгчидтэй харьцуулахад тогтмол

60 Vaccari, C., Valeriani, A., Barbera, P., Bonneau, R., Jost, J. T., Nagler, J., & Tucker, J. A. (2015). Political expression and action on social media: Exploring the relationship between lower- and higher-threshold political activities among Twitter users in Italy. *Journal of Computer-Mediated Communication*, 20, 221-239

61 Zhang, X., & Lin, W.-Y. (2014). Political participation in an unlikely place: How individuals engage in politics through social networking. *International Journal of Communication*, 8, 21-42

62 Bode, L., Vraga, E. K., Borah, P., Shah, V. D. (2014). A New Space for Political Behavior: Political Social Networking and its Democratic Consequences. *Journal of Computer-Mediated Communication*

63 Hsieh, Y., & Li, M. (2014) Online political participation, civic talk, and media multiplexity: How Taiwanese citizens express political opinions on the Web. *Information, Communication & Society*, 17, 26-44

64 Holt, K., Shehata, A., Stromback, J., & Ljungberg, E. (2013). Age and the effects of news media attention and social media use on political interest and participation: Do social media function as leveller? *European Journal of Communication*, 28, 19-34

65 Tang, G., & Lee, F. F. (2013). Facebook use and political participation: The impact of exposure to shared political information, connections with public political actors, and network structural heterogeneity. *Social Science Computer Review*, 31, 763-773

66 Skoric, M. M., Pan, J., & Poor, N. D. (2012, May). Social Media and Citizen Engagement in a City-State: A Study of Singapore. In Sixth International AAAI Conference on Weblogs and Social Media

67 Smeltzer, S., & Keddy, D. (2010). Won't you be my (political) friend? The changing face (book) of sociopolitical contestation in Malaysia. *Canadian Journal of Development Studies/Revue canadienne d'études du développement*, 30(3-4), 421-440

68 Muhamad, R. (2015). Online Opposition and Elections in Malaysia. *Asian Social Science*, 11(10), 281

69 Hyun, K. D., & Kim, J. (2015) Differential and interactive influences on political participation by different types of news activities and political conversation through social media. *Computers in Human Behavior*, 45, 328

хэрэглэгчдийн улс төрд оролцох магадлал нь өндөр байдаг.⁷⁰ Нас,⁷¹ хүйс⁷² зэрэг хүн ам зүйн хүчин зүйлс нь цахим болон цахим бус улс төрийн оролцоонд нөлөөлдөг болохыг тодорхой судалгаанууд харуулж байна.

Хэвлэл мэдээллээр мэдээлэл түгээхэд мэдээллийн найдвартай байдлын асуудал маш чухлаар тавигддаг. Уламжлалт хэвлэл мэдээлэлд сэтгүүлзүйгээр мэргэшсэн ажилтнууд ажиллаж, мэдээллийг нийтлэхийн өмнө хянаж нягтлах редакцтай байдаг учраас мэдээлэл нь харьцангуй найдвартай.⁷³ Нийгмийн сүлжээний сувгуудаар нийтлэгдэж буй мэдээ, мэдээллийн найдвартай байдал тулгамдсан асуудал болж байна. Нийгмийн сүлжээний сувгууд нь мэдээллийн урсгалыг хэт хурдсаж, хэт их мэдээ шүүлтүүргүйгээр цацагдах болсоноор нийгэмд олон төрлийн үл ойлголцлыг үүсгэх болсон хэмээн шүүмжлэх хэсэг ч байна. Тиймээс судлаачид олон нийтийн оролцоог сайжруулах, харилцаа холбоог илүү үр дүнтэй болгоход нийгмийн сүлжээний сувгуудад тавигдаж буй мэдээллийн найдвартай байдлыг чухлаар авч үзэх ёстой хэмээн үзжээ.⁷⁴

Өнөөгийн дэлхий ертөнцөд улс төрийн намууд, нэр дэвшигчид сонгогчдыг ятган үнэмшүүлэхэд нийгмийн сүлжээний гүйцэтгэх үүргийг үнэлэх болсон.⁷⁵ Сүүлийн жилүүдэд улс төрчид олон нийттэй харилцах, үзэл бодлоо илэрхийлэх, бусдад нөлөөлөх зорилгоор нийгмийн сүлжээний сувгуудыг идэвхтэй ашиглаж байна. Улс төрчид олон нийт, ялангуяа залуучуудад мэдээлэл хүргэх зорилгоор нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглах болсноор улс төрийн кампанит ажил явуулах тактикт ихээхэн өөрчлөлт гараад байна. Нийгмийн сүлжээ нь сонгогчид, бусад улс төрчид, улс төрийн сэтгүүлчдийн анхаарлыг татахын зэрэгцээ олон нийтийг дэмжлэгийг хүртэх боломжийг олгодог олон талт арга хэрэгсэл юм.

АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обамагийн 2008 оны сонгуульд ялалт байгуулахад нөлөөлсөн нэг зүйл нь шинэ хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглаж чадсан явдал байв. 2008 оны сонгуулийн кампанит ажлын үеэр Америкийн интернет хэрэглэгчдийн 74 орчим хувь сонгуультай холбоотой мэдээ, мэдээллийг онлайн байдлаар хүлээн авч байсан нь тус улсын насанд хүрсэн хүн амын 55 хувийг төлөөлж байсныг Пью судалгааны төв дурдсан байдаг.⁷⁶ Харин АНУ-ын ерөнхийлөгчийн 2012 оны сонгуульд нийгмийн сүлжээний сувгууд улс төрийн оролцооны индэр болж, Ерөнхийлөгч Обама залуучуудыг дахин өөрийн талдаа татсан. Үүнээс хойш улс төрчдийн ихэнх нь сонгуулийн кампанит ажлынхаа тактикаа

70 Hampton, N. K., Goulet, S. L., Rainie, L., Purcell, K. (2011) Social networking sites and our lives: How people's trust, personal relationships, and civic and political involvement are connected to their use of social networking sites and other technologies. Pew Research Center's Internet & American Life Project. Washington, D.C. 20036

71 Smith, M. A., Shneiderman, B., Milic-Frayling, N., Mendes Rodrigues, E., Barash, V., Dunne, C., & Gleave, E. (2009) Analyzing (social media) networks with NodeXL. In Proceedings of the fourth international conference on Communities and technologies (pp. 255- 264). ACM

72 Wen, N., Xiaoming, H. A. O., & George, C. (2013). Gender and political participation: News consumption, political efficacy and interpersonal communication. *Asian Journal of Women's Studies*, 19(4), 124-149

73 Adeyanju, A. (2015). Comparative Study of Social Media, Television and Newspapers' News Credibility, International Conference on Communication, Media, Technology and Design

74 Kang, M. (2010). Measuring social media credibility: A study on a Measure of Blog Credibility. Institute for Public Relations, 59-68

75 Acar, E. (2012). Social Media June 12 general elections, Edibe Sozen (Ed.), We globalize all local, İstanbul: Alfa Publications, 259-274

76 Aaron Smith, Pew Research Center "The Internet's Role in Campaign 2008" (April 15, 2009) <https://www.pewresearch.org/internet/2009/04/15/the-internets-role-in-campaign-2008/>

боловсруулахдаа нийгмийн сүлжээний сувгуудын гүйцэтгэх үүргийг харгалзан үздэг болж, тэдний хувьд фэйсбүүк, твиттер нь улс төрийн коммуникацийн чухал хэрэгсэл болов. АНУ-ын нэгэн адилаар, бусад оронд улс төрчид твиттер, фэйсбүүкийг улс төрийн үйл ажиллагаандаа ашиглах нь нэмэгдэж байна. Үүнд Швед, Финланд, Их Британи, Итали, Норвеги, Энэтхэг, Пакистан болон бусад орныг дурдаж болно.

Нийгмийн сүлжээний сувгуудын хэрэглэгчдийн дийлэнх хэсэг нь залуучууд байдаг учраас залуучуудыг татах, нөлөөлөх зорилгоор улс төрийн намууд өөрийн сошиал медиа аккаунтуудтай болж, ололт амжилт, бодлого, мөрийн хөтөлбөр, үйл ажиллагаа зэргээ нээлттэй мэдээлдэг болж байна. Үр дүнд нь, сонгогчид фэйсбүүк, твиттер зэрэг нийгмийн сүлжээний сувгуудад хандвал, ихэнх улс төрийн нам, улс төрчдийн пейж, группыг харах боломжтой болсон бөгөөд тэд улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, сонгогчдод сэтгэгдэл үлдээх зорилгоор нийгмийн сүлжээнд идэвхтэй ажилладаг. Зарим тохиолдолд зөвхөн улс төрчид төдийгүй иргэдийн улс төрчидтэй шууд харилцах зорилгоор нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглах нь бий.

Интернэт, мэдээллийн технологи, нийгмийн сүлжээний сувгууд олон давуу талтай. Үүний зэрэгцээ нийгмийн сүлжээний сувгуудтай холбоотой үүсдэг сөрөг талууд цөөнгүй байна. Тухайлбал, нийгмийн сүлжээний сувгуудын хэрэглээ өсч байгаатай холбогдуулан эмэгтэй улс төрчдийн эсрэг үйлдэгдэх цахим хүчирхийлэл нэмэгдэж байна. НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын талаарх 65 дугаар комиссын хурлын үеэр эмэгтэй улс төрчдийн эсрэг үйлдэгдэж буй цахим хүчирхийлэл нь эмэгтэйчүүдийн нийгмийн амьдралын бүхий л салбарт тэгш оролцох эрхээ хэрэгжүүлэхэд саад тогтгор учруулж байгаад оролцогчид ихээхэн санаа зовниж байгаагаа илэрхийлсэн.⁷⁷

Дэлхийн өнцөг булан бүрд улс төрд оролцож буй эмэгтэйчүүд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр онлайн хүчирхийлэл, дарамт, хүйсээр ялгаварлан гадуурхлын бай болох нь түгээмэл байна. Жишээлбэл, 2020 оны АНУ-ын Конгрессын сонгуулийн үеэр хийсэн дүн шинжилгээ нь эмэгтэй нэр дэвшигчид эрэгтэйчүүдээс илүүтэй онлайн хүчирхийлэлд өртөх магадлал өндөр байгааг тогтоосон. Ардчилсан намаас нэр дэвшиж буй эмэгтэйчүүд фэйсбүүк дээр тус намаас нэр дэвшсэн эрэгтэйчүүдээс 10 дахин илүүтэй доромжилсон сэтгэгдлүүдийг авсан.

Энэтхэг, Их Британи, Украин, Зимбабве зэрэг орнуудад ижил төстэй хандлагууд ажиглагджээ.⁷⁸ Тухайлбал, олон улсын хүний эрхийн байгууллага болох Эмнести Интернэшнл Их Британийн 2017 оны парламентын ээлжит сонгуулийн өмнө твиттерт идэвхтэй байдаг 177 парламентын эмэгтэй гишүүний талаарх жиргээнд дүн шинжилгээ хийсэн байна. Тус судалгаанаас үзэхэд, цагаан арьстай эмэгтэйчүүдтэй харьцуулахад хар арьстай, ази гаралтай үндэстний цөөнх, парламентын эмэгтэй гишүүд онлайн хүчирхийлэлд илүүтэй өртдөг болох нь харагджээ. Судалгаанд

77 MSMagazine “How Digital Media is Threatening Women’s Rights and Democracy” (November 31, 2021) <https://msmagazine.com/2021/11/30/social-media-bullying-trolls-online-abuse-harassment-womens-rights-democracy/>

78 Carnegie Endowment for International Peace “Tackling Online Abuse and Disinformation Targeting Women in Politics” (November 30, 2020) <https://carnegieendowment.org/2020/11/30/tackling-online-abuse-and-disinformation-targeting-women-in-politics-pub-83331>

хамрагдсан цагаан арьстай парламентын гишүүд цөөнхийн төлөөлөл болсон эмэгтэйчүүдтэй харьцуулахад 8 дахин олон байсан боловч хар арьстай, ази гаралтай үндэстний цөөнх, парламентын эмэгтэй гишүүд нь доромжилсон утга агуулга бүхий жиргээний бараг тал хувь (41 хувь)-ийг хүлээн авсан байна.⁷⁹ Аль улс төрийн нам байх, тухайн улс төрч нь хэн байхаас хамаарч онлайн хүчирхийллийн түвшин өөр, өөр байх боломжтой боловч парламентын эмэгтэй гишүүдийн хувьд эдгээрээс үл хамааран цахим халдлагаас ангид байж чадахгүй байна. Цахим халдлагад хамгийн их өртсөн 5 парламентын эмэгтэй гишүүний 3 нь Лейбор намынх, 1 нь Консерватив намынх, 1 нь Шотландын Үндэсний намынх байсан байна.⁸⁰

Нийгмийн сүлжээн дэх дайралт, доромжлол нь олон нийтийн мэтгэлцээн, хэлэлцүүлэгт оролцох, улс төрийн үзэл бодол, байр сууриа олон нийтэд нээлттэй илэрхийлэх гэсэн эмэгтэй улс төрчдийн хүсэл эрмэлзлийг мохоох болов.⁸¹ 2020 онд хийгдсэн судалгаанаас үзэхэд, улс төр дэх эмэгтэйчүүд нэр дэвших эрхээ авч, сонгуулийн кампанит ажлаа явуулах явцдаа онлайн хүчирхийлэл, дарамтад өртдөг болох нь харагдсан байна.⁸²

Дэлхий дахиныг хамарсан цар тахлын нөлөөгөөр олон орны парламент зайнаас болон хосолсон байдлаар нэгдсэн болон хороодын хуралдаанаа зохион байгуулж, санал хураалтаа явуулахын зэрэгцээ төрийн хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлж, олон нийтийн оролцоог бий болгох замаар үйл ажиллагаагаа шинэ хэлбэрээр явуулах буюу цар хүрээг нь багасгасан. Цахим технологийг ашиглах нь улс төрийн үйл ажиллагаанд биечлэн оролцоход гэр бүлийн гишүүдээ асрамжлах үүрэг хүлээсэн болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд тулгардаг зарим төрлийн бодит саад бэрхшээлийг хөнгөвчлөхөд дөхөм үзүүлснийг энд дурдах хэрэгтэй.⁸³

79 Amnesty International UK “Black and Asian women MPs abused more online” <https://www.amnesty.org.uk/online-violence-women-mps>

80 Мөн тэнд

81 IKNOWPOLITICS “Summary of the discussion on online violence against women in politics” (November 2020) https://www.iknowpolitics.org/sites/default/files/summary_e-discussion_on_online_vawp.pdf

82 Inter-parliamentary union “Women in parliament in 2020” The year in review https://www.iknowpolitics.org/sites/default/files/2020-women_in_parliament_en.pdf

83 AntónioGuterres “Remarks at the Opening of the 65th Session of the Commission on the Status of Women” (21 March, 2022) <https://www.un.org/sg/en/content/sg/speeches/2021-03-15/remarks-opening-of-65th-session-of-csw>

Шигтгээ 1. Эмэгтэй улс төрчдийн хувьд сошиал медиа бол хоёр талдаа иртэй “илд”

Вашингтон хотод байрладаг тинк танк хүрээлэнгийн саяхан гаргасан судалгаанаас үзэхэд, АНУ болон бусад улсын алинд ч сонгуульт ажил эрхэлж байгаа эсвэл эрхлэхийг зорьж буй эмэгтэйчүүд имиджээ өсгөх, бусдад хүргэх гэсэн мессежээ илүү мэдрэмжтэй, цензурт баригдаагүй байдлаар дамжуулах зорилгоор уламжлалт мэдээллийг хэрэгслийг тойрч нийгмийн сүлжээнд тулгуурлах нь нэмэгдэж байна.

Вильсоны төв гэх судалгааны байгууллагын Дэлхийн эмэгтэйчүүдийн манлайллын санаачилга судалгааны судлаач Люсина Ди Мекогийн хэлснээр, нийгмийн сүлжээний сувгууд эмэгтэй манлайлагчдад сонгогчидтой шууд холбогдох боломжийг олгож, өнгөрсөн хугацаанд бидний харж ирсэн урьдчилан бэлдсэн имиджээс давж, илүү дахин давтагдашгүй, өөрийнхөөрөө байх нөхцөлийг бүрдүүлж байна. 33 орны 88 эмэгтэй манлайлагчидтай хийсэн ярилцлагад тулгуурласан Люсина Ди Мекогийн судалгаанаас харахад, хэдийгээр сошиал медиа орчин нэлээд хортой нөлөөтэй боловч эмэгтэй улс төрчид онлайн дэмжигчдийн хүчтэй сүлжээ бий болгох замаар улс төрийн амбицаа дэмжүүлэхийн тулд твиттер, фэйсбүүкийн аль алиныг ашиглах нь түгээмэл болж байна.

Нийгмийн сүлжээний сувгуудаар дамжуулан мессежээ хүргэх нь хүмүүсийн санаа бодолд нөлөөлөх боломжтой нэлээд итгэлтэй арга зам юм. Уламжлалт хэвлэл мэдээлэлд эмэгтэйчүүдийн байр суурь сул байгаа энэ үед нийгмийн сүлжээ ихээхэн хүчтэй тэнцвэржүүлэгч болох боловч нийгмийн сүлжээний сувгуудаар мессежээ амжилттай хүргэх эсэх нь тэдний нийгмийн сүлжээн дэх ур чадвараас ихээхэн хамаарна. Нийгмийн сүлжээг үр дүнтэй, дахин давтагдашгүй байдлаар хэрэглэдэг нэр дэвшигч нь илүү хүчтэй, илүү сайн мессеж хүргэх боломжтой.

Шууд онлайн харилцах олон давуу тал байгаа боловч өргөн хүрээнд олон нийтэд хандах нь хоёр талтай болохыг Дэлхийн эмэгтэйчүүдийн манлайллын судалгаа харуулж байна. Твиттерт эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүд хүчирхийлэл дайралтын бай болох нь их төдийгүй шүүмжлэлийн мөн чанар нь өөр байгааг Ди Мекогийн удирдсан судалгаа харуулав. “Жишээ нь, твиттерт өрнөж байгаа ярианууд нь эмэгтэй улс төрчдийн дэвшүүлж буй бодлого гэхээс илүү тэдний хувийн зан чанарын талаар байдаг” хэмээн Ди Меко хэлсэн бөгөөд эмэгтэйчүүд хуурамч аккаунтуудын бай болох илүү магадлалтайг нэмж хэлжээ.

Кампанит ажлаа эхлэхээс өмнө хуурамч аккаунтуудыг илрүүлэх, ажилтнуудаа дижитал технологид сургах зэргээр онлайн хүчирхийлэл заналхийлэлд хариу үйлдэл үзүүлэх стратегитай болох хэрэгтэйг бүх нэр дэвшигч, түүн дотор эмэгтэйчүүдэд хандан зөвлөж байна.

Өмнө нь Твиттер компанид улс төрийн болон бодлогод нөлөөлөх асуудал хариуцсан борлуулалтын хэлтсийг удирдаж байсан улс төрийн зөвлөх Женна Голден нэр дэвшигчид тэвчихийн аргагүй хор нөлөө бүхий онлайн орчинтой нүүр тулсан ч гэлээ улс төрийн тавцанг орхих нь шийдэл биш гэдгийг зөвлөж байна.

Ди Мекогийн тайлангийн өөр нэг чухал үр дүн нь эмэгтэйчүүдийн кампанит ажлын хүрээнд ирсэн хүчирхийлэл заналхийлэлд үр дүнтэй хариу өгөх чадвар нь улам сайжирч байна. Өмнө нь эмэгтэй нэр дэвшигчдэд “өндөр ёс суртахуунтай байж хариу дайралт хийхгүй байх”, сексист дайралтыг үл тоох хэрэгтэй хэмээн зөвлөдөг байсан бол онлайн эсвэл кампанит ажил явуулж байгааг үл харгалзан эмэгтэйчүүд шүүмжлэл хэлж, хүчирхийлэл заналхийлэлд хариу өгөх байдлаар олонд танигдах байдлаа нэмэгдүүлэх боломжтой хэмээн сүүлийн үед зөвлөх болов.

Эх сурвалж:VOA News

Нөгөөтэйгүүр, цар тахлын улмаас парламентын үйл ажиллагаанд виртуаль байдлаар оролцох шаардлагатай болсон нь улс төрийн эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг улам бэхжүүлсэн. Тодруулбал, парламентын хуралдаанд биечлэн оролцогчдын дийлэнх нь эрэгтэй гишүүд байж, харин эмэгтэйчүүд гол төлөв виртуаль байдлаар оролцож байсан нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны харагдах байдал, нөлөөг бууруулах болсон. Үүнтэй адилаар, цар тахлын үед улс

төрийн кампанит ажлыг биечлэн явуулахад хязгаарлалт тавьж байсан нь элит болон элит бус эмэгтэйчүүдийн хоорондын ялгааг улам гүнзгийрүүлж,⁸⁴ аль хэдийн улс төрийн хэлхээ холбоо, нөөц бий болгож, олонд танигдсан эмэгтэйчүүдэд давуу талыг бий болгож байв.

Цар тахалтай тэмцсэн сүүлийн хоёр жилийн хугацаанд дэлхийн эмэгтэй удирдагчид дэлхий нийтийг хамарсан энэхүү хямралтай үр дүнтэй тэмцсэн хэмээн үнэлэгдэж байсан боловч эмэгтэй улс төрчид ихэнх тохиолдолд асуудлын гадна үлдэж байв. Сонгогдсон эмэгтэй албан тушаалтан, нэр дэвшигчид болон эмэгтэй сонгогчид ковид-19 цар тахалд илүүтэй өртөж, жендэрийн тэгш байдлыг арилгахад олсон амжилтууд ухралтанд орж, эмэгтэйчүүдэд тулгардаг хориг саадыг улам бэхжүүлээд байна.⁸⁵

Гэвч социал медиагийн бий болгож буй эерэг нөлөөллийг дутуу үнэлж болохгүй юм. Эмэгтэйчүүдэд олгогдсон нөөц хязгаарлагдмал байдаг нь тэднийг бүтээлчээр ажиллаж, хямд боловч бусадтай өрсөлдөхүйц кампанит ажил явуулах арга замыг эрэлхийлэхэд хүргэдэг. Тэдэнд сонгуулийн мөрийн хөтөлбөрөө илүү олон сонгогчдод хүргэхэд нийгмийн сүлжээний сувгууд эерэг өөрчлөлтийг авчирч байна. Тухайлбал, эмэгтэй улс төрчдийн хувьд онлайн болон нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглан сонгуулийн ажилдаа зориулан хөрөнгө босгох боломж нээгдэж байна. Онлайнгаар хөрөнгө босгох буюу “crowd funding” нь улс төрийн кампанит ажилд зориулан хөрөнгө босгох харьцангуй шинэ хэрэгсэл бөгөөд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын дунд энэ нь улам бүр түгээмэл болж байна.

Эмэгтэй нэр дэвшигчид социал медиа, интернет болон мобайл технологийг ашиглах замаар зээл авах, гэр бүлээсээ мөнгө хөрөнгөний туслалцаа хүсэх гэх мэт санхүүтэй холбоотой шахалт дарамтаас зайлсхийж, сонгуулийн сурталчилгаанд шаардлагатай санхүүжилтээ цуглуулахын зэрэгцээ сонгогч, дэмжигчидтэй заавал нүүр тулан уулзах шаардлагагүй болсноор тээврийн болон бусад зардлыг хэмнэх боломжтой болсон. Сонгуулийн кампанит ажилдаа зориулан хандив цуглуулах юмуу эсвэл гар утасны төлбөр төлөх технологийг ашиглах нь эмэгтэй нэр дэвшигчдэд багахан хэмжээтэй хандивыг хурдан бөгөөд хялбар цуглуулах нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ технологи нь АНУ-ын 2012 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын санхүүжилт босгох үйл явцад эргэлтийн шинжтэй өөрчлөлтийг авчирсан бөгөөд нэр дэвшигч Барак Обамагийн сонгуулийн кампанит ажил нийт цуглуулсан хөрөнгийнхөө 41 хувийг иргэдийн хандивласан бага хэмжээтэй хандиваар бүрдүүлжээ.

Цаг хугацаа хэмнэсэн технологиуд (жишээ нь: Mail Merge) кампанит ажлынхаа явцын талаар мэдээлэл өгөх юмуу эсвэл хандив хүсэх боломжтой дэмжигчдийнхээ жагсаалтыг нэгтгэн гаргах боломжийг олгохын зэрэгцээ дэмжигчид рүүгээ хувьчилсан цахим шуудан илгээх технологийн нөхцөлийг бүрдүүлдэг.

84 Inter-parliamentary union “Women in parliament in 2020” The year in review https://www.iknowpolitics.org/sites/default/files/2020-women_in_parliament_en.pdf

85 Institute for Democracy and Electoral Assistance “The Impact of the COVID-19 Pandemic on Women in Politics” (21 March - 11 April 2022) <https://www.idea.int/news-media/events/impact-covid-19-pandemic-women-politics>

Шигтгээ 2. Сонгуулийн кампанит ажилд хөрөнгө босгоход онлайн болон мобайль технологийг ашиглах нь

Их Британи: 2015 оны парламентын сонгуулийн үеэр Лэйбор намын зүгээс намд нь хандив өгөх сонирхолтой хүмүүс click дарж, бага хэмжээний хандив (5, 10, 20 фунт гэх мэтээр) өгөхийг намынхаа дэмжигчдэд уриалах зорилготой имэйл явуулах замаар онлайнгаар хөрөнгө босгох драйвыг ажиллуулсан. Намынхаа нэр хүнд бүхий гишүүд рүүгээ нэрээр нь хандаж имэйл явуулжээ.

Fundly: Энэ нь тодорхой үйл ажиллагаа, төсөл юмуу эсвэл кампанит ажилд зориулан хөрөнгө босгоход ашигладаг “crowd funding”-ийн платформ юм. Fundly нь аль ч хүний сошиал медиа аккаунттай холбогддог бөгөөд төрийн бус байгууллага, бизнесийн жижиг байгууллага, хувь хүмүүс, түүний улс төрийн сонгуульд нэр дэвшигчид хөрөнгө босгох зорилгоор ашигладаг. Тус платформ нь фото зураг, видео постлох, хандивлагчиддаа имэйл явуулах, цаг үеийн мэдээлэл илгээх боломжийг хэрэглэгчиддээ олгохын зэрэгцээ кампанит ажил удирддаг хүмүүс гар утас бровзерээрээ хандивын мэдээлээ цаг тухайд нь шалгах нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Дэлхийн даяар Fundly-ийн хэрэглэгчид 34 тэрбум ам.долларын хөрөнгө босгосны 25 тэрбум нь харилцан бие биедээ эзэлдүүлэх үйлчилгээнээс хөрөнгө босгожээ.

Crowdpac: Энэ нь улс төрийн сонгуульд нэр дэвшигчид, нийгмийн байгууллагууд хөрөнгө босгоход зориулсан, нээлттэй платформ юм. Тус цахим хуудас нь хэрэглэгчиддээ зориулан “болзолт кампанит ажил” болон “шууд кампанит ажил” гэсэн хоёр төрлийн аль нэгээр нь хандив цуглуулах хүсэлтийн загварыг санал болгодог. Боломжит нэр дэвшигчид нэр дэвшихээ баталгаажуулах хүртэл “Start Running” хуудсаар дамжуулан дэмжихээ амласан хүмүүсийн амлалтуудыг бодит мөнгө хөрөнгө болгох боломжтой эсэхээ мэдэх боломжтой. Цахим хуудсыг нь татаж авч суурилуулахад үнэ төлбөргүй бөгөөд хэрэглэгчид нь хандивлагчийн хандивыг 100 хувь хүлээн авах боловч хандивлагч тал нь кредит картнаасаа бага хэмжээний хураамж (30 цент гэх мэт)-ийг төлөх юмуу эсвэл Crowdpac үйлчилгээнд сонголтоор хураамж төлөх боломжтой. 2018 оны завсрын сонгуулийн үеэр АНУ-д энэ цахим хуудсыг өргөнөөр ашигласан.

Square: Тус компани нь соронзон уншигч (iPads-д холбох боломжтой)-аар үнэгүй хангадаг бөгөөд татаж авах боломжтой аппликейшн (Square Point of Sale) нь шууд болон хаяггүйгээр шилжүүлэгхүлээн авах боломжийг олгодог. Жижиг бизнес эрхлэгчдийн ашигладаг энэхүү тогтолцоо нь арга хэрэгсэл, технологийн хувьд кампанит ажилд зориулан нэг удаагийн хандивыг хялбархан цуглуулах нөхцөлийг бүрдүүлсэн. Энэ аппликейшныг ашиглахад хэрэглэгчээс гарах зардал нь бага (шилжүүлэг тутмын 2.75 хувийг шимтгэл болгон авдаг) бөгөөд сар тутам эсвэл урт хугацаанд төлбөр төлөх шаардлагагүй юм.

Эх сурвалж:OECD⁸⁶

Нийгмийн сүлжээний сувгууд өргөн тархаж, түгээмэл хэрэглэгдэх болсон нь хүмүүсийн хоорондоо харилцах, мэдээлэл хуваалцах арга замуудыг огцом өөрчилсөн. Мэдээлийн технологийн салбарт гарсан өөрчлөлт нь сонгуулийн үйл явцад томоохон нөлөө үзүүлж, иргэд, сонгогчдын мэдээлэл олж авахад хэрэглэдэг сувгуудыг өөрчлөхийн зэрэгцээ улс төрчид сонгогчдод мөрийн хөтөлбөр болон үзэл бодлоо танилцуулахдаа нийгмийн сүлжээний сувгуудыг өргөн хэрэглэх болов.

Нийгмийн сүлжээний сувгууд нь өртөг багатай, хувийн санаачилга голлох үүрэг гүйцэтгэдэг учраас улс төрийн өрсөлдөөнд сул оролцдог эмэгтэй парламентын гишүүдэд тэнцвэржүүлэгчийн үүрэг гүйцэтгэдэг нь улс төрд оролцох эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх боломжтой хэмээн үзэж байна. Европын парламентын 2013 оны судалгаанд дурдснаар, мэдээллийн шинэ хэрэгслүүд нь эмэгтэйчүүдийг

86 OECD “Women’s Political Participation in Jordan” OECD, 2018 <https://www.oecd.org/mena/governance/womens-political-participation-in-jordan.pdf>

эрх мэдэлжүүлэхэд эерэг нөлөө үзүүлж, бусад эмэгтэйчүүдтэй хэлхээ холбоо тогтоох, өөртөө итгэх итгэл олж авах, сонгогчидтой шууд холбогдох, сонирхолтой асуудлуудаар эмэгтэйчүүд болон үе тэнгийнхнийгээ уриалах, улс төрчдийн сонирхол төрүүлэх эрх мэдлийн альтернатив үндсийг тавьсан байна. Онлайн улс төрийн харилцаа холбоо, ялангуяа нийгмийн сүлжээгээр дамжуулан холбогдох нь улс төрчид өөрсдийн хүргэх гэж буй мессеждээ хяналт тавих боломжийг олгож байна. Нөгөөтэйгүүр, улс төрийн намын аппаратад оролцоо багатай эмэгтэйчүүдийн сонгогдох боломжийг нэмэгдүүлж байна.

Шигтгээ 3. Сельфи улс төрийн кампанит ажлын стратеги болох нь

АНУ-ын Ерөнхийлөгчийн 2020 оны сонгуульд нэр дэвшигчдийн дотроос Элизабет Уаррен ганцаараа сельфи авсан улс төрч биш боловч Массачусетс мужийн сенатор болох түүний хувьд сельфидэх нь кампанит ажлынх нь чухал хэсэг болж, үүгээрээ бусад нэр дэвшигчээс ялгагдаж байсан юм. Э.Уаррены кампанит ажлынхны хэлснээр, 6 сарын өмнө кампанит ажлаа эхлүүлснээс хойш тэрээр хотын захиргааны танхим болон бусад үйл ажиллагааны үеэр аль хэдийн 35 мянган сельфи авахуулсан байна.

Ухаалаг утас, Фэйсбүүк, Инстаграмын эрин үед нэр дэвшигч сельфи авахуулах нь улс төрчдийн хувьд бараг “заавал” шаардлагатай зүйл болоод байна. Сельфидэх нь сонгогчидтойгоо харилцах нэг арга зам болсон.

Харин Э.Уаррены хувьд кампанит ажилдаа өөрийнх нь “сельфиний” цуваа гэж нэрлэсэн хүмүүстэй зураг авахуулах үйл ажиллагааг ашигладаг бөгөөд өрсөлдөгчдөөсөө ялгаатай нь энэ үйл ажиллагааныхаа үеэр сельфидэх гэсэн хүмүүсийн утсыг туслахууддаа өгч, зургийг нь авч өгч байв. Түүний хэлснээр, сельфиний цуваагаар дамжуулан, сонгогчид юунд санаа зовниж байгааг богино хугацаанд ч гэсэн сонсч авдаг байна. Хамтдаа авахуулсан зургаа хадгалж болдог болохоор зураг авахуулах мөч нь хувийн харилцаа тогтооход чухал ач холбогдолтой байдаг байна.

Эх сурвалж: USA Today

3.2. МОНГОЛ УЛСАД ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХЭД НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ СУВГУУДЫН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Монголчуудын цахим хэрэглээ

Монгол Улс 3.4 сая хүн амтай.⁸⁷ Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Үндэсний статистикийн хороотой хамтран “Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээний судалгаа”-гаас үзэхэд, Монгол Улсын 335 сум, суурин газарт өндөр хурдны интернэт сүлжээ орсноор нийт өрхийн 80 хувь нь интернэт хэрэглэж байна.

Мөн үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо жил бүр өсөн нэмэгдэж, 2021 оны байдлаар нийт иргэдийн 97.6 хувь нь гар утас хэрэглэж, үүнээс ухаалаг гар утасны хэрэглээ 84.7 хувьд хүрсэн. Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 98

⁸⁷ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан “Монгол Улсын хүн амын тоо” https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSQ_0300_003V1&SEX_select_all=0&SEXSingleSelect=_1&AGE_GROUP5_select_all=0&AGE_GROUP5SingleSelect=_1&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2021&viewtype=table

хувь нь үүрэн утас, үүнээс 90.4 хувь нь ухаалаг утас сүүлийн гурван сард хэрэглэсэн байна.⁸⁸ Үүнээс үзэхэд, монголчууд интернетэд холбогдон мэдээ, мэдээлэл авах боломж зохих хэмжээнд хангагдсан хэмээн дүгнэж болохоор байна.

“Хүн ам, орон сууцны 2022 оны тооллого”-оор 6 болон түүнээс дээш хүн амын 49 хувь буюу 1338.6 мянга нь эрэгтэйчүүд, 1394.3 мянга буюу 51 хувь нь эмэгтэйчүүд байна. Эрэгтэйчүүдийн 62.7 хувь, эмэгтэйчүүдийн 66.6 хувь нь интернет хэрэглэгч болж, өмнөх тооллоготой харьцуулахад 34.3 нэгж хувь болон 33.8 нэгж хувиар тус тус нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн дунд интернетийн хэрэглээ өндөр байна.⁸⁹

Монгол Улсад интернэт сүлжээнд холбогдсон 4.69 сая мобайл төхөөрөмж байгаа нь нийт хүн амын 141.8 хувьтай тэнцэж байна. Мөн манай улсад интернэт хэрэглэгчдийн тооноос илүү буюу 2.6 сая идэвхтэй сошиал медиа хэрэглэгч байна. 2020-2021 оны хоорондох нэг жилийн хугацаанд Монгол Улсад идэвхтэй сошиал медиа хэрэглэгчдийн тоо 400 гаруй мянгаар буюу 18.2 хувиар нэмэгджээ. Үүний нэлээдгүй хэсэг нь хуурамч болон бот хаягууд байх магадлалтай гэдгийг анхаарах хэрэгтэй.⁹⁰

Монголчуудын хамгийн түгээмэл ашигладаг нийгмийн сүлжээний суваг нь фэйсбүүк болж байна. Нийт сошиал медиа идэвхтэй хэрэглэгчийн 2.5 сая нь фэйсбүүкийг ашиглаж байгаа бөгөөд үүний дараа инстаграм, линкедин, твиттер зэрэг сошиал медиа платформууд удаалж байна (Зураг 5-ыг үзнэ үү).

Зураг 5. Монголчуудын түгээмэл ашигладаг сошиал медиа платформууд



Эх сурвалж: *ltoim.mn*

⁸⁸ Цахим хөгжил, харилцаа холбооны яам “Судалгаа: Нийт өрхийн 80% нь интернэттэй, иргэдийн 97.6% нь гар утастай байна”(2022.02.22) <https://ikon.mn/n/2h0z>

⁸⁹ Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо “Интернет, гар утасны хэрэглээ”, УБ 2021 он https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Internet__phone_use_2020.pdf&ln=Mn

⁹⁰ О.Мөнхбат “Монголын интернэт хайлтыг сүлжээний бизнесүүд тэргүүлж, шинжлэх ухаан дата үүсэх хэмжээнд хүрсэнгүй” <http://ltoim.mn/article/OcvVj/27690>

2021 оны байдлаар, фэйсбүүк хэрэглэгчдийн ихэнх нь 52.6 хувь нь эмэгтэйчүүд, 47.4 хувь нь эрэгтэйчүүд байна. Насны хувьд 25-аас 34 хүртэлх насныхан хамгийн олон буюу 760 мянга орчим байна. Харин инстаграмын хэрэглэгчдийн 61 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол насны хувьд 18-24 насныхан голчлон хэрэглэж байна.⁹¹ Эндээс дүгнэхэд, Монгол Улсад эмэгтэйчүүд сошиал медиа платформуудыг түлхүү хэрэглэдэг болох нь харагдаж байгаа юм.

Монголын улс төрчид иргэд, олон нийт, сонгогч, дэмжигчидтэй харилцахад нийгмийн сүлжээний сувгуудыг хэрхэн ашигладаг талаар хангалттай хэмжээнд судлаагүй байна. Энэ талаар хийгдсэн цөөн хэдэн судалгаа нь гол төлөв ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн нэр дэвшигчдийн үйл ажиллагаанд төвлөрсөн байна. Тухайлбал, улс төр судлаач Ц.Мөнхцэцэг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуульд нийгмийн сүлжээний сувгууд хэрхэн нөлөөлсөн талаар судалгаа хийсэн бөгөөд тус судалгаанаас үзэхэд, өмнөх сонгуулиудтай харьцуулахад нэр дэвшигчид сурталчилгааны сувгийн хувьд нэлээд хатуу хязгаарлалт дор сурталчилгаа явуулсан учраас МАН болон АН-ын нэр дэвшигчид нийгмийн сүлжээний сувгуудыг сурталчилгаанд түлхүү ашигласан. Харин МАХН-аас нэр дэвшигч С.Ганбаатарын хувьд нийгмийн сүлжээг бус иргэдтэй хийх нүүр тулсан уулзалтууд сурталчилгааны гол суваг нь болж байв.⁹²

Дээр дурдсан судалгаанд дурдснаар, 2017 оны сонгуулийн сурталчилгааны бүхий л хугацаанд нэр дэвшигч Х.Баттулга өрсөлдөгч М.Энхболдын эсрэг сөрөг сурталчилгааг фэйсбүүкээр амжилттай явуулсан бол М.Энхболдын хувьд мөн л өрсөлдөгч Х.Баттулгын эсрэг сөрөг сурталчилгааг твиттерт давамгайлсан явуулсан. Нэр дэвшигч Х.Баттулгын хувьд фэйсбүүкт давамгайл байсны гол үзүүлэлт бол түүний сурталчилгаа, Live буюу шууд дамжуулалт бүхий бичлэгүүд сонгуулийн сурталчилгааны бүхий л үед хамгийн олон үзэгч, хандалттай байсан явдал юм.

Улмаар ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн үеэр фэйсбүүк нь нэр дэвшигчдийн талаар мэдээлэл авч буй гурав дахь том суваг болсон нь харагдсан. Судалгаанд оролцсон иргэдийн 39.3 хувь нь нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг фэйсбүүкээс авч байна гэж хариулсан. Харин твиттерээс мэдээлэл авч буй сонгогчдын хувь 5.4 байгаа юм.⁹³

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгуулийг ажигласан Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын тайланд дурдснаар, энэ удаагийн сонгууль нь цар тахлын хязгаарлалттай нөхцөлд явагдсан учраас нэр дэвшигчид олон нийтийг хамарсан уулзалт, сонгуулийн арга хэмжээ зохион байгуулсан боловч ерөнхийдөө сонгогчидтой аль болох шууд харилцахгүй байх, нийгмийн сүлжээний сувгууд, ялангуяа фэйсбүүк ашиглан сурталчилгаагаа явуулахыг зорьсон байна.⁹⁴ Эндээс дүгнэхэд, цар тахлын хязгаарлалтын нөлөөгөөр сонгуульд нэр дэвшигчдийн иргэд, сонгогчидтойгоо уламжлалт байдлаар буюу биечлэн уулзах, олныг хамрах

91 Б.Анхилам “Монголчуудын сошиал медиа хэрэглээг тандсан судалгааг хүргэж байна” (2021.01.05) <https://www.peak.mn/news/mongoliin-soshial-media-statistik>

92 Ц.Мөнхцэцэг “Цахим популизм буюу сонгууль дахь сошиал сүлжээний нөлөө” (2017.10.27) <http://muki.mn/post/46623>


93 Мөн тэнд

94 ЕАБХАБ “АИХЭГ-ийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгууль ажиглах тусгай хорооны эцсийн тайлан”, Варшав хот, 2021 он https://www.osce.org/files/f/documents/9/6/509063_0.pdf

үйл ажиллагаа явуулах боломж нь хязгаарлагдсан учраас нийгмийн сүлжээний сувгуудад тулгуурлан сонгуулийн сурталчилгаагаа явуулахад хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, цар тахлын аргагүй нөхцөл байдал сонгуулийн сурталчилгааг цахимжуулах суурь шалтгаан болсон хэмээн үзэж байна.

АНУ-ын Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн Монгол Улсад 2020 оны 5 дугаар сарын 14-нөөс 6 дугаар сарын 15-ны өдөр явуулсан судалгаанаас үзэхэд, монголчуудын улс төрийн талаарх мэдээллийг авахад хамгийн их ашигладаг мэдээллийн хэрэгсэл нь телевиз, дараагаар нь сошиал медиа орж байна (Зураг 6-ы үзнэ үү).⁹⁵ Энэ нь цаашид улс төрийн мэдээ, мэдээлэл түгээх, хүлээн авахад сошиал медиагийн гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэнэ хэмээн таамаглахад хүргэж байгаа юм.

Зураг 6. Монголчуудын улс төрийн талаар мэдээлэл авахад хамгийн ашигладаг мэдээллийн хэрэгсэл



Эх сурвалж: БНОУХ

“Залуу судлаачдыг дэмжих сан” ТББ-ын 2021 онд хийсэн “Эмэгтэйчүүдийн амьдралын чанар-2021” судалгаагаар эмэгтэйчүүд өдөр тутмын амьдралаа хэрхэн өнгөрүүлж, гэр бүлийн болон ойр зуурын ажлуудад хэдий хэр хугацааг дунджаар зарцуулдгийг судалгаагаар тогтоосон (Хүснэгт 9-ийг үзнэ үү). Хэдийгээр цагийн хуваарилалтыг бүрэн хэмжээгээр илэрхийлж чадахгүй ч голлох үйл ажиллагаануудад хэдий хэр хугацаа зарцуулж байгааг доорх хүснэгтээс барагцаалж болно.⁹⁶

⁹⁵ БНОУХ “Залуучуудын санаа бодлын судалгаа” https://www.iri.org/wp-content/uploads/legacy/iri.org/mongolia_ned_youth_poll_2020_-_public_deck_mongolian_final.pdf

⁹⁶ Залуу судлаачдыг дэмжих сан “Эмэгтэйчүүдийн амьдралын чанар-2021” судалгааны тайлан, УБ., 2021 он <https://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/18841.pdf>

Хүснэгт 9. Эмэгтэйчүүдийн өдөр тутмын үйл ажиллагаануудад зарцуулдаг хугацаа /минутаар/

Үйл ажиллагаа	Минут
Та хоногт хэдэн цаг унтдаг вэ?	443
Та өглөөний цай уухдаа дунджаар хэр хугацаа зарцуулдаг вэ?	24
Та оройн хоолоо идэхдээ дунджаар хэр хугацаа зарцуулдаг вэ?	33
Та зөвхөн өөрийн чөлөөт цагтаа зориулж өдөрт дунджаар хэдэн цагийг зарцуулдаг вэ?	35
Та өдөрт дасгал хөдөлгөөн хийхэд дунджаар хэдэн цагийг зарцуулдаг вэ?	92
Та өдөрт дасгал хөдөлгөөн хийхэд дунджаар хэдэн цагийг зарцуулдаг вэ?	39
Та өдөрт ажиллах/суралцахад дунджаар хэдэн цагийг зарцуулдаг вэ?	290
Та өдөрт дунджаар хэдэн цагийг гэрийн ажил хийхэд зарцуулдаг вэ?	139
Та өдөрт дунджаар хэдэн цагийг хүүхдэдээ /тоглох, хичээл давтуулах гэх мэт/ зарцуулдаг вэ?	90
Та социал сүлжээ ашиглахад /Фэйсбүүк, Инстаграм, Твиттер гэх мэт/ дунджаар хэдэн цаг зарцуулдаг вэ?	132
Та өдөрт дунджаар хэдэн цагийг утсан харилцаанд зарцуулдаг вэ?	48

Тухайлбал, эмэгтэйчүүд 7.38 цагийг унтахад, 4.83 цагийг ажиллаж, суралцахад, **2.2 цагийг интернэт болон социал сүлжээ ашиглахад** зарцуулдаг бол 3.81 цагийг гэр орны ажил болон хүүхэд харахад зарцуулж, 1.53 цагийг өөрийн чөлөөт цагтаа зарцуулдаг гэж хариулжээ. Энэ нь эмэгтэйчүүдийн өдөр тутмын амьдралд социал медиа хэрэглээ тодорхой байр суурь эзэлдэг болсныг харуулж байгаа хэрэг юм.

Дээр дурдсан судалгаанд интернэт орчинд цаг заваа хэрхэн өнгөрөөдөг болохыг тодруулахад, эмэгтэйчүүд интернэт орчинд хамгийн ихээр олон нийтийн сүлжээ, мэдээ үзэх, цахим нийтлэл унших зэрэгт түлхүү цаг зарцуулдаг бол тоглоом тоглох, блог унших бичих, кино үзэх зэрэгт хамгийн бага цаг зарцуулдаг байна (Зураг 7-г үзнэ үү). Үүнээс дүгнэхэд, эмэгтэйчүүдийн хувьд социал медиа буюу олон нийтийн сүлжээнд цаг өнгөрүүлэх нь интернэтэд чөлөөт цагаа өнгөрөөх үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг болох нь харагдаж байна.

Зураг 7. Интернэтэд чөлөөт цагаа өнгөрөөдөг байдал



Эх сурвалж: Эмэгтэйчүүдийн амьдралын чанар-2021” судалгаа

Судалгааны арга зүй: Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх нийгмийн сүлжээний сувгуудын үзүүлэх нөлөөлөлд шинжилгээ хийхдээ, дэлхийн олон улсад хийгдсэн судалгааны асуулгыг ашигласан болно. Парламент дахь эмэгтэйчүүдийн дэлхийн форумаас Фэйсбүүк компани, Харвардын их сургуулийн Кеннедигийн нэрэмжит засаглалын сургууль дахь Хэвлэл мэдээлэл, улс төр, төрийн удирдлагын Шоренштейн төвтэй хамтран Парламент дахь эмэгтэйчүүдийн дэлхийн форумын сүлжээнд нэгдсэн үндэсний эмэгтэй хууль тогтоогчдоос онлайнаар асуулга судалгаа авсан байна. Асуулга судалгааны хуудсыг 900 орчим хууль тогтоогчид тарааж, 107 улсын 531 судлаач асуулга судалгааг бүрэн гүйцэд бөглөсөн.⁹⁷


Дээр дурдсан судалгаа нь нийтдээ 51 асуулт бүхий, өргөн хүрээг хамарсан байсан бөгөөд Монгол Улсад энэхүү судалгааг авахдаа асуулгад багтсан асуултуудын тоог багасгаж, 16-д багтаасан.

Асуулга судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллийн үр дүн: Асуулга судалгааны үндсэн асуултуудыг асуухаас өмнө судалгаанд оролцогчдын ерөнхий болон хувийн мэдээллийн талаарх асуултуудыг асуусан болно. Энэхүү судалгаанд оролцсон хүмүүсийн мэдээллийг дараах байдлаар тоймлон харуулж байна.

Судалгаанд оролцогчдын нас. Зураг 6-д үзүүлсний дагуу судалгааны нийт оролцогч (n=23)-ийн дунд 26-35 насныхан 34.8%, 36-45 насныхан 34.8%, 46-55 насныхан 21.7%, 56-аас дээш насныхан 8.7% тус тус эзэлж байна.


⁹⁷ Women in Parliaments Global Forum “Social Media: Advancing Women in Politics?” (October 2016) https://www.womenpoliticalleaders.org/wp-content/uploads/2016/10/WIP-Harvard-Facebook-Study_Oct2016.pdf

Зураг 8. Судалгаанд оролцогчдын нас



Боловсролын байдал. Нийт судалгаанд хамрагдсад (n=23)-ын 30.4% нь бакалавр, 56.5% нь магистр, 13% нь докторын зэрэгтэй байна.

Зураг 9. Судалгаанд оролцогчдын боловсрол



Оршин суугаа газар. Нийт судалгаанд хамрагдсад (n=23)-ын 65.2% нь Улаанбаатар, 30.4% нь бусад хот суурин газарт, 4.3% нь хөдөө, орон нутагт амьдарч байна.

Зураг 10. Судалгаанд оролцогчдын оршин суугаа газар



Намын харъяалал. Судалгааны нийт оролцогчид (n=23)-ын 50% нь эрх баригч, 36.4% нь сөрөг хүчний, 13.6% нь гуравдагч хүчний намд харьяалагдаж байна.

Зураг 11. Судалгаанд оролцогчдын намын харъяалал




Улс төрийн үзэл баримтлал. Судалгааны нийт оролцогч (n=23)-ийн 60.9 нь өөрсдийгөө төвийн, 30.4% нь зүүний аядуу чиг баримжаатай, 8.7% нь барууны аядуу чиг баримжаатай хэмээн тодорхойлжээ.

Зураг 12. Судалгаанд оролцогчдын улс төрийн үзэл баримтлал



Судалгаанд оролцогчдын улс төрийн манлайлал. Нийт судалгаанд хамрагдсад (n=23)-ын 34.8% нь намын аппаратад, 21.7% нь УИХ, 21.7% нь сум, дүүргийн ИТХ, 13% нь аймаг, нийслэлийн ИТХ, баг, хороондын Иргэдийн нийтийн хурал зэрэгүлс төрийн албан тушаалд сонгогдож ажиллаж байгаа/байсан байна.


Зураг 13. Судалгаанд оролцогчдын улс төрийн манлайлал



Судалгааны үр дүн. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудын нөлөөлөлд шинжилгээ хийх зорилготой энэхүү асуулга судалгааны явцад дараах үр дүнд хүрсэн болохыг толилуулж байна. Үүнд:

Үр дүн 1. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 82.6% улс төрийн үйл ажиллагаандаа нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглаж байна.


Зураг 14. Судалгаанд оролцогчдын нийгмийн сүлжээг улс төрийн үйл ажиллагаанд ашиглаж буй байдал



Энэ нь улс төрийн харилцаа, холбоонд нийгмийн сүлжээний сувгууд чухал байр суурь илтгэж байгаа юм. Эмэгтэй улс төрчид нийгмийн сүлжээний сувгуудыг идэвхтэй хэрэглэхэд нийгмийн сүлжээний бусад мэдээллийн хэрэгслүүдээс харьцуулахад бий болж буй давуу талууд нөлөөлсөн байж болох магадлалтай.

Үр дүн 2. Нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн ихэнх нь идэвхтэй хэрэглэгчид байна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь 1-ээс дээш нийгмийн сүлжээний сувгийг хэрэглэдэг байна. Энэ дотроо фэйсбүүкийг улс төрийн ажилдаа ашигладаг эмэгтэй улс төрчдийн 86.9% нь өдөр тутам хэрэглэдэг байгаа юм. Үүнээс үзэхэд, монголчуудын дийлэнх нь фэйсбүүкийг идэвхтэй хэрэглэдгээс үүдэн эмэгтэй улс төрчид ч мөн улс төрийн үйл ажиллагаанд нийгмийн сүлжээний энэхүү сувгийг ашиглах шаардлагатай болсон хэмээн дүгнэж болохоор байна.

Зураг 15. Судалгаанд оролцогчдын социал медиа хэрэглээний давтамж




Монгол Улсад эмэгтэй улс төрчид фэйсбүүк, твиттер, ютүүб, инстаграм зэрэг нийгмийн сүлжээний сувгуудыг түгээмэл хэрэглэдэг бол тик ток, whatsapp, wechat зэргийг огт ашиглахгүй байна. Энэ нь манай интернет хэрэглэгчдийн дийлэнх нь фэйсбүүк, твиттер зэргийг хэрэглэдгээс шалтгаалан тус сувгаар дамжуулан олон нийттэй харилцах нь оновчтой хэмээн үзсэнтэй холбоотой байж болох юм.

Үр дүн 3. Судалгаанд оролцогчид фэйсбүүкийн 91,000-аас 154 хүртэл дагагчтай бөгөөд үүнийг дундажчлан авч үзвэл, судалгааны нэг оролцогч дунджаар 8,458 орчим хүнд хүрч мэдээ, мэдээлэл хүргэдэг байна. Үүнээс үзэхэд, эмэгтэй улс төрчид нийгэмд улс төрийн болон бусад тулгамдсан асуудлаар мэдээ, мэдээлэл түгээхэд чухал үүрэгтэй оролцох болсныг илтгэж байгаа юм.

Үр дүн 4. Судалгаанд оролцогчид твиттерийн 48,100-аас 100 хүртэл дагагчтай байна. Фэйсбүүктэй харьцуулахад дагагчидын тоо бага байгаагаас үзэхэд дээр дурдсанчлан твиттер нь фэйсбүүктэй харьцуулахад хэрэглээ байгааг харуулж байна.

Үр дүн 5. Судалгааны оролцогчдын 87% нь нийгмийн сүлжээний аккаунтаа өөрөө хөтөлдөг бол 8.7% нь тусгайлан ажилтан хөлсөлдөг, 4.3% ерөнхийдөө өөрөө хөтөлдөг боловч бусдын туслалцаа авдаг байна. Эндээс үзэхэд, улс төрч эмэгтэйчүүдийн дийлэнх хэсэг нь нийгмийн сүлжээний сувгуудаар мэдээ, мэдээлэл түгээх зорилгоор тодорхой хугацааг цахим орчинд өнгөрүүлдэг болох нь харагдлаа.

Зураг 16. Сошиал медиа аккаунт хэрхэн хөтөлдөг тухайд




“Эмэгтэйчүүдийн аж байдал-2021” судалгаанд эмэгтэйчүүдийн өдөр тутам сошиал медиа ашиглахад 2.2 цагийг зарцуулдаг хэмээн дурдсанаас илүү хугацааг улс төр ч эмэгтэйчүүд зарцуулдаг байж магадлалтай байна. Энэ нь улс төрч эмэгтэйчүүдийн өдөр тутмын ажлын хуваарьт нийгмийн сүлжээнд зарцуулах хугацаа чухал байр суурь эзэлж байгааг харуулж байна.

Нөгөөтэйгүүр, эмэгтэй улс төрчид нийгмийн сүлжээний аккаунтаа өөрөө хөтөлөх хандлагатай байгаа нь тэд нийгмийн сүлжээний сувгуудтай харьцах тодорхой техникийн болон бусад үр чадварыг эзэмшсэн болохыг илтгэж байна.


Үр дүн 6. Судалгаанд оролцогчид улс төрийн зорилгоор нийгмийн сүлжээг ашиглах тухайд нэлээд мэдлэгтэй болох нь харагдлаа. Оролцогчдын 21.7% нь энэ талаар маш сайн мэдлэгтэй, 43.5% нь сайн мэдлэгтэй хэмээн өөрсдийгөө тодорхойлсон бол 34.8% нь энэ талаар бага зэрэг мэдлэгтэй байна.

Зураг 17. Улс төрийн зорилгоор нийгмийн сүлжээг ашиглах талаарх мэдлэг



Үр дүн 7. Эмэгтэй улс төрчид нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглах явцад гадаад төрхийг нь гутаан доромжилсон үнэлгээг авах нь нийтлэг байна. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 87 хувь нь ямар нэг байдлаар (цөөн тохиолдолд, заримдаа, байнга) гадаад төрхийг нь гутаан доромжилох явдалтай нүүр тулгарчээ.

Зураг 18. Нийгмийн сүлжээгээр авсан үнэлгээ



Энэ нь нийгмийн сүлжээний сувгуудад өрнөж буй хэлэлцүүлэг нь эмэгтэй улс төрчдийн дэвшүүлж буй бодлого гэхээс илүү тэдний хувийн зан чанарын талаар байдгийг нотлон харуулж байна.

АНУ-ын Бүгд найрамдахчуудын хүрээлэнгийн 2020 хийсэн судалгаанд, улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангагдахгүй байгаагийн хамгийн гол саад бэрхшээл 5 дугаарт, “эмэгтэйчүүд сонгуульд өрсөлдснөөр нүд үзүүлэгдэх, заналхийлэгдэх, нэр хүндэд нь муугаар нөлөөлөхөөс эмээдэг”, 9 дүгээрт “эмэгтэйчүүд сонгуульд өрсөлдснөөр хүчирхийлэлд өртөхөөс эмээдэг” зэрэг дурдагдсан. Үүнтэй холбогдуулан тайлбарлахад, нийгмийн сүлжээний сувгуудыг

ашиглах нь эмэгтэй улс төрчид гадаад төрхийг нь гутаан доромжлох явдалтай нүүр тулгарахад хүргэж байгаа энэ нөхцөлд нийгмийн сүлжээний сувгууд алсдаа эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хязгаарлаж болох магадлалтай юм.

Иймд эмэгтэй улс төрчид онлайн хүчирхийлэл заналхийлэлд хариу үйлдэл үзүүлэх стратегитай болох шаардлагатай байна. Ялангуяа, судалгааны өмнөх үр дүнд дурдсанчлан, эмэгтэй улс төрчид нийгмийн сүлжээний аккаунтуудаа дийлэнх тохиолдолд өөрсдөө хөтөлдөг байгаа энэ нөхцөлд онлайн заналхийллийн бай болгохгүйн тулд дижитал технологид сурах, боломжтой бол нийгмийн сүлжээний сувгуудаа хөтлөх тусгайлан мэргэшсэн мэргэжилтнүүдийг авч ажиллуулах боломжийг судлах боломжтой.


Үр дүн 8. Нийгмийн сүлжээний сувгуудааар мэдээ, мэдээлэл түгээх зорилтот бүлгээ тодорхойлохдоо, улс төрч эмэгтэйчүүдийн 39.1% нь “тойргийн сонгогчид”, 26.1% нь “олон нийт”, 21.7% нь эмэгтэй сонгогчид, 8.7% нь хэвлэл мэдээллийнхэн, 4.3% нь “гэр бүл” хэмээн үзжээ. Эндээс харахад, жирийн иргэдийн хувьд гэр бүл, найз нөхөдтэйгөө харилцаа холбоотой байх зорилгоор сошиал медиаг ашигладаг бол улс төрчдийн тухайд тойргийн сонгогчдоос авахуулаад хэвлэл мэдээллийнхэнтэй харилцаа холбоо тогтооход сошиал медиаг ашиглаж байна хэмээн дүгнэж болохоор байна.

Зураг 19. Сошиал медиагаар мэдээлэл түгээх зорилтот бүлэг



Үр дүн 9. Улс төрч эмэгтэйчүүдийн хувьд өөрийгөө таниулах, улс төрийн байр сууриа бэхжүүлэх, улс төрийн үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэх, олон нийтийн санаа бодлыг мэдэх, сонгогч, дэмжигчидтэйгээ шууд харилцахад фэйсбүүк платформ чухал үүрэгтэй байна. Ялангуяа олон нийтийн санаа бодлыг мэдэх, сонгогч, дэмжигчидтэйгээ шууд харилцахад фэйсбүүк нь твиттерээс илүү үр дүнтэй хэмээн судалгаанд оролцогчдын 69.5% дүгнэжээ.

Зураг 20. Сошиал медиа платформуудын үр дүнтэй байдал




Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоонд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийн нэг нь хөрөнгө мөнгө босгох асуудал болох нь өмнөх бүлгийн судалгаанаас харагдсан. Улс төрчид сонгуулийн кампанит ажилдаа ихээхэн хэмжээний зардал гаргадгийн дийлэнх хэсэг нь сонгуулийн мөрийн хөтөлбөрийг таниулах нэр дэвшигчийг сурталчлах, уулзалт, хурал цуглаан зохион байгуулахад зарцуулагддаг. Харин нийгмийн сүлжээний сувгууд нь энэхүү зардлыг хөнгөвчлөх давуу талыг бий болгож байна.

Асуулга судалгаанд оролцогчдын хариултаас үзэхэд, нийгмийн сүлжээний сувгуудаас фэйсбүүкийг өөрийгөө таниулахад ашиглах нь тохиромжтой байна. Иймд эмэгтэй улс төрчид өөрийгөө сонгогч олонд таниулахад уламжлалт мэдээллийн хэрэгслээс илүүтэй нийгмийн сүлжээний сувгуудад тулгуурлах боломжтой.

Үр дүн 10. Судалгаанд оролцогчид нийгмийн сүлжээний сувгуудын үр дүнтэй байдлыг шинээр гарч ирж буй болон сонгуульт албан тушаалд ажиллаж байгаа улс төрчид, сонгуулийн кампанит ажил, бодлогын байр сууриа дэмжүүлэх, эерэг имидж бүрдүүлэх зэргийн хүрээнд авч үзэхэд, нийгмийн сүлжээний сувгууд нэлээд үр дүнтэй байна. Ялангуяа, сонгуульт албан тушаалд ажиллаж байгаа эмэгтэй улс төрчид нийгмийн сүлжээний сувгуудыг үр дүнтэй хэмээн үнэлжээ. Мөн бодлогын байр сууриа дэмжүүлэхэд тэднийг ашиглахад үр дүнтэй байна.

Зураг 21. Нийгмийн сүлжээний сувгуудын үр дүнтэй байдал



БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Нийгмийн сүлжээний сувгууд нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд эерэг болон сөрөг нөлөөтэй байна. Улс төрийн виртуаль оролцоо, интернетийн хэрэглээнд улам бүр тулгуурлах болсноор эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэй улс төрчид онлайн хүчирхийлэлд өртөх нь нэмэгдэх болсон байна. Харин нийгмийн сүлжээний сувгуудыг үр дүнтэй хэрэглэх нь улс төрч эмэгтэйчүүдийг хямд, хязгаарлалт багатай зардлаар олон хүнд хүрэх боломжийг олгоод зогсохгүй тээврийн болон бусад зардлыг хэмнэдэг давуу талтай. Мөн түүнчлэн, эдийн засгийн эрх мэдэл, улс төрийн томоохон санхүүжүүлэгчдээс хөрөнгө татах боломж багатай эмэгтэй нэр дэвшигчид сошиал медиагаар дамжуулан улс төрийн кампанит ажилдаа зориулан хөрөнгө босгоход хялбар болсоор байна. Эндээс үзэхэд, улс төр дэх эмэгтэйчүүдийн сошиал медиа платформуудыг ашиглахтай холбоотой мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн чадавхжуулах болон сургалтын санаачилгууд дэмжих замаар тэдний бусадтай харилцаа харилцааны стратеги болон сонгогчдод хүрч ажиллах

Монголын тухайд улс төрч эмэгтэйчүүдийн улс төрийн манлайлалд томоохон тээг болдог зүйл нь улс төрийн кампанит ажлаа санхүүжүүлэх хөрөнгө мөнгө босгоход тулгардаг хүндрэл бэрхшээл байдаг. Энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд нийгмийн сүлжээний сувгууд эерэг нөлөө үзүүлэх боломжтой юм. Учир нь Монгол Улсын иргэд интернетэд холбогдон мэдээ, мэдээлэл авах боломж, дэд бүтэц нь зохих хэмжээнд хангагдсан хэмээн дүгнэж болохоор байна. Нөгөөтэйгүүр, эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн дунд интернетийн хэрэглээ өндөр байна. Монголчуудын хамгийн түгээмэл ашигладаг нийгмийн сүлжээний суваг нь фэйсбүүк бол эрэгтэйчүүдтэй харьцуулахад монгол эмэгтэйчүүд сошиал медиа платформуудыг түлхүү хэрэглэдэг болох нь судалгаанаас харагдсан.

Гэвч монголын улс төрчид иргэд, олон нийт, сонгогч, дэмжигчидтэй харилцахад нийгмийн сүлжээний сувгуудыг хэрхэн ашигладаг талаар хангалттай хэмжээнд судлаагүй байна. Энэ талаар хийгдсэн цөөн хэдэн судалгаа нь гол төлөв ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдсөн нэр дэвшигчдийн үйл ажиллагаанд төвлөрсөн байна. Улмаар ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн үеэр фэйсбүүк нь нэр дэвшигчдийн талаар мэдээлэл авч буй гуравдахь том суваг болсон нь харагдсан.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын зорилго нь улс төр дэх жендэрийн тэгш бус байдлыг бууруулахад социал медиаг ашиглах боломжид дүн шинжилгээ хийхэд чиглэсэн. Судалгааны зорилгод нийцүүлэн, дэлхийд болон Монгол Улсад шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо ямар байгааг илрүүлэх зорилгоор статистик баримтуудыг нэгтгэлээ.

Монгол Улсад төдийгүй дэлхий даяар жендэрийн тэгш байдал хангагдаагүй хэвээр байгааг статистик баримт мэдээллээс харж болно. Хамгийн ноцтой нь цар тахалтай холбоотойгоор бүх салбарт, ялангуяа улс төрд жендэрийн тэгш бус байдлыг арилгахад олсон ололт амжилт алдагдан, ухралтанд орсон явдал юм. Гэвч удаан боловч зарим өөрчлөлт гарч байгааг үгүйсгэж болохгүй. Жишээлэхэд, Монгол Улсын УИХ-ын 8 дахь удаагийн сонгуулийн үр дүнд сонгогдсон нийт гишүүдийн 13 нь буюу 17.1 хувь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх 7 удаагийн парламентуудаас хамгийн өндөр үзүүлэлт юм. Мөн Монгол Улс аймаг, нийслэлийн түвшинд түүхэндээ анх удаа эмэгтэй засаг даргатай боллоо.

Монгол Улсад сонгосон сэдвийн хүрээнд хийсэн судалгаануудыг авч үзвэл, тоон болон чанарын судалгааны аргуудыг аль алиныг нь ашигласан байна. Судалгаанд хамрагдагсдын хувьд улс төрч эмэгтэйчүүдээс авсан ярилцлагын судалгаа зонхилж байгаа бол энд дурдагдсан тоон судалгаа нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлсийг сонгогчдоос буюу иргэдээс асууж тодорхойлсноороо онцлогтой.

Судлагдсан байдлын судалгаанаас үзэхэд *эрэгтэйчүүд давамгайлсан улс төрийн бүтэц, нэр дэвшиж өрсөлдсөн намын нэр хүнд, сонгуулийн сурталчилгаа явуулахад шаардлагатай хөрөнгө босгоход тулгардаг хүндрэл* зэрэг нь улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарладаг зүйлсээр нэрлэгджээ.

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудын үзүүлэх нөлөөлөлд шинжилгээ хийхдээ, дэлхийн олон улсад хийгдсэн судалгааны асуулгыг ашигласан болно. Парламент дахь эмэгтэйчүүдийн дэлхийн форумас Фэйсбүүк компани, Харвардын их сургуулийн Кеннедигийн нэрэмжит засаглалын сургууль дахь Хэвлэл мэдээлэл, улс төр, төрийн удирдлагын Шоренштейн төвтэй хамтран Парламент дахь эмэгтэйчүүдийн дэлхийн форумын сүлжээнд нэгдсэн үндэсний эмэгтэй хууль тогтоогчдоос онлайн асуулга судалгаа авсан байна. Асуулга судалгааны хуудсыг 900 орчим хууль тогтоогчид тарааж, 107 улсын 531 судлаач асуулга судалгааг бүрэн гүйцэд бөглөсөн.

Дээр дурдсан судалгаа нь нийтдээ 51 асуулт бүхий, өргөн хүрээг хамарсан байсан бөгөөд Монгол Улсад энэхүү судалгааг авахдаа асуулгад багтсан асуултуудын тоог багасгаж, 12-д багтаасан.

Монгол Улсад хийгдсэн энэхүү судалгаанд хамрагдсан эмэгтэй 82.6% улс төрийн үйл ажиллагаандаа нийгмийн сүлжээг ашиглаж байна. Нийгмийн сүлжээ

хэрэглэгчдийн ихэнх нь идэвхтэй хэрэглэгчид байна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь нэгээс дээш нийгмийн сүлжээний хэрэглэдэг. Энэ дотроо фэйсбүүкийг улс төрийн ажилдаа ашигладаг эмэгтэй улс төрчдийн 86.9% нь өдөр тутам ашиглаж байгаа юм.

Судалгаанд оролцогчид фэйсбүүкийн 91,000-аас 154 хүртэл дагагчтай бөгөөд үүнийг дундажчлан авч үзвэл, судалгааны нэг оролцогч дунджаар 8,458 орчим хүнд хүрч мэдээ, мэдээлэл хүргэдэг байна. Үүнээс үзэхэд, эмэгтэй улс төрчид нийгэмд улс төрийн болон бусад тулгамдсан асуудлаар мэдээ, мэдээлэл түгээхэд чухал үүрэгтэй оролцох болсныг илтгэж байгаа юм.

Судалгаанд оролцогчид твиттерийн 48,100-аас 100 хүртэл дагагчтай байна. Фэйсбүүктэй харьцуулахад дагагчдын тоо бага байгаагаас үзэхэд дээр дурдсанчлан твиттер нь фэйсбүүктэй харьцуулахад хэрэглээ байгааг харуулж байна.

Нийгмийн сүлжээний сувгуудаар мэдээ, мэдээлэл түгээх зорилтот бүлгийн хувьд тодорхойлохдоо, улс төрч эмэгтэйчүүдийн 39.1% нь “тойргийн сонгогчид”, 26.1% нь “олон нийт”, 21.7% нь эмэгтэй сонгогчид, 8.7% нь хэвлэл мэдээллийнхэн, 4.3% нь “гэр бүл” хэмээн үзжээ. Эндээс харахад, жирийн иргэдийн хувьд гэр бүл, найз нөхөдтэйгөө харилцаа холбоотой байх зорилгоор социал медиаг ашигладаг бол улс төрчдийн тухайд тойргийн сонгогчдоос авахуулаад хэвлэл мэдээллийнхэнтэй харилцаа холбоо тогтооход социал медиаг ашиглаж байна хэмээн дүгнэж болохоор байна.

Улс төрч эмэгтэйчүүдийн хувьд өөрийгөө таниулах, улс төрийн байр сууриа бэхжүүлэх, улс төрийн үйл ажиллагаагаа олон нийтэд хүргэх, олон нийтийн санаа бодлыг мэдэх, сонгогч, дэмжигчидтэйгээ шууд харилцахад фэйсбүүк платформ чухал үүрэгтэй байна. Ялангуяа олон нийтийн санаа бодлыг мэдэх, сонгогч, дэмжигчидтэйгээ шууд харилцахад фэйсбүүк нь твиттерээс илүү үр дүнтэй хэмээн судалгаанд оролцогчдын 69.5% дүгнэжээ.

Судалгаанд оролцогчид нийгмийн сүлжээний сувгуудын үр дүнтэй байдлыг шинээр гарч ирж буй болон сонгуульт албан тушаалд ажиллаж байгаа улс төрчид, сонгуулийн кампанит ажил, бодлогын байр сууриа дэмжүүлэх, эерэг имидж бүрдүүлэх зэргийн хүрээнд авч үзэхэд, нийгмийн сүлжээний сувгууд нэлээд үр дүнтэй байна. Ялангуяа, сонгуульт албан тушаалд ажиллаж байгаа эмэгтэй улс төрчид нийгмийн сүлжээний сувгуудыг үр дүнтэй хэмээн үнэлжээ. Мөн бодлогын байр сууриа дэмжүүлэхэд тэднийг ашиглахад үр дүнтэй байна.

Судалгааны оролцогчдын 87% нь нийгмийн сүлжээний аккаунтаа өөрөө хөтөлдөг бол 8.7% нь тусгайлан ажилтан хөлсөлдөг, 4.3% ерөнхийдөө өөрөө хөтөлдөг боловч бусдын тусалцаа авдаг байна. Эндээс үзэхэд, улс төрч эмэгтэйчүүдийн дийлэнх хэсэг нь социал медиагаар мэдээ, мэдээлэл түгээх зорилгоор тодорхой хугацааг цахим орчинд өнгөрүүлдэг болох нь харагдлаа.

Судалгаанд оролцогчид улс төрийн зорилгоор нийгмийн сүлжээг ашиглах тухайд нэлээд мэдлэгтэй болох нь харагдсан. Оролцогчдын 21.7% нь энэ талаар маш сайн мэдлэгтэй, 43.5% нь сайн мэдлэгтэй хэмээн өөрсдийгөө тодорхойлсон бол 34.8% нь энэ талаар бага зэрэг мэдлэгтэй байна.

Эмэгтэй улс төрчид нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглах явцад гадаад төрхийг нь гутаан доромжилсон үнэлгээг авах нь нийтлэг байна. Тодруулбал, судалгаанд оролцогчдын 87 хувь нь ямар нэг байдлаар (цөөн тохиолдолд, заримдаа, байнга) гадаад төрхийг нь гутаан доромжлох явдалтай нүүр тулгарчээ.

Энэ нь нийгмийн сүлжээний сувгуудад өрнөж буй хэлэлцүүлэг нь эмэгтэй улс төрчдийн дэвшүүлж буй бодлого гэхээс илүү тэдний хувийн зан чанарын талаар байдгийг нотлон харуулж байна. Нийгмийн сүлжээний сувгуудыг ашиглах нь эмэгтэй улс төрчид гадаад төрхийг нь гутаан доромжилох явдалтай нүүр тулгарахад хүргэж байгаа энэ нөхцөлд нийгмийн сүлжээний сувгууд алсдаа эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог хязгаарлах болох магадлалтай юм.

СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

Монгол Улс бүх салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах үүргийг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө төдийгүй нийт иргэдийнхээ өмнө хүлээсэн билээ. Энэ үүрэг хариуцлагыг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжиндоо тодорхой тусгаж, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад тодорхой ололт амжилт гаргасан боловч цар тахлын нөлөөгөөр олсон ололт амжилт алдагдаж, бусад салбартай харьцуулахад улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангалтгүй байгааг энэхүү судалгаа харуулж байна. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо бүрэн хангагдахгүй байхад олон зүйл нөлөөлж байгаа юм. Судалгааны хүрээнд тодорхойлогдсон эдгээр шалтгааныг арилгахад анхаарах шаардлагатай. Ялангуяа, эмэгтэй улс төрчид сонгуульд амжилттай өрсөлдөх нэг хүчин зүйл болох сонгогч, олон нийтэд танигдах, бодлого, мөрийн хөтөлбөрөө хүмүүст хүргэх шаардлагыг цахим байдлаар шийдвэрлэх боломжтой. Тиймээс сонгуулийн болон улс төрийн бусад үйл ажиллагаанд цахим платформууд, тэр дундаа нийгмийн сүлжээний сувгуудыг хэрэглэхтэй холбоотой хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эмэгтэйчүүдэд ээлтэй хэрэглээг бий болгох нь чухал юм.

Монгол Улсад хийгдсэн судалгаануудаас үзэхэд, эмэгтэйчүүд улс төрийн сонгуульд нэр дэвших, амжилттай өрсөлдөхөд санхүүгийн асуудал саад тээг учруулдаг болох нь харагдсан. Энэхүү судалгаанд өгүүлсэнчлэн, эмэгтэй улс төрчдийн сонгуулийн кампанит ажлын зардлын дийлэнх хэсэг нь сонгогчдод өөрсдийгөө болон мөрийн хөтөлбөрөө таниулахад зарцуулагддаг учраас нийгмийн сүлжээний сувгуудаар сонгуулийн сурталчилгаа явуулах нь харьцангуй зардал багатай арга зам юм. Үүний зэрэгцээ Их Британи зэрэг зарим оронд эмэгтэйчүүд crowd-funding буюу хөрөнгө бөөнөөр босгох үйл ажиллагаанд зориулсан платформуудыг улс төрийн үйл ажиллагаандаа ашиглах нь түгээмэл болоод байна. Иймд энэ жишгийг харгалзан монголын эмэгтэй улс төрчид нийгмийн сүлжээний сувгуудаар өөрсдийгөө сурталчлан таниулах, сонгогч, иргэдтэй тулж ажиллах, хөрөнгө босгох платформуудыг идэвхтэй ашиглах боломж бий. Асуулга судалгаанд оролцогчдын дийлэнх нь нийгмийн сүлжээний сувгуудыг улс төрийн ажилдаа идэвхтэй хэрэглэдэг байгаас үзэхэд ийм боломж өндөр байна. Гагцхүү тэднийг энэ чиглэлд сургаж,

чадавхжуулах, техник технологи ашиглах ур чадварыг нэмэгдүүлэх сургалтын үйл ажиллагааг хялбар бөгөөд өртөг багатайгаар, олон хүнд хүргэж зохион байгуулах шаардлагатай юм.

Хэдийгээр нийгмийн сүлжээний сувгууд нь эмэгтэйчүүдийн сонгогдох эрхийг хангахад нааштай нөлөө үзүүлж байгаа боловч онлайн хүчирхийлэл, доромжлолын бай болж байгаа талаар дэлхийн бусад оронд хийгдсэн судалгаа төдийгүй толилуулж буй энэхүү судалгаа нотлон харуулж байгаа юм. Иймд эмэгтэй улс төрчид онлайн хүчирхийлэл заналхийлэлд хариу үйлдэл үзүүлэх стратегитай болох шаардлагатай байна. Ялангуяа, судалгааны үр дүнгүүдэд дурдсанчлан, дийлэнх тохиолдолд эмэгтэй улс төрчид нийгмийн сүлжээний аккаунтуудаа өөрсдөө хөтөлдөг байгаа энэ нөхцөлд онлайн заналхийллийн бай болгохгүйн тулд дижитал технологид сурах, боломжтой бол нийгмийн сүлжээний сувгуудаа хөтлөх тусгайлан мэргэшсэн мэргэжилтнүүдийг авч ажиллуулах боломжийг судлах боломжтой.

Энэхүү судалгаанд шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудын үзүүлэх нөлөөлөлд дүн шинжилгээ хийсэн билээ. Цаашид энэ чиглэлийн судалгааг үргэлжлүүлэх тохиолдолд, эмэгтэй, эрэгтэй улс төрчдийн нийгмийн сүлжээний сувгуудын хэрэглээг харьцуулж үзсэний үндсэн дээр нийгмийн сүлжээний сувгууд тэдний алинд нь илүүтэй давуу тал үүсгэж байгаад дүн шинжилгээ хийх хэрэгцээ шаардлагай байна. Учир нь монголчуудын цахим хэрэглээг авч үзвэл, эрэгтэйчүүдтэй харьцуулбал эмэгтэйчүүдийн интернет хэрэглээ өндөртэй байгаа боловч улс төрчид сонгуулийн болон бусад улс төрийн үйл ажиллагаандаа нийгмийн сүлжээний сувгуудыг хэрэглэдэг болсноос хойш ч гэсэн улс төрд эрэгтэйчүүд давамгайлсан хэвээр байгаа юм. Өөрөөр хэлбэл, нийгмийн сүлжээний сувгууд эмэгтэйчүүдэд давуу талтай мэт боловч энэ нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад нөлөөлөл нь өндөр эсэхийг тогтоох шаардлага бий.

НОМ ЗҮЙ

- А.Цээсүрэн “Ховд аймгийн Засаг даргаар Э.Болормааг сонгожээ” (2022.08.29) <https://news.mn/r/2583939/>
- А.Төгөлдөр “УИХ эмэгтэй даргатай боллоо” (2020.06.30) <https://ikon.mn/n/1xdl>
- Б.Анхилам “Монголчуудын сошиал медиа хэрэглээг тандсан судалгааг хүргэж байна” (2021.01.05) <https://www.peak.mn/news/mongoliin-soshial-media-statistik>
- Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн “Залуучуудын санал бодлын судалгаа” УБ хот, 2020
- Залуу судлаачдыг дэмжих сан “Эмэгтэйчүүдийн амьдралын чанар-2021” судалгааны тайлан, УБ., 2021 он <https://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/18841.pdf>
- Жендэрийн үндэсний хороо “Монгол Улс: Жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин (Сүүлийн үеийн тоо баримтаар)” 2020 он

- Жендэрийн Үндэсний хороо “Суурь судалгааны тайлан” (2020 он)
- Г.Тэгшсүрэн “Шинэ сайд нар мэдээлэл өгч байна” <https://gogo.mn/r/ojn6d>
- Г.Батмандах “Залуу захирлууд ярьж байна” (2017.04.20) <https://news.mn/r/763325/>
- ЕАБХАБ, “ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгуулийн ажиглах хорооны тайлан”, 2016 он
- ЕАБХАБ “АИХЭГ-ийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны сонгууль ажиглах тусгай хорооны эцсийн тайлан”, Варшав хот, 2021 он https://www.osce.org/files/f/documents/9/6/509063_0.pdf
- Л.Бямбаханд “Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хязгаарлагч хүчин зүйлүүд” Монгол дахь ардчилал, иргэний нийгмийн өнөөгийн байдлын нийгэм-улс төрийн судалгаа, УБ 2020 он
- Монгол Улсын Үндсэн хууль <https://legalinfo.mn/mn/detail/367>
- Монголын Эмэгтэйчүүдийн Сан, “Орон нутгийн ИТХ-д нэр дэвшиж буй эмэгтэйчүүдийн чадавхийг үнэлэх нь” судалгааны тайлан”, 2012 он
- Монцамэ “УИХ-ын эмэгтэй гишүүд бүлэг байгуулав” (2020.08.20) <https://montsame.mn/mn/read/234160>
- Монцамэ “Л.Өлзийсайханыг УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилохыг дэмжив” (2019.05.08) <https://montsame.mn/mn/read/188770>
- Мэдээ. Мн “Э.Гэрэлт-од: Монгол Улсад нэг нам давамгайлсан улс төрийн тогтолцоо бүрдэж байна” (2021.03.25) <https://medee.mn/p/157682>
- НҮБХХ, “Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх нь” УБ хот, 2014 он
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм, 1945 он
- НҮБ, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт <https://legalinfo.mn/mn/detail/1257>
- О.Мөнхбат “Монголын интернэт хайлтыг сүлжээний бизнесүүд тэргүүлж, шинжлэх ухаан дата үүсэх хэмжээнд хүрсэнгүй” <http://itoim.mn/article/Ocv-Vj/27690>
- Р.Бурмаа, “Улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцоо: Туршлага ба сургамж. Монгол Улс”, УБ хот, 2013 он
- Р.Оюунцэцэг “Монголэмэгтэйчүүдтөртүшилцэхэдюсаадболдогвэ?” <https://ikon.mn/n/1rlr>
- Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайлан: Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн бүртгэлийн тайлан <https://csc.gov.mn/s/52/914>
- Ц.Мөнхцэцэг “Цахим популизм буюу сонгууль дахь сошиал сүлжээний нөлөө” (2017.10.27) <http://muki.mn/post/46623> Статистикийн мэдээллийн нэгдсэн сан “Монгол Улсын хүн амын тоо” https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_003V1&SEX_select_all=0&SEXSingleSelect=_1&AGE_GROUP5_select_all=0&AGE_GROUP5SingleSelect=_1&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2021&viewtype=table

- Цахим хөгжил, харилцаа холбооны яам “Судалгаа: Нийт өрхийн 80% нь интернэттэй, иргэдийн 97.6% нь гар утастай байна”(2022.02.22) <https://ikon.mn/n/2h0z>
- ҮСХ “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоо”, 2019 он
- ҮСХ “Интернет, гар утасны хэрэглээ”, УБ 2021 он https://1212.mn/BookLibrary-Download.ashx?url=Internet__phone_use_2020.pdf&ln=Mn
- Acar , E. (2012). Social Media June 12 general elections, Edibe Sozen (Ed.) , We globalize all local , Istanbul: Alfa Publications, 259-274
- Adeyanju, A. (2015). Comparative Study of Social Media, Television and Newspapers’ News Credibility, International Conference on Communication, Media, Technology and Design
- Amnesty International UK “Black and Asian women MPs abused more online” <https://www.amnesty.org.uk/online-violence-women-mps>
- AntónioGuterres “Remarks at the Opening of the 65th Session of the Commission on the Status of Women” (21 March, 2022) <https://www.un.org/sg/en/content/sg/speeches/2021-03-15/remarks-opening-of-65th-session-of-csw>
- Aaron Smith, Pew Research Center “The Internet’s Role in Campaign 2008” (April 15, 2009) <https://www.pewresearch.org/internet/2009/04/15/the-internets-role-in-campaign-2008/>
- Anwar, M., & Jan, M. (2010). Role of Media in Political Socialization: The Case of Pakistan. *Dialogue*, 5(3), 212- 27
- Bode, L., Vraga, E. K., Borah, P., Shah, V. D. (2014). A New Space for Political Behavior: Political Social Networking and its Democratic Consequences. *Journal of Computer-Mediated Communication*
- Bronstein, J., & Aharony, N. (2015). Personal and political elements of the use of social networking sites. *Information Research*, 20(1)Carnegie Endowment for International Peace “Tackling Online Abuse and Disinformation Targeting Women in Politics” (November 30, 2020) <https://carnegieendowment.org/2020/11/30/tackling-online-abuse-and-disinformation-targeting-women-in-politics-pub-83331>
- Kang, M. (2010). Measuring social media credibility: A study on a Measure of Blog Credibility. *Institute for Public Relations*, 59-68
- Hampton, N. K., Goulet, S. L., Rainie, L., Purcell, K. (2011) Social networking sites and our lives: How people’s trust, personal relationships, and civic and political involvement are connected to their use of social networking sites and other technologies. Pew Research Center’s Internet & American Life Project. Washington, D.C. 20036
- Himelboim, I., Lariscy, R. W., Tinkham, S. F., & Sweetser, K. D. (2012). Social media and online political communication: The role of interpersonal informational trust and openness. *Journal of Broadcasting & Electronic Media*, 56(1), 92-115
- Holt, K., Shehata, A., Stromback, J., & Ljungberg, E. (2013). Age and the effects of news media attention and social media use on political interest and participation: Do social media function as leveller? *European Journal of Communication*, 28, 19–34

- Hsieh, Y., & Li, M. (2014) Online political participation, civic talk, and media multiplexity: How Taiwanese citizens express political opinions on the Web. *Information, Communication & Society*, 17, 26–44
- Hyun, K. D., & Kim, J. (2015) Differential and interactive influences on political participation by different types of news activities and political conversation through social media. *Computers in Human Behavior*, 45, 328
- Johnson, J. K & Kaye, K. B. (2014). Credibility of Social Network Sites for Political Information among Politically Interested Internet Users. *Journal of Computer-Mediated Communication* 19, 957–974
- Gionis, A., Terzi, E., & Tsaparas, P. (2013). Opinion Maximization in Social Networks. In *SDM* (pp. 387-395)
- IKNOWPOLITICS “Summary of the discussion on online violence against women in politics” (November 2020) https://www.iknowpolitics.org/sites/default/files/summary_e-discussion_on_online_vawp.pdf
- Inter-parliamentary union “Women in parliament in 2020” The year in review https://www.iknowpolitics.org/sites/default/files/2020-women_in_parliament_en.pdf
- Inter-parliamentary union “Women in parliament in 2020” The year in review https://www.iknowpolitics.org/sites/default/files/2020-women_in_parliament_en.pdf
- Institute for Democracy and Electoral Assistance “The Impact of the COVID-19 Pandemic on Women in Politics” (21 March - 11 April 2022) <https://www.idea.int/news-media/events/impact-covid-19-pandemic-women-politics>
- IPU “New IPU report: more women in parliament and more countries with gender parity”(03 March 2022) <https://www.ipu.org/news/press-releases/2022-03/new-ipu-report-more-women-in-parliament-and-more-countries-with-gender-parity>
- IRIM судалгааны хүрээлэн. (2015). *Монгол Улс дахь Жендерийн эрх тэгш байдал (Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа)*. Улаанбаатар : Швейцарийн Хөгжлийн Агентлаг.
- IRIM “Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдал: (Нөхцөл байдлын товч үнэлгээ, Баримт бичгийн судалгаа), УБ, 2014 он
- MSMagazine “How Digital Media is Threatening Women’s Rights and Democracy” (November 31, 2021) <https://msmagazine.com/2021/11/30/social-media-bullying-trolls-online-abuse-harassment-womens-rights-democracy/>
- Muhamad, R. (2015). Online Opposition and Elections in Malaysia. *Asian Social Science*, 11(10), 281
- News Press “Д.Энхцэцэг: УИХ-ын 2020 оны сонгуулийн зардал хоёр дахин өссөн ч зарцуулалт нь тодорхойгүй байна”<https://news-press.mn/v1/%D0%AF%D1%80%D0%B8%D0%BB%D1%86%D0%B%D0%B0%D0%B3%D0%B0/news/26022>
- OECD “Women’s Political Participation in Jordan” OECD, 2018 <https://www.oecd.org/mena/governance/womens-political-participation-in-jordan.pdf>

- Payne, A. (2009). *The New Campaign: Social Networking Sites in the 2008 Presidential Election*
- Rainie, L., Smith, A., Schlozman, L. K., Brady, H., & Verba, S. (2012). *Social Media and Political Engagement*. Pew Research Center's Internet & American Life Project. Washington, D.C. 20036
- Skoric, M. M., Pan, J., & Poor, N. D. (2012, May). *Social Media and Citizen Engagement in a City-State: A Study of Singapore*. In *Sixth International AAAI Conference on Weblogs and Social Media*
- Smeltzer, S., & Keddy, D. (2010). *Won't you be my (political) friend? The changing face (book) of sociopolitical contestation in Malaysia*. *Canadian Journal of Development Studies/Revue canadienne d'études du développement*, 30(3-4), 421-440
- Smith, M. A., Shneiderman, B., Milic-Frayling, N., Mendes Rodrigues, E., Barash, V., Dunne, C., & Gleave, E. (2009) *Analyzing (social media) networks with NodeXL*. In *Proceedings of the fourth international conference on Communities and technologies* (pp. 255- 264)
- Tang, G., & Lee, F. F. (2013). *Facebook use and political participation: The impact of exposure to shared political information, connections with public political actors, and network structural heterogeneity*. *Social Science Computer Review*, 31, 763–773
- Vaccari, C., Valeriani, A., Barbera, P., Bonneau, R., Jost, J. T., Nagler, J., & Tucker, J. A. (2015). *Political expression and action on social media: Exploring the relationship between lower- and higher-threshold political activities among Twitter users in Italy*. *Journal of Computer-Mediated Communication*, 20, 221–239
- Wen, N., Xiaoming, H. A. O., & George, C. (2013). *Gender and political participation: News consumption, political efficacy and interpersonal communication*. *Asian Journal of Women's Studies*, 19(4), 124-149
- *Women in Parliaments Global Forum "Social Media: Advancing Women in Politics?"* (October 2016) https://www.womenpoliticalleaders.org/wp-content/uploads/2016/10/WIP-Harvard-Facebook-Study_Oct2016.pdf
- World Economic Forum "The Global Gender Gap Index 2018"
- World Economic Forum "The Global Gender Gap Index 2020"
- World Economic Forum "The Global Gender Gap Index 2021"https://www3.weforum.org/docs/WEF_GGGR_2021.pdf
- Zhang, X., & Lin, W.-Y. (2014). *Political participation in an unlikely place: How individuals engage in politics through social networking*. *International Journal of Communication*, 8, 21–42



Б.Гэрэлсүрэн

Монголбанкны мэдээллийн технологийн аудитор

ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ШИНЖИЛГЭЭ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

I. УДИРТГАЛ

Дэлхий дээр харилцаа холбоо, мэдээллийн технологийн хэрэглээ, зах зээл, орон зай, хил хязгааргүй болж хүний өдөр тутмын амьдрал, хөдөлмөр бүтээмж, эдийн засагт их өөрчлөлтийг авчирсан, аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал буюу дижитал хувьсгалын эринд бид амьдарч байна.

Улс орнуудын засгийн газар, бизнесийн байгууллагууд үйл ажиллагаа, үйлчилгээндээ дижитал шилжилт хийж, үүлэн технологи, юмсын интернэт, хиймэл оюун ухаан, блокчейн, их өгөгдөл, сансрын технологи, робот, 3D хэвлэл, генетик инженерчлэл, физик ертөнцийг биологи, дижитал ертөнцөд ойртуулах технологийн нэгдэлүүд нь дэлхийн бүх л салбарын инновац, хөгжлийг тодорхойлж байна.

Монгол Улсын хувьд Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.3.2.1-д “Цахим засгийг хөгжүүлэх замаар төрийн алба, үйлчилгээг иргэндээ хандсан, үр нөлөөтэй, шуурхай, хэмнэлттэй болгоно”, 3.6.2.2-р зүйлд “Төрийн мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангахын тулд үнэн, бодитой, цаг үеэ олсон, шаардлагатай мэдээллийг төрийн мэдээллийн санд төвлөрүүлж, эрх бүхий этгээд хамтран ашиглах солилцох нөхцөлийг бүрдүүлнэ”, 3.6.4.4-р зүйлд “Нийгэмд мэдээллийг хүртээмжтэй, түргэн, шуурхай хүргэх мэдээллийн хэрэгсэл, дэд бүтцийн хөгжлийг дэмжиж найдвартай ажиллагааг хангана” гэж тусгасан.¹

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийг баталсан. Үүндээ цахим засгийг хөгжүүлэх “Сайн засаглал” зорилгыг тодорхойлж “Үр дүнтэй цахим засаглал”, “Үр нөлөөтэй цахим засаглал”, “Иргэн төвтэй цахим засаглал” зорилтуудад хуваан, хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй, цахим засаглалыг хөгжүүлнэ гэж тусгасан.² Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх замаар эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгох зорилт тавьж ирэх дөрвөн жилд “Цахим үндэстэн” болох уриалгыг дэвшүүлж буй. Энэхүү зорилгын хүрээнд төрийн ажил, үйлчилгээг цахимжуулах, ашиглалтыг нь сайжруулах, цахим шилжилтийг шат дараатай хийх, иргэдийн мэдээллийн технологийн боловсролыг дээшлүүлэх, дижитал эдийн засгийг хөгжүүлэх, инновацид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухай дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн чадавх, инноваци үйлдвэрлэл, үндэсний хөгжлийн хурдасгуур гэсэн стратегийн зургаан зорилтыг дэвшүүлж, төлөвлөгөөг баталсан байна.

Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 4.1-д “цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй

1 Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” <https://legalinfo.mn/mn/detail?lawid=208070&showType=1>

2 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. <https://legalinfo.mn/mn/detail?lawid=211057&showType=1>

хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ”, 4.1.1-д “төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна” гэж тус тус бодлогын бичиг баримтууд, тогтоол шийдвэрт цахим шилжилт хийх төлөвлөгөө, алсын хараагаа тодорхойлжээ.

Иймд энэхүү “Монгол улсын цахим засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын хэрэгжилтийн шинжилгээ, цаашдын чиг хандлага” судалгаагаар цахим засаглалыг хөгжүүлэхээр баталсан бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, төрийн цахим үйлчилгээний нөхцөл байдал, цахим шилжилт хийж буй улс орнуудын туршлага, олон улсын чиг хандлагын талаар судалж, цаашид хэрэгжүүлэх санал, зөвлөмж боловсруулав.

1.1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэхэд захиргааны хүнд суртал, дүрэм журам тодорхой бус, албан хаагчдын мэргэшсэн бус, шуурхай бус байдал, сөрөг хандлагаас үүдэлтэй бэрхшээл саад нийтлэг шинжтэй болсон. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж тааруу, уян хатан бус байгаагаас иргэд, хувийн хэвшлийг дэмжсэн төрийн бодлого, зохицуулалтын үр дүн, үр нөлөө суларч байна. Тухайлбал, 2018 онд Дэлхийн банкны засаглалын судалгаагаар Монгол Улсын Засгийн газрын үр нөлөөний индекс 45.6 байгаа бөгөөд 209 улсаас 114-т эрэмбэлэгдсэн байна. Энэ нь төрийн бодлого, хэрэгжилт муу, төрийн үйлчилгээ иргэдийн хүсэн хүлээсэн шаардлагыг бүрэн хангахгүй байгааг илтгэнэ. Иймд: 1) төрийн үйлчилгээг үр дүнд чиглэгдсэн, уян хатан хэлбэрээр зохион байгуулах, 2) төрийн үйлчилгээг орон зай, цаг хугацааны саадыг даван туулж чадахуйц, хүнээс хамааралгүй, хүнд сурталгүй болгоход чиглэгдсэн “Цахим Монгол” шилжилт хийх нь зүйтэй юм.³

Засгийн газрын 2018.08.22-ний өдрийн “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 259 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төрийн цахим мэдээлэл солилцох тогтолцоонд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг, 2 дугаар хавсралтаар “Төрийн цахим мэдээлэл солилцох тогтолцоог ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг тус тус баталсан.⁴

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18 дахь заалт буюу Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн 196 дугаар тогтоолын хавсралт “Үндсэн тогтолцооны үйл ажиллагааг зохицуулах, тогтолцоо ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам” баталсан.⁵ Энэ журам нь суурь болон төрөлжсөн мэдээллийн сангаас үндсэн болон дэмжих тогтолцоонд мэдээлэл нийлүүлэх, үндсэн болон дэмжих тогтолцоогоор дамжуулан төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд үйлчилгээ авах, хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх замаар мэдээлэл солилцохтой холбоотой харилцааг зохицуулах зорилготой.

3 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” төслийн эхний хувилбар. УБ., 2019. 69 дэх тал

4 Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын хавсралт

5 Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралт

Төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй байлгах, төрийн бодлого боловсруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй, чирэгдэлгүй болгож, түргэн шуурхай хүргэх, иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хамтын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, харилцаа холбооны дэвшилтэт технологийг ашиглах замаар цахим үйлчилгээг тулгуур болгон улс орны дотоод гадаад харилцаа, засаглалын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах нь Цахим засаглал гэж ойлгож болно.

Төрийн байгууллага дээр өөрийн биеэр очилгүйгээр, төрийн үйлчилгээг байршил, цаг хугацаанаас үл хамааран хаанаас ч авах боломжийг бүрдүүлж, төрийн бүх үйлчилгээг үе шаттайгаар цахимжуулж буй “E-Mongolia” төрийн цахим үйлчилгээний нэгдсэн тогтолцоо болон гар утасны аппликейшнд төрийн 57 байгууллагын 574 үйлчилгээг цахимжуулж, 1,9 сая хэрэглэгчтэй, 800 мянган хүн гар утасны аппликейшн ашиглаж, давхардсан тоогоор 8,5 сая үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгжид үзүүлжээ.

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан хэлтсээс хоёр жил тутамд цахим засгийн хөгжлийн судалгааг гаргадаг. НҮБ-ын гишүүн 193 орны цахим засгийн хөгжлийг үнэлдэг энэ тайлан нь Онлайн үйлчилгээний индекс, Харилцаа холбоо дэд бүтцийн индекс, Хүний капиталын индекс гэсэн гурван бүлэг үндсэн үзүүлэлт дээр тооцоолон гаргадаг. Монгол улс цахим засгийн хөгжлийн индексээр 2016 онд 84, 2018, 2020 онуудад 92 дугаарт эрэмбэлэгдсэн.⁶

Дээрх үзүүлэлтээс харахад батлагдсан, төлөвлөсөн бодлого, шийдвэр хангалттай, ухаалаг төхөөрөмж, гар утас, интернэт хэрэглэгчдийн тоогоороо дэлхийд тэргүүлж байгаа ч цахим засгийн, дижитал өрсөлдөх чадварын олон улсын статистикт нэг л сайн урагшлахгүй байгаа нь юу өгүүлнэ вэ?

1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгааны зорилго нь цахим засаглалын өнөөгийн байдал, цахим засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын хэрэгжилтэд шинжилгээ хийж, цахим шилжилт хийсэн улс орнуудын сайн туршлага, олон улсын чиг хандлагын талаар судалж, бодлогын хэрэгжилтэд тулгарч буй асуудлыг тодорхойлж, сайжруулах санал, зөвлөмж боловсруулахад оршино.

1.3. СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

Судалгааны ажлын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Цахим засаглалын бодлого төлөвлөлт, эрх зүйн орчны өнөөгийн байдлын шинжилгээ хийх
- Цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлж буй улс орнуудын сайн туршлага, Олон улс, бүс нутгийн стратегиудад тусгагдсан цахим засаглал,

6 UN E-Government Surveys 2016, 2018, 2020

дигитал шилжилтийн талаарх бодлогын зорилго, зорилт, тэргүүлэх чиглэлийг судлах

- Дээр дурьдсан судалгаа, шинжилгээний үр дүнд дүгнэлт хийж, зөвлөмж боловсруулах

1.4. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааны ажилд чанарын судалгааны аргыг ашиглан мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хууль эрх зүйн орчин, бодлогын бичиг баримтууд, үндэсний хөтөлбөрүүдэд хэрэгжилтийн шинжилгээ хийлээ. Үүнд урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд багтсан болно. Энэхүү судалгаанд хэрэглэсэн дараах нэр томъёо, тодорхойлолтыг дор дурдсан утгаар хэрэглэв:

Цахим засаглал - Төрийн үйл ажиллагааг иргэдэд ил тод, түргэн шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хамтын ажиллагааг хангах, оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаанд мэдээллийн технологи, харилцаа холбооны дэвшилтэт технологийг ашиглах замаар цахим үйлчилгээг тулгуур болгон засаглалын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах үйл явцыг;

Дигитал засаглал – Цахим засаглалын хөгжлийн дараагийн үе шат буюу төрийн үйл ажиллагаанд дигитал дэвшилтэт технологиудыг нэвтрүүлсэн, төрийн байгууллага, иргэд, аж ахуйн нэгж, бизнесийн байгууллага хоорондын дигитал экосистем;

Дигитал шилжилт – Дигитал шилжилт нь дэвшилтэт технологи, интеграцлалын нэгдлээр тодорхойлогддог бөгөөд дигитал тогтолцоо, шинэлэг бизнесийн загвар, шинэ процесс давамгайлж, ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох үйл ажиллагаа;⁷

Дигитал засгийн газар гэдэг нь олон нийтийн үнэ цэнийг бий болгохын тулд засгийн газруудын шинэчлэлийн стратегийн нэг хэсэг болох дигитал технологийг ашиглахыг хэлнэ. Энэ нь дигитал засгийн газарт тулгуурладаг

Мэдээллийн үйлдвэрлэл, хүртээмжийг дэмждэг төрийн байгууллагууд, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд, иргэдийн холбоод, хувь хүмүүсээс бүрдсэн экосистем;

⁷ European Commission. (2019). Digital transformation. Retrieved from https://ec.europa.eu/growth/industry/policy/digitaltransformation_en

II. МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

2.1 МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Цахим засаглалын хөгжилд хууль, эрх зүйн орчин нь түүний хамрах хүрээ, зохицуулах харилцаа, хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан журмуудын хэрэгжилттэй нягт уялдаа холбоотой. Иймд одоо мөрдөгдөж байгаа Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын батлагдсан хуулиудын хамрах хүрээ, зохицуулах харилцааг тоймлож үзлээ.

Хүснэгт 1. Салбарын хууль, хуулийн зохицуулах харилцаа⁸

Хуулийн нэр	Батлагдсан он	Зохицуулалт
Харилцаа холбооны тухай хууль /шинэчилсэн найруулга/	2001	Харилцаа холбооны сүлжээ байгуулах, ашиглах, хамгаалах, зах зээлийн үр өгөөжтэй, шударга өрсөлдөөнийг дэмжих, иргэн, хуулийн этгээдийг харилцаа холбоо, мэдээллийн технологийн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээгээр хүртээмжтэй хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.
Радио долгионы тухай хууль	1999	Радио долгионыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулна.
Шуудангийн тухай хууль	2003	Шуудангийн сүлжээ, түүний ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон харилцааг зохицуулна.
Олон нийтийн радио, телевизийн тухай хууль	2005	Монголын ард түмэнд үйлчлэх олон нийтийн радио, телевизийг үүсгэн байгуулж, түүний зорилго, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, эрх зүйн үндсийг тогтооно.
Инновацийн тухай хууль	2012	Инновацийн үйл ажиллагааны зарчим, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, төрийн дэмжлэг, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулан эзэмших, ашиглах, эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна.
Шилэн дансны тухай хууль	2014	Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоо /цаашид "шилэн данс" гэх/-г бүрдүүлэхэд оршино.
Төрийн албаны тухай хууль	2017	Төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна.
Цахим гарын үсгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/	2021	Цахим орчинд хүн, хуулийн этгээд цахим гарын үсэг хэрэглэх, түүнд тавигдах эрх зүйн болон техникийн шаардлага, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.
Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/	2021	Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулахтай холбогдсон харилцааг тухайлсан хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

8 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан <https://legalinfo.mn/mn>

Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль	2021	Хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.
Кибер аюулгүй байдлын тухай хууль	2021	Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо, зарчим, эрх зүйн үндсийг тогтоох, кибер орон зай, кибер орчин дахь мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Дээрх хүснэгтэд дурьдсан хуулиудаас судалгааны хүрээнд нийцэх Харилцаа холбооны тухай хууль болон цахим засгийн хөгжлийн багц хууль болох Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль, Хууль тогтоомжийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1. хэсэгт заасан “хууль тогтоомжийн зорилгыг хангаж байгаа түвшинг тодорхойлох” шинжилгээ хийлээ.

2.1.1 Харилцаа холбооны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн хэм хэмжээний хүрээнд

Зах зээлийн харилцааны нөхцөлд зохицсон эрх зүйн харилцааг бүрдүүлэх зохицуулах зорилгоор “Монгол Улсын Харилцаа холбооны тухай хууль” 1995 онд батлагдсан нь манай улсын харилцаа холбооны салбарын бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлэх, цахилгаан холбооны сүлжээ ба үйлчилгээг зах зээлийн харилцаанд шилжүүлэх эхлэлийг тавьсан гэж үздэг.⁹ Улмаар 2001 онд батлагдсан Харилцаа холбооны тухай хуулийн шинэчилсэн найруулга нь харилцаа холбооны зах зээл дэх төрийн оролцоог багасгах зорилгоор хөндлөнгийн зохицуулалтын механизмыг бүрдүүлж өгсөн ба үүнээс хойш энэхүү хуулинд нийтдээ 11 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөж байна.

Засгийн газар нь хуулийг хэрэгжүүлэх бүрэн эрхийн хүрээнд хуулийн 5.1.5 “харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр мэдлэг шингэсэн өндөр технологи, экспортын чиг баримжаатай үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бодлогын судалгаа шинжилгээний байгууллагын дүрэм, зардлыг санхүүжүүлэх журам” мөн хуулийн 30¹.3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэх захиргааны байгууллагын жагсаалтыг Засгийн газар гэж тус тус заасан ч журам батлагдаагүй, хэрэгжилтгүй байна.

Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хуулийн дараах заалтуудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

6.1.3. харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинэ технологи нэвтрүүлэх, давамгайл байдлаа сөргөөр ашиглахыг хязгаарлаж, өрсөлдөөнийг дэмжихэд баримтлах чиглэл, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбогдсон журам, заавар, аргачлал батлах, хэрэгжилтийг зохион байгуулах; технологи нэвтрүүлэхтэй холбогдсон журам, заавар, аргачлал батлах, хэрэгжилтийг зохион байгуулах;

⁹ Ж.Баатархүү. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжлийн судалгаа. УБ., 2018. 11 дэх тал

6.1.15.г.харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүний оюуны өмч, зохиогчийн эрхийг хамгаалах

6.1.15.д.төрийн байгууллагын үйл ажиллагаа болон харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн судалгаа шинжилгээний ажлын харилцан уялдааг хангах;

Харилцаа холбооны тухай хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлтөөр хуулийн 30¹дүгээр зүйлд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудитын зохицуулалт туссан. Мөн аудитын эрх зүйн харилцааг зохицуулахаар хэсгүүд туссан ч батлагдаагүй, хэрэгжилтгүй байна.

30¹.2.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, эрх олгох журам, харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийх аргачлалыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дарга батална.

30¹.4.Энэ хуулийн 30¹.3-т заасан жагсаалтад хамаарах байгууллага хоёр жил тутам харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн тайлангаа харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж, тайланг олон нийтэд нээлттэй, ил тод байлгана.

2.1.1 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн хэм хэмжээний хүрээнд

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана гэж заасны дагуу нийт 67 мэдээллийг цахим хуудсаараа болон хэвлэл мэдээлэлд нээлттэй ил тод болгохоор хуульчилсан ч энэ ажил хэрэгжиж эхлээгүй байна. Хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний хүрээнд 18 (Засгийн газрын тогтоолоор-13, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалаар-3, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Хууль зүй дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар-1) журам, заавар, төлөвлөлт батлагдах ёстойгоос 10 журам батлагдсан байна. Үүнд¹⁰:

- Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн 196 дугаар тогтоолын хавсралт “Үндсэн тогтолцооны үйл ажиллагааг зохицуулах, тогтолцоо ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”
- Засгийн газрын 2022.05.18-ны өдрийн 200 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”
- Засгийн газрын 2022.05.18-ны өдрийн 200 дугаар тогтоолын 2 дугаар

¹⁰ Цахим хөгжил харилцаа холбооны яамны цахим хуудас. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан <https://legalinfo.mn/mn>

- хавсралт “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн тогтолцооны үйл ажиллагааны журам”
- Засгийн газрын 2022.05.18-ны өдрийн 201 дүгээр тогтоолын хавсралт “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”
 - Засгийн газрын 2022.05.18-ны өдрийн 202 дугаар тогтоолын хавсралт “Нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал”
 - Засгийн газрын 2022.05.25-ны өдрийн 206 дугаар тогтоолын хавсралт “Хүн, хуулийн этгээдэд цаасан хэлбэрээр мэдээлэл өгөхтэй холбогдон гарах зардал тооцох аргачлал, зардлыг төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам”
 - Засгийн газрын 2022.05.31-ний өдрийн 211 дүгээр тогтоолын хавсралт “Хязгаарлалттай мэдээллийг өгсөн, дамжуулсан тохиолдолд мэдээллийн эзэнд мэдэгдэл хүргүүлэх, ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх журам”
 - Засгийн газрын 2022.05.31-ний өдрийн 219 дугаар тогтоолын хавсралт “Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам”
 - Засгийн газрын 2022.06.15-ны өдрийн 232 дугаар тогтоолын хавсралт “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”
 - Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022.05.02-ны өдрийн А/18 дугаар тушаалын хавсралт “Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн тогтолцоо үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам”

Хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн хэм хэмжээний хүрээнд батлагдаагүй 8 журам байна. Үүнд:

Засгийн газрын тогтоолоор:

- Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам
- Төрийн үйлчилгээний нэгдсэн тогтолцоогоор дамжуулан мэдээлэл хариуцагчаас олгох лавлагаа, тодорхойлолтын загвар
- Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам
- Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлт
- Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журам

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын тушаалаар:

- Нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг зохион байгуулах,

үнэлгээ хийх, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам /ХЗДХ-ийн болон ЦХХХ-ны сайд хамтран батлах/

- Үндсэн тогтолцоо, дэмжих тогтолцооны техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал
- Цахим хэлбэрээр үүсгэх нийтийн мэдээллийн сангийн нэгдсэн ангилал, код, тайлбар

2.1.3 Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн хэм хэмжээний хүрээнд

Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн талаарх төрийн зохицуулалтыг бий болгох, Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022.06.23-ны өдрийн А/28 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчид гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”, 2022.06.29-ний өдрийн А/30 дугаар тушаалаар “Тоон гарын үсгийн гэрчилгээний үндэсний сан бүрдүүлэх журам” баталсан. Цахим хөгжил харилцаа холбооны яам нь “Нийтийн түлхүүрийг гэрчилгээжүүлэх, гэрчилгээ олгосон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тухай мэдээллийг агуулсан гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэхтэй холбогдсон журам”, “Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлагыг тодорхойлох, аюулгүй байдлын хяналтыг тодорхойлсон баримт бичиг”, “Нийтийн түлхүүрийн дэд бүтцэд тавигдах шаардлага”, “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглах талаар хөгжлийн бодлогын баримт”-ыг боловсруулж, батлан мөрдүүлэхээр хуулинд туссан ч батлагдаагүй байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглахтай холбогдсон нийтлэг дүрэм, журам, заавар”, “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн стандарт”, “Гэрчилгээ олгох үйлчилгээний тариф тогтоох аргачлал”, “Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлага, аюулгүй байдлын хяналтыг тодорхойлсон баримт бичиг”, “Гэрчилгээний мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, хадгалах журам”, “Гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой бүртгэл журам”-уудыг Цахимын гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотой дахин боловсруулж, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.

2.1.4 Хувь хүний өгөгдөл хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн хэм хэмжээний хүрээнд

Хувь хүний өгөгдөл хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр дагаж мөрдөхөөс өмнө хуулиар зөвшөөрснөөс бусад мэдээлэл хариуцагчийн цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг устгах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын 2022.04.13-ны өдрийн 55 тоот захирамжаар байгуулагдан, ажлын хэсгийн удирдамжид туссан

ажлуудыг богино хугацаанд хэрэгжүүлжээ.

Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2-т заасан хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журмыг батлаагүй байна.

Хуульд "Мэдээлэл хариуцагч" гэж хуульд заасны дагуу, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг хэлнэ гэж тодорхойлсон. Иймд Мэдээлэл хариуцагч хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж болох бөгөөд мэдээллийн эзний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөхүйц шийдвэр гаргах, хүний эмзэг мэдээллийг байнга боловсруулах тохиолдолд үнэлгээ хийх аргачлал, журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар хуулинд заасан ч хэрэгжээгүй байна.

2.1.5 Кибер аюулгүй байдлын хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн хэм хэмжээний хүрээнд

Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн 197 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах, ашиглах журам", 2 дугаар хавсралтаар "Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох байгууллагын жагсаалт"¹¹ мөн Засгийн газрын 2022.05.25-ны өдрийн 207 дугаар тогтоолын хавсралт "Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалт"¹²-ыг тус тус баталсан байна. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад 16 чиглэлийн 216 байгууллага багтсан байна.

Кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох, хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журам", "Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги", "Үндэсний хэмжээний кибер халдлагаас хамгаалах төлөвлөгөө", "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх үндэсний төв болон нийтийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төвүүдийн ажиллах журам, тавигдах шаардлага", "Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тоо, ажиллах журмыг батлах" зэрэг журам, стратеги, төлөвлөгөө Засгийн газраас батлагдахаар хуулинд туссан ч батлагдаагүй байна.

Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох, хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам", Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журмыг тагнуулын байгууллага, зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлыг хангах байгууллагатай хамтран боловсруулах, Кибер аюулгүй байдлын үндэсний стратегийг зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлыг хангах байгууллагатай хамтран боловсруулах, Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам,

¹¹ Засгийн газрын 2022 оны 197 дугаар тогтоолын хавсралт

¹² Засгийн газрын 2022 оны 207 дугаар тогтоолын хавсралт

аргачлалыг тагнуулын байгууллагатай хамтран боловсруулж батлахаар тус тус туссан ч боловсруулж, батлагдаагүй байгаа нь цахим засгийн хөгжлийн нэг тулгуур, кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны тогтолцоо бий болох хүчин зүйлсийг хязгаарлаж байна.

2.1.6 Бүлгийн дүгнэлт

Монгол улсын хэмжээнд өнөөгийн байдлаар 830 хууль батлагдан мөрдөгдөж байгаагаас мэдээллийн сан, цахим бүртгэл, цахим харилцаа, мэдээллийн тогтолцоотой холбоотой зохицуулалт 157 хуулинд тусгагдсан байна. Татварын ерөнхий хууль, Иргэний хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Сонгуулийн автоматжуулсан тогтолцооны тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төв банкны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Авлигын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль зэрэг бусад салбарын хуулийн зохицуулалтад мэдээллийн технологи, харилцаа холбоо, цахим харилцаа, мэдээллийн сантай холбоотой зүйл заалтын нэр томъёо болон салбар хоорондын уялдааг хангах, эрх зүйн зохицуулалтыг хянах шаардлага урган гарч байна. Төрийн цахим шилжилтийг хийхэд салбар хоорондын мэдээллийн сан дахь нэг утгатай мэдээлэл нь зөрөх, давхардах магадлалтай тул хууль, эрх зүйн актын технологийн нэр томъёо, тодорхойлолт, зохицуулах харилцааг нийцүүлэх шаардлагатай байна. Цахим засгийг хөгжүүлэх эрх зүйн орчны үндэс суурь болсон багц хуулиудыг хэрэгжүүлэх журам батлагдаагүй, дагаж мөрдөх заавар аргачлал, журмын хэрэгжилт хангалтгүй байгаа нь хуулиудын зорилгыг биелүүлэх эрх зүйн чадамжгүй байна.

2.2 МОНГОЛ УЛСЫН УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГОД ОРСОН ЦАХИМ ЗАСАГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Энэ хэсгээр Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.1-д заасан урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан цахим засаглал, төрийн үйлчилгээг цахимжуулахтай холбоотой зорилго, зорилтуудыг тоймлож, цахим засаглалыг хөгжүүлэхээр батлагдсан, хэрэгжих хугацаа нь дууссан үндэсний хөтөлбөрүүдийн биелэлт, мөн бусад салбарын хөгжлийн бодлогод цахим шилжилттэй холбоотой арга хэмжээ, төлөвлөгөө тусгагдсан эсэх, хоорондын уялдаа холбоог судлана.

2.3 “АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан урт хугацааны хөгжлийн бодлогод 9 зорилго дэвшүүлсний нэг болох “Сайн засаглал” зорилтын хүрээнд хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй, цахим засаглалыг төлөвшүүлнэ гэж тусгажээ. “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг - тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба

төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр - хувийн хэвшил - иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүхий л хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно” гэж сайн засаглалыг тодорхойлсон.¹³

Хүснэгт 2. Цахим Монгол зорилтыг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагааны ерөнхий чиглэл

1-р үе шат (2020-2030)	2-р үе шат (2031-2040)	3-р үе шат (2041-2050)
Үр дүнтэй цахим засаглал	Үр нөлөөтэй цахим засаглал	Иргэн төвтэй цахим засаглал
Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлэх үе	Эдийн засаг, нийгмийн бүх салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновацийг нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх үе	Хүний хөгжлийг дэмжсэн цахим засаглалыг хөгжүүлэх үе
<ol style="list-style-type: none"> 1. Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, төгөлдөржүүлэх 2. Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгож хөгжүүлэх 3. Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээг шат дамжлагагүй, шуурхай болгох 4. Төрийн байгууллагууд хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээлэл солилцоо сайжирч, захиргааны зардлыг бууруулж, үйлчилгээний үр дүнг сайжруулах 5. Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Цахим засаглалыг хөгжүүлэх бодлого, эрх зүйн орчныг олон улсын жишигт хүргэх 2. Цахим мэдээллийн нэгдсэн санг эдийн засгийн харилцаанд бүрэн шилжүүлэх 3. Иргэдийн төрийн үйлчилгээнд зарцуулах хугацааг багасгах 4. Иргэн, төр, бизнесийн байгууллагууд мэдээлэл солилцооны үүлэн технологид бүрэн шилжүүлж, ил тод төрийн албаны тогтолцоог бэхжүүлэх 	<ol style="list-style-type: none"> 1. Хүний хөгжлийг дэмжсэн цахим засаглалын бодлого, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх 2. Цахим мэдээллийн нэгдсэн сангийн дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлж хөгжүүлэх 3. Иргэн төвтэй, ухаалаг засаглалыг төлөвшүүлэх 4. Иргэн, төр, бизнесийн байгууллагуудын мэдээлэл солилцооны чанарыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх 5. Цахим засаглалын технологийг олон улсын жишигт хүргэн авлига, хүнд сурталгүй нийгмийн харилцааг төлөвшүүлэх

¹³ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” төслийн эхний хувилбар. УБ., 2019. 87 дах тал

2.3.1 Цахим Монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн тогтолцоо) зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа¹⁴

Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, төгөлдөржүүлэх чиглэлээр:

- Мэдээллийн аюулгүй байдлын, Цахим гарын үсгийн, Мэдээллийн сангийн, Хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг боловсруулж батлуулан, түүнтэй нийцүүлэн холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулна.
- Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлж хэвшүүлнэ.
- Цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардлагатай мэдээллийн технологийн салбарын стандарт, тушаал шийдвэр, дүрэм, журмыг боловсруулж, батална.

Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгож хөгжүүлэх чиглэлээр:

- Их өгөгдөл (big data)-д суурилсан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг бий болгоно.
- Интернэтийн хурдыг нэмэгдүүлж, орон нутгийн түвшинд иргэд интернэт ашиглах чадварыг сайжруулна.
- Орон зайн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлж шийдвэр гаргах бүх түвшинд ашиглана.
- Газарзүйн мэдээллийн тогтолцоонд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ.
- Цахим бизнес, онлайн, зайн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээг шат дамжлагагүй, шуурхай хүргэх тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр:

- Төрийн байгууллагаас авдаг тодорхойлолт, зөвшөөрөл, лавлагаа, дүгнэлтийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, хөдөлгөөнт холбооны технологийг ашиглан төрийн үйлчилгээний нэгдсэн порталаас үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Цахим төлбөр тооцооны тогтолцоог төрийн мэдээлэл солилцооны нэгдсэн тогтолцоотой холбоно.
- Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэхэд мэдээлэл, харилцаа холбооны дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн оролцоог дэмжиж хэрэгжүүлнэ.

¹⁴ Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

- Нэг иргэн-нэг бүртгэл хөтөлбөрийг эрчимжүүлж, төр иргэнээс нэг л удаа мэдээлэл авдаг тогтолцоонд шилжүүлнэ.

Төрийн байгууллагууд хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээлэл солилцоог сайжруулан, захиргааны зардлыг бууруулж, үйлчилгээний үр дүнг дээшлүүлэх чиглэлээр:

- Төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох үүлэн тооцооллын дэд бүтцийг өргөтгөж хөгжүүлнэ.
- Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, сүлжээ бий болгоно.
- Төрийн байгууллагад мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой хэрэглээг нэвтрүүлэх, байгууллага хооронд сайн туршлага хуваалцах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.
- Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцад иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлж оролцоог хангах, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр:

- Иргэд төрийн байгууллагын албан тушаалтнуудтай цахим хэлбэрээр харилцах соёлыг хэвшүүлнэ.
- Тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянах тогтолцоог бүрдүүлж, хэвшүүлнэ.
- Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлэх, хүнд суртал, авлига хамгийн их үүсгэж буй үйлчилгээг цахимжуулна. (Цахим гааль, цахим татвар, цахим иргэний бүртгэл, цахим шүүх, цахим газрын харилцаа, цахим эрүүл мэнд, цахим боловсрол гэх мэт)
- Хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд оролцох, төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.
- Мэдээллийн технологийн аудитын чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэн төрийн байгууллагын үйлчилгээ болон мэдээллийг цахим хэлбэрээр хүргэж байгаа байдалд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх үйл ажиллагааг хэвшүүлнэ.

Зураг 1. Цахим Монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн тогтолцоо) зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа



2.5 МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030

Улсын Их Хурлын 2016 оны 02 сарын 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баталсан. Дэлхийн Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн 17 зорилго, 169 зорилттой уялдуулж боловсруулсан үзэл баримтлалд мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хөгжлийн хүрэх үр дүнг 3 үе шатаар төлөвлөжээ.¹⁵ Үүнд:

Мэдээллийн технологийн, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөнө.

I үе шат (2016-2020): Нийт хүн амын 70 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, газар нутгийн байршлаас үл хамаарсан ижил үнэ, тарифыг мөрдөж, Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалын хэмжээг арав дахин нэмэгдүүлэх.

II үе шат (2021-2025): Нийт хүн амын 90 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, хөдөө, орон нутгийн хүн амын 70 хувь нь өргөн зурвасын интернетийн үйлчилгээ ашиглах, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 50-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлэх.

¹⁵ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030

III үе шат (2026-2030): Нийт хүн амын 95 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 85-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөн ашиглах.

Технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа туршин нэвтрүүлэх санхүүжилтийг 2016-2020 онд ДНБ-ий 2 хувь, 2025 онд 2,5 хувь, 2030 онд 3 хувь хүртэлх түвшинд хүргэнэ.

2.6 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Улсын Их Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан Засгийн газар 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө боловсруулахдаа халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг амжилттай даван туулж, хүн, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулах, бүс ба орон нутгийг хөгжүүлэх, өмнөх Засгийн газрын бодлогын залгамж чанарыг хадгалахад онцгой анхаарч, зургаан багц асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилго, зорилтууд дэвшүүлжээ. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд багтсан төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай хүргэх, цахим засаглалыг хөгжүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой “Засаглалын бодлого”-ын хэсгүүдийг түүвэрлэлээ. Үүнд:

2.6.1 “Цахим Монгол” төрийн шуурхай үйлчилгээ¹⁶

- Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.
- Төрийн байгууллагын мэдээллийг иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг байдлыг халж, иргэд нэг удаа бүртгүүлээд төрийн цахим үйлчилгээг шуурхай авдаг болох зорилтыг бүрэн хэрэгжүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” арга хэмжээг үргэлжлүүлэн, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн стандартад оруулна.
- Хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн, технологийн аюулгүй, зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлийг шинэ түвшинд гаргана.
- Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.
- Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.
- Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах дэд бүтцийг байгуулж, хамрах хүрээг өргөжүүлж, багтаамжийг нэмэгдүүлнэ.

¹⁶ Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралт. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

- Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ.
- Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.
- Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.
- Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.
- Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн санг цалингийн нэгдсэн тогтолцоотой холбож, орон тоо, цалин хөлсний зардлын төлөвлөлт, хэрэгжилт, хяналтыг сайжруулна.
- Цахим сургалтын платформ бий болгож, цахим агуулга хөгжүүлж бэлтгэнэ. Зурагт болон интернэтгүй өрх, хүн амыг цахим сургалтад хамрагдах боломжийг бий болгохын тулд тохирсон сургалтын хэлбэр, хувилбаруудыг судалж, бэлтгэнэ.
- Цахим сургалтын тогтолцоог бий болгох, хууль эрх зүйн бүрдүүлнэ.
- “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.
- Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд зөвшөөрлийн цахим бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төрөөс олгох зөвшөөрлийн тоог цөөлж, олон шат, дамжлагыг багасгах, бизнес ээлтэй хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг боловсронгуй болгоно.

2.7 МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан үндсэн чиглэлийн зорилт-5 болох Засаглал зорилтод “Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болно” тусгажээ¹⁷. Зорилтын хүрээнд цахим засаглалыг хөгжүүлэхтэй холбоотой заалтуудыг шүүж үзлээ. Үүнд:

17 Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралт. Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

2.7.1 Засаглал. Цахим Монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн тогтолцоо)

- Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ.
- Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбоно.
- Цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгож хөгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлттэй болгоно.
- Төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал бууран үйлчилгээний үр дүн сайжирна.
- Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал нэмэгдэж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөл бүрдэнэ.

Мэдээллийн аюулгүй байдал:

- Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийг үндэсний чадавхыг бэхжүүлнэ.
- Кибер аюулгүй байдлыг хангах тогтолцоог бэхжүүлнэ.
- Мэдээлэл, технологи, харилцаа холбооны тогтолцоо, техник хэрэгсэл, програм хангамжийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн тогтолцоо бүрдэж, технологийн хараат байдал буурч, кибер гэмт хэрэг, кибер хандлагатай тэмцэх чадавх дээшилсэн байна.

Хүснэгт 3. Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд орсон бусад салбарын цахимжилтын төлөвлөгөө

Салбар	Үйл ажиллагаа
Боловсрол	<ul style="list-style-type: none"> - Цахим, зайн сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтоон, сургалтын платформыг хөгжүүлэн багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлсэн насан туршийн тогтолцоог бэхжүүлнэ. - Боловсролын удирдлагын мэдээллийн тогтолцоог бүх түвшинд хөгжүүлж, бусад салбарын мэдээллийн сантай холбон, бодлого, төлөвлөлт, статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашиглан, боловсролын үйлчилгээг цахимжуулна.
Эрүүл мэнд	Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ
Хөдөлмөрийн зах зээл	Оюуны хөдөлмөрийг дэмжсэн, цахим зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ.
Ухаалаг санхүүгийн зах зээл	Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ.

Хууль сахиулах салбарын хөгжил	Хууль сахиулах байгууллагад иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдож, иргэдэд үйлчлэх таатай орчныг бүрдүүлнэ
Дагуул хот	Цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулна

2.8 “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО” ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Шинэ сэргэлтийн бодлого”, 2 дугаар хавсралтаар “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр, 3 дугаар хавсралтаар “Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалт батлагдсан.¹⁸ Шинэ сэргэлтийн бодлого нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, биеэ даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /Ковид-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтцийн болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөрт зургаан багц асуудлыг дэвшүүлжээ. Багц зорилтын зургаа дахь нь Төрийн бүтээмжийн сэргэлт зорилт бөгөөд төрийн үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна гэж тусгасан байна. Үүнд:

- Цахим үндэстэн болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн тогтолцооноос олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх
- Оройн зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч бусад байгууллагын санг нэгдсэн стандартад шилжүүлэх, геопорталаар дамжуулан төрийн бодлого төлөвлөлт, шийдвэр гаргалтын “Нэг газрын зураг”, иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай “Нээлттэй газрын зураг” цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлэх
- Хаягийн нэгдсэн тогтолцоог хэрэглээнд нэвтрүүлэх
- Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн тогтолцоонд суурилсан 3 болон 4 хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх

¹⁸ Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Шинэ сэргэлтийн бодлого

- Улсын хэмжээнд хот суурины төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулах
- Цахим үйл ажиллагаатай газрын биржийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулан газрын биржийн үйл ажиллагааны тодорхой хувиар газар хөгжүүлэх санг бүрдүүлж, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах
- Инновац, аж үйлдвэрийн IV хувьсгал, хиймэл оюун, блокчейн зэрэг технологийн хөгжилд түшиглэсэн шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх
- Гаалийн хяналт бүрдүүлэлт, лабораторийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хилийн хяналт шалгалтад зарцуулах хугацааг бууруулах
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулж, тусгай зөвшөөрлийн тоон нэмэгдүүлэн хөрөнгө оруулалтыг татах боломжийг бүрдүүлэх
- Төрийн үйл ажиллагааг ил тод шуурхай болгох, төрийн хүнд суртлыг арилгах, бизнес эрхлэгчдийг дэмжих тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тоог 2 дахин цөөрүүлж, цахимаар олгох, сунгах боломжийг бүрдүүлэх

Тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн санг бүрдүүлж, нээлттэй байлгах

“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн үйл ажиллагааг хүнд сурталгүй, түргэн шуурхай цахимаар хүргэх, цахим шилжилттэй холбоотой 14 зорилт бүхий арга хэмжээ, түүний хүрэх үр дүнг тодорхойлж өгсөн байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулах, Хаягий нэгдсэн тогтолцоо бий болгох, Төрийн үйл ажиллагааг ил тод, шуурхай болгох, төрийн хүнд суртлыг арилгах, бизнес эрхлэгчдийг дэмжих тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн тоог 2 дахин цөөрүүлж, цахимаар олгох, сунгах боломжийг бүрдүүлэхээр тусгаж өгсөн нь өмнөх бодлогын бичиг баримтуудаас давхцалгүй байна.

2.9 ЦАХИМ ҮНДЭСТЭН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/24 тушаалаар “Цахим үндэстэн” баримтлах чиглэл, дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг батлан, 2022-2027 онд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.¹⁹ Монгол улсын эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, мэдлэг оюунд тулгуурласан цахим үндэстнийг цогцлоон хөгжүүлэх зорилготой уг хөтөлбөрт дэд бүтцийн бэлэн байдлыг хангах, цахим засаглалыг хөгжүүлэх, кибер аюулгүй байдлыг хангах, тоон бичиг үсгийн чадавхийг сайжруулах, инновац үйлдвэрлэлийг хөгжүүлэх, технологийн дэвшлийг үндэстний хөгжлийн хурдасгуур болох 6 зорилт дэвшүүлсэн байна.

¹⁹ Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/24 тушаал, <https://mddc.gov.mn/mn/>

Зураг 2. Цахим үндэстэн дунд хугацааны хөтөлбөрийн зорилтууд



Зорилт 1. Дижитал дэд бүтэц

Мэдээллийн технологи, харилцаа холбооны өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангахуйц суурь дэд бүтцийн бэлэн байдлыг хангана.

Зорилт 2. Цахим засаглалыг хөгжүүлэх

Нийгэм, эдийн засгийн бүх салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологи, инновацийг нэвтрүүлж, бүтээмж, үр ашгийн нэмэгдүүлэх замаар хүнд сурталгүй, шуурхай, ил тод цахим засаглалыг хөгжүүлнэ.

Зорилт 3. Кибер аюулгүй байдлыг хангах

Цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэн, төр хувийн хэвшил, иргэний мэдээллийн аюулгүй байдлыг мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан хүртээмжтэй байдлыг хангана.

Зорилт 4. Тоон бичиг үсгийн чадавхийг сайжруулах

Бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхийг дээшлүүлэн, тоон хуваагдалыг бууруулж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ололт амжилтад тулгуурлан нийгэм эдийн засгийн бүхий л салбарт инновац хийх чадвартай бүтээлч иргэдтэй болно.

Зорилт 5. Инновац үйлдвэрлэлийг хөгжүүлэх

Мэдээллийн технологи, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, юмсын интернэт, үүлэн технологи, блокчэйн зэрэг шинэ дэвшилтэт технологид суурилсан тогтолцоонуудыг

хөгжүүлж, электроникийн үйлдвэрлэл, судалгаа шинжилгээ, технологи дамжуулалт, инновац, үйлдвэрлэлийг дэмжих замаар дижитал эдийн засгийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

Зорилт 6. Үндэсний хөгжлийн хурдасгуур

Нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлж, өрсөлдөх чадвар, бүтээмж, үр өгөөжийг дээшлүүлнэ.

БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

“Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилтууд болох Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Сайн засаглал, Амар тайван, аюулгүй нийгэм дэд хэсгүүдэд цахим засаглалыг хөгжүүлж бэхжүүлэх төлөвлөгөө болон соёлын үйлдвэрлэл, эрүүл мэнд, хууль сахиулах, боловсрол, байгаль орчин, нийтийн тээвэр, төрийн албаны зэрэг цахим шилжилттэй холбоотой нийт 121 зорилго, зорилт багтсан нь мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хөгжил, инновац нь бусад салбарын хөгжил, алсын харааг тодорхойлж байгааг харж болно. Гэвч салбар бүр тусдаа цахим хөгжлийн алсын хараатй байгаа нь салбар хоорондын цахим засаглалын бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалт, хүний нөөцийн уялдаа байхгүй, төлөвлөлтөд давхардал үүссэн байна.

Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэл бодлогын баримт бичигт туссан **Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн тогтолцоо) зорилт нь** Алсын хараа-2050 бодлогын Цахим Монгол зорилтын I үе шат (2020-2030) болох Үр дүнтэй цахим засаглал дэд зорилттой нийцэж байна. Мөн бодлогын бичиг баримтад боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөрийн зах зээл, санхүүгийн зах зээл, хууль сахиулах салбарын цахим үйлчилгээ, цахим мэдээллийн сан, цахим шилжилт, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой нийт 20 зорилт багтсан байна.

Улсын Их Хурлын тогтоолоор 2016 онд батлагдсан “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичгийг биелэлт тооцох хугацаанаас нь өмнө буюу Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон байна. Иймд үзэл баримтлалын I үе шат (2016-2020)-д нийт хүн амын 70 хувийг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбоно гэж төлөвлөсөн бөгөөд 2022 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын нийт хүн амын 84.3% нь интернэт хэрэглэж байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Цахим Монгол төрийн шуурхай үйлчилгээ” төлөвлөгөөнөөс гадна бусад нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбарт төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим шилжилт хийхтэй холбоотой цахим сургалтын платформ, эрүүл мэндийн нэгдсэн сан үүсгэж цахим эрт илрүүлэг, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарыг цахимжуулах, аялал жуулчлалын цахим платформ, уламжлал соёлын цахим контент, цахим соёлын сан, хөрөнгийн биржийн арилжаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурласан,

цахим арилжааны дэд бүтэц, төсөв, санхүүгийн нэгдсэн цахим тогтолцоо нэвтрүүлэх зэрэг нийт 29 арга хэмжээний төлөвлөгөө багтсан ч олон ниитийн цахим боловсрол хэрэглээ, хөдөө аж ахуй, газар тариалан, байгаль орчины салбарын цахимжилттай холбоотой төлөвлөгөө ороогүй байна. Үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр нь төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх салбар дундын бодлогогүй, хөрөнгө оруулалт, хэмжих нэгжээр илэрхийлэх нарийвчилсан төлөвлөгөөгүй байна.

Түүнчлэн “Цахим үндэстэн” дунд хугацааны дунд хугацааны зорилтот хөтөлбөр нь 6 зорилтын 123 үйл ажиллагаа багтсан байна. Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлж, олон улс, бүс нутгийн салбарын байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах тодорхой санал санаачилгуудыг тусгасан нь цахим засаглалыг хөгжүүлэх бодлогын өмнө дурьдсан бичиг баримтуудын төлөвлөгөө, үйл ажиллагаанд ороогүй шинэлэг арга хэмжээ болжээ. Цахим үндэстэн болох зорилгыг хэрэгжүүлэх хөтөлбөр нь үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төсөл, төслийн жагсаалт батлаж, тодорхойлоогүй байна.

III. ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТЫН ХЭРЭГЖИЛТ

3.1 ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ, ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОЙМ

Хүснэгт 4. Цахим засаглалыг хөгжүүлэх бодлогын бичиг баримт, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тойм

Бодлогын баримт бичиг	Хэрэгжсэн хугацаа	Үр дүн, Хэрэгжилтийн тойм
Цахим засгийн газрын мастер төлөвлөгөө	2002-2010	Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хууль эрх зүйн шинэтгэл хийх, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан түүний эрх зүйн орчин бүрдүүлэх зорилтууд хэрэгжсэн. Монгол Улсын аймаг, сум, төвлөрсөн газруудад шилэн кабел, интернэтийн сүлжээнд холбогдож, цахим засгийг хөгжүүлэх хатуу дэд бүтэц бий болж, интернэтийн гадаад гарцын багтаамж 2005 онд 78Мбит/с, интернэт хэрэглэгч 22000, өргөн зурвасын шилэн кабелийн урт 3251 км, үүрэн холбооны хэрэглэгч 551000 байсан бол 2012 онд интернэтийн гадаад гарцын багтаамж 22Гбит/с, интернэт хэрэглэгч 654009, өргөн зурвасын шилэн кабелийн урт 18123.8 км, үүрэн холбооны хэрэглэгч 3409005 болж өссөн байна.
Цахим монгол үндэсний хөтөлбөр	2005-2012	Төрийн мэдээллийн сүлжээг байгуулах, өргөтгөн шинэчлэх, төрийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн. Үндэсний дата төв байгуулсан. Иргэний цахим үнэмлэх, Нийтийн түлхүүрийн дэд бүтэц төсөл хэрэгжсэн нь төрийн үйлчилгээний олон талт цахим хэрэглээг бий болгох 2010.07.05-ны өдрөөс эхлэн орон даяар иргэний шинэчилсэн бүртгэлийг эхлүүлж, 21 аймгийн 331 сум, 9 дүүргийн 132 хороо, нийт 463 нэгжээр дамжуулан иргэдийг бүртгэлд хамруулан Монгол улсын иргэн цахим үнэмлэхтэй болсон байна.
Монгол улсад бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр	2008-2012	“Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2011 оны 312 дугаар тогтоолын хэрэгжилт, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний Дата төв УТҮГ, Тагнуулын ерөнхий газрын Кибер аюулгүй байдлын газар хамтран Төрийн захиргааны төв байгууллагуудад мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ 2013, 2015 онуудад хийсэн нь энэ хөтөлбөрийн чухал хэрэгжилт болсон байна. Хувь хүний өгөгдөл хамгаалах хуулийн төсөл, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах хуулийн төслүүдийн суурь судалгаа хийгдсэн байна.
Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр	2010-2015	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Харилцаа холбоо мэдээллийн технологийн газраас нийт 102 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт зарцуулж, 19 багц төслийг санхүүжүүлжээ. ТҮЦ машин төслийг 2013 онд эхлүүлж, Улаанбаатар хот болон орон нутагт 108 машин байрлуулж, төрийн 3 байгууллагын 16 үйлчилгээг нэвтрүүлжээ. Төрийн үйлчилгээний www.ezasag.mn портал төсөл хэрэгжүүлж, иргэдийн эрэлт ихтэй төрийн 4 байгууллагын 25 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлжээ.
Цахим засаг үндэсний хөтөлбөр	2012-2016	

<p>Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого</p> <p>/Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоол/</p>	2017-2025	<p>Засгийн газрын 2018 оны тогтоол “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх зарим арга хэмжээний тухай”, “Төрийн цахим мэдээлэл солилцох тогтолцоонд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”, “Төрийн цахим мэдээлэл солилцох тогтолцоог ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалт”, Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоол “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам” батлан, дээрх журмуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төрийн мэдээлэл солилцооны ХУР тогтолцоо, танилт нэвтрэлтийн ДАН тогтолцоо хөгжүүлсэн нь төрийн үйлчилгээг цахимжуулахад үр дүнтэй ажил болжээ.</p> <p><i>/Тус бодлогын бичиг баримтыг Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон байна./</i></p>
<p>Цахим засаглал үндэсний хөтөлбөр</p>	2019-2022	<p>Цахим хөгжлийн багц хуулиуд болох “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай”, “Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай”, “Кибер аюулгүй байдлыг тухай”, “Цахим гарын үсгийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга батлагдсан. E-Mongolia-Төрийн үйлчилгээний нэгдсэн портал тогтолцоог хөгжүүлж нэвтрүүлсэн нь цахим засаглалын хөгжлийг нэг шат урагшлуулсан үйл ажиллагаа болсон байна.</p> <p><i>/Тус хөтөлбөрийг Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон байна./</i></p>

3.1.2 Ухаалаг засаг төсөл

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаар Дэлхийн банкны Олон улсын ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ухаалаг засаг” төслийн санхүүжилтийн хэлэлцээрийг баталсан байна. Төслийн удирдах хороог Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2015 оны 180 дугаар тушаалаар, Төсөл хэрэгжүүлэх нэгжийг Сангийн сайдын 2015 оны 213 дугаар тушаалаар тус тус байгуулсан. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг төрийн үйл ажиллагаанд оновчтой ашиглах замаар төрийн үйлчилгээг илүү үр ашигтай, ил тод, хүртээмжтэй болгох зорилготой төсөл нь Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацийн санхүүжилтээр 19,4 сая долларын хөнгөлттэй зээлээр 2015-2022 онд хэрэгжсэн байна.²⁰

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Ухаалаг засаг төслийн гол үр дүн, хэрэгжилтийг тоймловол:

Цахим үйлчилгээг хүргэхэд:

- Төрийн 12 байгууллагын 112 үйлчилгээг цахимжуулж, e-Mongolia тогтолцоогоор дамжуулан иргэд ААН цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээг авч байна. Нийт дүнгээр 3,416,562 удаагийн цахим үйлчилгээг хүргэж, энэ нь иргэд, ААН-ээс 48.4 тэрбум төгрөгийг хэмнэсэн.

²⁰ Ухаалаг засаг төслийн цахим хуудас. <https://www.smart.gov.mn/mn/>

- Эд хөрөнгийн эрхийн цахим бүртгэлийг орон даяар нэвтрүүлж, үл хөдлөхийн гэрчилгээ олгоход зарцуулдаг дундаж хугацаа 14 хоног байсныг 3-5 хоног болгон буурууллаа.
- Эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сан, тогтолцоо, дэд бүтцийг шинэчлэн, цахим бүртгэлийн үйлчилгээг хүргэх орчныг бүрдүүлснээр үл хөдлөх хөрөнгийн лавлагаа авахад 3 өдөр зарцуулдаг байсан одоо 3 минутад авдаг болов.

Цахим үйлчилгээг хүргэх тогтолцоонуудыг нэвтрүүлэхэд:

- Төрийн цахим үйлчилгээний болон үйл ажиллагааны 14 тогтолцоо, програм хангамжийг шинэчлэн сайжруулж, шинээр нэвтрүүлснээр цахим үйлчилгээг хүргэх хөдөлгүүрийг хурдасгав.
- Төрийн мэдээлэл солилцох ХУР тогтолцооны техник, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг өргөтгөснөөр ХУР тогтолцоонд холбогдсон байгууллагын тоо 2 дахин, цахим үйлчилгээний мэдээлэл солилцох сервисийн тоо 2.5 дахин өсөв.

Цахим үйлчилгээний найдвартай дэд бүтцийг хангахад:

- Төрийн цахим мэдээллийн 80 хувийг хадгалж хамгаалдаг Үндэсний дата төвийн серверийн өрөөний хүчин чадлыг 2 дахин, өгөгдлийн сангийн багтаамжийг 3 дахин нэмэгдүүлэв.
- Монгол Улсад анх удаа төрийн цахим мэдээллийг байгалийн гамшиг, эрсдэлээс хамгаалах Үндэсний Нөөц дата төвийг ашиглалтад оруулав. Ингэснээр болзошгүй цахим мэдээллийн алдагдал, эдийн засгийн хохирлоос урьдчилан сэргийлж байна.
- Нээлттэй өгөгдлийг түгээх, ашиглах зорилгоор 232 нээлттэй өгөгдлийг нэгдсэн порталаар нийтлээд байна.

3.2 ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

Энэ бүлгээр төрийн цахим үйлчилгээний хэлбэр, төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх стратегийг танилцуулж, уламжлалт төрийн үйлчилгээнээс төрийн цахим үйлчилгээг хэрэгжүүлэхэд амжилттай нэвтрүүлсэн төслүүдийн хэрэгжилтэд шинжилгээ хийлээ.

Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд төрийн байгууллага хоорондын зохион байгуулалтын асуудлыг зохицуулсан дараах дүрэм журмыг Засгийн газар болон Улсын Их хурлаас баталсан байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Төрийн цахим мэдээлэл солилцох тогтолцоонд холбох төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг баталсан.²¹ Үүнд төрийн 33 байгууллагын нийт 175 үйлчилгээ

²¹ Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

жагсаалт багтсан байна.

- Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Төрийн цахим мэдээлэл солилцох тогтолцоог ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний жагсаалт”-ыг баталсан.²² Үүнд төрийн 38 байгууллагын нийт 320 үйлчилгээний жагсаалт багтсан байна.
- Засгийн газрын 2019 оны “Төрийн үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” 149 дүгээр тогтоол нь “Нэг цонхны үйлчилгээ”, “Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийг” үйлчилгээний нэгдсэн төв болгон өөрчлөх, иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим үзүүлэх, үйлчилгээний нэгдсэн төвийн мэдээллийн тогтолцоог хөгжүүлэн төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбох талаар зохих арга хэмжээ авах зорилготой батлагджээ.²³
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18 дахь заалт буюу Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн 196 дугаар тогтоолын хавсралт “Үндсэн тогтолцооны үйл ажиллагааг зохицуулах, тогтолцоо ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”²⁴
- Улсын Их Хурлын 2020 оны 4 сарын 9-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” УИХ-ын 32 дугаар тогтоолыг баталсан.²⁵

Тус тогтоолын хавсралтад “Төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх” чиглэлээр дараах арга хэмжээг тусгасан. Үүнд:

- Цахим худалдаа, төрийн цахим үйлчилгээний төрлийг өргөжүүлэх, эрчимжүүлэх, цахим хичээлийн нэгдсэн портал бий болгох, Ковид-19 цар тахлын мэдээллийн програм хангамж, аппликейшн хөгжүүлэх, үйлчилгээг цахим хэлбэрээр авсан бол энэ үнэ тарифыг бууруулах, банк хоорондын шимтгэлийг тэглэх;
- Төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийхэд Засгийн газрын Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангаас дэмжлэг үзүүлэх, Олон нийтийг төөрөгдүүлсэн худал ташаа мэдээ, мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх, хязгаарлах болон цахим орчнй үйлчилгээ эрхлэгч /цахим хуудас, цахим орчин дахь олон нийтийн сүлжээ, аппликейшн гэх мэт/-тэй хамтран ажиллах зохицуулалтын журмыг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах;

Дээрх батлагдсан журам, баримт бичгийн зохион байгуулалтаар төрийн цахим үйлчилгээний нэгдсэн тогтолцоо, төрийн мэдээлэл солилцооны ХУР тогтолцоо

22 Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

23 Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоол

24 Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралт

25 Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын хавсралт

зохицуулагдаж, ажиллаж байна. Төрийн цахим харилцааны тухай хуулийн төсөл боловсруултын шатандаа байсан боловч тодорхой чиг үүргүүд нь Нийтийн мэдээлэл авах эрхийн тухай хуулийн зохицуулалт руу шилжсэн байна. Гэвч цаашид бидэнд салбар хоорондын цахим харилцааг зохицуулахад Цахим засаглалын хөгжлийн тухай болон, Төрийн цахим харилцааны тухай хуулийн зохицуулалт шаардлагатай болно.

Төрийн үйлчилгээ авахын тулд иргэд цаг хугацаа, ажлын цаг, зардал, замын түгжрэл, хүнд суртал зэрэг олон төвөгтэй асуудлуудтай тулгардаг байсан өмнөх үеэ бодвол төрийн цахим үйлчилгээний тогтолцооны ачаар эрэлт ихтэй төрийн үйлчилгээнүүд цахим хэлбэрт шилжсээр байна.

Зураг 3. Уламжлалт төрийн үйлчилгээний бэрхшээл




Орчин үед иргэн, албан байгууллагад зориулсан ухаалаг төрийн үйлчилгээг хэрхэн хамгийн богино хугацаанд, зардал, төвөг багатай хүргэх вэ, иргэдийн хүсэлтийг төрийн back-office процесстэй хэрхэн уялдуулах вэ, гэх мэт олон асуудлыг өөр хооронд нь уялдаатай байдлаар загварчлах, технологийн боломжууд дээр суурилсан дижитал засаглалын бодлого, дижитал үйлчилгээний загварчлал, нээлттэй өгөгдөл, их өгөгдөл зэрэг дэвшилүүдийг олон улс орны засгийн газрууд ашиглаж байна. Төрийн цахим үйлчилгээний тогтолцоог боловсруулахдаа дараах зарчмуудыг зайлшгүй тусгах шаардлагатай. Үүнд:

- Иргэн төвтэй, иргэдийн оролцоог хангасан
- Иргэнийг цахим орчинд таних боломжтой
- Өгөгдлийн нэг эх үүсвэртэй
- Процесст суурилсан
- Дундын дэд бүтэцтэй

Нууцлал, аюулгүй байдлыг хангасан

Иргэн төрийн үйлчилгээ авахын тулд олон албан байгууллага, үйлчилгээний ажилтантай биечлэн уулздаг уламжлалт хэлбэрээс дижитал хэлбэрт шилжиж дараах хөгжлийн үе шаттай хэрэгжиж байна.

Зураг 4. Төрийн үйлчилгээний хөгжлийн үе шат²⁶



3.2.1 Төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх стратеги

Хүснэгт 5. Төрийн цахим үйлчилгээний хэлбэрүүд²⁷

G2C	Government to Citizens	Төрөөс иргэн хоорондын үйлчилгээ
C2G	Citizen to Government	Иргэн төрд хоорондын
G2G	Government to Government	Төрийн байгууллага хоорондын
G2E	Government to Employees	Төр болон хөдөлмөр эрхлэгчид хоорондын
G2B	Government to Business	Төр болон бизнесийн байгууллага хоорондын

Төрийн цахим үйлчилгээний дээрх хэлбэрүүдийг хэрэгжүүлэхэд дараах стратегийг баримтлан ажиллавал үр дүнтэй. Үүнд:

- Иргэн төвтэй (бизнесийн салбарын хувьд Компани төвтэй) төрийн үйлчилгээний бодлого, ажлын даалгавар боловсруулах, загварчлах, бусад үйлчилгээтэй уялдуулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах ажлын нэгдсэн аргачлал боловсруулах
- Төрийн үйлчилгээний дизайн гаргах, боловсронгуй болгох ажлыг салбар бүрт тоггмол хийснээр иргэнээ дээдэлсэн, оновчтой, зардал хэмнэсэн, төрийн ухаалаг, тоон үйлчилгээнүүдийг өөр хоорондоо уялдаатайгаар, шат дараалалтайгаар, загварчлах, Service Excellence буюу төрийн үйлчилгээний төгөлдөршил рүү тэмүүлэх

²⁶ Төрийн үйлчилгээний нэгдсэн портал. <https://e-mongolia.mn/about/introduction>

²⁷ Maria, P., Nawaf, A., & Paul, S. (2014) Security Factors Influencing End Users' Adoption of E-Government.

- Төрийн үйлчилгээний нэгдсэн дижитал платформ байгуулж, иргэдэд зориулсан бүх төрлийн онлайн үйлчилгээнүүдийг удирдах
- Yanqing, G. (2010) “E-Government: Definition, Goals, Benefits and Risks”, 2010 International Conference on Management and Service Science. pp. 1-4.
- Иргэн, бизнесийг хөтөлбөргүй таньж, баталгаажуулах болон нууцлалыг хангах цахим гарын үсэгт суурилсан хандалтын нэгдсэн удирдлагын платформыг зохион байгуулж, нууцлал аюулгүй байдлыг хангах
- Технологийн мэдлэг өндөртэй шинэ үеийн төрийн албан хаагчдын үе ирж байгаа давуу талд түшиглэх
- Олон яам, агентлаг, албан тушаалтнуудаар дамжсан үйлчилгээнүүд нь шат дамжлага болгонд иргэнд мэдээлэл өгөх, иргэн өөрийнхөө хүсэлтэнд хяналт тавих, процесс бүрт санал гомдол гаргах боломжоор хангагдсан байх
- Иргэн Засгийн газарт байгаа өөрийнхөө талаарх мэдээлэл болон ямар байгууллагаас хэдийд, ямар шалтгаанаар өөрийнх нь мэдээлэлд хандсан зэргийг хянах боломжоор хангагдсан байх г.м

3.3 ЦАХИМ ЗАСАГ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖСЭН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

Цахим засаг хөтөлбөрийн “төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох” зорилтын хүрээнд хэд хэдэн төсөл, арга хэмжээг Засгийн газраас хэрэгжүүлсэн байна. Үүнд:

3.3.1 ТҮЦ машин - Төрийн үйлчилгээний цахим машин

Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн, иргэн өөрт ойрхон байрлаж байгаа газраас шаардлагатай бичиг, баримт, лавлагааг цаг хугацаа хэмнэж, хүнд суртал, дараалал чирэгдэлгүй авах боломжийг бүрдүүлсэн, төрийн үйлчилгээг цахимжуулах, цахим засгийн хөгжлийг урагшлуулсан төслийн нэг ТҮЦ машин. ТҮЦ машинаар дамжуулан төрийн үйлчилгээний G2C (төрөөс иргэнд чиглэсэн үйлчилгээ), C2G (иргэнээс төрд чиглэсэн үйлчилгээний) хэлбэрүүд хэрэгжиж, иргэд дэвшилтэт технологи ашиглан төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах, яам, агентлаг, төрийн байгууллагуудад өөрийн санал хүсэлт, өргөдөл гомдлоо илгээх боломж бүрдсэн. Иргэний цахим үнэмлэх анх удаа олон нийтийн хэрэглээнд нэвтэрч, иргэдийн цахим оролцоог нэмэгдүүлсэн, төрийн цахим үйлчилгээний давуу талыг мэдэрсэн амжилттай төсөл болсон.²⁸

“ТҮЦ” машины үйлчилгээний баримт нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт ашиглагддаг QR кодоор баталгаажсан нууцлалтай цаасан дээр хэвлэгддэг учраас дуурайлгах, хуулбарлах боломжгүй. 2013 оноос хойш амжилттай хэрэгжиж байгаа

²⁸ ТҮЦ машины цахим хуудас. <https://tutsmashin.gov.mn/>

ТҮЦ машинаас Эрүүл мэндийн яамны Ковид-19 урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ авах мөн И-Монголиад бүртгүүлэх боломжтой болсон байна.

Зураг 5. ТҮЦ машины үйлчилгээний загвар



3.3.2 11-11 төв

Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төв нь иргэдийг сонсох, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн санал, санаачилгын эргэх холбоог сайжруулах, уг тогтолцоог бий болгох, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, хүнд сурталгүй хүргэх зорилгоор 2012 оны 10 дугаар сард нэвтрүүлж эхэлжээ.²⁹ 11-11 төвийн программын хэрэглэгч талуудад төрийн байгууллага, оператор, иргэн, төрийн байгууллагын удирдлага, тухайн байгууллагын дээд шатны удирдлага багтаж байгаа бөгөөд тус тогтолцоо нь иргэдийн санал, хүсэлтийг дуудлага, мессеж, чат 12 сувгаар хүлээн авч бүртгэдэг байна. Үүнд:

- 11-11 дугаарт дуудлага хийх
- 11-11 төвд биеэр ирэх
- Фэйсбүүк хуудсаар хандах
- Заагдсан байршлын киоскт очих
- Факс илгээх
- Цахим шуудан илгээх - 1111@gov.mn

²⁹ Иргэд, олон нийттэй харилцах төвийн цахим хуудас. <https://11-11.mn/>

- Цахим хуудсаар зочлох - www.11-11.mn
- Дуут шуудан илгээх 11-11 дугаарт
- Твиттер хуудсаар хандах
- Мобайл апп ашиглах
- Веб чат - www.11-11.mn холбогдох

Хүсэлтийг хүлээн авч холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Тухай бүр шаардлагатай тайлан, мэдээ, мэдээллээр Засгийн газар, яам, агентлагуудыг хангаж, өнөөгийн байдлаар тус тогтолцоонд нийт 75 төрийн байгууллага холбогдон иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэж байна. Төрийн цахим үйлчилгээний нэг хэлбэр болох иргэд, албан байгууллагын цахим оролцоог хангасан чухал төсөл болсон.

3.3.3 ХУР систем – Төрийн мэдээлэл солилцооны тогтолцоо

“ХУР” төрийн мэдээлэл солилцооны систем нь төрөөс иргэд рүү чиглэсэн үйлчилгээ, үйл ажиллагааг илүү хялбарчлах зорилгоор олон улсын жишигт нийцсэн, найдвартай ажиллагаатай, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, цахим засаглалын суурь бүрэлдэхүүн хэсгийн нэг юм. “ХУР” нь төрийн үйлчилгээний мэдээллийг тасалдалгүй ажиллагаатай, төвлөрсөн удирдлагатай платформоор дамжуулан байгууллага хоорондын уялдаа холбоог шинэ түвшинд гаргах, иргэд аж ахуй нэгжид хүрэх төрийн үйлчилгээг хөнгөвчлөх зорилготой мэдээлэл солилцооны тогтолцоо юм. Төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдийг төрийн мэдээлэл солилцооны тогтолцоонд холбох, төрийн үйлчилгээний нэгдсэн портал болон төрийн үйлчилгээний платформоор дамжин хүрэх үйлчилгээ юм.

Монгол Улс бие даасан төрийн мэдээлэл солилцооны тогтолцоотой болох, төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагааг сайжруулах, хялбаршуулах, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 28–ны өдрийн А/61 тоот тушаалаар баталсан “Төрийн мэдээлэл солилцооны тогтолцооны талаар баримтлах бодлогын чиглэл”-ийн хүрээнд нээлттэй эхийн платформ дээр суурилсан, “Enterprise Service Bus” архитектуртай “ХУР” төрийн мэдээлэл солилцооны системийг Үндэсний дата УТҮГ-аас хөгжүүлэн ажиллаж байна.³⁰

Энэхүү тогтолцоо нь мэдээллийг хоёр төрийн байгууллага хооронд шууд солилцдог, мэдээллийн санг хуулбарлаж, шинэчлэх байдлаар үйлчилгээ үзүүлж буй төрийн байгууллагуудын үйлчилгээний уламжлалт шийдлийг бүрэн халж, мэдээллийг илүү уян хатан шийдэлтэйгээр шуурхай, аюулгүй, найдвартай харилцан солилцуулах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа билээ. Тус тогтолцоонд хувийн байгууллагууд ч холбогдох боломжтой бөгөөд энэ нь иргэд төрийн байгууллага болон бусад үйлчилгээний байгууллагуудаас үйлчилгээ авахад шаардаглагатай лавлагаа, тодорхойлолтуудыг бүрдүүлэхэд учирдаг хүндрэлүүдийг бүрэн арилгахад чухал үүрэг гүйцэтгэх юм.

Уг үйлчилгээний хөгжүүлэлт, идэвхжүүлэлтийг 2018 онд дараах байдлаар гүйцэтгэсэн.

- “ХУР” Төрийн мэдээлэл солилцооны системийн хүрээнд:
- “ХУР” Төрийн мэдээлэл солилцооны системийг бүрэн ажиллагаанд оруулж, хамгийн эхний цахим үйлчилгээг үзүүлэх,
- Төрийн үйлчилгээний платформыг үйлчилгээнд нэвтрүүлэх,

Төрийн үйлчилгээний цахим порталыг үйлчилгээнд гаргах,

ХУР нь төрийн цахим үйлчилгээний G2G (төрийн байгууллага хоорондын), G2C (Төрөөс иргэн хоорондын үйлчилгээ) G2B (Төр болон бизнесийн байгууллага хоорондын) загварыг хэрэгжүүлсэн чухал тогтолцоо болсон.

3.3.4 Танилт нэвтрэлтийн ДАН тогтолцоо

Танилт нэвтрэлтийн тогтолцоо нь цахим орчинд бүхий л төрлийн цахим үйлчилгээг авахад тухайн иргэнийг таньж баталгаажуулах боломжийг бүрдүүлэх, хувийн хэвшил болон төрийн үйлчилгээний өөр хоорондоо харилцан хамааралгүй тогтолцоонуудтай нягт уялдаатай ажиллах боломжтой платформ бүхий тогтолцоо юм.

Хэрэглэгч танилт нэвтрэлтийн тогтолцоог 1 удаа ашиглан нэвтэрснээр тус тогтолцоонд холбогдсон бүх төрлийн тогтолцоонууд рүү нэвтрэх эрхтэй болдогоороо давуу талтай.

Тус тогтолцоо нь төрийн цахим үйлчилгээний ХУР, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоонуудтай холбогдож ажилладаг ба төрийн үйлчилгээний хүртээмж, үр ашиг, төрийн байгууллагуудын бүтээмжийг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой суурь тогтолцооны нэг болж хөгжиж байна.³¹

Хүснэгт 6. Уламжлалт тогтолцоо болон нэвтрэлтийн тогтолцооны ялгаа

Уламжлалт тогтолцоонуудын сул тал	Нэвтрэлтийн тогтолцооны давуу тал
<ul style="list-style-type: none"> • Тогтолцоо бүр иргэний бүртгэл үүсгэн, нууц үг болон бусад мэдээллийг хадгалдаг. • Байнгын нууц үг ашиглах, мэдээллийн аюулгүй байдлын нууцлал, хамгаалалтыг нэвтрүүлээгүй олон тооны тогтолцоонуудээс үүдэн мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлдэг. • Иргэн бүр тогтолцоонууд рүү өөрийн үүсгэсэн өөр өөр бүртгэл, нууц үг ашиглан нэвтэрч орох шаардлагатай. 	<ul style="list-style-type: none"> • Танилт нэвтрэлтийн тогтолцооны нэвтрэлтийг ашиглаж буй тогтолцоо нь нэр болон нууц үг хадгалах шаардлагагүй. • Иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулах хөгжүүлэлтийн давхардсан зардлыг бууруулдаг. • Тогтолцоо бүр танилт нэвтрэлтийн тогтолцоог ашигласнаар мэдээллийн аюулгүй байдлыг нэг тогтолцооноос хянах боломж бүрдэнэ.

31 Үндэсний дата төв УТУГ-ын цахим хуудас. <https://datacenter.gov.mn/service/dan>

3.4.5 E-Mongolia Төрийн үйлчилгээний нэгдсэн портал тогтолцоо

Дээр дурьдсан төрийн үйлчилгээг цахимжуулах тогтоолуудыг хэрэгжүүлэх зорилгоор E-Mongolia төслийн хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төрийн зарим үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахим болон операторын горимоор үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний нэгдсэн портал тогтолцоо www.e-mongolia.mn, төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн тогтолцоо www.erp.e-mongolia.mn-ийг хөгжүүлэн ажиллаж байна. 21 аймгийн төрийн үйлчилгээ цахимжиж, орон нутагт e-Mongolia төвүүд нээгджээ. Өнөөдрийн байдлаар www.e-mongolia.mn төрийн үйлчилгээний нэгдсэн тогтолцооноос 61 байгууллагын 657 үйлчилгээ цахимаар авах боломжтой, гар утасны аппликейшнаас 144 үйлчилгээг цахимаар авах боломжтой болжээ. E-Mongolia-г 1,363,366 хэрэглэгч 684 цахим үйлчилгээг 13,906,868 удаа цахимаар авч, жилийн дотор 4,8 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, иргэн, төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн 64,5 тэрбум төгрөгийн хэмнэлт хийсэн нь Монгол улсын цахим засгийн хөгжлийг нэг шат урагшлуулсан амжилттай төсөл болжээ.

3.4 Бүлгийн дүгнэлт

Цахим монгол (2005-2012) үндэсний хөтөлбөрт Хууль эрх зүй, бодлого зохицуулалтын орчин, Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, Манлайлал, шинэчлэл, Мэдээлэл, харилцаа холбоо технологийн хэрэглээ, түүний харилцан уялдаа, Мэдээлэл, харилцаа холбоо, технологи ашиглан эдийн засгийн өсөлтийг хангах, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийг олон нийтэд сурталчлах, төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг 7 стратеги, 25 зорилтын хүрээнд 146 арга хэмжээ тусгагдсанаас 80 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 58 арга хэмжээ 70-90 хувийн биелэлттэй, 8 арга хэмжээ 50-60 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна. Засгийн газрын 2017 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 47 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого” дунд хугацааны хөгжлийн стратеги 2017-2025 онд хэрэгжихээр батлагдсан ч хэрэгжиж дуусах хугацаанаасаа өмнө буюу 4 жилийн өмнө, Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан Цахим засаглал үндэсний хөтөлбөр батлагдсан ч хэрэгжиж дуусах хугацаанаасаа өмнө буюу 1 жилийн өмнө Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор тус тус хүчингүй болгосон байна. Төрийн захиргааны байгууллагаас дунд хугацааны хөгжлийн бодлого, үндэсний хөтөлбөр боловсруулахаар судалгаа, шинжилгээ хийх, санал авах, хүний нөөцийн багаа бүрдүүлэх, хэлэлцүүлэг хийхэд дундажаар 6 сараас дээш хугацаа зарцуулдаг, боловсруулж эцсийн шатанд хүрсэн бичиг баримтаа Засгийн газар болон Улсын Их Хурлын тогтоолоор батлуулахад мөн дундажаар 6 сараас дээш хугацаа зарцуулдаг. Иймд бодлогын баримт бичгийг хугацаанаас өмнө хүчингүй болгох нь салбарын бодлогын тогтвортой байдлыг алдагдуулсан асуудал үүснэ. Мөн хүчингүй болгосон баримт бичиг, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хүрсэн үр дүнгээ нарийвчлан тооцож олон нийтэд ил тод мэдээллэх нь зүйтэй. Бодлогын бичиг баримт хүрэх үр дүнтэй, хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй, төсвийн төсөөлөлтэй, бусад салбарын бодлоготой уялдахуйц байх хэрэгтэй.

Хүснэгт 7. Цахим засаг үндэсний хөтөлбөр биелэлт (2012-2016)

Зорилт	Биелэлт
Зорилт-1. Цахим засгийг хөгжүүлэх бодлого зохицуулалт, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	60%
Зорилт-2. Мэдээллийн технологийн дэд бүтцийг хөгжүүлэх	80%
Зорилт-3. Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох	50%
Зорилт-4. Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн цахим үйлчилгээг ашиглах мэдлэг иргэдэд олгох.	30%
Ерөнхий биелэлт	55%


Хүснэгт 8. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (2010-2015)

Зорилт	Биелэлт
Зорилт-1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрхзүйн орчинг бүрдүүлэх	62.22%
Зорилт-2. Мэдээллийн аюулгүй байдлын эмзэг байдлыг бууруулах, хариу үйлдэл хийх тогтолцоог бүрдүүлэх	51.03%
Зорилт-3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээний соёл бий болгон төлөвшүүлэх, иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хүний нөөцийг хөгжүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийн таатай орчин бүрдүүлэх	20.83%
Зорилт-4. Төрийн мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоо бүрдүүлэх	48.13%
Ерөнхий биелэлт	45.55%

IV. МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХӨГЖИЛ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улсын мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хөгжил өнөөг хүртэлх хугацаанд орон нутагт техник технологийн суурь дэд бүтцийг өргөтгөн 21 аймгийн 324 сум, суурин шилэн кабелийн сүлжээнд холбогдсон, улсын хэмжээнд хот хооронд 36724 км, хот суурин 6294 км нийт 49,943 км шилэн кабелийн сүлжээ тавигдсан байна.

Зураг 6. 2019 оны 11 дүгээр сарын байдлаар Монгол Улсын харилцаа холбооны сүлжээний зураглал




Радио релейний сүлжээний тархалт 8400 км-т хүрч, манай улсын бүх аймаг, сумын төв, томоохон суурин газрууд холбооны сүлжээнд холбогдсон. Монгол улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5G технологийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэлийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/45 тушаалаар батлан гаргасан байна.³²

Үүрэн утас хэрэглэгчдийн тоо 2002 онд 235 мянга байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй хэрэглэгч давхардсан тоогоор 6 сая 294 мянга, идэвхитэй хэрэглэгч 4 сая 687 мянгад хүрсэн байна.³³

32 Цахим хөгжил, харилцаа холбооны яамны цахим хуудас. <https://mddc.gov.mn/mn/>


33 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://www.1212.mn/>

График 1. Монгол улсын үүрэн холбооны идэвхитэй хэрэглэгчийн тоо 2016-2021 он




Интернэтийн бүтцийн хувьд Монгол Улсад интернэтийн үйлчилгээ эрхэлж, гадаад гарцын урсгалын хэмжээ 780 г бит/сек, интернэт хэрэглэгчдийн тоо давхардсан тоогоор 4 сая 137 мянга хүрснийг статистик үзүүлэлтээс харж болно.

График 2. Монгол улсын интернэт хэрэглэгчдийн тоо 2016-2021 он




Ухаалаг төрөөрөмж хэрэглэгчдийн сүүлийн 5 жилийн статистик тогтмол өссөн байна. Хүн амын тоо, ялангуяа насанд хүрсэн иргэний тооноос үүрэн холбооны идэвхитэй хэрэглэгч, ухаалаг төхөөрөмж хэрэглэгч болон интернэт хэрэглэгч 2 дахин их, илт давуу, байгаа нь манай улсад цахим үйлчилгээний төлөвшилийг бий болгож, тоон бичгийн үсгийн хоцрогдолыг арилгах боломж байгааг өгөгдөлийн шинжилгээнээс харагдаж байна.

График 3. Монгол улсын ухаалаг төхөөрөмж хэрэглэгчдийн тоо 2017-2021 он



Гэрээт интернэт хэрэглэгчдийн тоо 2020 онд өмнөх жилүүдийг бодвол огцом өссөн нь цар тахлын үед цахимаар бүх шатны сургалт, зайнаас ажил явагдаж байсантай холбоотой гэж дүгнэж болохоор байна.

График 4. Монгол улсын гэрээт интернэт хэрэглэгчдийн тоо 2016-2021 он



Статистикаас харахад манай улсын хувьд иргэд интернэт, цахим орчинд мэдээ, мэдээллийг авч ашиглах, цахим үйлчилгээг хот хөдөө хаанаас ч төрийн үйлчилгээг гар утсаараа авч, мөн сурч боловсрох үндсэн суурь нөхцөл бүрдсэн ч иргэдийн технологийн мэдлэг дутмаг байгаа нь цахим хэрэглээ дэхь хүний хөгжлийн индексээр дэлхийд хоцрогдож байгаа нь олон улсын тайлангуудаас харж болно. Цахим үндэстэн бий болох үндсэн хэрэгцээ болох Тоон бичиг үсэгтэн төлөвлөгөөг үе шаттай хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Хүснэгт 7. НҮБ-ын цахим засаглалын хөгжлийн индекс 2016-2020

НҮБ-ын цахим засаглалын судалгаа	2016	2018	2020
Байр (192 орноос)	84	92	92
Цахим засаглалын хөгжлийн индекс (EDGI)	0.5194	0.5824	0.6497
Цахим үйлчилгээний индекс (OSI)	0.5145	0.5972	0.5294
Харилцаа холбооны дэд бүтцийн индекс (ТИ)	0.2841	0.3602	0.6135
Хүмүүн капиталын индекс (HCI)	0.7597	0.7899	0.8063
Цахим оролцооны индекс (EPI)	0.7119	0.736	0.6071
100 хүнд ноогдох гар утасны тоо	105.06	111.24	120
Интернэт ашиглалтын хувь	27	22.27	47.12
100 хүнд ноогдох суурин утасны тоо	7.92	7.44	9.66
100 хүнд ноогдох үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо	24.70	80.28	83.72


Нэгдсэн Үндэстний Байгууллагаас дэлхийн улс орнуудын төрийн үйлчилгээгээ цахимжуулсан түвшинг тодорхойлох зорилгоор Цахим засгийн хөгжлийн индекс, судалгааны тайланг³⁴ 2 жил тутам гаргадаг. Тус судалгааны 2016, 2018, 2020 онуудын Монгол улсын байр, индексийн үзүүлэлтийг дээрх хүснэгтээр харьцууллаа. Монгол улс 2020, 2018 онд цахим хөгжлийн индексээр 192 орноос 92 дугаар байрт орж 2016 оноос 8 байраар ухарсан ч цахим үйлчилгээний индекс, харилцаа холбооны дэд бүтцийн индекс, хүмүүн капиталын индекс, цахим оролцооны индекс нь тус бүртээ дээшилсэн байгаа нь дэлхийн дундаж цахим хөгжлийн индекс урагшилж, улс орнууд цахим засаглалдаа анхаарч хөгжүүлсэн нь харагдаж байна. Бид цахим засаглалын хөгжлөөр дэлхийд тэргүүлэгч улсуудтай харьцуулахад 0,3261 пунктээр доогуур байгаа боловч дэлхийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад дээгүүр байна.

34 UN E-Government Surveys. 10 July 2020 <https://publicadministration.un.org/en/Research/UN-e-Government-Surveys>

V. ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ ДЭЛХИЙ ДАХИНД

Европын холбоо 2021 оны 3 дүгээр 9-ний өдөр Дижитал Европ-2030 стратегийг танилцуулсан. Дижитал Европ-2030 стратегид ирэх 10 жилд дижитал ур чадвар, бизнесийн дижитал шилжилт, төрийн байгууллагын дижитал шилжилт, аюулгүй, тогтвортой дэд бүтэц гэсэн 4 зорилт дэвшүүлсэн байна.³⁵ Европын холбооноос 2021-2023 онд хэрэгжүүлэх дижитал стратегийн дижитал ур чадвар зорилтын хүрээнд жендерийн харьцаанд анхааран 20 сая мэдээлэл, харилцаа холбооны мэргэжилтнүүдийг бэлтгэх, хүн амын 80 хувиас доошгүй хувийг цахим ур чадвартай болгох, цахимжих боломжтой төрийн үйлчилгээг 100 хувь цахимжуулахаар төлөвлөжээ. Дэлхийн цахилгаан холбооны байгууллага дижитал шилжилтийн энтерфрайз архитектур, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) дижитал шилжилтийн стратеги-2020 тус тус танилцуулсан. Дэлхийд цахим засаглалын хөгжлөөрөө тэргүүлэгч орнуудад дижитал шилжилт эрчимтэй явагдаж, тоон технологи, дижитал засгийн газрын стратеги, төлөвлөгөөг дижитал үйлчилгээ, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд шинэ технологийн бодлого, загвар гаргаж, аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалд технологийн хөгжлийн урдаараа өрсөлдөж байна.

Зураг 7. Европын холбооны төрийн үйлчилгээний дижитал шилжилтийн загвар



35 Europe's Digital Decade: digital targets for 2030. https://ec.europa.eu/info/strategy/priorities-2019-2024/europe-fit-digital-age/europes-digital-decade-digital-targets-2030_en

Дэлхийн банкнаас Дижитал засаглалын бэлэн байдлыг үнэлэх концепцийг жишиг болгож 2020 онд танилцуулсан.³⁶ Цахим засаглал, дижитал шилжилтийг хийхэд гол бүрэлдэхүүн хэсгүүдийг тусгасанаараа онцлогтой. Хөгжиж буй орнуудын цахим засаглалын бодлогод загвар болсон платформ. Цахим засаглалд удирдлага улсын төрийн манлайлал, хэрэглэгч төвтэй загвар, төрийн захиргааны шинэчлэлт өөрчлөлт, иргэдийн цахим бичиг үсгийн чадамж, соёлтой хэрэглээ, технологийн дэд бүтцийн бэлэн байдал, хатуу зөөлөн дэд бүтэц, цахим үйлчилгээ, тогтолцоо дэх нууцлал, аюулгүй байдал, хууль эрх зүйн зохицуулалт, тогтвортой бодлого, байгальд ээлтэй экосистем бүхий дижитал шийдэлд тулгуурлан дижитал засгийн газрыг хөгжүүлэхийг санал болгож байна.

Зураг 8. Дэлхийн банкны Дижитал засаглалын бэлэн байдлыг үнэлэх үзүүлэлтүүд



Эх үүсвэр: Дэлхийн банк, DGRA team, 2020

5.1 СИНГАПУРЫН ДИЖИТАЛ ШИЛЖИЛТИЙН ХӨГЖИЛ

Сингапур улс 1990-ээд онд даяараа өргөн зурвасын холболттой болсон анхны улсуудын нэг байсан бол 2000-аад онд арал даяар өргөн зурвасын сүлжээ, утасгүй сүлжээний цэгүүдийг нэвтрүүлж мөн анхдагч улс болсон. Олон жилийн турш Сингапур нь Дэлхийн эдийн засгийн форум, Дэлхийн цахилгаан холбооны байгууллагын цахим засгийн хөгжлийн тайлан зэрэг нэр хүндтэй судалгаануудад тэргүүлэгч байсаар ирсэн. Сингапурын Засгийн газрын технологийн агентлаг (Govtech) нь үндэсний цахим засгийн бодлого, дижитал шилжилтийн стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага юм. Ерөнхий сайдын дэргэдэх Ухаалаг

³⁶ Digital Government Readiness Assessment (DGRA) Toolkit V.31 Guidelines for Task Teams <https://documents.worldbank.org/en/publication/documents-reports/documentdetail/999901588145595011/digital-government-readiness-assessment-dgra-toolkit-v-31-guidelines-for-task-teams>

үндэстэн ба дижитал засаглалын хороо (SNDGO) нь “Ухаалаг үндэстэн” бодлогын бичиг баримт болон үндэсний томоохон дижитал төслүүдийг удирдан хэрэгжүүлдэг. Мөн ухаалаг үндэстэн байгуулахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоо, технологийн хэрэглээний чадавхи дээр анхаарч ажилладаг. Засгийн газрын технологийн агентлаг (Govtech) болон Ухаалаг үндэстэн ба дижитал засаглалын хороог (SNDGO) хамтад нь Ухаалаг үндэстэн ба Дижитал засгийн групп (SNDGG) гэж нэрлэдэг байна. Цахим засгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 2000-2005 онд, iGov 2010 (2006-2010), eGov 2015 (2011-2015) стратегийг тус тус амжилттай хэрэгжүүлсэн. Сингапур улс 2014 онд “Ухаалаг үндэстэн” санаачилга, стратегийг эхлүүлсэн бөгөөд, гол төсөл нь Дижитал засаг төсөл. Сингапурын төрийн цахим үйлчилгээг судлаж үзэхэд нь дараах портал тогтолцоонуудтай байна. Үүнд:³⁷

1. reach.gov.sg - Иргэдийн цахим оролцооны нэгдсэн портал тогтолцоо
2. data.gov.sg – Төрийн нээлттэй өгөгдөлийн тогтолцоо
3. gov.sg – төрийн нэгдсэн портал
4. life.gov.sg – Төрийн үйлчилгээний портал (гар утасны аппликейшнтай) LifeSG нь танд төрийн үйлчилгээнд хялбархан хандах, хамгийн сүүлийн үеийн мэдээ, шинэчлэлтийг авах, өөрийн программыг хянах гэх мэт олон боломжийг олгоно.
5. singapass.gov.sg – Үндэсний дижитал танилт нэвтрэлтийн тогтолцоо нь иргэд болон бизнес эрхлэгчдэд засгийн газар болон хувийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай харилцахад тохиромжтой платформ (гар утасны аппликейшнтай) зэрэг иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага хоорондын төрийн дижитал үйлчилгээний нийт 28 портал тогтолцоотой байна.

Ухаалаг үндэстэн ба Дижитал засгийн группээс (SNDGG) жил бүр иргэд, аж ахуйн нэгжээс төрийн дижитал үйлчилгээний сэтгэл хангамжийн судалгаа авдаг бөгөөд судалгаанд оролцсон иргэдийн 99 хувь нь төрийн дижитал үйлчилгээний чанар хүртээмжид сэтгэл хангалуун, 84.5 хувь Ковид-19 та үед авч хэрэгжүүлсэн төрийн дижитал шийдэлд сэтгэл хангалуун, 94 хувь нь сүүлийн нэг жилд бизнесийн байгууллагад зориулсан төрийн дижитал үйлчилгээний чанар хүртээмж дээшилсэн судалгааны дүн гарсан нь төрийн цахим үйлчилгээний хөгжил индексээрээ дэлхийд тэргүүлэгч орон болохыг иргэд нь ч мөн хүлээн зөвшөөрч, төрийн шийдвэр гаргалтанд нь иргэд санал бодлоо илэрхийлдэг нээлттэй болох нь харагдаж байна. 2023 он гэхэд Засгийн газрын мэдээллийн тогтолцоонуудын 70-с доошгүй хувийг үүлэн технологид шилжүүлэх, засгийн газрын дижитал төслүүдийг хиймэл оюун ухаанд суурилсан технологиор хөгжүүлэх төлөвлөгөөтэй.³⁸

³⁷ <https://www.smartnation.gov.sg/initiatives/digital-government-services/>

³⁸ Smart Nation Singapore. Government agency website. <https://www.smartnation.gov.sg/>

5.2 БНСУ-ЫН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ

БНСУ нь мэдээлэл, харилцаа холбоо, мэдээлэлжүүлэлт, цахим засаглал, дижитал засаглалын чиглэлээр дэлхийд тэргүүлэгч орон. НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал хариуцсан хэлтсээс хоёр жил тутамд дэлхийн улс орнуудын Цахим засгийн хөгжлийн индексээр БНСУ 2010, 2012, 2014 онуудад дарааллан 193 орноос дэлхийд тэргүүлсэн нь сүүлийн 50 жил тасралтгүй ахицтай хөгжсөн төрийн үйлчилгээний цахим тогтолцоо, иргэдийн оролцооны тогтолцоо, бодлогын тогтвортой, үр дүнтэй хэрэгжилт нөлөөлсөн. Солонгос улсын Цахим засаглалын амжилтын хүчин зүйлүүд нь улс төр, нийгэм, эдийн засаг, үйлдвэрлэлийн орчин, улс төрийн шийдэмгий байдал, манлайлал, алсын хараа, бодлогын зорилго, төслийн стратегийн тэргүүлэх чиглэл, хэрэгжүүлэх тогтолцоо, хүний болон санхүүгийн нөөцийн хуваарилалт, байгууллагуудын хамтын ажиллагаа, нэгдсэн тогтолцоо, санал хүсэлт-оролцоо, суралцах чадвар юм.³⁹

Хүснэгт 8. БНСУ-ын Цахим засгийн хөгжлийн үе шат

Үе шат	Гол үр дүн
Оршил 1980-1990	Үндэсний мэдээллийн 5 үндсэн тогтолцоог бий болгосон (NBIS) Компьютерийн сүлжээг өргөтгөх, хэрэглээг дэмжих тухай хууль баталсан (1987)
Суурь 1990-2000	Мэдээлэл, харилцаа холбооны үндэс суурийг тавьж, интернэт нэвтрүүлсэн Мэдээллийн тогтолцоог түгээх, ашиглахыг дэмжих тухай хууль баталсан (1995)
Эхлэл 2001-2002	Цахим засаглалын чиглэлээр 11 томоохон ажил хийсэн Цахим засаглалын тухай хууль баталсан (2001)
Тархалт 2003-2007	Цахим засгийн 31 замын зураглалын ажлыг гүйцэтгэсэн Төрийн яам, агентлагуудыг хооронд нь холбож, нэгтгэх үндсийг тавьсан
Нийцэл 2008-2010	Үндэсний мэдээллийн ил тод байдлын мастер төлөвлөгөөг гаргасан (2008) Нээлттэй байх, хуваалцах, хамтран ажиллах зарчимд тулгуурлан цахим засаглалын 12 үйл ажиллагааг хийж гүйцэтгэсэн
Ухаалаг засаг 2011-2015	Цахим засаглалын ирээдүйн төлөвлөгөө, Ухаалаг төр 2011-2015 оныг санаачилсан

2020 оны 7 дугаар сард БНСУ-ын Засгийн газар Солонгосын шинэ хэлэлцээр стратегийн батласан бөгөөд үүнд Дижитал шинэ хэлэлцээр стратеги багтжээ. Мөн Дижитал засаглалын мастер төлөвлөгөө 2021-2025, Хиймэл оюун ухааныг хөгжүүлэх үндэсний стратеги зэрэг нэгдмэл ойлголт, нэгдсэн хөрөнгө оруулалттай дижитал шилжилтийн бодлого хэрэгжүүлж байна.

БНСУ-ын Гаалийн байгууллага 2006 онд дэлхийд анх удаа онлайн экспорт, импортын UNI-PASS цахим гаалийн тогтолцоог нэвтрүүлж, Дэлхийн Гаалийн

³⁹ Song, H.-I., CHO T., 2007, "Electronic Government of Korea - Performance and Tasks," Informatization Policy, vol. 14, n°4, p. 20-37.

Байгууллагын 169 гишүүн орноос хамгийн хурдан гаалийн тогтолцоогоор шалгарч цомыг хүртэж байжээ.

Мөн цахим худалдан авалтын тогтолцоо буюу KONEPS нь 2006 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Төрийн шилдэг үйлчилгээний шагналыг (PSA) хүртэж, Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (OECD) ил тод байдлыг сайжруулах шилдэг үйлчилгээгээр шалгарч, Дэлхийн мэдээллийн конгрессын "Дэлхийн шилдэг мэдээллийн технологийн үйлчилгээ шагнал"-ын эзэн болсон. Татварын цахим үйлчилгээ болох Home Tax Service нь Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (OECD)-ын шилдэг загваруудын нэгээр шалгарсан бөгөөд, иргэдийн цахим оролцоонд зориулсан "e-people" вэб хуудас нь 2006 оны Дэлхийн цахим засгийн форумас улс төрийн шилдэг 10 цахим үйлчилгээний нэгээр шалгарч байжээ.⁴⁰

Цахим худалдан авалтын тогтолцоо - KONEPS (www.g2b.go.kr)

- Тойм: Худалдан авах ажиллагааны бүх үйл ажиллагаа нь онлайнаар зохицуулагддаг бөгөөд төрийн худалдан авах ажиллагааны үр ашиг, ил тод байдлыг хангах зорилгоор худалдан авах ажиллагаа нэг цонхоор нээлттэй ажилладаг.
- Үйлчилгээ: Тендер шалгаруулалт, гэрээ байгуулах, хүргэх, нийлүүлэх зэрэг худалдан авах ажиллагааны бүх үе шатууд болон төлбөрийг онлайнаар зохицуулж, худалдан авалтын явцыг бодит цаг хугацаанд хянах боломжтой. Бүртгэгдсэн бүх аж ахуйн нэгжүүд G2B тогтолцоонд нэг бүртгэлээр улсын байгууллага, орон нутгийн засаг захиргааны байгууллага, төрийн өмчит байгууллага зэрэг бүх төрийн байгууллагуудын тендерт оролцох боломжтой.
- Тогтолцоо хөгжүүлсэн хугацаа: 12 сар
- Тогтолцоо хөгжүүлсэн өртөг: 9.2 сая доллар

Цахим гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээ - UNI-PASS

- Тойм: Экспорт, импортын ложистикийн бизнес, үйл явцыг сайжруулах, оновчтой болгох, хэрэглэгчдэд ээлтэй багц логистик боловсруулах үйлчилгээг хэрэгжүүлэх зорилгоор гаалийн үйлчилгээг цахим хэлбэрээр нэг цэгээс хүргэх портал тогтолцоо.
- Үйлчилгээ: Гаалийн байгууллагад экспорт, импортын тайлан, шалгалт, хорио цээрийн мэдүүлэг, нэг цэгийн үйлчилгээ үзүүлэхийн тулд бусад байгууллагуудтай тогтолцоо нь холбогдсон.
- Тогтолцоо хөгжүүлсэн хугацаа: 18 сар
- Тогтолцоо хөгжүүлсэн өртөг: 13.8 сая доллар

⁴⁰ E-Government systems of Korea, 100 acknowledged worldwide.
<https://www.dgovkorea.go.kr/>


Татварын цогц үйлчилгээ - www.hometax.go.kr

- Тойм: Татвар төлөгчид татварын албанд очихгүйгээр гэртээ болон ажил дээрээ татварын асуудлаа онлайнар шийдвэрлэх боломжтой тогтолцоо
- Үйлчилгээ: Бүртгэл, тооцоо, төлбөр зэрэг татварын бүх үйл ажиллагаа онлайнар боловсруулагдаж, татвар төлөгч хүссэн үедээ мэдээлэл авах боломжтой. Татвар төлөгч болон түүний татварын төлөөлөгч, иргэний 18 гэрчилгээг хүсч, хүлээн авах боломжтой.

Цахим хүн - www.epeople.go.kr

- Тойм: Иргэдийн санал хүсэлтийг нэг цонхоор хянан шийдвэрлэх замаар бодлого боловсруулахад иргэдийн оролцоог дэмждэг.
- Үйлчилгээ: Төрийн институцийг боловсронгуй болгох, шударга бус үйл ажиллагаа, удирдлагын тухай, төрийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, мэдэх, санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох зорилгоор иргэдийн гомдол, саналыг хүлээн авч, боловсруулдаг. Мөн хүмүүс онлайнар санал, гомдол, төрийн ажиллагааны хэрэгжилтийг шалгах боломжтой. Их өгөгдөлийн шинжилгээний тогтолцоотой.
- Тогтолцоо хөгжүүлсэн хугацаа: 50 сар
- Тогтолцоо хөгжүүлсэн өртөг: 10 сая доллар

Зураг 9. БНСУ-ын төрийн цахим үйлчилгээний тогтолцоо⁴¹



41 Kim, Kibyoung, Korea's E-government strategy for new digital economy environment, 2018

5.3 ХБНГУ-ЫН ЦАХИМ ЗАСАГЛАЛЫН ХӨГЖИЛ

Цахим шилжилтийг эрчимтэй хийж буй улсын нэг нь ХБНГУ. ХБНГУ-д түүхий эдийн нөөц бага, эрчим хүчний үнэ өндөр, хүн амын өндөр насжилттай холбоотойгоор ажиллагсдын дундаж нас нэмэгдэж буй тул үйлдвэрлэлийн салбарт өсөлтийг хангах нэгэн гарц бол хиймэл оюун ухаанд суурилсан цахим шилжилтийг амжилттай хийх явдал болж байна. Иймд цахим шилжилтийг Холбооны Засгийн газар 2010 оноос хойш тодорхой бодлого, стратегийн хүрээнд цогц байдлаар төлөвлөж, хэрэгжүүлж байна. ХБНГУ-ын Бундестагийн Enquete комиссоос 2010-2013 онд гаргасан “Интернет ба дижитал нийгэм” цуврал судалгааны тайлан мэдээ, Холбооны Засгийн газрын Дижитал хөтөлбөр 2014-2017, Холбооны Засгийн газраас 2016 онд баталсан Дижитал стратеги 2025, Холбооны Засгийн газраас 2018 онд гаргасан “Дижиталчлалыг хөгжүүлэх нь” стратегийн хүрээнд улс орон даяар шат дараалсан цэгцтэй арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна. ХБНГУ-ын Холбооны Засгийн газраас өдгөө баримтлан хэрэгжүүлж буй үндсэн баримт бичиг болох “Дижиталчлалыг хөгжүүлэх нь” стратеги нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллага гэсэн зорилтот бүлгүүдэд чиглэсэн доорх үндсэн таван чиглэлийн нийт 145 цөм төслийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.⁴² Үүнд:

- Цахим орчны талаарх мэдлэг чадварыг бий болгох,
- Дэд бүтэц ба тоног төхөөрөмжөөр хангах,
- Инновац ба цахим шилжилтийг хийх,
- Цахим шилжилтийн үед нийгэмд зохих өөрчлөлтийг хийх,
- Орчин үеийн улсыг бий болгох гэсэн үндсэн чиглэлүүд орж байна.

2020 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн ХБНГУ-ын Холбооны Засгийн газрын хуралдаанаас “Дижиталчлалыг хөгжүүлэх нь” стратегийг хэрэгжүүлэх хянах самбар бүхий нарийвчилсан график гаргасан бөгөөд дээр дурдсан 145 цөм төслийг нэг бүрчлэн задалж, нийт 663 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. ХБНГУ ийнхүү цахим шилжилтийг бүхий л салбар, чиглэлийг хамруулан далайцтай, эрчимтэй явуулж буйн үр дүнг судлан үзэхэд доорхи хоёр дүгнэлтэнд хүрч байна.⁴³

- ХБНГУ улс орныхоо хэмжээнд цахим шилжилтийг эрчимтэй явуулж байна. Германы дотооддоо явуулж буй судалгааны дүнгээр ХБНГУ нь 2019 онд дижиталчлалын индексээр 67,6 хувьд хүрсэн нь 2017 оны үзүүлэлттэй харьцуулахад 5 хувиар өсчээ.
- Германы дотоодод цахим шилжилт амжилттай явагдаж, өмнөх жилүүдээс тодорхой ахиц гарч байгаа ч дэлхийн бусад өндөр хөгжилтэй орнуудтай харьцуулахад арай удаашралтай явж байна. Үүнийг Швейцарийн Менежмент, Хөгжлийн Институт (IMDIstitute of Management Development)-ээс уламжлал болгон гаргадаг “Дэлхийн улс орнуудын дижитал өрсөлдөх чадвар 2020” судалгааны үр дүнгээс тодорхой харж болохоор байна. Уг

⁴² Zukunftsbild “Industrie 4.0”, Bundesministerium für Bildung und Forschung

⁴³ Ц.Лхам, ХБНГУ-ын цахим шилжилт, цахим хөгжлийн чиг баримжаа, түүний Монгол Улсад тусах нөлөө, 2020

судалгаанд дурдсанаар, ХБНГУ дижитал өрсөлдөх чадварын хувьд 2016 онд 15 дугаар байранд орж байсан бол 2020 оны байдлаар 18 дугаар байранд орж, урьд жилүүдтэй харьцуулахад ухарсан үзүүлэлттэй гарчээ.

Хүснэгт 10. Олон улс, бүс нутгийн байгууллага, судлаачид

“Дижитал шилжилт”-ийг тодорхойлсон тодорхойлолтын түүвэр

Эх сурвалж	Тодорхойлолт
Европын холбоо (2019)	“Дижитал шилжилт нь дэвшилтэт технологи, интеграцчлалын нэгдлээр тодорхойлогддог бөгөөд дижитал тогтолцоо, шинэлэг бизнесийн загвар, шинэ процесс давамгайлж, ухаалаг бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох үйл ажиллагаа”
Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага OECD (2018)	“Дижитал шилжилт гэдэг нь дижиталчлал, дижитал эдийн засгийн нийгэмд үзүүлэх үр нөлөөг хэлнэ. Дижиталчлал гэдэг нь аналог өгөгдөл, процессыг машин унших боломжтой формат руу хөрвүүлэх явдал. Дижиталчлал гэдэг нь тоон технологи, өгөгдлийг ашиглах болон тэдгээрийн харилцан холболт юм. Энэ нь шинэ эсвэл одоо байгаа үйл ажиллагаанд өөрчлөлт оруулахад хүргэдэг.”
Ismail, Khater, and Zaki (2017)	[Дижитал шилжилт нь] компаниуд бизнесийн олон хэмжигдэхүүнийг өөрчилснөөр дээд зэргийн гүйцэтгэл, тогтвортой өрсөлдөх давуу талтай болох зорилгоор олон тооны шинэ дижитал технологийг нэгтгэх үйл явц юм. Үүнд бизнес загвар, хэрэглэгчийн туршлага (дижитал бүтээгдэхүүн, үйлчилгээг багтаасан) дижиталчлах үйл ажиллагаа (дотоод процесс, шийдвэр гаргах үйл явц), хүмүүс (технологийн ур чадвар, хэрэглээ, соёл) болон тогтолцоо, технологи зэрэг орно.
Schwertner (2017)	Дижитал шилжилт нь "Илүү ашигтай орлого, илүү өрсөлдөх чадвар, өндөр үр ашигтай бизнесийн шинэ загвар, үйл явц, програм хангамж, тогтолцоог бий болгох технологийн хэрэглээ."
Deloitte (2018)	“Дижитал шилжилт гэдэг нь байгууллагын үйл ажиллагаа, хүртээмжийг сайжруулахын тулд дэвшилтэт технологийг ашиглах явдал юм. Тоон хэлбэрт шилжсэн бизнесийн хувьд дижитал технологи нь сайжруулсан үйл явц, ур чадвар, бизнесийн шинэ загваруудыг бий болгодог.”
Bloomberg (2018)	“Дижитал шилжилт нь байгууллагаас технологийн өөрчлөлтийг илүү сайн зохицуулахыг шаарддаг. Аж ахуйн нэгж нь үйлчлүүлэгчдэд чиглэгддэг тул өөрчлөлтийг үндсэн чадвар болгох. Ийм өөрчлөлт нь дижиталжуулалтын байнгын санаачилгад тус дөхөм болох боловч тэдэнтэй андуурч болохгүй.”

VI. ДҮГНЭЛТ

Монгол улсын хөгжлийн өнөөгийн түвшин, эдийн засгийн өнөөгийн байдлаас үл хамааран мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт гарч буй дэлхийн өөрчлөлт, шинэчлэл нь нийгмийн харилцаанд хувьсгал, дижитал эдийн засгаар дэлхийд өрсөлдөх шинэ боломжийг өгч байна. Энэ нь төрөөс иргэн аж ахуйн нэгж, байгууллагатай харилцах шинэ соёлыг дэлгэрүүлж, төрийн үйлчилгээ ил тод, хүний оролцоогүй болох хүнд суртал, авилгал багасах, нийгэм эдийн засгийн чухал ач холбогдолтой.

Төрөөс цахим засаглалыг хөгжүүлэхээр 2002 оноос эхлэн анхаарч Цахим засгийн газрын мастер төлөвлөгөө, Мэдээлэл харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх бодлогын бичиг баримт, Цахим Монгол үндэсний хөтөлбөр, Цахим засаг үндэсний хөтөлбөр, Цахим засаглал үндэсний хөтөлбөр, Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого зэргийг батлан хэрэгжүүлж өдий хүрсэн. Өнөө цагт “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор Шинэ сэргэлт хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд цахим засаглалыг хөгжүүлж, бэхжүүлэх зорилтууд багтаж, мөн Цахим үндэстэн дунд хугацааны бодлогын баримтлах чиглэл хэрэгжиж байна. Үндэсний хөтөлбөр, бодлогын бичиг баримтуудаас харахад хэрэгжилт хүссэн үр дүндээ хүрээгүй нь тухайн үеийн нийгэм эдийн засгийн байдал, улс төрийн манлайлал, нэгдмэл ойлголт, хөрөнгө оруулалт, цахим засгийг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллагын эрх зүйн чадамж, иргэдийн оролцоо, цахим бичиг үсгийн чадвартай шууд холбогдож байна. Энэхүү судалгаанаас харахад Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үе үеийн үйл ажиллагааны төлөвлөгөө, мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцож өмнөх бодлогоосоо дараагийн бодлого боловсруулахад хяналт, үнэлгээ хийсэн бодлогын залгамж байхгүй байна. Дээрх бичиг баримтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд давхардал их байна. Цаашид харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, Цахим үндэстэн болох стратегийг хэрэгжүүлэхэд бусад салбарын технологийн хөгжлийг давхар тодорхойлж хөндлөн бүтэцтэй ажиллах шаардлагатай байна.

Монгол улсын хүн ам тархан суурьшсан, нөхцөлд хөдөө орон нутгийн иргэд, нүүдлийн малажахуй эрхэлдэг, газар тариаланчид, улирлын чанартай бизнес эрхэлдэг онцлогоос хамаарч тэдний ажиллаж амьдардаг алслагдсан газарт хөдөлгөөнт холбооны сүлжээ бүрэн дүүрэн хүрээгүй байна. Ухаалаг төхөөрөмж, гар утастай хэрэглэгч, интернэт хэрэглэгчийн тоо хүн амын тооноос илүү байгаа нь дийлэнх нь хот суурин газрын хэрэглэгч байгаатай холбоотой. Хөдөө орон нутгийн бүх хэрэглэгч ухаалаг гар утасгүй, цахим хэрэглээний ур чадвар нь харилцан адилгүй, суурин интернэт нийт өрхийн 32.7 хувь, Улаанбаатар хотын 50.6 хувьд хүрсэн байгаа нь “хүн амд өндөр хурдны интернэт хүргэх” тухай Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэхэд тулгамдаж байгаа гол асуудлын нэг. Мөн цахим орчинд хүүхэд хамгаалах чиглэлээр бүх шатны сургуулийн сургалтын хөтөлбөр оруулах, өсвөр насны хүүхэд, багачуудын

цахим орчны зохистой хэрэглээний мэдлэг ойлголтыг нийгэмд дэлгэрүүлэх, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн хамтарсан ойлголт, итгэлцэлийн орчинг бий болгоход анхаарах шаардлагатай байгааг кибер аюулгүй байдлын статистик, цахим орчноос үүсэлтэй гэмт хэргийн тоо баримт харуулж байна. Эцэг эх нь технологи, цахим хэрэглээний мэдлэггүй, мэддэг ч оролцдоггүй байдал нь зүй бус контент үзэх болон цахим гэмт хэргийн хохирогч болох магадлалыг дагуулдаг. Иймд бүх нийтийн цахим боловсрол, зохистой хэрэглээний бодлого, хэрэгжилт маш чухал байна.

Харилцаа холбооны тухай хуулийн 30^{1.5}."Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит" гэж тухайн байгууллагад ашиглаж байгаа харилцаа холбоо, мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, техникийн шийдэл, харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр нь байгууллагын стратегийн зорилтыг хангахад дэмжлэг үзүүлж, стандартад нийцэж байгаа эсэхийг хөндлөнгийн этгээдээс тогтоож, дүгнэлт, зөвлөмж гаргах хараат бус үйл ажиллагааг ойлгоно гэж, мөн Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.9. "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ" гэж цахим мэдээлэл, мэдээллийн тогтолцоо, мэдээллийн сүлжээний кибер аюулгүй байдал алдагдах, аюул занал тохиолдох магадлал, эмзэг байдлын түвшин, түүнээс үүсэх үр дагавар, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох мэргэшсэн үйл ажиллагааг 4.1.10."Мэдээллийн аюулгүй байдлын аудит" гэж кибер аюулгүй байдлын хууль тогтоомж, холбогдох журам, стандартад нийцсэн эсэхэд дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх хараат бус хөндлөнгийн мэргэжлийн үйл ажиллагааг; гэж тус тус тодорхойлж заасан байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээний тус тусдаа үйл ажиллагаа мэт тодорхойлж хоёр хуулинд салгаж зохицуулалт хийхээр заасан нь тохиромжгүй бөгөөд үйл ажиллагааны хүрээ хязгаар нь давхардалтай байна.

Цаашдаа дижитал шилжилтийг хурдасгах, олон улсын сайн туршлагыг судлах, Алсын хараа-2050, Шинэ сэргэлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, Цахим үндэстэн дунд хугацааны бодлогын бичиг баримтыг тогтоосон хугацаандаа төлөвлөөний дагуу амжилттай хэрэгжүүлж, E-Mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталын үйл ажиллагааг тогтвортой, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг ханган хөгжүүлэх, бодлогын залгамж халааг алдагдуулахгүй байх, дижитал шилжилтийг хэсэгхэн төрийн байгууллага бус салбар бүрт нөлөөлөх хөгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд батлагдсан бодлогуудаа уялдаа холбоотойгоор хяналттай хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдлаа.

Дэлхийд цахим засаглалын хөгжлөөрөө тэргүүлэгч Дани, Их Британи, Сингапур, БНСУ, Эстони зэрэг улсууд цахим засаглалаас дижитал засаглалыг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. Их өгөгдөлд суурилсан газрын газар, Үүлэн технологид суурилсан газрын газар, Хиймэл оюунд суурилсан төрийн дижитал үйлчилгээ, блокчейнд суурилсан төрийн цахим үйлчилгээг амжилттай нэвтрүүлж байна.

Европын холбоо нь 2019 оноос эхлэн бизнес, нийгмийн өөрчлөлтөд дижитал шилжилтийн давуу талыг онцлох болсон. Мөн Европын холбооны улс орнуудын дижитал шилжилтийн ахиц дэвшлийг хэмжихэд чиглэсэн мониторинг, үнэлгээний

тогтолцоо бий болгох үйл ажиллагааг санаачлан ажиллаж байна.

2017 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD) нь дэлхийд “Дижитал руу шилжих нь: Өсөлт, сайн сайхан ирээдүйн төлөөх өөрчлөлтийг хийх нь” шинэ төслийг эхлүүлсэн. Төслийн зорилго нь “Бодлого боловсруулагчдад дижитал өөрчлөлтийг илүү сайн ойлгоход нь туслах, дижитал болон өгөгдөлд тулгуурласан дэлхийд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогын орчныг бүрдүүлэх” юм. Яагаад дижитал өөрчлөлтөд маш их анхаарал хандуулах хэрэгтэй вэ? Нэгдүгээрт, дижиталчлал нь нийгэм, эдийн засаг, бизнесийн хөгжлийн салшгүй хэсэг юм. Дижиталчлал ба даяаршилын үйл явц нь бидний өнөөгийн оршин тогтнол тодорхойлж байна. Европын холбооны урьдчилсан таамаглалаар 2030 он хүртэлх дэлхийн гол чиг хандлагын нэг нь “аж үйлдвэрийн 4-р хувьсгал, технологийн хувьсгал” байх болно гэж үзэж байна. “Улс төр, засаглал, боловсрол, шинжлэх ухаан, амьдралын хэв маяг, хиймэл оюун, нээлттэй тогтолцоо, эрүүл мэнд, түүний дотор хүний геномын өөрчлөлт зэрэг нийгмийн бүхий л салбарууд технологийн ололтоор өөрчлөгдөнө”

ЗӨВЛӨМЖ

- Харилцаа холбооны тухай хуулинд туссан харилцаа холбоо, мэдээллийн технологийн аудит, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн мэдээллийн аюулгүй байдлын аудит мөн кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зохицуулалтыг тус тусын хуулинд туссан хэрэгжүүлэх журмаар үйл ажилгааны хүрээ хязгаарыг тодорхойлж журамлах;
- Харилцаа холбооны тухай хуулийн 6^{1.1}.”Монгол Улсад харилцаа холбоо, мэдээллийн технологи нэгдмэл бодлого, төлөвлөлттэй байна”, 6^{1.3}.”Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага Засгийн газраар шийдвэрлүүлэх харилцаа холбоо, мэдээллийн технологийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн хүрээний асуудлаар харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авсан байна”, 6^{1.4}.”Салбар хооронд харилцаа холбоо, мэдээллийн технологид тулгуурласан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх бодлого, төлөвлөлтийн асуудлыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ” гэж тус тус заасан үндэслэлээр төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн технологийн бодлогод шинэчлэл хийх, заавар, зөвлөмж өгөх, нэр томъёо, мэдээллийн сангийн давхардал арилгах;
- Кибер аюулгүй байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг хүрээнд бүх төрийн захиргааны байгууллагад мэдээллийн технологийн бодлого, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авалт, төрийн албан хаагчдын цахим ур чадварыг үнэлгээ, сүлжээ, програм хангамж, өгөгдөл, мэдээллийн сан, ашиглагдаж байгаа техник тоног төхөөрөмжийн ашиглалт хадгалалт хамгаалалт, сул зогсолт, давхардалыг үнэлэх мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрсдэлийн үнэлгээг 2 жил тутамд хийх;

- Цахим засгийг хөгжүүлэх чиглэлээр батлагдсан багц хуулиуд болох Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хувь хүний өгөгдөл хамгаалах тухай хуулийг тус тус хэрэгжүүлэхэд дагаж гарах журмуудыг боловсруулж батлан, хуулийн хэрэгжилтийг хангах;
- Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хууль, урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг оновчтой үнэлэх, хэрэгжилтийн хяналтын тогтолцоог Засгийн газрын бүтцийн хэмжээнд бий болгох, бодлогын төлөвлөгөөний давхардалд үүсгэхгүйгээр бодлогоо тодорхойлох;
- 2002 оноос хэрэгжсэн бодлогын бичиг баримтын хэрэгжилтэд “Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх мөн төрийн цахим үйлчилгээг ашиглах мэдлэг, технологийн ур чадварыг иргэдэд олгох” зорилт арга хэмжээнүүд тусгагдсан ч хэрэгжилт хангалтгүй байна. Иймд төрийн албан хаагчдын технологийн ур чадварыг дээшлүүлэх арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төрийн албаны зөвлөл, Цахим хөгжил харилцаа холбооны яамтай хамтран бодлогыг түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- Боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, банк санхүү, уул уурхай, эрчим хүч, нийгмийн хамгаалал, зам тээвэр, байгаль орчин зэрэг нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбар бүрд төрийн цахим үйлчилгээ нь харилцан уялдаагүй байна, мөн нэгдсэн бодлогогүйгээс болж салбар бүрт дэвшилтэт технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ нь их хэмжээний хөрөнгө оруулалтын давхардалтайгаар нэвтэрч байна. Иймд Монгол Улсад мэдээллийн технологи, харилцаа холбооны нэгдмэл бодлого, төлөвлөлт, зохион байгуулалттай хөгжүүлэхийн тулд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь салбар хоорондын уялдааг хангах хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Төрөөс иргэнд (G2C), иргэн төрд (C2G) гэсэн цахим үйлчилгээнээс бусад төрийн байгууллага (G2G) хоорондын болон бизнесийн байгууллага хоорондын (G2B), (G2E) цахим үйлчилгээний платформыг хөгжүүлэх стратеги бодлогод тусгагдаагүй байгаа тул дараагийн бодлого, хөтөлбөрт тусгах;
- Цахим засаглалыг хөгжүүлэхээр хангалттай хууль, эрх зүйн орчин, бодлого, төсөл хөтөлбөр батлагдсан ч хоорондын уялдаа холбоогүй, давхардсан, зарим хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөлгүй дэндүү тунхагийн шинжтэй байна. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого-2025, “Цахим засаглал” үндэсний хөтөлбөр нь хугацаанаасаа өмнө хүчингүй болсон тул Улсын Их Хурал, Засгийн

- газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, тооцсоны үндсэн дээр хүчингүй болгодог байх, төрийн бодлогын хэрэгжилтийн хяналт, хөрөнгө оруулалт, үр өгөөжийн цахим хяналтын самбар бүхий нэгдсэн тогтолцоог Засгийн газрын түвшинд хэрэгжүүлэх;
- Төрийн байгууллагад ажиллаж байгаа мэдээллийн технологийн инженер, хүний нөөцийг тогтвортой байдлыг хангах үүднээс цалин урамшуулал, нийгмийн асуудлыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж байж төрийн их өгөгдөл, нууц, эмзэг мэдээлэлтэй ажиллаж байгаа чадварлаг хүний нөөцийг ажиллуулах боломжтой.
 - E-Mongolia академиас Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн хэрэглээний боловсролын тогтолцоог бий болгох;
 - Хил хязгааргүй цахим ертөнцөд төрөөс мэдээллийн технологийн салбарын хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бий болгож, Үндэсний дижитал контентийг дэмжин хөгжүүлэх бодлоготой болох;

VII. НОМ ЗҮЙ

A. Монгол хэл дээрх эх сурвалж:

- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралт “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого
- Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолын хавсралт Цахим засаг үндэсний хөтөлбөр
- Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоолын хавсралт Цахим засаглал үндэсний хөтөлбөр
- Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Шинэ сэргэлтийн бодлого”, 2 дугаар хавсралт “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх үе шатны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралт “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”
- Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолын хавсралт “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”
- Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралт “Монголын улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- Улсын Их Хурлын 2020 оны 24 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/24 тушаалын хавсралт “Цахим үндэстэн” дунд хугацааны зорилтот хөтөлбөр
- Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолын хавсралт Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого батлах тухай
- Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралт Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралт “Үндсэн тогтолцооны үйл ажиллагааг зохицуулах, тогтолцоо ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /шинэчилсэн найруулга/ хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390263044601>
- Кибер аюулгүй байдлын тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390365491061>
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390288615991>
- Хууль тогтоомжийн тухай хууль
- <https://legalinfo.mn/mn/detail/11119>
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль <https://le->

galinfo.mn/mn/detail/15403

- Цахим гарын үсгийн тухай хуулийн
- <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390355252531>
- Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралт “Үндсэн тогтолцооны үйл ажиллагааг зохицуулах, тогтолцоо ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”
- Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам”
- Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн тогтолцооны үйл ажиллагааны журам”
- Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралт “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”
- Засгийн газрын 2022 оны 202 дугаар тогтоолын хавсралт “Нээлттэй өгөгдлийн төлбөр тооцох аргачлал”
- Засгийн газрын 2022 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Хүн, хуулийн этгээдэд цаасан хэлбэрээр мэдээлэл өгөхтэй холбогдон гарах зардал тооцох аргачлал, зардлыг төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журам”
- Засгийн газрын 2022 оны 211 дүгээр тогтоолын хавсралт “Хязгаарлалттай мэдээллийг өгсөн, дамжуулсан тохиолдолд мэдээллийн эзэнд мэдэгдэл хүргүүлэх, ашиглах хүсэлт гаргасан, гуравдагч этгээдэд өгсөн, дамжуулсан талаарх бүртгэл хөтлөх журам”
- Засгийн газрын 2022 оны 219 дугаар тогтоолын хавсралт “Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам”
- Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолын хавсралт “Нээлттэй өгөгдлийн жагсаалт”
- Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/18 дугаар тушаалын хавсралт “Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн тогтолцоо үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам”
- Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Швейцарын хөгжлийн агентлаг, Азийн сан. “Цахим засаглалын бэлэн байдлын үнэлгээ” судалгааны тайлан
- Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв. Мэдээллийн технологийн салбарын хөдөлмөрийн зах зээл, ур чадварын дутагдалыг тодорхойлох судалгаа
- Ц.Лхам, ХБНГУ-ын цахим шилжилт, цахим хөгжлийн чиг баримжаа, түүний Монгол Улсад тусах нөлөө, 2020
- Ж.Баатархүү. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжлийн

- судалгаа. УБ., 2018. 11 дэх тал
- Үндэсний статистикийн хороо. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан <https://www.1212.mn/>
 - Харилцаа холбооны зохицуулах хорооны цахим хуудас. <https://crc.gov.mn/>

Б. Гадаад хэл дээрх эх сурвалж:

- UN E-Government Surveys. Digital Government in the Decade of Action for Sustainable Development.2020 <https://publicadministration.un.org/en/Research/UN-e-Government-Surveys>
- UN E-Government Surveys. E-government in support of sustainable development. 2016 <https://publicadministration.un.org/egovkb/Portals/egovkb/Documents/un/2016-Survey/E-Government%20Survey%202016.pdf>
- UN E-Government Surveys. Gearing e-government to support transformation towards sustainable and resilient societies. 2018 https://publicadministration.un.org/egovkb/Portals/egovkb/Documents/un/2018-Survey/E-Government%20Survey%202018_FINAL%20for%20web.pdf
- Nawaf Alharbi, Maria Papadaki & Paul Dowland.,(2016) “Security Factors Influencing End Users’ Adoption of E-Government”
- [Natalja Verina](#), & [Jelena Titko](#).,(2019) “Digital transformation: conceptual framework”
- IMD and Cisco initiative. Digital business transformation. A conceptual Framework.Guiding questions for each category of digital business transformation. 2015
- ITU. SDG Digital Investment Framework. 2019
- E-Government systems of Korea. 100 acknowledged worldwide.
- https://ssproxy.ucloudbiz.olleh.com/v1/AUTH_43bef30e-e040-499e-86d0-70552f8bf804/CDNStorage/upload/attach/2021/12/27/e-Government%20Systems%20of%20Korea-100%20acknowledged%20worldwide.pdf
- Ministry of the Interior and Safety of South Korea, Digital Government master-plan 2021-2025. <https://www.dgovkorea.go.kr/>
- Choong-Sik Chung, Hanbyul Choi, and Youngmin Cho. Analysis of Digital Governance Transition in South Korea: Focusing on the Leadership of the President for Government Innovation. 2022
- E-Government and Digitalization trends in advanced countries. National
- Digital Government Readiness Assessment (DGRA). Toolkit V.31.,2020
- SDG Digital Investment Framework. A Whole-of-Government Approach to Investing in Digital Technologies to Achieve the SDGs
- OECD, Recommendation of the Council on Digital Government Strategies

- European location interoperability solutions for E-Government-ELISE <https://joinup.ec.europa.eu/collection/elise-european-location-interoperability-solutions-e-government>
- Song, H. I., 2002, “Prospects and Limitations of the E-Government Initiative in Korea”, International Review of Public Administration, vol.7, n°2, p.45-53. KAPA, Seoul, Korea.
- Song, H.-I., Cho T., 2007, “Electronic Government of Korea - Performance and Tasks,” Informatization Policy, vol. 14, n°4, p. 20-37.
- Zukunftsbild “Industrie 4.0”, Bundesministerium für Bildung und Forschung
- <https://digital-skills-jobs.europa.eu/en/actions/national-initiatives/national-strategies/germany-digital-strategy-2025>
- Kim, Kibyoung, Korea’s E-government strategy for new digital economy environment, 2018



Л.Галбаатар

Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч

ШУДАРГА ШҮҮХЭЭР ШҮҮЛГЭХ ЭРХИЙГ ЦАХИМ ШҮҮХ ХУРАЛДААНД ХАНГАХ НЬ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаажсан. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1-т “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэж заасан.¹ Мөн 16 дугаар зүйлийн 14-т зааснаар өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.

Монгол Улс 1968.01.05-нд гарын үсэг зурж, 1974.11.18-нд соёрхон баталсан “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-д шударга шүүхээр шүүлгэх эрх баталгаажсан.²

Тухайлбал, Пактын 14 дүгээр зүйлд 1-т “Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй”, 2-т “Эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй”, 3-т “Хүн бүр өөрийг нь яллагдагчаар татсан аливаа эрүүгийн хэргийг хянан хэлэлцэхэд бүрэн тэгш эрхийн үндсэн дээр дараахь наад захын баталгаагаар хангагдах эрхтэй: (а) оногдуулж байгаа ялын шинж чанар, үндэслэлийг ойлгох хэлээр нь даруй, нарийвчлан мэдэгдэх; (б) өмгөөлүүлэх ажлаа бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх, сонгож авсан өмгөөлөгчтэйгээ харилцах; (в) зүй бусын хойшлуулалтгүйгээр шүүгдсэн байх; (г) хэргийг нь шүүхээр хянан хэлэлцэхэд байлцах, өөрийгөө биечлэн өмгөөлөх буюу өөрийн сонгон авсан өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх; өмгөөлөгчгүй байгаа бол өмгөөлүүлэх эрхийнх нь тухай өөрт нь мэдэгдсэн байх; шүүн таслах ажлын эрх ашиг шаардаж байвал ямар ч тохиолдолд, өөрт нь томилсон өмгөөлөгчтэй байх, ийм аливаа тохиолдолд өмгөөлөгчийн хөлсийг төлөх хүрэлцээтэй мөнгө хөрөнгө байхгүй бол үнэ төлбөргүй үйлчлүүлэх; (д) өөрийнх нь эсрэг мэдүүлэг өгч байгаа гэрчийг байцаалгах буюу байцаалгуулах, эсрэг гэрчтэй адил нөхцөлөөр өөрийн өмнөөс гэрч оролцуулах болон шалгуулах; (е) шүүн таслах ажиллагаа явуулж байгаа хэлийг ойлгохгүй буюу үг хэлээр ярьдаггүй тохиолдолд орчуулагчийн туслалцааг үнэ төлбөргүй авах; (ё) өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, бурууг хүлээх тулган шаардалтад өртөхгүй” гэж заасан.

Иймд эдгээр Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд баталгаажсан шударга шүүхээр шүүлгэх эрхийг цахим шүүх хуралдаанд хэрхэн хангаж буй байдалд дүн шинжилгээ хийх, түүнийг хэрхэн сайжруулах арга замыг дэвшүүлэхийн тулд дараах үндэслэл, зорилго, зорилт, арга зүйг баримтлав.

1 Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 1992 он, №1

2 International Covenant on Civil and Political Rights. Adopted by the General Assembly of the United Nations on 19 December 1966. <https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/international-covenant-civil-and-political-rights>

1.1. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Улсын Их Хурлаас 2020.04.29-ний өдөр батласан “Коронавируст халдвар / ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн 9.11-т “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх болон бусад эрх бүхий байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх зарим ажиллагааг цахимаар явуулж болох бөгөөд эдгээр байгууллага иргэний үндсэн эрх, эрх чөлөөний баталгааг дордуулахгүйгээр өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журмыг баталж, хэрэгжилтийг зохион байгуулна.” гэж заасан.

Үүний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020.11.24-ний өдрийн 116 дугаар тогтоолоор Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн хөдөлгөөний аргачлалд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Уг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд бүх шатны шүүх цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой болон бусад шүүх хуралдааныг “Zoom”, “Skype” болон бусад программ хангамж ашиглан цахимаар буюу зайнаас явуулсан.³

Улсын Их Хурлаас Монгол Улсын шүүхийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2021.01.15-ны өдөр батлаж, 2021.03.01-ний өдрөөс эхлэн үйлчилж байна.⁴ Тус хуулийн 12.4-т “Шүүх өөрийн цахим хуудастай байх бөгөөд шийдвэр, үйл ажиллагаагаа олон нийтэд тогтмол мэдээлнэ”, 12.6-д “Төрийн болон албаны, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг цахимаар болон телевизээр нэвтрүүлж болох бөгөөд холбогдох журмыг Ерөнхий зөвлөл батална.”, 22.8-д “Хуульд өөрөөр заагаагүй бол бүх шатны шүүх шийдвэрээ шүүхийн шийдвэрийн нэгдсэн цахим санд байршуулна...”, 71.1.12-т “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоо, цахимаар шүүх хуралдааныг зохион байгуулах программ хангамжийг хөгжүүлэх, хэвийн ажиллагааг хангах”, 71.1.14-т “...шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журмыг хуульд заасны дагуу батлах”, 71.1.27-д “цахимаар хийсэн худалдаа, цахим орчинд хийсэн гэрээ, хэлцэл, интернэт үйлчилгээ, интернэт орчинд анх удаа хэвлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн талаар маргаан, интернэтэд нийтлэгдсэн буюу түгээсэн бүтээлийн зохиогчийн эрх буюу бусад холбоотой эрхийг зөрчсөнтэй холбоотой маргаан, интернэтийн домэйн нэр, эзэмшил, түүний зөрчилтэй холбоотой маргааныг тухайлан хуульд заасан тохиолдолд цахим шүүхээр шийдвэрлэх платформ, эсхүл шүүх хуралдааныг цахимаар хэрэгжүүлэх программ хангамжийг хөгжүүлэх”, 75.2.5-д “шүүхийн үйл ажиллагааны талаар олон нийтийн саналыг бичгээр болон цахим хэлбэрээр авах ажлыг зохион байгуулах”, 107.3-т “Төрийн байгууллага, хуулийн этгээд нь бичмэл нотлох баримтыг ..., эсхүл хуульд заасны дагуу цахим хэлбэрээр өгч болно” гэж тус тус заасан.

3 Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан – 2020. Улаанбаатар, 2021. 34 дэх тал https://www.judcouncil.mn/site/news_full/11129

4 Монгол Улсын шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2021 он, №05

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс одоогоор дараах хэм хэмжээг баталсан байна:

- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.02.24-ний өдрийн 39 дүгээр тогтоолын хавсралт “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам”
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.02.24-ний өдрийн 41 дүгээр тогтоолын хавсралт “Хэргийн хөдөлгөөний нэгдсэн тогтолцоо ашиглах журам”
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.03.31-ний өдрийн 82 дугаар тогтоолын хавсралт “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам”.

Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020.02.10-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөө”-ний 3.3.3-т “Цахим шүүхийг хөгжүүлэх” гэж заасан бөгөөд түүнд дараах арга хэмжээг тусгажээ:

- 3.3.3.1. Цахим шүүхийг хөгжүүлэх цогц зураглал хийх, хэрэгжүүлэх үе шатыг тодорхой болгох,
- 3.3.3.2. Шүүх цахимаар нэхэмжлэл хүлээн авах, өмгөөлөгч, хэргийн оролцогчтой цахимаар харилцах, улсын тэмдэгтийн хураамжийг цахимаар төлөх, цахим нотлох баримтыг үнэлэх эрх зүйн орчин бүрдүүлэх,
- 3.3.3.3. Цахим шүүхийн дэд бүтцийг (мэдээллийн сүлжээ, техник болон программ хангамж, мэдээллийн сан, мэдээллийн тогтолцооны загвар) бүрдүүлэх, шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх,
- 3.3.3.4. Иргэн, захиргааны хэргийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахим хэлбэрт үе шаттай шилжүүлэх.
- Мөн 3.5.9-д “Иргэд шүүхэд цахимаар хандах, мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээг нэвтрүүлэх” зорилт дэвшүүлсэн.⁵

Энэ нь Монгол Улсын шүүхийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр хүргэх, шүүх хуралдааныг цахимаар зохион байгуулах эрх зүйн үндэс бүрдсэн болохыг харуулж байна. Харин эрх зүйн үндэслэлээс гадна бодит байдалд цахим шүүхийн хүртээмж ямар байгаа вэ гэдэг нь судлах ёстой асуудал болсон.

1.2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Энэхүү судалгааны ажлын зорилго нь шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах хүрээнд цахим шүүх хуралдааныг зохион байгуулахад тулгарч буй асуудлыг тодорхойлж, цаашид шүүхийн цахим хуралдааны хүртээмж, давтамжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай санал, зөвлөмж боловсруулахад оршиж.

⁵ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020.02.10-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөө” https://www.judcouncil.mn/site/status_page/stratek

1.3. СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

Судалгааны зорилгыг хангахын тулд дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Монгол Улсад шүүх хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх,
- Практикт нэвтрүүлсэн цахим шүүх хуралдааны хамрах хүрээ, хүртээмжийг тодорхойлох,
- Цаашид Монгол Улсад шүүх хуралдааныг цахимаар зохион байгуулахад анхаарах асуудал, сайн туршлагыг тодорхойлох.

1.4. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхдээ дараах арга зүйг баримтлав.

- Баримт бичгийн судалгаа хийв. Энэ хүрээнд шүүхийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актаас цахим шүүх хуралдаан, шүүхийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг судалж, тэдгээрт дүн шинжилгээ хийв.
- Мөн дээрх нөхцөлөөр бусад улсын холбогдох зохицуулалтыг олж, тэдгээрийг харьцуулан судалж, Монгол Улсын зохицуулалтад тусгах шаардлагатай эсэх талаар санал бэлтгэв.
- Шүүх хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулж буйтай холбоотой холбогдох тоон мэдээлэл, статистикт дүн шинжилгээ хийх замаар нөхцөл байдлыг тоон утгаар илэрхийлэв.
- Түүнчлэн, цахим шүүх хуралдаанд оролцсон шүүгч, прокурор, өмгөөлөгч, хуульч, бусад оролцогчоос мэдээлэл авч, холбогдох санал, шүүмжийг нэгтгэн бэлтгэв.

Энэхүү судалгаанд хэрэглэсэн дараах нэр томъёо, ойлголтыг дор дурдсан утгаар хэрэглэв:

- **Цахим шүүх хуралдаан** (Virtual Hearings) - оролцогч биечлэн оролцох шаардлагагүйгээр дуу-дүрсний хэрэгслээр явуулах шүүх хуралдаан⁶
- **Шударга шүүхээр шүүлгэх эрх** (Right to a Fair Trial) - Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрх⁷
- **Шүүх хуралдаанд цахимаар оролцох** - шүүх хуралдаанд сүлжээ ашиглан тоног төхөөрөмж, техник хэрэгслийн тусламжтайгаар биечлэн оролцох⁸
- **Зохигч** - Нэхэмжлэгч, хариуцагч, хуульд заасны дагуу тэдгээртэй эрх зүйн хувьд ижил эрх, үүрэгтэйгээр хэрэгт оролцож байгаа этгээд.⁹

6 The Supreme Court of Victoria. Virtual Hearings Glossary. May, 2020 <https://www.supremecourt.vic.gov.au/law-and-practice/virtual-hearings/virtual-hearings-glossary>

7 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйл

8 Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.03.31-ний өдрийн 82 дугаар тогтоолын хавсралт “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам”-ын 21.2 дахь хэсэг

9 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.1 дэх хэсэг

II. ЦАХИМ ШҮҮХ ХУРАЛДААНЫ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

2.1. ЦАХИМ ШҮҮХ ХУРАЛДААНЫ ҮР АШИГ

Цахим шүүх хуралдаан нь хүртээмжтэй, үр өгөөжтэй, зардал болон хугацаа хэмнэх давуу талтай.¹⁰ Үүнийг дараах хүснэгтэд товч тайлбарлав.

Хүснэгт 1. Цахим шүүх хуралдааны үр ашиг

Үр ашиг	Тайлбар
Хүртээмжтэй	Оролцогчдод, ялангуяа эрүүл мэнд, өвчний улмаас эсвэл хорио цээрийн дэглэмийн улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон хүмүүсийг шүүх хуралдаанд оролцоход хялбар болгож, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангаж байна. Мөн шүүх хуралдаан хойшлох явдлыг бууруулахад эерэг нөлөөтэй.
Үр өгөөжтэй	Шүүх хуралдааны зохион байгуулалтыг уян хатан болгож, түүний хойшлох явдлыг бууруулахад тусалдаг. Шүүхэд биечлэн оролцуулахаас бага цаг зарцуулдаг.
Замын зардал болон хугацаа хэмнэх	Шүүхэд очих, буцахад зардлаас гадна хугацаа их зарцуулдаг. Энэ хүндрэлийг цахим шүүх хуралдаанаар шийдвэрлэх боломжтой.
Зардал хэмнэдэг	Биечлэн оролцуулдаг хуралдаанаас илүү зардал багатай байдаг. Энэ нь замын зардал, шүүхийн зардалтай холбоотой байдаг. Шүүхийн байран дахь ажилтнуудын зардал, их талбай, байршил ашиглах явдлыг багасгадаг.

Дээрх байдлаар цахим шүүх хуралдааны үр ашгийг хүртэхийн тулд шүүхэд хандах буюу цахим шүүх хуралдаанд оролцохтой холбоотой цахим хэрэгслийг бэлтгэх, хэрэглэх шаардлага үүснэ.¹¹

Хүснэгт 2. Цахим шүүх хуралдааны бэлтгэл болон үндсэн үе шатанд хамаарах арга хэрэгсэл

	Нэхэмжлэл гаргах	Хариуцагчийн тайлбар	Урьдчилсан хэлэлцүүлэг	Шүүх хуралдаан	Шийдвэр гаргах
Хувь хүний бэлтгэл					
Цахимаар материал өгөх	✓	✓	✓		✓
Цахим гарын үсэг	✓	✓	✓	✓	✓
Цахим нотариат			✓	✓	✓
Цахим төлбөр	✓	✓			
Цахимаар баримт бичиг гаргуулах			✓		
Цахим бүртгэл, мэдээлэл			✓	✓	✓

¹⁰ Sparq feed. Benefits of virtual hearings | Are remote courts here to stay? <https://www.sparq.live/feed/benefits-of-virtual-hearings>

¹¹ Civil Legal System Modernization. How Courts Embraced Technology, Met the Pandemic Challenge, and Revolutionized Their Operations. Report. December 1, 2021 <https://www.pewtrusts.org/en/research-and-analysis/reports/2021/12/how-courts-embraced-technology-met-the-pandemic-challenge-and-revolutionized-their-operations>

Цахим шүүх хуралдаан				
Онлайнаар маргаан шийдвэрлэх			✓	✓
Цахим хуралдаан			✓	✓
Зайнаас тангараг өргөх/ баталгаа гаргах			✓	✓
Цахимаар мэдүүлэг өгөх			✓	✓
Цахим шүүх хуралдаан				✓

Эдгээр арга хэрэгсэл тус бүр дээр Монгол Улсын хувьд ямар байгааг дараах хүснэгтэд авч үзэв. Эндээс харахад, цахим шүүх хуралдааны арга хэрэгслийг Монгол Улсад бүрэн нэвтрүүлээгүй буюу хэрэглээгүй байна.

Хүснэгт 3. Цахим шүүх хуралдааны арга хэрэгслийг Монгол Улсад нэвтрүүлсэн эсэх нөхцөл байдал

Цахим арга хэрэгсэл	Монгол Улс дахь нөхцөл байдал
Хувь хүний бэлтгэл	
Цахимаар материал өгөх	Цахимаар материалаа илгээх тусгай тогтолцоо байхгүй. Зөвхөн шүүхийн мэйлээр илгээх нөхцөлөөр хязгаарлагдаж байна.
Цахим гарын үсэг	<p>2011.12.15-нд батлагдсан Цахим гарын үсгийн тухай хуулийн 6.2-т зааснаар тоон гарын үсгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс олгосон тоон гарын үсгийн гэрчилгээ бүхий иргэн, хуулийн этгээд хэрэглэж болно. Тус хуулийг Цахим гарын үсгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон 2022.05.01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон.</p> <p>Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10.1-т “Тоон гарын үсэг нь гэрчилгээжүүлэх байгууллагаас олгосон гэрчилгээтэй байна.”, 11.1-т “Гэрчилгээг Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд таван жил, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүнд түүний оршин суух хугацаагаар, эсхүл гурван жилээс дээш хугацаагаар оршин суух бол гурван жилийн хугацаагаар олгоно.” гэж заасан. Мөн хуулийн 15.1-т зааснаар гэрчилгээ эзэмших хүсэлтийг Монгол Улсын иргэн улсын бүртгэлийн байгууллагад, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр гаргана.</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газраас Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны иргэддээ 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн тоон гарын үсгийг иргэний үнэмлэхийн санах ой буюу чипэнд суулган олгож эхэлсэн. 2022.08.12-ны өдрийн байдлаар 265,365 иргэнд иргэний үнэмлэхийн санах ой буюу чипэнд суулгаж тоон гарын үсгийг олгосон байна.¹²</p> <p>Энэ нь Монгол Улсын 16 ба түүнээс дээш насны нийт 2,267,792 иргэний 11.7% нь тоон гарын үсэгтэй байгааг харуулж байна.¹³</p>

12 “Улсын бүртгэлийн байгууллагаас иргэдэд гар утасны аппликэйшнээр дамжуулан тоон гарын үсгийг олгож эхэллээ”. 2022-08-12 <https://burtgel.gov.mn/post/61211>; <https://burtgel.gov.mn/g-sign>

13 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Монгол Улсын хүн амын тоо, нэг нас, хүйс, насны бүлгээр https://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_0300_071V3&Group_select_all=0&GroupSingleSelect=_10402_10403_10404_10405_105_106_107_108_109_110_111_112_113_114_115&Sex_select_all=0&SexSingleSelect=_18YearY_select_all=0&YearYSingleSelect=_2021&viewtype=table

Цахим нотариат	Нотариатын тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2019.05.30-ны өдрийн хуулиар “Цахим үйл ажиллагаа эрхлэх” гэсэн 25 дүгээр зүйл нэмсэн. Тус зүйлийн 25.2-т зааснаар нотариатч нь гэрчилсэн үйлдэл бүрээр цахим бүртгэл хийх, мэдээлэл үүсгэх, санд байршуулах, баяжуулах, улсын бүртгэл, татварын болон холбогдох бусад байгууллагад дамжуулах, лавлагаа, мэдээлэл авах, зуучлах замаар нотариатын цахим үйл ажиллагаа эрхэлнэ. Энэ нь нотариатын цахим мэдээллийн сантай холбоотой бөгөөд иргэнд цахим хэлбэрээр нотариатын үйлчилгээ үзүүлэхтэй хамааралгүй байна.
Цахим төлбөр	Шүүхийн ерөнхий зөвлөл “Гэрэгэ системс” ХХК-тай хамтран улсын тэмдэгтийн хураамжийг киоск машинаар төлөх үйлчилгээг 2019.11.01-ний өдрөөс эхлэн шинээр нэвтрүүлсэн. Ингэснээр шүүхийн байран дахь болон бусад цэгт байрлуулсан киоск машинаар улсын тэмдэгтийн хураамжийг төлж шууд шүүхэд хандах боломжтой болсон. Гэхдээ цахим банк, төлбөрийн хэрэгслээр дамжуулан улсын тэмдэгтийн хураамжийг зайнаас төлөх, түүнийг тооцох, бүртгэх нөхцөл бүрдээгүй байна.
Цахимаар баримт бичиг гаргуулах	Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020 оны 61 дүгээр тушаалаар Шүүхийн тамгын газар Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээс цахим хэлбэрээр лавлагаа, мэдээллийг авах журам баталсан. 2020.06.03-ны өдрөөс эхлэн иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зорилгоор бүх шатны шүүхийн тамгын газраас төрийн мэдээлэл, солилцооны “ХУР” системд хандан лавлагаа, мэдээллийг цахим хэлбэрээр хүлээн авах “Шүүхийн цахим лавлагааны тогтолцоо”-ийг шүүхийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна. Гэхдээ төрийн мэдээллийн санд хамааралгүй бусад баримт бичгийг цахимаар гаргуулах, солилцох асуудал орхигдсон.
Цахим бүртгэл, мэдээлэл	Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.02.24-ний өдрийн 41 дүгээр тогтоолын хавсралтаар “Хэргийн хөдөлгөөний нэгдсэн тогтолцоо ашиглах журам” баталсан. Гэхдээ энэ журмын дагуу тус тогтолцоог зөвхөн шүүгч, шүүхийн захиргааны ажилтан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны нэгдсэн тогтолцоо хариуцсан албан хаагч, тухайн шүүхийн Тамгын газрын мэдээлэл технологийн чиг үүрэг хариуцсан албан хаагч хэрэглэх бөгөөд хэргийн оролцогч, иргэд тус тогтолцооны бүртгэл, мэдээлэлтэй чөлөөтэй ашиглах боломжгүй.
Цахим шүүх хуралдаан	
Онлайнаар маргаан шийдвэрлэх	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиудад зааснаар урьдчилсан хэлэлцүүлэг нь шүүх хуралдаанд хамаарахгүй. “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам”-д зөвхөн шүүх хуралдааныг хамруулсан.
Цахим хуралдаан	
Зайнаас тангараг өргөх/ баталгаа гаргах	
Цахимаар мэдүүлэг өгөх	
Цахим шүүх хуралдаан	

Цахим шүүх хуралдаан гэх ойлголтын хүрээнд дараах технологийн ойлголт, нэр томъёог дагалдуулан хэрэглэж байна.¹⁴ Эдгээр нь “Зүүм” програмыг дагалдсан ойлголт, нэр томъёо юм. Монгол Улсын хувьд цахим шүүх хуралдаанд тус програмыг ихэвчлэн ашиглаж байна. Тухайлбал, 2021 онд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх коронавируст халдварын цар тахлын хүнд үед шүүхийн үйлчилгээг

хэвийн үргэлжлүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулахаас гадна товлогдсон шүүх хуралдааны 90 хувийг зүүм программаар зохион байгуулсан.¹⁵

Хүснэгт 4. Цахим шүүх хуралдаанд хамаарах технологийн зарим ойлголт, түүний тайлбар

Ойлголт	Тодорхойлолт
Аппликейшн /Application/	Ихэвчлэн "апп" гэж нэрлэдэг програм буюу програм хангамжийн хэсгийг хэлнэ.
Тусгаарлах өрөө /Breakout rooms/	Зүүм програм дээр түүний зохион байгуулагч (шүүхийн ажилтан буюу түүний туслах) нь оролцогчдыг хүлээлгийн өрөө буюу үндсэн хуралдаанаас бусад өрөөнд хуваарилах буюу байрлуулах зориулалтаар хэрэглэдэг.
Дуудлага /Call/	Дуу-дүрсний буюу дууны холболт. "Дуудлага"-ыг дуусгаснаар шууд дамжуулалт буюу дуу-дүрсний хурал зогсоно.
Төхөөрөмж /Device/	Гар утас, таблет, компьютер зэрэг харилцаа холбооны зорилгоор ашигладаг цахим төхөөрөмж.
Галерей харах /Gallery view/	Зүүм програм дээр хуралдааны бүх оролцогчдыг тоймлох буюу бүхэлд нь харах боломжийг оролцогчдод олгодог.
Зохион байгуулагч /Host/	Цахим хуралдааны үндсэн оператор. Ихэвчлэн шүүхийн ажилтны туслах нь зохион байгуулагч болдог.
Холбоос /Link /URL/ hyperlink/	Хаяг/байршил. 'Link' дээр дарснаар хэрэглэгчийг онлайн хурал, дуу-дүрс бүхий хуралд холбоно.
Хурлын нэвтрэх үг /Meeting ID/Password	Зүүм програм дээрх хуралд ороход шаардлагатай нэвтрэх эрх. Энэ эрх буюу хуралд орох дэлгэрэнгүй мэдээллийг шүүх хуралдааны бүх талд имэйлээр илгээсэн урилгад тусгадаг.
Дууг хаах /Mute/	Дуу-дүрсний буюу дууны хуралдааны үеэр микрофоныг хаах үүрэгтэй. Ингэснээр микрофоноор ямар нэг дуу дамжуулахгүй бөгөөд хуралдааны бусад оролцогчид сонсгохгүй.
Бичлэг хийж байна /Recording (s)/	Хуралдааныг дуу, дүрс, бичвэрийн форматаар баримтжуулах зорилгоор хийж буй бичлэг. Шүүх хуралдааны явцыг нууцаар бичих нь хориотой болохыг анхаарна уу.
Илтгэгчийг харах /Speaker view/	Зүүм программ дээр тухайн үед ярьж буй оролцогчийн дүрсийг автоматаар томруулах замаар түүн рүү төвлөрөн харах боломжийг оролцогчдод олгодог.
Зүүм /Zoom/	Zoom вэб хуудас эсвэл програмыг ашиглан цахим шуудангийн урилга, утсаар залгах замаар дуу-дүрс, дууны бичлэг хэлбэрээр цахим хурал, уулзалт хийх боломж олгодог харилцааны үйлчилгээ.

Энд дурдсан цахим шүүх хуралдааны үр ашгийг ковид-19 цар тахлын үед улс, орнууд хамгийн их хүртжээ.¹⁶

¹⁵ Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын Шүүхийн тайлан – 2021. Улаанбаатар. 2022 он. 132 дахь тал


¹⁶ International Bar Association. The Global Impact of the Covid-19 Pandemic on Commercial Dispute Resolution in the First Year. 2 June 2021 <https://www.ibanet.org/global-impact-covid-19-pandemic-dispute-resolution>

2.2. МОНГОЛ УЛС ДАХЬ ЦАХИМ ШҮҮХ ХУРАЛДААНЫ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Монгол Улсын хүн амын нягтрал бага, өргөн уудам нутагт тархан суурьшсан байдал нь цахим шүүх хуралдааны хэрэгцээг нэмэгдүүлж байна. Тодруулбал, нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн ам 2.1 байна.¹⁷ Мөн цар тахлын нөхцөл байдалд иргэд шүүхэд цахимаар үйлчлүүлэх хэрэгцээ, шаардлага нэмэгдсээр байна. 2022.07.21-ний өдрийн байдлаар Монгол Улсад ковид-19 цар тахлын батлагдсан тохиолдол: 934,357, нас барсан: 2,119 байна.¹⁸ Нийт товлогдсон шүүх хуралдааны ойролцоогоор ¼ нь дээрх нөхцөл байдалтай холбоотойгоор хойшилж байна.¹⁹ Тодруулбал, нийслэл дэх шүүхүүдийн хувьд авч үзвэл 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 27543 шүүх хуралдаан товлосноос Ковид-19 цар тахлаас шалтгаалан 6840 шүүх хуралдаан буюу 24.8 хувь нь хойшилсон. Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал, хэргийн оролцогч ковидын халдвар авсан, шүүхийн байр тусгаарлалтад орсон гэх мэт цар тахалтай холбоотойгоор шүүх хуралдаан удаа дараа хойшилж шүүн таслах ажиллагаа хэвийн, тасралтгүй явуулахад бэрхшээл учирснаар хэрэг хуулийн хугацаанд шийдэгдэхгүй асуудал гарч байна.

Энэ нь шүүхийн үйл ажиллагаа тасралтгүй байх, иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрх хангагдахгүй байх нөхцөлд хүргэх үр дагавартай байна. Ийм нөхцөлд цахим шүүх хуралдааны хүртээмж, давтамжийг нэмэгдүүлэх нь улам чухал болж байна. Монгол Улсын шүүхийн хэмжээнд 2015-2021 онд 36351 шүүх хуралдааныг зайнаас буюу цахимаар зохион байгуулсан байна. Үүнээс 21 мянган хэргийн шүүх хуралдааныг ковид-19-ийн тархалт идэвхтэй үе буюу 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 09 дүгээр сар хүртэлх 10 сарын хугацаанд хийжээ. Энэ нь дээрх хугацаанд улсын хэмжээнд нийт товлон зарласан 72327 хэргийн 29 хувийг эзэлж байна. Дуу-дүрсний төхөөрөмж ашиглан цахимаар явуулж шийдвэрлэсэн тус шүүх хуралдаануудад нийт 39657 хүн гэрээсээ /зайнаас/ буюу цахимаар оролцжээ. Эндээс харахад, цаашид 1 сард дунджаар 2100 шүүх хуралдааныг цахимаар зохион байгуулах боломжтой төдийгүй хэрэгцээтэй байна. Мөн 1 сард дунджаар 3965 хүн цахимаар зохион байгуулах шүүх хуралдаанд оролцох сонирхолтой байна гэж үзэж болох юм.

График 1. Улсын хэмжээнд нийт зарласан шүүх хуралдаан дахь цахим шүүх хуралдааны эзлэх хувь, 2020.12-2021.09




17 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn

18 WHO. Mongolia Situation <https://covid19.who.int/region/wpro/country/mn>

19 “Зууны мэдээ” сонин. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргаа, удирдлагын газрын Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга Э.Амарсанаагийн ярилцлага. 2021.07.06 http://www.judcouncil.mn/site/news_full/11363

График 2. Шүүх хуралдаанд зайнаас буюу цахимаар оролцуулсан байдал (хуралдааны тоо), 2015-2021 он



Хүснэгт 5. Шүүх хуралдаанд алсын зайнаас онлайн хэлбэрээр оролцуулсан байдал

№	Холбогдсон чиглэл	Тоо						
		2015	2016	2017	2018	2019	2020	2021
1	Орон нутгийн шүүхийн шүүх хуралдаанд Улаанбаатар хотоос	36	74	191	621	746	1502	21,000
2	Орон нутгийн шүүхийн шүүх хуралдаанд бусад орон нутгаас	98	310	331	506	620	704	
3	Нийслэл дэх эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдаанд хорих 461-р ангиас	132	211	321	311	402	531	464
4	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаанд хорих 461-р ангиас	95	238	97	121	678	705	
5	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдаанд хорих 461-р ангиас	84	152	35	111	163	4761	
Нийт		445	985	975	1670	2609	8203	21464

Шүүх хуралдааныг цахимаар зохион байгуулахтай холбоотой өнөөгийн үр дүнд хүрэхийн тулд Шүүхийн ерөнхий зөвлөл 2015-2021 онд дараах ажлыг үе шаттай хийжээ.²⁰

2015 он:

Аймгийн төвөөс алслагдсан сум дундын 7 шүүхэд видео хурлын төхөөрөмж суурилуулснаар Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхээс бусад орон нутгийн шүүхүүд видео хурлын төхөөрөмжтэй болсон. Энэхүү төхөөрөмжийг ашиглан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс энэ онд нийт 28 удаагийн сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг онлайн хэлбэрээр явуулсан байна. Үүнээс гадна шүүхүүд хоорондоо

²⁰ Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан, 2015-2021 он. <https://judcouncil.mn/site/news/22>

холбогдож мэдээ, мэдээлэл солилцох, шүүх хуралдаанд алсын зайнаас нэхэмжлэгч, хариуцагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, шүүгдэгч, хохирогч, гэрч, шинжээчийг оролцуулах боломж бүрдсэн. Ингэснээр хэргийн болон шүүх хуралдааны оролцогчид Монгол Улсын нутаг дэвсгэрт хаана ч явсан шүүхийн тамгын газраар дамжуулан шүүх хуралдаанд онлайнгаар оролцох, гэрч асуух боломж бүрдэж, иргэд алсын зайг үл харгалзан, цаг хугацаа хэмнэн өөрийн эрхийг хамгаалах иргэний үндсэн эрхийг бүрэн хангаж чадсан гэж үзэж байна. 2015 онд улсын хэмжээнд нийт 445 удаа онлайнгаар шүүх хуралдаанд иргэдийг оролцуулсан байна.

Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 2015.07.08-ны өдрийн “Шүүх, хууль сахиулах байгууллагуудын мэдээллийн цахим нэгдсэн сүлжээ бүрдүүлэх тухай” 23 дугаар тогтоол, Монгол Улсын Хууль зүйн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Улсын ерөнхий прокурорын хамтран 2015.09.04-ний өдрийн “Шүүх, хууль сахиулах байгууллагуудын өгөгдөл солилцох дундын нэгдсэн сан бүрдүүлэх” тушаал батлагдсан.

2016 он:

Шүүхээр үйлчлүүлэгчид зайнаас шүүх хуралдаанд оролцох, шүүх хуралдааны үед баримт бичиг шинжлэн судлахад 760,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч Монгол Улсын нийт шүүхэд нийлүүлсэн нь хэргийн оролцогчид шүүх хуралдаанд зайнаас оролцох, шүүх хуралдаанд орчин үеийн техник тоног төхөөрөмж ашиглах, шүүхийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шүүхийн төсөв болон иргэдийн мөнгө, цаг хугацааг хэмнэх зэрэг сайн үр дүн гарч байна. 2015 онд шүүх хуралдаанд хэргийн оролцогчид 445 удаа зайнаас оролцож байсан бол 2016 онд энэ тоо 2 дахин өссөн байна. Онлайн шүүх хуралдаан өмнөх онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн нь нийт шүүх хуралдааны бараг 2 хувьд хүрээд байгаа нь Монгол улсын шүүхэд шинэ үзэгдэл болсон.

2017 он:

2012 оноос хойш Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим төслийн нэгжтэй хамтран ажиллаж 2017 онд шүүх, хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан мэдээллийн давхардлыг арилгах, гомдол мэдээлэл, гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хянан шалгах, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны менежментийг сайжруулан хялбаршуулах, цахим мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгоор шүүхийн эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн тогтолцоог амжилттай нэвтрүүлж, эрүүгийн хэргийн шүүхүүдийн тогтолцооны хэрэглэгчдэд онлайн болон утсаар заавар зөвлөгөө өгч ажилласан. Энэ тогтолцоонууд нэвтэрснээр цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд мэдээлэл солилцдог болж, нэгдсэн статистик болон төрөл бүрийн судалгаа гарах боломжтой болсон.

“Монгол Улсын шүүхийн мэдээлэл, санал асуулгын киоск тогтолцоо”-ийг боловсруулж анхан болон давж заалдах шатны шүүхүүд ашиглаж эхэлснээр шүүхээс иргэдэд мэдээлэл өгөхөөс гадна иргэд шүүхийн үйлчилгээнд үнэлгээ өгч, санал сэтгэгдлээ илэрхийлэх боломж бүрдсэн. Уг тогтолцоо нь шүүхийн үүдэнд

байрлах киоск төхөөрөмжөөр дамжуулан нэг загвараар Монгол Улсын шүүхүүдийн хаяг байршил, шүүх хуралдааны зар, шүүхийн танилцуулга, нэхэмжлэлийн загвар, шүүхийн ёс зүй, санал хүсэлт, улсын тэмдэгтийн хураамж, шүүхийн захиргааны ажилтны ёс зүй, санал асуулга зэрэг мэдээлэл өгнө.

Шүүхийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, шүүхийн архивын баримтыг мэдээллийн цахим санд оруулж, эрэлт хайлтыг боловсронгуй болгох, баримт мэдээллийг цахим хэлбэрээр хадгалж ашиглах “Шүүхийн цахим архив” тогтолцоог хөгжүүлсэн. Энэхүү тогтолцоог Дархан-Уул, Дорнод, Сэлэнгэ, Хэнтий аймаг, Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь шүүх, Шүүхийн төрөлжсөн архивд амжилттай нэвтрүүлсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах хэлтэстэй хамтран “Эрэн сурвалжлах, албадан ирүүлэх бүртгэл тайлангийн тогтолцоо”-ийг боловсруулсан. Цагдаагийн ерөнхий газраас нийт 8958 мэдээллийг Microsoft Office Excel програмаар хүлээн авч өөрийн тогтолцооны баазад хөрвүүлэн оруулж өдөр тутмын хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Тус тогтолцоо нь нийт шүүхийн хэмжээнд эрэн сурвалжлах албадан ирүүлэх бүртгэлийг тухайн шүүх бүртгэж Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрхээр нийтэд нь харах олон талт судалгаа, лавлагаа гаргах тогтолцоо юм. Мөн шүүхийн цагдаа өдөр тутмын тайланг бүртгэх, бүртгэсэн мэдээллийг Шүүхийн тамгын газрын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн эрхээр танилцах боломжтой юм.

2018 он:

2017 онд нэвтрүүлсэн “Монгол Улсын шүүхийн мэдээлэл” тогтолцоог илүү өргөн хүрээнд ашиглахаар 2018 оны 10 дугаар сараас Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй ажиллуулж эхлэв. Шүүхээр үйлчлүүлэх иргэд шүүхийн байранд очихгүйгээр мэдээлэл авч, санал хүсэлтээ Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүхийн тамгын газруудад илгээх боломжтой болсон.

Шүүхийн мэдээллийн технологийн хэлтэс батлагдсан даалгаврын дагуу шинээр шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тогтолцоо боловсруулж, нийслэл дэх шүүхүүдийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулан нийслэл дэх анхан шатны шүүхүүдэд нэвтрүүлж, 2019 оны 1 сарын 2-ноос нийт шүүхэд ашиглаж эхэлсэн. Ингэснээр шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт, шүүх хуралдаанд оролцсон байдал гэх мэт бүх статистикийн мэдээлэл тухайн шүүхийн хэмжээнд болон улсын хэмжээнд харагддаг болсон.

Иргэн, захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн тогтолцоог шат дараатайгаар нэвтрүүлсэн нь хэргийн хөдөлгөөний бүхий л мэдээ, судалгаа, статистик гаргах боломж бүрдэв. Нэг дор цугларсан энэ мэдээллийг “Хэргийн хөдөлгөөний удирдлагын төв”-өөс цогц байдлаар шүүх болон иргэдэд нээлттэй, шуурхай мэдээлэх, шүүх, шүүгчийн ачаалал тооцох, статистик тайлан гаргах боломжтой болсон.

2019 он:

Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яам хамтран шүүхийн

“Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн тогтолцоо”-ийг 2017 онд нэвтрүүлсэн. 2019 онд уг тогтолцоог Шүүхийн ерөнхий зөвлөл улсын хэмжээнд эрүүгийн хэргийн хөдөлгөөнийг хянах бүрэн боломжтой болгож, тайлан статистик үнэн зөв гаргах нөхцөлийг бүрдүүлсэн.

“ХУР” төрийн мэдээлэл солилцооны системээс шүүхэд шаардлагатай лавлагаа, тодорхойлолт татах “Шүүхийн цахим лавлагааны тогтолцоо” ашиглалтад оруулсан. Энэхүү тогтолцоогоор 18 төрлийн мэдээлэл татах бөгөөд иргэн, захиргааны хэргийн шүүхүүд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэвтрүүлснээр бусад төрийн байгууллагаас лавлагаа, тодорхойлолт авдаг цаг хугацааг хэмнэх боломжтой болсон.

Шүүхийн ерөнхий зөвлөл “Гэрэгэ системс” ХХК-тай хамтран улсын тэмдэгтийн хураамжийг киоск машинаар төлөх үйлчилгээг 2019 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн шинээр нэвтрүүлсэн. Их ачаалалтай буюу Нийслэлийн төвийн 6 дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх болон Шүүхийн төрөлжсөн архивд цахим төлбөрийн тогтолцоог эхний ээлжид нэвтрүүлсэн. Иргэн, хуулийн этгээд Иргэний болон Захиргааны хэргийн шүүхээр эрх зүйн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр улсын тэмдэгтийн хураамж төлөхийн тулд харьяа дүүргийн татварын байгууллага руу очиж “Татварын нэхэмжлэх” гаргуулан авч, энэ “Татварын нэхэмжлэх”-н дагуу банканд дугаарлан гүйлгээ хийн баримтыг шүүхэд өгдөг байсан. Энэ нь цаг алдах, хүнд суртал үүсгэх зэрэг шүүмжлэл дагуулдаг байсан. Харин энэхүү тогтолцоог нэвтрүүлснээр шүүхийн байран дахь болон бусад цэгт байрлуулсан киоск машинаар улсын тэмдэгтийн хураамжийг хэдхэн секундийн хугацаанд төлж шууд шүүхэд хандах боломжтой болсон.

2020 он:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн байранд байрладаг онлайн хуралдааны төхөөрөмжийг шүүх хуралдааны дэг сахиулахтай холбоотой асуудлаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газарт шилжүүлсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020.11.24-ний өдрийн 116 дугаар тогтоолоор Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн хөдөлгөөний аргачлалд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Уг нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд бүх шатны шүүх цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой болон бусад шүүх хуралдааныг “Zoom”, “Skype” болон бусад программ хангамж ашиглан цахимаар буюу зайнаас явуулсан. Тодруулбал гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед анхан болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэхдээ шүүх хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шүүх хуралдааны бэлтгэл хангах, шүүх хуралдаанд оролцогчийг дуу-дүрсний төхөөрөмж ашиглан цахимаар оролцуулах, шүүхийн шийдвэрийг гардуулах буюу хүргүүлэх, давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдлыг холбогдох шүүхэд хүргүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан. Уг түр аргачлалд заасны дагуу зарим шүүх хуралдаанд хэргийн оролцогчдыг шүүхийн байранд ирүүлэхгүйгээр цахимаар буюу зайнаас оролцуулсан.

Эрүүгийн хэргийн хөдөлгөөний түр аргачлалын 5.3.2 дахь хэсэгт “Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд улсын яллагч, шүүгдэгч, өмгөөлөгчийг биечлэн оролцуулах бөгөөд бусад оролцогч биечлэн оролцох хүсэлт гаргасан тохиолдолд тусгайлан тоногдсон өрөөнөөс дуу-дүрсний төхөөрөмж ашиглан цахимаар оролцуулна.” гэж заасны дагуу зарим шүүхэд онлайн хурлын өрөө бэлтгэж хоёр өөр танхимаас шүүх хуралдааны явуулсан. Танхим хүрэлцэхгүй тохиолдолд гэрч, хохирогчийг хамгаалах өрөөнд зарим оролцогч нарыг цахимаар оролцуулан шүүх хуралдааныг хэвийн тасралтгүй явуулах нөхцөл боломжоор хангаж ажилласан.

Иргэний хэргийн хөдөлгөөний түр аргачлалын 4.2.2 дахь хэсэгт “Энэ аргачлалын 4.2.1-д заасны дагуу шүүх хуралдаанд дуу-дүрсний төхөөрөмж ашиглан цахимаар оролцох хэргийн оролцогчдод товыг долоо хоногоос доошгүй хоногийн өмнө мэдэгдэж, шүүх хуралдаанд бэлтгэх ажлыг шүүхийн Тамгын газар зохион байгуулна” гэж заасны дагуу хуулийн хугацаанд хэргийн оролцогч нарт шүүх хуралдааны товыг мэдэгдсэн.

Шүүхийн үйл ажиллагаанд “Шүүх хуралдааны явцыг мэдээлэх цахим тогтолцоо”, “Шүүхийн цахим лавлагааны тогтолцоо”, “Хэргийн хөдөлгөөний удирдлагын төв” цахим тогтолцоо, дуу авиаг бичвэрт хувиргах “Чимэгэ” тогтолцоог туршилтын журмаар тус тус нэвтрүүлж, Шүүхийн шийдвэрийн цахим сан www.shuukh.mn-г шинэчилсэн.

2021 он:

Нийслэл дэх шүүхүүдийн хувьд 2021 оны эхний хагас жилийн байдлаар нийт 27543 шүүх хуралдаан товлосноос Ковид-19 цар тахлаас шалтгаалан 6840 шүүх хуралдаан буюу 24.8 хувь нь хойшилсон. Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал, хэргийн оролцогч ковидын халдвар авсан, шүүхийн байр тусгаарлалтад орсон гэх мэт цар тахалтай холбоотойгоор шүүх хуралдаан удаа дараа хойшилж шүүн таслах ажиллагаа хэвийн, тасралтгүй явуулахад бэрхшээл учирснаар хэрэг хуулийн хугацаанд шийдэгдэхгүй асуудал гарсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа цагдан хорих хаалттай ангид цагдан хоригдсон этгээдийг шүүх хуралд цахимаар оролцуулах боломжтой шүүх танхимыг нээснээс хойш 8 дахь жилдээ ямар нэгэн зөрчилгүй техникийн гэмтэл сааталгүй 2696 хурлыг зохион байгуулснаас 2021 онд нийт 464 хурлыг зохион байгуулан ажилласан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс www.shuukh.mn цахим сайтыг боловсронгуй болгож, шүүх хуралдааны явцыг мэдээлэх www.live.shuukh.mn цахим сайтыг ашиглалтад оруулсан боловч шүүхийн ажлын ачааллаас шалтгаалж мэдээлэл нь тогтмол шинэчлэгдэхгүй байна. Цаашид нийт шүүхийн тамгын газраас www.live.shuukh.mn сайтад мэдээллээ шуурхай шинэчлэн оруулж хэвших нь шүүхийн ил тод, нээлттэй байдлыг хангахад чухал ач холбогдолтойг анхаарч ажиллах нь зүйтэй талаар мэдэгдсэн.

Шүүхийн хэвлэл мэдээллийн хэлтсээс шүүхэд хянан шийдвэрлэж буй олны анхаарал татсан хэргийн шийдвэрийг цаг алдалгүй хүргэх, иргэдийн санал

сэтгэгдлийг шуурхай хүлээн авч, эргэх холбоо тогтоох зорилгоор “Шүүхийн мэдээ”, “Шүүхийн ерөнхий зөвлөл” фэйсбүүк хуудас болон твиттер хуудсыг хөтөлж, олны анхаарал татсан хэргийн тов, шийдвэрийг шуурхай мэдээлж байна. 2021 онд олны анхаарал татсан хэргийн шийдвэрлэлтийн талаар болон шүүхийн мэдэгдэл зэрэг 258 мэдээллийг “Шүүхийн мэдээ” фэйсбүүк хуудсаар мэдээлсэн.

Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 2021.12.06-ны өдрийн байдлаар ШШГЕГ-ын харъяа Цагдан хорих 461, хорих 409 дүгээр ангид хоригдож буй яллагдагч, шүүгдэгчийн шүүх хуралдаанд цахимаар оролцох хүсэлтийг хангаж нийт 351 хэргийн 704 оролцогчийг шүүх хуралдаанд оролцуулах бэлтгэл ажлыг ханган ажилласан.

2021 онд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх коронавируст халдварын цар тахлын хүнд үед шүүхийн үйлчилгээг хэвийн үргэлжлүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулахаас гадна товлогдсон шүүх хуралдааны 90 хувийг цахим (зүүм программ)-аар зохион байгуулсан нь иргэд, хэргийн оролцогчдын хөрөнгө мөнгө, цаг хугацааг хэмнэсэн чухал ажил болсон.

Цар тахлын үед журмын дагуу хэргийн оролцогч нарт хэргийн материалыг цахимаар танилцуулж ажилласан боловч олон хавтас, ээдрээ төвөгтэй маргааны хувьд хэргийн материалыг цахимаар танилцуулахад хүндрэлтэй байсан тул шүүхийн үйлчилгээний төвийг мөн зориулалтын тусгаарлагч ханаар тохижуулж өгснөөр иргэд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан олон хавтас баримттай шүүхийн байранд ирж танилцах боломжийг бүрдүүлж, цар тахлын үед шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэж ажиллахыг зорьсон.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.03.31-ний өдрийн хуралдаанаар “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам”-ыг баталсан. Тус зөвлөлийн мэдээлснээр, энэхүү журам батлагдахаас өмнө дагнасан эрхзүйн зохицуулалт байгаагүй хэдий ч техник, технологийн дэвшил ашиглан Монгол Улсын шүүхүүдэд шүүх хуралдаанд хэргийн оролцогчдыг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг 2015 оноос үе шаттай зохион байгуулж эхлээд 2021 оны 09 сар хүртэл нийт 35904 шүүх хуралдааныг цахимаар амжилттай зохион байгуулсан туршлага байна. Үүний 21 мянган хэргийн шүүх хуралдааныг нь ковид-19-ийн тархалт идэвхтэй үе буюу 2020 оны 12 дугаар сараас 2021 оны 09 дүгээр сар хүртэлх 10 сарын хугацаанд хийжээ. Энэ нь дээрх хугацаанд улсын хэмжээнд нийт товлон зарласан 72327 хэргийн 29 хувийг нь эзэлж байна. Дуу-дүрсний төхөөрөмж ашиглан цахимаар явуулж шийдвэрлэсэн тус шүүх хуралдаануудад нийт 39657 хүн гэрээсээ/зайнаас/ буюу цахимаар оролцжээ.


Эдгээр шүүхүүдийн хэргийн шийдвэрлэлтээс үзэхэд шүүх хуралдааны оролцогчийг цахимаар оролцуулах тоо жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай болсон байна. Гэтэл энэ харилцааг нарийвчлан зохицуулсан дүрэм, журам байхгүйгээс цахимаар зарласан шүүх хуралдаан хойшлох, шүүх хуралдааны дэг зөрчигдөх, хэргийн оролцогчийн эрх хөндөгдөх зэрэг сөрөг үр дагаврууд гарах, хуралдаан үр дүнгүй болох эрсдэл үүсч эхлээд байв.

III. ЦАХИМ ШҮҮХ ХУРАЛДААНЫ ҮР ДҮН, СОРИЛТ

3.1. МОНГОЛ УЛС ДАХЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Эдийн засгийн эрх чөлөөний индексийн олон улсын тайланд дурдсанаар Монгол Улсын шүүхийн үр ашигтай байдал сүүлийн 5 жилд анх удаа дэлхийн дундаж руу ойртсон.²¹ Үүний шалтгааныг тус тайланд “Хэдийгээр шүүх хараат бус боловч авлига, гуравдагч этгээдийн улс төрийн нөлөөнд шүүх өртөмтгий байна” гэжээ.

График 3. Монгол Улсын шүүхийн үр ашигтай байдал, 2017-2022




Энэ нь “Дэлхийн шударга ёсны төсөл”-өөс гаргасан “Эрх зүйт ёсны индекс”-ийн 2017-2021 оны тайланд дурдсан Монгол Улсын иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн шүүх дэх төрийн бусад институтын зохисгүй нөлөөний үзүүлэлтээс тодорхой харагдаж байна. Эндээс харахад, эрүүгийн хэргийн шүүх дэх гаднын нөлөөлөл нь иргэний хэргийн шүүх дэх нөлөөллөөс илүү байгаа төдийгүй Монгол Улсын шүүхийн үйл ажиллагаанд төрийн бусад институтын хөндлөнгийн нөлөөлөл их буйг илтгэж байна.²²

21 The Heritage Foundation. “2022 Index of Economic Freedom” Judicial Effectiveness: Mongolia <https://www.heritage.org/index/visualize?cnts=mongolia&type=11>


22 WJP Rule of Law Index 2021. World Justice Project, 2021. p123. <https://worldjusticeproject.org/our-work/research-and-data/wjp-rule-law-index-2021>

График 4. Монгол Улсын иргэний болон эрүүгийн хэргийн шүүх дэх төрийн бусад институтийн зохисгүй нөлөөллийн үзүүлэлт, 2017-2021



Энэ үзүүлэлт шүүхэд итгэх иргэдийн итгэл хэр байгааг тодруулах шаардлагатай болохыг харуулж байна. Учир нь НҮБ-аас сайшаан дэмжсэн шүүгчийн ёс зүйн олон улсын стандарт болох “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчим”-ын тайлбарт шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх нь шүүх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн хүчин зүйл болохыг тэмдэглэсэн.²³ Монгол Улсын хувьд шүүхэд итгэх иргэдийн итгэл хэдэн хувьтай байгааг дотоод, гадаадын хэд хэдэн судалгааны ажилд дүгнэсэн байдаг.²⁴

График 5. Монгол Улсад шүүхээр үйлчлүүлээгүй иргэдийн шүүхэд итгэх итгэл, 2007-2020 он




Эндээс харахад, Монгол Улсын шүүхийн үйл ажиллагаа үр өгөөжгүй байх, шүүхийн хараат бус байдал хангалтгүй байх нь түүнд итгэх иргэдийн итгэлд шууд нөлөөлж байна. Шүүхийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх нэг арга зам нь цахим шүүх хуралдаан гэж үзэж Шүүхийн тухай хуулийг шинэчлэн найруулахдаа энэ талаар зохицуулсан байна. Цахим шүүх хуралдаанд холбогдох эрх зүйн асуудлыг дараах дэд хэсэгт дэлгэрүүлэн авч үзэв.

23 “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчим, түүний тайлбар”. Орчуулсан Л.Галбаатар, редактор Н.Эрдэнэцогт. Улаанбаатар. 2018. ISBN 978-99978-3-936-7. Азийн сан. 88 дахь тал

24 Шүүхийн ерөнхий зөвлөл. Эмхтгэсэн Т.Мэндсайхан. Шүүхийн захиргааны хөгжил, 2018, 193, 222, 228, 229, 231 дахь тал.

3.1.1. Эрх зүйн зохицуулалт

Цахим шүүх хуралдааныг дэмжсэн эрх зүйн зохицуулалт бол Улсын Их Хурлаас 2020.04.29-ний өдөр баталсан Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль юм. Тус хуулийн 9.11-т зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулж болох бөгөөд эрх бүхий байгууллагууд холбогдох журмыг баталж, хэрэгжилтийг зохион байгуулна. Үүний дагуу дагалдах журам, хэм хэмжээ батлагдан хэрэгжсэн байна. Гэхдээ Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг зөвхөн танхимын хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд цахим хуралдаан хийгээгүй байна.²⁵ Мөн Улсын Их Хурлаас 2021.01.15-ны өдөр баталж, 2021.03.01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилсэн Монгол Улсын шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуульд цахим шүүх хуралдааныг тусгайлан дэмжсэн зохицуулалтыг тусгажээ. Тодруулбал, тус хуулийн 71.1.14-т зааснаар шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журмыг хуульд заасны дагуу батлах үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл хүлээсэн.



Зураг 1. Цар тахлын нөхцөл байдалд шүүх хуралдааныг явуулсан байдал

²⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааны мэдээ <http://conscourt.gov.mn/>

Үндсэн хуулийн цэцийн даргын 2020.11.19-ний өдрийн 33 дугаар тушаалын хавсралт “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хангах түр журам”, 2021.09.06-ны өдрийн 23 дугаар тушаалын хавсралт “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Үндсэн хуулийн цэцийн дунд, их суудлын хуралдаанд маргагч талуудыг оролцуулах түр журам” http://conscourt.gov.mn/?page_id=741

Хүснэгт 6. Цахим шүүх хуралдааныг дэмжсэн эрх зүйн зохицуулалтын тойм

Огноо	Эрх зүйн акт	Зохицуулалт
2019.06.05	Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам /Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоол/	Энэ журмын зорилго нь төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, мэдээллийн сан, мэдээлэл солилцох тогтолцооны аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах, төрийн үйлчилгээг иргэн, байгууллагад цахим хэлбэрээр хүргэхэд оршино. Улсын бүртгэлийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэхэд энэ журмыг баримтална.
2020.04.29	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9.11	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулж болох бөгөөд холбогдох журмыг эрх бүхий байгууллага баталж, хэрэгжилтийг зохион байгуулна
2020.05.21	Шүүхийн тамгын газар Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээс цахим хэлбэрээр лавлагаа, мэдээллийг авах журам /Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020 оны 61 дүгээр тушаал/	2020.06.03-ны өдрөөс эхлэн иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зорилгоор бүх шатны шүүхийн тамгын газраас төрийн мэдээлэл, солилцооны “ХУР” системд хандан лавлагаа, мэдээллийг цахим хэлбэрээр хүлээн авах “Шүүхийн цахим лавлагааны тогтолцоо”-ийг шүүхийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллаж байна.
2020.11.24	Гамшгаас хамгаалах, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед баримтлах Эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний түр аргачлал /Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 116 дугаар тогтоол/	Шүүхийн хэлэлцүүлэг болон шүүх хуралдаанд шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдааны нарийн бичгийн даргаас бусад оролцогчийг дуу-дүрсний төхөөрөмж ашиглан өөр газраас цахимаар оролцуулж болно. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд улсын яллагч, шүүгдэгч, өмгөөлөгчийг биечлэн оролцуулах бөгөөд бусад оролцогч биечлэн оролцох хүсэлт гаргасан тохиолдолд тусгайлан тоногдсон өрөөнөөс дуу-дүрсний төхөөрөмж ашиглан цахимаар оролцуулна. Төрийн болон албаны нууцын зэрэглэлтэй, эсхүл хаалттай хэлэлцэх шүүх хуралдаанд хэргийн оролцогчийг дуу-дүрсний төхөөрөмж ашиглан цахимаар оролцуулахгүй.
2021.01.15	Монгол Улсын шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 71.1.14	Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн бие даасан байдлыг хангах хүрээнд шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журмыг батлана.

2022.03.31	Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам /Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 82 дугаар тогтоол/	Энэ журам хаалттай явагдах шүүх хуралдаанд хамаарахгүй. Шүүх хуралдаанд оролцогч нь шүүх хуралдааны товыг мэдсэний дараа шүүх хуралдаанд цахимаар оролцох бол энэ тухай шүүгчийн туслахад бичгээр, эсхүл утсаар, шүүхийн Тамгын газрын албан ёсны цахим шуудангийн хаягаар мэдэгдэнэ. Шүүгчийн туслах шүүх хуралдааныг цахимаар зохион байгуулах нөхцөл, боломжийг судалж, тухайн хэргийг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнд өдөрт нь багтаан танилцуулна. Шүүх хуралдаанд оролцогчийг цахимаар оролцуулах эсэх талаарх шүүгч, шүүх бүрэлдэхүүний хариуг шүүгчийн туслах шүүх хуралдаан эхлэхээс 3 хоногийн өмнө мэдэгдэнэ. Цахимаар оролцогч нь шүүхийн байрнаас оролцох тохиолдолд тухайн шүүхийн Тамгын газар зохион байгуулна. Бусад тохиолдолд цахимаар оролцогч нь сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, харагдах орчин зэрэг нөхцөлийг хангасан байна.
2022.05.11	“Үндсэн тогтолцооны үйл ажиллагааг зохицуулах, тогтолцоо ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам” /Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоол/	Энэ журмын зорилго нь суурь болон төрөлжсөн мэдээллийн сангаас үндсэн болон дэмжих тогтолцоонд мэдээлэл нийлүүлэх, үндсэн болон дэмжих тогтолцоогоор дамжуулан төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд үйлчилгээ авах, хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх замаар мэдээлэл солилцохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино. Үндсэн тогтолцоо нь “Үндэсний дата төв” УТҮГ-т байрших тархмал бүтэц бүхий төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” систем байна.

Үүний дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.03.31-ний өдрийн 82 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам” үйлчилж байна. Энэ журмын дагуу шүүх хуралдааныг цахимаар хийх нь хэргийн оролцогчийн хүсэл зоригоос хамаарах бөгөөд тийнхүү цахим шүүх хуралдаан хийх эсэхийг шүүх бүрэлдэхүүн эцэслэн баталгаажуулна. Харин хаалттай явагдах шүүх хуралдаанд тус журам хамаарахгүй.

Хүснэгт 7. Цахим шүүх хуралдаан хийж болохгүй тохиолдол

№	Шүүх хуралдаан хаалттай явагдах нөхцөл	Холбогдох зохицуулалт
1	Төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг хамгаалах шаардлагатай хуралдаан	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай / шинэчилсэн найруулга / хуулийн 3.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг
2	Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан	
3	Арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл түүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх	
4	Хамгаалалтад байгаа гэрчийн мэдүүлгийг уншиж сонсох, эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад олж авсан нотлох баримтыг шинжлэн судлах	

5	Хэргийн нотлох баримт, эсхүл үйл явдал төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд хамаарах бол хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн буюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулж болно.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн 8.2 дахь хэсэг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 9.2 дахь хэсэг
6	Арбитрын ажиллагааны аль нэг тал энэ бүлэгт заасан өргөдөл, хүсэлтийг хянан хэлэлцэх шүүхийн ажиллагааг хаалттай явуулах тухай хүсэлт гаргасныг Монгол Улсын нийтлэг ашиг сонирхолд харшлахгүй гэж шүүх үзсэн бол уг ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаалттай явуулахаар шийдвэрлэж болно.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн 160 ^о .1 дэх хэсэг

Дээрх зохицуулалтын хүрээнд танхимын болон цахим шүүх хуралдааны зохион байгуулалт ялгаатай эсэх талаар дараах хүснэгтэд харьцуулан авч үзэв.

Хүснэгт 8. Танхимын болон цахим шүүх хуралдааны зохион байгуулалт /иргэний хэргийн шүүх хуралдааны жишээн дээр/

Үндсэн нөхцөл	Танхим	Цахим
1/ Шүүх хуралдааны нийтлэг зохицуулалт		
Зохигч, түүнчлэн шүүх хуралдаанд ирвэл зохих бусад оролцогчдод шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг шүүхийн мэдэгдэх хуудсаар тэдгээрийн оршин суугаа буюу ажлын газрын хаягаар мэдэгдэнэ /77.1/	Тийм	Тийм. Шүүх хуралдаанд оролцогч нь шүүх хуралдаанд цахимаар оролцох бол энэ тухай шүүгчийн туслахад бичгээр, эсхүл утсаар, шүүхийн Тамгын газрын албан ёсны цахим шуудангийн хаягаар мэдэгдэнэ. Шүүгчийн туслах шүүх хуралдааныг цахимаар зохион байгуулах нөхцөл, боломжийг судалж, тухайн хэргийг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнд өдөрт нь багтаан танилцуулна. Шүүх хуралдаанд оролцогчийг цахимаар оролцуулах эсэх талаарх шүүгч, шүүх бүрэлдэхүүний хариуг шүүгчийн туслах шүүх хуралдаан эхлэхээс 3 хоногийн өмнө мэдэгдэнэ.
Шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн шүүхийг хүндэтгэх, хуралдааны танхимд тогтоосон журмыг сахих, хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах үүрэгтэй /90.1/	Тийм	Тийм
Шүүх хуралдаанд оролцогч мэдүүлэг, тайлбар өгөх, дүгнэлт гаргахдаа суудлаасаа босно /90.2/	Тийм	Тийм
Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгч хуралдааны танхимд орж ирэх, шүүхийн шийдвэрийг уншиж сонсох үед танхимд байгаа бүх хүн суудлаасаа босно /90.3/	Тийм	/Энэ талаар журамд тусгайлан заагаагүй. Гэхдээ шүүх хуралдаанд цахимаар оролцогч шүүх хуралдааны дэгийг сахих үүрэгтэй/

Шүүх хуралдааны журам зөрчсөн этгээдэд эхний удаа шүүх хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Дахин зөрчил гаргасан этгээдийг шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдааны танхимаас гаргаж энэ тухай шүүх хуралдааны тэмдэглэлд тусгуулж, хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ /90.4/	Тийм	Тийм
Бүх шатны шүүх шийдвэрээ зөвлөлдөх тасалгаанд гаргана /94.1/	Тийм	Тийм
Шүүх хуралдааны тэмдэглэлийг дэлгэрэнгүй бичнэ /96.1/	Тийм	Тийм
<i>2/ Анхан шатны шүүх хуралдааны дэг /115-119 дүгээр зүйл/</i>		
Шүүх хуралдааныг нээх	Тийм	Тийм
Шүүх хуралдааны ирц ба түүнд оролцох эрхийг шалгах	Тийм	Тийм
Зохигч, оролцогч шүүх хуралдаанд ирээгүй бол түүний эзгүйд хэргийг шийдвэрлэх	Тийм	Тийм
Орчуулагч, хэлмэрчийн үүргийг тайлбарлах	Тийм	Тийм
Гэрчийг гаргах	Тийм	Тийм. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга цахимаар оролцож байгаа гэрч, насанд хүрээгүй этгээдийг мэдүүлэг өгөхөд шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр шүүх хуралдаанд буюу тогтолцоонд оруулж, бусад үед шүүх хуралдаанаас буюу тогтолцооноос гаргана.
Шүүх бүрэлдэхүүнийг зарлах ба татгалзан гаргах эрхийг тайлбарлах	Тийм	Тийм
Хэргийн оролцогчийн эрх, үүргийг тайлбарлах	Тийм	Тийм
Хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх	Тийм	Тийм
Хэрэг хэлэлцэж эхлэх	Тийм	Тийм
Зохигч, оролцогч мэтгэлцэх	Тийм	Тийм
Нотлох баримтыг шинжлэх, асуулт тавих	Тийм	Тийм
Гэрчийн мэдүүлэг сонсох	Тийм	Тийм
Бичмэл, цахим болон эд мөрийн баримтыг шинжлэх	Тийм	Тийм
Шинжээчийн дүгнэлт сонсгох	Тийм	Тийм
Хэргийн оролцогчоос нэмж тодруулах	Тийм	Тийм
Иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргах	Тийм	Тийм
Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орох	Тийм	Тийм
Монгол Улсын нэрийн өмнөөс шийдвэр гаргах	Тийм	Тийм
Шийдвэрийг танилцуулах, гардуулах	Тийм	Тийм

Эндээс харахад, шүүх хуралдаанд оролцогч нь шүүх хуралдааны товыг мэдсэний дараа шүүх хуралдаанд цахимаар оролцох бол энэ тухай шүүгчийн туслахад мэдэгдэх, тийнхүү цахим хуралдаан хийхийг шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдэхээс бусад тохиолдолд танхимын болон цахим шүүх хуралдааны зохион байгуулалт, дэгтэй холбоотой ялгаа гарахгүй байна.

3.1.2. Цахим шүүх хуралдаанд оролцогчидтой хийсэн ярилцлага

Дээрх зохицуулалтын дагуу хаалттай хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулах нь тохиромжтой эсэх талаар болон цахим шүүх хуралдааны эерэг, сул талын талаар холбогдох оролцогчидтой ярилцлага хийв. Шүүх хуралдааны үндсэн оролцогч болох шүүгч, прокурор, өмгөөлөгч болон хуульч, хэргийн оролцогч бүхий нийт 20 хүнтэй цахимаар ярилцсан бөгөөд тэдний 50% нь захиргааны хэргийн шүүх хуралдаанд, 37.5% нь эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд, 12.5% нь иргэний хэргийн шүүх хуралдаанд тус тус цахимаар оролцсон байна.

График 6. Ярилцлагын оролцогчид





График 7. Оролцсон цахим шүүх хуралдаан



Хүснэгт 9. Цахим шүүх хуралдаанд оролцогчид түүний давуу тал, хүндрэл, бэрхшээлийг дүгнэсэн байдал

Цахим шүүх хуралдааны давуу тал	Цахим шүүх хуралдааны хүндрэл, бэрхшээл
<ol style="list-style-type: none"> 1. Цаг хугацаа хэмнэх 2. Орон зайн хамааралгүй 3. Оролцоог хангах 4. Зардал хэмнэх 5. Эрүүл мэнд, аюулгүй байдалд тустай 6. Хурдан, шуурхай 	<ol style="list-style-type: none"> 1. Техник, тоног төхөөрөмжийн ажиллагааны доголдол 2. Хэргийн материалыг цахимаар шилжүүлэх, танилцах боломж хязгаарлагдмал 3. Хэргийн оролцогчийн хувийн зохион байгуулалт хангалтгүй
<p>Цахим шүүх хуралдаанд оролцогчдын зүгээс ярилцлагад хэлсэн үгсээс:</p> <ul style="list-style-type: none"> • Замын түгжрэнд удахгүй. Ялангуяа хойшлох хуралдаанд шүүх дээр очих гэж хугацаа алддаг. • Хол байгаа оролцогчийг оруулах боломжтой, цаг, мөнгө хэмнэх, чирэгдэлгүй, шуурхай үйлчилгээ, шүүх хурал хойшлохгүй, танхимын багтаамж муу үед зайнаас хийх нь зүгээр, цар тахал, амьсгалын замын өвчнөөс сэргийлнэ, аюулгүй байдал эрсдэлгүй /хэргийн оролцогчийн довтолгоо/ • Цаг хэмнэх, орон зайн хамааралгүй, санхүүгийн хэмнэлттэй • Хурдан шуурхай Хөл хорио тогтоосон онцгой нөхцөлд цахимаар оролцох 	<p>Цахим шүүх хуралдаанд оролцогчдын зүгээс ярилцлагад хэлсэн үгсээс:</p> <ul style="list-style-type: none"> • Техникийн нөхцөл байдлаас шалтгаалан дуу нь сонсогдохгүй байх асуудал гарсан. Тоног төхөөрөмжийн найдвартай, аюулгүй байдлыг сайтар хангах. • Шүүх хуралдааны танхимын тоног төхөөрөмжийг сайжруулах, хэргийн оролцогчид тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах • Нэг удаа сүлжээ тасарч байсан удаа бий • Техник, программыг сайжруулах • Техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал чухал Хэргийн материалыг цахимд шилжүүлж танилцах боломжоор хангах

Хүснэгт 10. Цахим шүүх хуралдаанд оролцогчид түүнийг зохион байгуулах асуудлаар илэрхийлсэн санал

Цахим шүүх хуралдаан хийх эсэхийг тодорхойлохтой холбоотой санал	Эрх зүйн зохицуулалттай холбоотой санал	Зохион байгуулалттай холбоотой санал
<p>Хөнгөн хэргүүдэд ашиглах</p> <p>Хөл хорио тогтоосон онцгой нөхцөлд цахимаар оролцох, бусад үед танхимаар оролцох</p> <p>Хаалттай шүүх хуралдаанд зайнаас орох оролцогчийн нөхцөл, шаардлагыг тодорхой болгож журамлах</p> <p>Оролцогчдод илүү боломж олгох</p>	<p>Оролцогчийн эрхийг хангаж цахимаар оролцож буй этгээдийн үүргийг чандлан биелүүлэх механизмыг хууль, журамд тодорхой оруулах</p> <p>Шүүгчид нөлөөлөх эрсдэлийг багасгах, процессын хуулиудад цахимаар хуралдаанд орохыг нарийвчлан журамлах</p> <p>Цахимаар нотлох баримт шинжлэн судлах асуудлыг тодорхой болгох</p>	<p>Шүүхийн захиргааны байгууллагууд техник хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг сайжруулах, сүлжээний найдвартай ажиллагааг хангах</p> <p>Цахим хурлын өрөө тоноглох, камер тод байх</p> <p>Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчдод зориулсан цахим танхимыг бүсчилж байгуулах</p> <p>Оролцогчдыг цахимаар оролцох нь илүү үр дүнтэй гэдгийг ойлгуулах, дадлага туршлагатай болгох</p> <p>Хэргийн оролцогчид цахимаар оролцохдоо шаардлага хангаагүй технологиор холбогддог асуудлыг шийдвэрлэх</p>

Эндээс харахад, цахим шүүх хуралдаан нь шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахад зайлшгүй шаардлагатай нэг механизм болохыг түүнд оролцсон шүүгч, прокурор, өмгөөлөгч, хуульч, хэргийн оролцогчид нэгэнт зөвшөөрч байна. Харин цахим шүүх хуралдааныг боловсронгуй болгох талаарх тэдний дараах санал нь шүүхийн захиргааны байгууллага болон шүүхийн үйл ажиллагааны зохион байгуулалттай холбоотой байна.

- Цахим хуралдаанд оролцох асуудлыг холбогдох хууль тогтоомжид нарийвчлан тусгах
- Цахимаар нотлох баримт шинжлэн судлах асуудлыг тодорхой болгох
- Шүүхийн захиргааны байгууллагууд техник хэрэгслийнхээ бүрэн бүтэн байдлыг сайжруулах, сүлжээний найдвартай ажиллагааг хангах.

Эдгээр асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хуульд заасан чиг үүргийн хүрээнд хариуцан судалж, шийдвэрлүүлэх боломжтой байна. Харин “Оролцогчдыг цахимаар оролцох дадлага туршлагатай болгох”, “Хэргийн оролцогчид цахимаар оролцохдоо шаардлага хангаагүй технологиор холбогддог асуудлыг шийдвэрлэх”-ийн тулд цахим шүүх хуралдаанд оролцогч ямар ур чадвар эзэмшсэн байх, тэдний одоогийн ур чадвар ямар байгааг тодорхойлох шаардлага үүсч байна.

IRIM судалгааны хүрээлэн НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Хурдасгуур Лабораторийн захиалгаар 2021.05.26-2021.08.10-ны хооронд хийж гүйцэтгэсэн “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгаа”-нд цахим ур чадварыг Европын Холбооны ДижКомп олон улсын стандартад тулгуурлан дараах 5 үзүүлэлтээр үнэлсэн байна.²⁶ Үүнд:

- Мэдээлэл хайх, олж авах ур чадвар;
- Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар;
- Цахим контент бүтээх ур чадвар;
- Аюулгүй байдлаа хангах ур чадвар;
- Асуудлыг шийдвэрлэх ур чадвар.

Үүнээс бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар болон асуудлыг шийдвэрлэх ур чадвар нь цахим шүүх хуралдаанд нэн тэргүүнд шаардлагатай байна.

26 НҮБХХ, Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM). “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгааны тайлан”. 2021.09
Independent Research Institute of Mongolia (IRIM). “Qualitative Assessment of Digital Access and Skills of Vulnerable Groups”. May– August, 2021 <https://www.undp.org/mongolia/publications/qualitative-assessment-digital-access-and-skills-vulnerable-groups>

Хүснэгт 11. Цахим шүүх хуралдаанд шаардлагатай цахим ур чадвар

Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадвар	Асуудлыг шийдвэрлэх ур чадвар
<ul style="list-style-type: none"> Цахим платформ, технологийн тусламжтайгаар хүмүүстэй харилцах Хамтран ажиллах Мэдлэг, мэдээлэл хуваалцах Цахим орчинд ёс зүй баримтлах Өөрийн гэсэн цахим профайл мэдээлэл бүхий дүр төрхтэй болох 	<ul style="list-style-type: none"> Өөрт тулгарсан техникийн асуудлыг шийдвэрлэх Хэрэгцээндээ тохирсон технологийн шийдлийг олох Цахим ур чадварын хэрэгцээ буюу цаашид энэ чиглэлээр сурах зүйлээ мэддэг байх

Монгол Улс хүн төвтэй хөгжлийг эрхэмлэж, хөгжлийн үр шимээс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримталж байна. НҮБ-ын гишүүн улс орнууд 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг батлахдаа “хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх” амлалтыг авсан. Түүнчлэн, хүн бүрийн эрхэм чанарыг хүлээн зөвшөөрөх нь суурь зарчим бөгөөд тогтвортой хөгжлийн зорилго, зорилт бүрийг улс үндэстэн, хүмүүс, нийгмийн хэсэг бүлэг бүрийн сайн сайхны төлөө хэрэгжүүлэхээ илэрхийлж, юуны түрүүнд нэн эрсдэлтэй байгаа хүн амын бүлгийг хамгийн түрүүнд анхааралдаа авахыг улс орнууд хүлээн зөвшөөрсөн.²⁷ Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5 дахь зорилгод “цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжих”, Зорилт 5.3-т “Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ”, түүнийг хэрэгжүүлэх үе шатын хүрээнд “Цахим засаглалыг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, хүн амыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбоно” гэж тус тус заасан.²⁸ Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан, амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур амьдралтай өрх, шилжигч өрх, хөдөөгийн/алслагдмал өрхийн цахим шүүх хуралдаанд шаардлагатай цахим ур чадвар ямар байгааг дээрх судалгаанд дурдсанаар дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 12. Цахим шүүх хуралдаанд шаардлагатай ур чадварыг зорилтот бүлэг эзэмшсэн байдлын дундаж үнэлгээ

Зорилтот бүлгийн төрөл	Бусадтай харилцах, хамтран ажиллах ур чадварын дундаж үнэлгээ	Асуудлыг шийдвэрлэх ур чадварын дундаж үнэлгээ
Ерөнхий дундаж үнэлгээ	2.9	3.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн	2.7	2.8
Өндөр настан	2.1	2.7
Амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур амьдралтай өрх	3.4	3.2
Шилжигч өрх	3.0	3.4
Хөдөөгийн/алслагдмал өрх	3.1	3.4

Ур чадварын үнэлгээ 1-рүү дөхөх тусам тухайн ур чадвар муу, 4-рүү дөхөх тусам сайн гэж үзнэ

27 Монгол Улсын Засгийн газар. Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2019: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт. Улаанбаатар хот. 2019. 52, 99 дэх тал

28 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. <https://legalinfo.mn/mn/detail?lawid=211057&showType=1>


Эндээс харахад, зорилтот бүлгийн буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан, амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур амьдралтай өрх, шилжигч өрх, хөдөөгийн/алслагдмал өрхийн цахим шүүх хуралдаанд шаардлагатай ур чадвар дунджаар 75%-тай байна. Хөгжингүй орны иргэдийн хувьд үндсэн цахим ур чадвар 65% байгаатай харьцуулахад дээрх үзүүлэлт харьцангуй сайн юм.²⁹ Гэхдээ дээрх зорилтот бүлгийн хувьд гэртээ компьютертой айл маш цөөн, интернэт холбогдолт бага, ихэвчлэн шаардлагатай үедээ утсаараа дата авч интернэт ашиглаж байгаа зэрэг нь зорилтот бүлгүүдийн санхүүгийн чадамжгүй байдлаас шууд хамааралтай байна. Мөн төхөөрөмжийг ашиглаж буй жил болон төхөөрөмжийн хүртээмжээс хамааран иргэдийн цахим ур чадвар ялгаатай байна.³⁰ Энэ нь цахим төхөөрөмж, интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэх тутам цахим шүүх хуралдаанд оролцох боломжийг нэмэгдэх, түүний үр ашигтай байдал дээшлэх боломжтой болохыг харуулж байна.

3.2. ГАДААДЫН ЗАРИМ УЛС ДАХЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ

“Цахим шүүх” гэдэгт дараах гурван нөхцөл зэрэг хангагдсан байхыг ойлгоно. Тодруулбал, цахим шүүх хуралдаан нь “цахим шүүх”-ийн бүрэлдэхүүн хэсэг байна.

- Нэхэмжлэл, хариу тайлбар, бусад хүсэлт, бичмэл нотлох баримтыг шүүхэд цахим хэлбэрээр гаргах (e-filing)
- Шүүх хуралдаан, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт цахимаар оролцох (virtual hearing)
- Хэргийн хөдөлгөөнийг цахимаар хянах (e-case management).³¹

Зураг 2. Цахим шүүхийн бүрэлдэхүүн



29 International Telecommunication Union, Development Sector. Digital Skills Insights - 2021. p41 https://academy.itu.int/sites/default/files/media2/file/21-00668_Digital-Skill-Insight-210831_CSD%20Edits%206_Accessible-HD.pdf

30 НҮБХХ, Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM). “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгааны тайлан”. 2021.09. 45, 46 дахь тал

31 Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. Цахим шүүхийн талаарх гадаадын зарим орны туршлага. “Шүүх эрх мэдэл” 2020/№1 https://www.judcouncil.mn/site/news_full/10293

Иймд НҮБ-аас 2 жил тутам гаргадаг “Цахим засаглалын индексийн судалгаа”-нд дурдсанаар, цахим засаглалын хөгжлөөр тэргүүлэгч 14 улсаас 4 улс, “маш сайн” үзүүлэлт бүхий 1 улсыг тус тус сонгон авч тэдгээрийн нөхцөл байдлыг дараах дэд хэсэгт авч үзэв.³² Эдгээр улс нь Монгол Улстай эрх зүйн тогтолцооны болон бүс нутгийн хувьд ойролцоо төдийгүй шүүх эрх мэдлийн үзүүлэлт нь өндөр юм.³³

Хүснэгт 13. Цахим засаглал болон эрх зүйт ёсны үзүүлэлтээр тэргүүлэгч зарим улс

Улс	Цахим засаглалын үзүүлэлт (НҮБ, 2020)			Эрх зүйт ёсны үзүүлэлт (WJP, 2021)			Эрх зүйн тогтолцоо
	Оноо	Байр	Ангилал	Оноо	Байр	Ангилал	
БНСУ	0.956	2	Тэргүүлэгч	0.74	20	Тэргүүлэгч	Холимог /Иргэний ба заншлын эрх зүй/
Эстони	0.9473	3	Тэргүүлэгч	0.81	11	Тэргүүлэгч	Иргэний эрх зүй
Сингапур	0.915	11	Тэргүүлэгч	0.78	17	Тэргүүлэгч	Холимог /Нийтлэг ба заншлын эрх зүй/
Япон	0.8989	14	Тэргүүлэгч	0.79	15	Тэргүүлэгч	Холимог /Иргэний ба заншлын эрх зүй//
БНХАУ	0.7948	45	Маш сайн	0.47	98	Дунджаас доогуур	Холимог /Иргэний ба заншлын эрх зүй/
Хонг Конг	-	-	-	0.75	19	Тэргүүлэгч	Холимог /Нийтлэг ба заншлын эрх зүй/
Монгол Улс	0.6497	92	Сайн	0.54	61	Дундаж	Холимог /Заншлын ба иргэний эрх зүй/

32 UN E-Government Surveys. 10 July 2020 <https://publicadministration.un.org/en/Research/UN-e-Government-Surveys>

33 The World Justice Project (WJP). Rule of Law Index 2021 <https://worldjusticeproject.org/our-work/research-and-data/wjp-rule-law-index-2021>
 University of Ottawa. Alphabetical Index of the Political Entities and Corresponding Legal Systems <http://www.juriglobe.ca/eng/sys-juri/index-alpha.php#MONGOLIA>

БНСУ:

2010 онд шинээр батласан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахимжилтыг дэмжих тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим баримт хэрэглэх тухай хуулиар цахим шүүхтэй холбогдох гол харилцааг зохицуулж байна.³⁴

Хамгийн анх 2010 онд “Electronic Case Filing System” (ECFS) буюу цахимаар нэхэмжлэл, гомдол, хариу тайлбар, нотлох баримт, шийдвэр гаргах тогтолцоог нэвтрүүлсэн.³⁵ Тус тогтолцоо нь хэргийн оролцогчид болон тэдний өмгөөлөгчид цахимаар нэхэмжлэл гаргах, холбогдох материалыг хүргүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцтай танилцах, оролцох боломжийг олгосон нэгдсэн тогтолцоо юм. Энэ тогтолцоог ашиглан нэхэмжлэл гаргасан нэхэмжлэгчид хариуцагч тал шүүхэд хариу тайлбар гаргах үед энэ тухай и-мэйл болон мессежээр мэдээлэл ирдэг байна. Цахимаар хэргийн материалтай танилцах болон процесс ажиллагаанд оролцохтой холбоотой эдгээр мэдэгдэл нь энэхүү тогтолцоог ашиглаж буй хэргийн бүх оролцогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдлыг шуурхай хянах боломжийг бүрдүүлдэг.

Энэхүү тогтолцооны тусламжтайгаар шүүгчид жилд дунджаар 3000 хүртэлх хэрэг шийдвэрлэх болжээ. Нөгөө талаас цахим туслалцааны төв нь байнга давтагддаг асуултын сан бүрдүүлснээр иргэдэд шүүхийн процессын талаар хэрэгтэй мэдээллээ түргэн шуурхай авах боломжийг нээжээ. Жишээлбэл зохигчид өөрсдийн хэрэгт холбогдох хууль, эрх зүйн зохицуулалт, төстэй шүүхийн шийдвэрүүд, судалгааны ажил, нийтлэлтэй танилцах боломжтой. Ингэснээр шүүх хуралд өөрийгөө өмгөөлөн оролцож буй этгээд нь мэргэжлийн хуульчийн туслалцаагүйгээр хариу тайлбар гаргах боломжтой болсон байна.

Дээрх тогтолцоо нь шүүгчдэд зориулсан үндсэн 4 хэсэгтэй байна:


- Хэлэлцэж буй хэргүүдийн явц болон онцлогоос хамаарч тэдгээрийг ангилж цэгцлэх
- Өөрийн гаргасан шүүхийн шийдвэр, захирамжийн сан үүсгэх
- Хэргүүдийг шүүхийн бүртгэлийн тусламжтайгаар өдөр, долоо хоног, сараар нь цэгцэлж өөрийн ажлаа хуваарилах.

Шүүгчийн захирамж бичих ажлыг дэмжих зорилготой төрөл бүрийн жишиг, загварын санд тулгуурлан шийдвэрээ боловсруулж цахим гарын үсгээ зурж баталгаажуулан цаг алдалгүй шийдвэрийн санд оруулж хэргийн бусад оролцогчдод мэдэгдэх.

34 Korean Law Information Center. Act on Promotion of the Digitalization of the Criminal Justice Process <https://law.go.kr/eng/engLsSc.do?menuId=2§ion=lawNm&query=digital&x=0&y=0#liBgcolor2>;
Act on the Use of Electronic Documents in Civil Litigations https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=32734&lang=ENG

35 БНСУ-ын Дээд шүүхийн вэб хуудас. E-Court system <https://eng.scourt.go.kr/eng/judiciary/eCourt/eTrials.jsp>; Korea Electronic Case Filing System <https://ecfse.scourt.go.kr/ecf/ecfE00/ECFE00.jsp>

Зураг 3. БНСУ-ын Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим тогтолцооны ерөнхий зураглал



Эстони улс:

Эстони улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 2009 онд нэмж, 2010.01.01-ний өдрөөс хүчин төгөлдөр болж үйлчилж буй 60¹ дугаар зүйлд “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахим мэдээллийн тогтолцоо” (e-file system)-ийн талаар зохицуулсан.³⁶ Тус цахим тогтолцооны ерөнхий зохицуулагч нь Хууль зүйн яам, түүний томилсон эрх бүхий албан тушаалтан байна.


Европын шүүхийн тогтолцооны үнэлгээний (CEPEJ) дагуу нийт 47 гишүүн улсын 46 нь цахим шүүхийн тогтолцоог хэрэгжүүлж эхэлжээ. Тэр дундаас Эстони улсын цахим шүүхийн тогтолцоо нь хэрэг шийдвэрлэх үр дүнтэй байдлаараа хоёрдугаарт орсон.³⁷ Тус тогтолцоо нь “E-file” нэгдсэн мэдээллийн тогтолцоо, “KIS” шүүхийн мэдээллийн тогтолцоо болон энгийн иргэд, олон нийтэд зориулсан портал сайт гэх үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. E-file тогтолцоогоор үндсэн мэдээллийн санг бүрдүүлдэг бол KIS тогтолцоогоор шүүхийн процессыг бүхэлд нь хянаж, зохион байгуулахад ашигладаг. Талууд портал сайтаар дамжуулан 24/7 нэхэмжлэл гаргах, бичиг баримт илгээх болон хэргийн явцтай танилцах боломжтой юм. Цахим шүүхийн тусламжтайгаар Эстони улсын хэрэг шийдвэрлэх дундаж хугацаа таван жилийн

36 Estonia – Code of Civil Procedure. §601. E-file proceedings information system <https://www.riigiteataja.ee/en/eli/ee/Riigikogu/act/531122021001/consolidate>

37 European Commission for the Efficiency of Justice (CEPEJ). Evaluation of judicial systems. <https://www.coe.int/en/web/cepej/cepej-work/evaluation-of-judicial-systems>
 Organisation of the ICT in the judicial system (Number of countries). 7/21/2020
https://public.tableau.com/app/profile/cepej/viz/ICTinjudiciaryv2020_1_0EN/ICTDevelopmentDashboard

хугацаанд 156 өдрөөс 99 өдөр болж буурсан ба 2018 онд нийт 73,000 хэргийг цахим шүүх хуралдаанаар шийдвэрлэжээ. Мэдээллийн санд бүртгэлтэй материалуудыг хувилж авах боломжгүй ба материал бүр нь огноо, электроник гарын үсгээр баталгаажсан байна. Түүнчлэн шүүхийн зүгээс шаардлагатай материалыг зөвхөн холбогдох талуудад нээлттэй байдлаар давхар нууцлал үүсгэх боломжтой юм. Эстони улсын нийт шүүгчдийн тоо 20 жилийн өмнөхтэйгөө адил боловч шийдвэрлэж буй хэргийн тоо даруй хоёр дахин ихэсчээ.

Зураг 4. Эстонийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төвлөрсөн мэдээллийн тогтолцоо (e-File)-ийн зураглал³⁸



Сингапур улс:

Сингапур улс 2000 онд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх үйл ажиллагаандаа “Electronic Filing System” буюу хамгийн анхны “Нэхэмжлэл, хариу тайлбар болон бичгийн хэлбэрээр шүүхэд гаргадаг бусад мэдүүлэг, тайлбар, хүсэлт, бичмэл нотлох баримтыг цахим хэлбэрээр мэдүүлэх” тогтолцоог нэвтрүүлж олон улсад цахим шүүхийн туршлагаараа тэргүүлсэн байна.³⁹ Үүнээс хойш гурван жилийн дотор Дээд шүүхэд хүлээгдээд байсан 2000 хэргийн ачаалал 92 хувиар буурчээ. EFS тогтолцоо нь техник технологийн хөгжлийн хэрээр хуучирч, дараах сул талтай болсон:

- Хуулийн нөхөрлөлүүд зөвхөн EFS тогтолцоог ашиглахын тулд тусгай компьютер хэрэглэх шаардлагатай.
- Програм хангамж болон техник хангамжийг байнгын шинэчлэх шаардлагатай.
- Хэргийн бүх материалд хандах боломжгүй.

Иймд 2013 онд eLitigation буюу интернэтэд суурилсан нэг удаагийн хандалтаар

38 Estonia – e-File <https://www.rik.ee/en/international/e-file>; https://e-justice.europa.eu/371/EN/service_of_documents_official_transmission_of_legal_documents?ESTONIA&member=1

39 Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. Цахим шүүхийн талаарх гадаадын зарим орны туршлага. “Шүүх эрх мэдэл” 2020/№1 https://www.judcouncil.mn/site/news_full/10293

нэхэмжлэл гаргаж, шүүх хуралдааны бүх явцыг хянах боломжтой бүрэн хэмжээний тогтолцоог нэвтрүүлжээ.⁴⁰ Хэрэглэгчид нэг удаагийн маягт бөглөсний дараа тус тогтолцоо нь шүүх хуралд шаардлагатай бусад бичиг баримтыг автоматаар боловсруулах чадвартай байна. Мөн шаардлагатай тохиолдолд шүүгчид цахим санд бүртгэгдсэн бүх мэдээллийг нэгэн файл болгож зөөврийн флаш дискэнд хуулж авах боломжтой. Дээрх тогтолцоо нь тус улсын Дээд шүүхийн 2013 оны удирдамжаар нарийвчлан зохицуулагдсан байна. 2020 оноос эхлэн тус тогтолцоог ашиглан цахим хуралдааны тов, мэдээлэлтэй танилцах боломжтой болсон. Мөн Сингапурын шүүхээс иргэдэд зориулсан цахим шүүх хуралдааны үеэр баримтлах дүрмийг энгийн үг, хэллэгээр бэлтгэн танилцуулсан.⁴¹ Түүнчлэн цахим шүүх хуралдаанд оролцогчийн 10 санамжийг Сингапурын шүүхүүдээс нэгтгэн гаргасан.⁴²

Зураг 5. Сингапурын цахим шүүх хуралдаанд оролцогчийн энгийн 10 санамж

ZOOM ETIQUETTE GUIDE FOR COURT USERS (10 HELPFUL QUESTIONS TO ASK YOURSELF)

1. **Have you updated your contact details and filed the required documents?**
 - You will need to update your contact details within 3 working days of the notice from the Court.
2. **Do you have video conferencing facilities?**
 - Usage of desktops and laptops is strongly encouraged, given the display size of these devices. A mobile tablet/ smartphone may be used as a backup.
 - If you do not have access to video conferencing facilities, you may contact the Court to access the facilities on-site for your hearing. The relevant contact details can be found in the notice from the Court.
 - The Courts' on-site video conferencing facilities are also wheelchair accessible.
3. **Is your video conferencing equipment in proper working order?**
 - If a smartphone is being used, ensure that it is placed on a secured stand and not handheld.
 - Connect your equipment to a power supply instead of working on battery mode.
 - Test your equipment before your hearing commences. Check that your microphone and headset are working.
 - Ensure that there is a stable Wi-Fi connection.
 - If you will encounter problems, you will need to notify the Court. The relevant contact details can be found in the notice from the Court.
4. **Is your space conducive for video conferencing?**
 - Be alone in a quiet room which allows you to follow the proceeding.
 - Place the main source of light behind the camera, in front of your face.
 - Switch off your smartphone if it is not used for the hearing.
5. **What should I wear and when should I log in?**
 - Dress appropriately like you would going to the office.
 - Lawyers should wear court attire.
 - Log in at least 15 – 30 minutes before your appointed time.
6. **How should I name myself on camera?**
 - Follow the directions stated in the notice from the Court.
 - For example:
Lead Counsel: "Lead Counsel - Mr John Lim"
Litigant/Witness: "D121/2022 Ms Jane Lee"
7. **How should I position myself on camera?**
 - Keep camera angle at your eye level.
 - Upper body must be visible.
 - Use a plain background, such as a plain wall or blinds. Do not use virtual backgrounds.
 - Switch on your camera at all times.
 - Mute your microphone when not speaking.
8. **What are the ground rules?**
 - This is a court hearing. You will need to comply with court etiquette except for the need to rise.
 - Seek permission from the Court if you need to excuse yourself during the hearing.
9. **Can I record the proceedings?**
 - Audio and/or video recordings are strictly prohibited.
 - Any unauthorised recordings are a contempt of court.
10. **What happens if the hearing cannot continue via Zoom?**
 - You will be given directions by the Court on how to proceed.

Technical guide on how to join a Zoom hearing

Should you need to attend a Zoom hearing, information on joining and using Zoom for your hearing will be provided in the notice from the Court informing you of your hearing.

40 Singapore – eLitigation https://www.elitigation.sg/_layouts/IELS/HomePage/Pages/Home.aspx

41 Singapore – Guide to virtual court sessions <https://www.judiciary.gov.sg/attending-court/virtual-court-sessions>

42 Singapore Courts - Zoom Etiquette Guide for Court Users (10 Helpful Questions to Ask Yourself) https://www.judiciary.gov.sg/docs/default-source/default-document-library/zoom-etiquette-guide-for-court-users-01jun2022.pdf?sfvrsn=9cb7a0e6_2

Хүснэгт 14. Цахим шүүх хуралдааны үеэр баримтлах зан үйл

Мөрдөх үйлдэл	Хориглох үйлдэл
<ul style="list-style-type: none"> • Шүүхийн мэдэгдэлд заасны дагуу дор хаяж 10 минутын өмнө эсвэл түүнээс эрт нэвтрэн орж бэлэн байгаарай. • Материалаа өөрт ойр байлгаж, хуралдаанд бэлтгэлтэй байгаарай. • Бүх цахим төхөөрөмжийг чимээгүй горимд шилжүүл. • Та үг хэлээгүй үедээ микрофоноо хааж байгаарай. • Шүүх хуралдааны турш камераа асаалттай байлгаарай. • Гэрлийн гол эх үүсвэрийг камерын ард болон нүүрнийхээ өмнө байрлуул. • Боломжтой бол микрофонтой чихэвч ашигла. • Үг хэлэхдээ шүүгчийн дохиог хүлээгээрэй. • Тодорхой ярь. 	<ul style="list-style-type: none"> • Гэрлийн гол эх үүсвэрийг ардаа байрлуулж сүүдэрт нүүрээ сайн харагдахгүй байлгах. • Цахим шүүх хуралдааны үеэр машин жолоодох, алхах. • Хэн нэгний яриаг таслах, таны ээлж болоогүй үед ярих. • Шүүх хуралдаанд дуу, дүрсний бичлэг хийх. • Шүүхээс зөвшөөрөл аваагүй хэн нэгнийг шүүх хуралдаанд оролцуулах.


Япон улс:

Дэлхийн банкны “Бизнес эрхлэх нь” тайлангийн 2017 оны дугаарт шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдээллийн технологийн хэрэглээ нэвтрүүлэх байдлаар дэлхийн бусад орноос Япон улс хоцорч яваа гэж үзэж, “Шүүхийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлсэн байдал”-д хатуухан үнэлгээ өгсөн байна.⁴³ Үүнтэй холбоотойгоор тус улсын засгийн газар 2017 оны 10 дугаар сард “Шүүхийн үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэсэг” байгуулж, тус ажлын хэсгээс 2018.03.30-нд “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдээллийн технологи хэрэглэх нь” гэх тайлан гаргасан.⁴⁴ Тус тайланд “3e” гэх ойлголтыг авч үзсэн. Үүнд цахимаар нэхэмжлэл, хүсэлт гаргах /e-Filing/, хэргийн хөдөлгөөний цахим тогтолцоо /e-Case Management/, цахим шүүх /e-Court/-г нэвтрүүлэхээр зорьж буй талаар дурдсан. Ингэхдээ шүүхээр үйлчлүүлэх иргэдийн хэрэгцээ, шаардлагын дагуу шүүхийн үйл ажиллагаанд болон бүх шатны шүүх хуралдаанд мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлэх шаардлагатай бөгөөд “гурван э” нь бие биенээсээ хамааралгүй боловч тэдгээр нь хамтран ажилласнаар шүүхийн үйл ажиллагаан дахь мэдээллийн технологийн хэрэглээг илүү үр дүнтэй болгох боломжтой гэж онцолжээ.

43 いよいよはじまる裁判手続のIT化 第1部：裁判手続のIT化・Q&A 山崎雄一郎・高梨滋雄 第2部：電子証拠とメタデータの
問題 櫻庭信之. LIBRA Vol.20 No.1-2 2020/1-2. p7
https://www.toben.or.jp/message/libra/pdf/2020_0102/p04-19.pdf

44 裁判手続等のIT化検討会「裁判手続等のIT化に向けた取りまとめー「3つのe」の実現に向けてー」20～22頁. p 7-15; 18
<https://www.kantei.go.jp/jp/singi/keizaisaisei/saiban/pdf/report.pdf>

Зураг 6. Япон улсын шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндсэн зураглал



Япон улсад 2022.05.18-ны өдөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар зохион байгуулах хууль буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн нэмэлтийг баталсан. Энэ хуульд иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг бүхэлд нь 2025 оноос эхлэн цахимаар зохион байгуулах талаар зохицуулсан. Тус хуулийн дагуу дараах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулна:

- Нэхэмжлэл, гомдол гаргах
- Нотлох баримт гаргах, шилжүүлэх
- Мэдүүлэг, тайлбар гаргах
- Мэтгэлцээн, хуралдаан.⁴⁵

БНХАУ:

БНХАУ-ын хувьд цахим шүүхийн хөгжилд онцгой анхаарч байна.⁴⁶ БНХАУ-д цар тахлын үеэр цахим шүүх хуралдааныг дэмжсэн дараах хэм хэмжээ, удирдамж гаргасан.

- 2020.03.02-нд Ардын Дээд шүүхээс хил дамнасан оролцогчдод зориулсан онлайн-аар нэхэмжлэл, бусад материал гаргах үйлчилгээгээр хангах тухай зохицуулалт гаргасан.⁴⁷

⁴⁵ Japan Enacts Bill to Make Civil Court Procedures Online. May 18, 2022 <https://www.nippon.com/en/news/yjj2022051800155/>; Japan enacts bill to have civil court procedures go virtual May 18, 2022 <https://www.japantimes.co.jp/news/2022/05/18/national/crime-legal/civil-lawsuits-online>

⁴⁶ Zhuhao Wang. China's E-Justice Revolution. Published by the Bolch Judicial Institute at Duke Law. Spring 2021, Vol. 105 No. 1 <https://judicature.duke.edu/articles/chinas-e-justice-revolution/>; Changqing Shi, Tania Sourdin and Bin Li, "The Smart Court – A New Pathway to Justice in China?" (2021) 12(1) International Journal for Court Administration 4. DOI: <https://doi.org/10.36745/ijca.367>; China Justice Observer. Why Chinese Courts Promote E-Filing System? . 08 Aug 2021 <https://www.chinajusticeobserver.com/a/why-chinese-courts-promote-e-filing-system>

⁴⁷ The Supreme People's Court of China. Guiding Opinions of the Supreme People's Court on Several Issues Concerning Properly Handling Civil Cases Related to COVID-19 Epidemic in Accordance with the Law (III). (2020) Fafa No.20 https://english.court.gov.cn/2021-10/23/c_761746.htm

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимаар явуулах журам баталсан. Ардын дээд шүүхийн 2021.05.18-ны өдрийн 1838 дугаар хурлаар батласан тус журмыг 2021.08.01-ний өдрөөс эхлэн мөрдөж байна. Энэ журмаар Ардын шүүх, талууд болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчид нэхэмжлэл гаргах, эвлэрүүлэн зуучлах, нотлох баримт гаргах, мэдээлэл авах, шүүх хуралдаанд оролцох зэрэг хэрэг хянан шийдвэрлэх бүх үйл ажиллагааг буюу түүний зарим хэсгийг шүүхийн цахим платформ ашиглан явуулж болно. Онлайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь офлайн шүүхийн үйл ажиллагаатай адил эрх зүйн үр дагавартай байна.⁴⁸
- Ардын шүүхийн онлайн эвлэрүүлэн зуучлалын журмыг баталсан. БНХАУ-ын Ардын дээд шүүхийн 2021.12.27-ны өдрийн 1859 дүгээр хурлаар баталсан тус журам 2022.01.01-ний өдрөөс эхлэн үйлчилж байна. Уг журам нь шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас өмнө буюу түүний явцад ардын шүүхийн эвлэрүүлэн зуучлалын платформ дээр хийгдсэн онлайн эвлэрүүлэн зуучлалд хамаарна.⁴⁹
- Цахим хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны журам баталсан. БНХАУ-ын Ардын дээд шүүхийн 2021.12.30-ны өдрийн 1861 дүгээр хурлаар баталсан тус журам 2022.03.01-ний өдрөөс эхлэн үйлчилж байна. Энэ журам нь онлайн шүүхийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх мэдээллийн тогтолцооны бүх түвшинд үйлчлэнэ.⁵⁰

Зураг 7. БНХАУ-ын Ханжоугийн интернэт шүүхийн цахим хуралдааны явц⁵¹



48 The Supreme People's Court of China. Online Litigation Rules of the People's Courts. Fa Shi [2021] No.12. May 18, 2021, and effective as of August 1, 2021) <https://english.court.gov.cn/pdf/OnlineLitigationRulesofthePeople'sCourts.docx>

49 The Supreme People's Court of China. Online Mediation Rules of the People's Courts. Fa Shi [2021] No. 23. December 27, 2021 <https://english.court.gov.cn/pdf/OnlineMediationRulesofthePeople'sCourts.docx>


50 The Supreme People's Court of China. The Online Operation Rules of the People's Courts. December 30, 2021 <https://english.court.gov.cn/pdf/OnlineOperationRulesofthePeople'sCourts.docx>


51 Imagine China Limited / Alamy stock photo.

Хонг Конг:

Хонг Конгийн Дээд шүүхийн Ерөнхий шүүгч “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим технологи ашиглах тухай” журам болон “Дүүргийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд цахим технологи ашиглах тухай журам”-ыг 2021.10.01-ний өдөр баталсан.⁵² Эдгээр журамд зааснаар цахим тогтолцоо ашиглан дүүргийн шүүхэд хандах буюу шүүхэд баримт, материал илгээх, түүнийг шүүх хүлээн авах, цаасан баримтыг шүүхээс цахим хэлбэрт хөрвүүлэх, баримт бичгийг цахимаар баталгаажуулах буюу цахим гарын үсэг зурах, цахим шүүх хооронд болон ердийн шүүх хооронд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тогтолцоогоор шилжүүлэх, төлбөр, хураамжийг цахимаар төлөх харилцааг зохицуулсан.

Зураг 8. Хонг Конгийн Шүүхийн хэргийн хөдөлгөөний нэгдсэн тогтолцооны үйлчилгээний нөхцөл




 司法機構
 JUDICIARY
Integrated Court Case Management System of the Judiciary
Terms and Conditions

Agreement to Terms and Conditions

1. The Chief Justice has designated the Integrated Court Case Management System ("iCMS") as an e-system referred to in Section 7 of the Court Proceedings (Electronic Technology) Ordinance ("the Ordinance") (Cap. 638), which is accessible through the Judiciary Web Portal. Access and use of the iCMS constitute unconditional acceptance of these terms and conditions as the same may be modified and/or supplemented from time to time in accordance with these terms and conditions.

Definitions

2. In these terms and conditions, unless the context otherwise requires -

- *"e-Courts" means a court and/or a tribunal specified by the rules made by the Chief Justice under Section 6 of the Ordinance;
- *"e-Services" means the electronic technology services under the iCMS for the applicable e Courts;
- *"Registered User" means a person who is registered as a user of the iCMS in accordance with the "Administrative Instructions on Matters relating to Registration as a User of the Integrated Court Case Management System"; and
- *"User" means anyone who uses the iCMS, including a Registered User.

Users' Obligations

I have read, understood and agreed with the terms and conditions above.

NEXT

3.3. ЦАХИМ ШҮҮХ ХУРАЛДААНТАЙ ХОЛБООТОЙ НИЙТЛЭГ СОРИЛТ

Цар тахлын үед цахим шүүх хуралдаантай холбоотой 23 оронд тусгайлан хууль тогтоомж, зохицуулалт, шүүхийн удирдамж баталсан байна.⁵³ Монгол Улсын хувьд цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор нийт шүүх хуралдааны дунджаар 29%-ийг цахимаар зохион байгуулсан бол АНУ-ын иргэний хэргийн шүүхүүдийн хуралдааны 76%, Английн Бизнес, өмчийн шүүхийн болон Хонг Конгийн олон улсын арбитрын хуралдааны 85% нь тус тус цахим хуралдаан байжээ.⁵⁴ Эндээс харахад,

52 Hong Kong e-Legislation. Court Proceedings (Electronic Technology) Ordinance (Cap. 638) https://www.elegislation.gov.hk/hk/cap638?xpid=ID_1623986255583_317;

Court Proceedings (Electronic Technology) (District Court Civil Proceedings) Rules (Cap. 638, section 26) (Enacting provision omitted—E.R. 1 of 2022) [1 October 2021] https://www.elegislation.gov.hk/hk/cap638C?xpid=ID_1624870678856_292;


Court Proceedings (Electronic Technology) (District Court) (Electronic Fees) Rules (Cap. 638, section 29) (Enacting provision omitted—E.R. 1 of 2022) [1 October 2021] <https://www.elegislation.gov.hk/hk/cap638E>;

53 International Bar Association. The Global Impact of the Covid-19 Pandemic on Commercial Dispute Resolution in the First Year. 2 June 2021 <https://www.ibanet.org/global-impact-covid-19-pandemic-dispute-resolution>

54 Thomson Reuters Institute. The Impacts of the Covid-19 Pandemic on State & Local Courts Study 2021:

Монгол Улсын цахим шүүх хуралдаан бусад улстай харьцуулахад бага хувьтай байна.

График 8. Цар тахалтай холбоотойгоор зохион байгуулсан цахим шүүх хуралдааны хувь



2020 оны 9, 10 дугаар сард “Baker McKenzie” олон улсын хуулийн фирмээс Английн иргэний хэргийн болон арилжааны хэргийн шүүх, олон улсын арбитраын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон хуульч, шүүгч, өмгөөлөгч, хэргийн оролцогчдоос авсан цахим шүүх хуралдаан, эвлэрүүлэн зуучлалыг цаашид үргэлжлүүлэх эсэх талаар асуулгын судалгаа авсан байна.⁵⁵ Энэхүү судалгаагаар дараах үр дүн гарсан байна:

Цахим шүүх хуралдаанд оролцогчдын хувьд ерөнхийдөө эерэг сэтгэгдэлтэй үлдсэн. Асуулгад оролцогчдын дийлэнх нь (~70%) ковид-19 цар тахал эхэлснээс хойш цахим хуралдаанд оролцсон бөгөөд тэдний дийлэнх нь түүнийг эерэгээр үнэлсэн. Зөвхөн 5.8% нь тааламжгүй буюу маш таагүй гэсэн сэтгэгдэлтэй үлджээ.

Цахим шүүх хуралдааныг завсрын үйл явцад илүүд үзэж байна. Санал асуулгад оролцогчдын дийлэнх нь (~70%) нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт цахим хуралдаан хийх нь илүү тохиромжтой гэж үзсэн бөгөөд 65% нь тангарагтны шүүх, гэрчийг нүүрэлдүүлж мэдүүлэг авахаас бусад нэгээс илүүгүй хоног үргэлжлэх тохиолдолд цахим хуралдааныг хийх нь зүйтэй гэж үзсэн байна.

Эцсийн буюу сүүлийн хуралдааныг биечлэн оролцуулж зохион байгуулах

A Look at Remote Hearings, Legal Technology, Case Backlogs, and Access to Justice. p3 <https://www.thomsonreuters.com/en-us/posts/legal/pandemic-impact-courts-report-2021/>;

Baker McKenzie. The Future of Disputes: Are Virtual Hearings Here To Stay? 2021. p3 <https://www.bakermckenzie.com/-/media/files/insight/publications/2021/01/future-of-disputes-campaign-brochure.pdf>;

Hong Kong International Arbitration Centre. Virtual Hearings at HKIAC: Services and Success Stories. 06 May 2020 <https://www.hkiac.org/news/virtual-hearings-hkiac-services-and-success-stories>

⁵⁵ Baker McKenzie. The Future of Disputes: Are Virtual Hearings Here To Stay? 2021. <https://www.bakermckenzie.com/-/media/files/insight/publications/2021/01/future-of-disputes-campaign-brochure.pdf>

хэрэгтэй гэж үзэж байна. Асуулгад оролцогчдын 85% нь тэдний дараагийн иргэний хэргийн шүүх хуралдааныг биечлэн оролцуулах хэлбэрээр зохион байгуулахыг илүүд үзжээ.

“Хосолсон” хуралдааныг илүү дэмжиж байна. Зарим оролцогч шүүх хуралдааны танхимд байлцах боломжийг олгодог, зарим нь видео болон утсаар хурлаар оролцох боломжийг олгодог “хосолсон” хуралдааныг санал асуулгад оролцогчдын олонх нь (~55%) дэмжсэн байна.

Хүснэгт 15. Дараа цахим болон биечлэн оролцох шүүх хуралдааны алийг сонгох талаарх асуулга: Английн шүүх хуралдаанд оролцогчдын туршлага

Хуралдааны үе шат	Цахим хуралдаан	Биечлэн оролцох хуралдаан	Хосолсон хэлбэр
Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг	69.8%	10.1%	20.1%
Шүүх хуралдаан/Шийдвэр гаргах	16.8%	48.2%	35%


Хүснэгт 16. Цахим шүүх хуралдаанд оролцоход учирсан бэрхшээл: Английн шүүх хуралдаанд оролцогчдын туршлага

46.5% цахим шүүх хуралдаанд төвлөрөхөд хэцүү	27.8% цахим шүүх хуралдаан нууцлал багатай, найдваргүй	55.6% цахим шүүх хуралдаанд гэрчээс мэдүүлэг авах явдлыг багасгадаг
36.8% цахим шүүх хуралдаанд олон нийт эргэлздэг	54.2% шүүхүүд технологид хөрөнгө их оруулах, шүүгчдийг сургах шаардлагатай	42.4% цахим шүүх хуралдаантай холбоотой хууль тогтоомжийг өөрчлөх шаардлагатай


Харин Томсон Ройтерс институтээс цар тахлын нөлөө АНУ-ын муж улсын болон орон нутгийн шүүхүүдэд хэрхэн нөлөөлснийг тодорхойлох хүрээнд 2021 оны 6 дугаар сард тус улсын шүүхийн 240 мэргэжилтэн буюу шүүгч, ерөнхий шүүгчид, шүүхийн захиргааны ажилтнууд, өмгөөлөгчид, шүүгчийн туслахуудаас цахим шүүх хуралдааны үеийн хүндрэл, бэрхшээлийг тодруулах асуулгын судалгаа авсан байна.⁵⁶ Тэдний 93% нь 2020 онд цахим шүүх хуралдаанд оролцсон бөгөөд 89% нь 2021 онд цахим шүүх хуралдаанд оролцжээ. АНУ-д цахим хуралдаан хийсэн байдал нийт 221 шүүх буюу орон нутгийн шүүх, муж улсын шүүхүүдийн хувьд төдийлөн ялгаагүй байх бөгөөд хаалттай буюу хувь хүний нууцтай холбоотой асуудлаар хийсэн цахим шүүх хуралдааны хувь бага байна.

⁵⁶ Thomson Reuters Institute. The Impacts of the COVID-19 Pandemic on State & Local Courts Study 2021: A Look at Remote Hearings, Legal Technology, Case Backlogs, and Access to Justice. 2021 https://legal.thomsonreuters.com/content/dam/ewp-m/documents/legal/en/pdf/white-papers/covid-court-report_final.pdf


График 9. АНУ-ын шүүхүүд цахим хуралдаан хийсэн хувь, хэргийн төрлөөр



Цахим шүүх хуралдааны орчинд тулгардаг гол бэрхшээлийн нэг нь баримт бичгийг зохион байгуулах, уялдуулах асуудал юм. Тодруулбал, нотлох баримт хуваалцах, нотлох баримт болон мультимедиа файлд нэвтрэх, бүх нотлох баримтыг цэгцлэх, нотлох баримт дээрх тайлбаруудтай танилцах нь цахим шүүх хуралдаанд оролцох үед бэрхшээл болж байна. Шүүх болон талууд нотлох баримт, баримт бичиг, файл, зураг, хэргийн бусад материалтай танилцаж чадахгүй нөхцөлд тэрхүү шүүх хуралдаан хууль ёсны чанараа алдах, хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж үзэхэд хүргэх бөгөөд Үндсэн хуулийн ноцтой зөрчил болж, тийм хуралдааны шийдвэрт давж заалдах нөхцөл болно.


График 10. АНУ-ын цахим шүүх хуралдааны орчин дахь сорилт, хувиар


Цахим шүүх хуралдаанд оролцогчдоос иргэний нэхэмжлэгч, прокурор, хариуцагчийн өмгөөлөгчид ихэвчлэн шүүхэд нотлох баримт гаргаж өгч, түүнийг шинжлэн судлуулж байна.

График 11. АНУ-ын цахим шүүх хуралдаанд нотлох баримт гаргаж, танилцуулж буй оролцогчдын хувь


Ихэнх шүүхэд буюу 72% нь цахим шүүх хуралдаанд танилцуулах, шинжлэн судлуулах материалыг мэйлээр дамжуулан хүлээн авч байна. Гэвч энэ нь талууд бүгд тэдгээр материалтай нэгэн зэрэг танилцах, түүний ил тод байдлыг хангах нөхцөлийг хязгаарлах юм.

График 12. АНУ-ын шүүхүүд цахим хуралдаанд танилцуулах, шинжлэх материалыг хүлээн авч буй байдал



Цахим шүүх хуралдаанд болон цахимаар мэдүүлэг авахад биеийн хэлэмж, зан байдлыг тодорхойлох, таних нь шинэ сорилт болж байна. Ерөнхийдөө дээрх судалгаанд оролцогчдын 35% нь цахим шүүх хуралдаан нь түүний оролцогч эсвэл гэрчийн найдвартай байдлыг үнэлэх чадварыг бууруулдаг гэж хариулсан бол 27% нь зан байдал болон биеийн хэлэмжийг унших чадвараа алддаг гэж үзсэн байна. Үүний зарим шалтгаан нь камерын чанар муу, гэрэлтүүлэг муу, интернэтийн холболт тогтворгүй, магадгүй хамгийн чухал нь гэрчийг цаана нь хэн нэгэн дасгалжуулж, түүнд зааварлаж байсан эсэх юм.

Шударга шүүхээр шүүлгэх эрхийг цахим шүүх хуралдаанд хангаж буй эсэхийг дээрх судалгаанд оролцогчдоос асуужээ. Ингэхэд, судалгаанд оролцогчдын 77% нь шударга шүүхээр шүүлгэх эрх илүү хангагдсан (42%) буюу өөрчлөгдөөгүй, хэвээрээ (35%) гэж үзсэн бол 23% нь буурсан гэж хариулжээ. Энэ нь судалгаанд хамрагдагсдын талаас илүү хувь нь цахим шүүх хуралдаанд оролцогчдын хувьд шударга ёсны хүртээмж нэмэгдсэн гэж үзсэн болохыг харуулж байна. Тодруулбал, цахим шүүх хуралдаанд шударга шүүхээр шүүлгэх эрх илүү хангагдсан гэж үзсэн хүмүүсийн гол шалтгаан нь талууд болон өмгөөлөгчид тав тухтай, ирц сайтай (ирц бүрдэхгүй байх тохиолдол багассан), талуудын оролцоо нэмэгдсэн явдал байна. Цахим шүүх хуралдааныг зөвшөөрснөөр шүүгч, өмгөөлөгч болон маргааны талууд өөр өөр шүүх рүү явах шаардлагагүй болсон.

График 13. Шударга шүүхээр шүүлгэх эрхийг цахим шүүх хуралдаанд хангасан хувь, АНУ-ын шүүхийн жишээн дээр





График 14. Хэрхэн шударга шүүхээр шүүлгэх эрхийг цахим шүүх хуралдаанд илүү хангасан бэ?, АНУ-ын шүүхийн жишээн дээр




Интернэтэд холбогдох болон шаардлагатай технологи хэрэглэх боломж хомс байдал нь цахим шүүх хуралдаанд шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилтийг бууруулах үндсэн нөхцөл болж байна.

График 15. Хэрхэн шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилтийг цахим шүүх хуралдаанд бууруулсан бэ?, АНУ-ын шүүхийн жишээн дээр



Дээр дурдсан хүндрэл, бэрхшээл нь цаашид цахим шүүх хуралдаанд оролцох эрмэлзлийг хэр бууруулах вэ гэдэг асуулт гарч байна. Өмнө нь иргэний хэргийн шүүх хуралдааны 76%-ийг цахимаар хийсэн бол ирээдүйд энэ үзүүлэлт 57% болж, 20% орчим буурч магадгүй байна.

График 16. АНУ-ын шүүхүүд цаашид цахим хуралдаан хийх төлөвлөгөөний хувь, хэргийн төрлөөр



IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

“Шударга шүүхээр шүүлгэх эрхийг цахим шүүх хуралдаанд хангах нь” сэдэвт судалгааны хүрээнд дараах дүгнэлт хийж, зөвлөмж бэлтгэлээ. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээгээр баталгаажсан шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах нэг үндсэн арга зам бол шүүх хуралдаан юм. Дэлхий дахинд цар тахлын нөхцөл байдал, газар зүйн байршлын хамаарлаас болж шүүх хуралдаан хойшлох, завсарлах, тасалдах, улмаар шударга шүүхээр шүүлгэх эрх хангагдахгүй байх бодит эрсдэл тулгарсаар байна. Улмаар Монгол Улсын шүүхийн үйл ажиллагаа үр өгөөжгүй байх, шүүхийн хараат бус байдал хангалтгүй байх нь түүнд итгэх иргэдийн итгэлд шууд нөлөөлж байна. Шүүхийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар шүүхэд итгэх иргэдийн итгэлийн нэмэгдүүлэх нэг арга зам нь цахим шүүх хуралдаан болж байна.

Энэхүү арга замыг нэвтрүүлэхийн тулд дэлхийн улсууд “цахим шүүх” гэх ойлголтын хүрээнд шүүхийн үйл ажиллагаа, хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулах эрх зүйн, технологийн болон зохион байгуулалтын олон ажлыг үе шаттайгаар зохион байгуулсаар байна. Тухайлбал, ковид-19 цар тахлын үед 23 оронд цахим шүүх хуралдаантай холбоотой тусгайлан хууль тогтоомж, зохицуулалт, шүүхийн удирдамж баталсан байна. Монгол Улсын хувьд Монгол Улсын шүүхийн хуулийн шинэчилсэн найруулгад шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах асуудлыг тусгаж, Шүүхийн ерөнхий зөвлөлөөс холбогдох журам баталсан. Тодруулбал, Монгол Улсад шүүх хуралдааныг цахимаар зохион байгуулах эрх зүйн үндэс бүрдсэн байна. Гэхдээ дан ганц эрх зүйн зохицуулалтаар цахим шүүх хуралдааны асуудлыг дүгнэх боломжгүй байна.

Монгол Улсад шүүх хуралдааны оролцогчийг цахимаар оролцуулах тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Цар тахлын нөхцөл байдлаас хамааран цахим шүүх хуралдаан, холимог хуралдаан цаашид ч үргэлжлэхээр байна. Тодруулбал, нийт шүүх хуралдааны 1/3 орчмыг цахимаар зохион байгуулсан бөгөөд 1 сард дунджаар 2100 цахим шүүх хуралдааныг зохион байгуулах боломжтой төдийгүй хэрэгцээтэй байна. Мөн 1 сард дунджаар 3965 хүн цахим шүүх хуралдаанд оролцох сонирхолтой байна. Энэ тоо цаашид ч өсөх боломжтой байна.

Гэхдээ цахим шүүх хуралдаан зохицуулалт зөвхөн нэг журмаар хязгаарлагдаж байна. Тодруулбал, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.03.31-ний өдрийн 82 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам” үйлчилж байх бөгөөд түүнд тусгаагүй орхисон зүйлс гарч байна. Тухайлбал, танхимын шүүх хуралдааны үед баримталдаг дэгийг цахим шүүх хуралдааны онцлогтой хэрхэн уялдуулах нь тодорхойгүй байна. Иймд шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журамд танхимын шүүх хуралдааны үед баримталдаг бүх дэгийг тусгаж цахим шүүх хуралдааны онцлогтой уялдуулах шаардлагатай байна.

Энэ хүрээнд цахим шүүх хуралдааны хууль ёсны, хүчин төгөлдөр байдлыг хангахын тулд гэрч, шүүх хуралдааны оролцогч мэдүүлэг, тайлбар өгөх, үг хэлэхийн

өмнө камерыг өрөөний эргэн тойронд эргүүлэх, эсвэл өөр хэнийг ч байлцуулахгүй байхыг тэднээс хүсэх гэх мэт арга замыг хэвшүүлэх шаардлагатай байна. Шүүхийн төсөв, бусад санхүүжилтын хүрээнд шүүхийн үйл ажиллагаанд ашиглаж буй хуучин мэдээллийн тогтолцоонуудыг шинэчлэх, цахим нотлох баримтыг дэмжсэн шийдэлд хөрөнгө оруулах, өргөн зурвасын интернэтийн холболтыг сайжруулах замаар цахим шүүх хуралдааны хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Үүнээс гадна, цахим шүүх хуралдаанд оролцогчдод зохих зааварчилгаа өгөх, тэдэнд туслах, тэрхүү хуралдааны үр нөлөөг алдагдуулахгүй байхад анхаарах ёстой нь зөвхөн Монгол Улсын гэлтгүй бусад улсад ч нийтлэг асуудал болж байна. Тухайлбал, цахим шүүх хуралдаанд оролцогчид дараах үнэлэмжтэй үлдсэн байна:

- Цахим шүүх хуралдаанд оролцогчдын хувьд ерөнхийдөө эерэг сэтгэгдэлтэй үлдсэн.
- Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт цахим хуралдаан хийх нь илүү тохиромжтой гэж үзсэн бөгөөд нэгээс дээш хоног үргэлжлэх хуралдааныг танхимын хэлбэрээр хийх нь зүйтэй гэж үзсэн байна.
- “Хосолсон” хуралдааныг илүү дэмжиж байна. Хуралдаанд бүх оролцогчийг бүгдийг танхимын, эсвэл цахим хуралдаанд оролцуулахаас илүүтэйгээр холимог байдлаар буюу тэднийг танхимд болон цахимаар оролцох боломжийг олгодог “хосолсон” хуралдааныг дэмжих хандлагатай байна.

Энэ хүрээнд шүүх, түүний ажилтнууд нь цахим шүүх хуралдаан болохоос өмнө хэргийн оролцогчид дадлага хийх, туршлагажихад зориулсан сургалт явуулж байх нөхцөлийг бүрдүүлэх, энэхүү сургалтыг оролцогчдын хэрэгцээнд нийцүүлэн уян хатан хөтөлбөртэй зохион байгуулах шаардлагатай байна. Түүнчлэн цахим шүүх хуралдааны зохион байгуулалт нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бууруулах нөхцөл болохгүй байхад онцгой анхаарч, энэ чиглэлээр иргэдээс тогтмол асуулга авч, шүүхэд итгэх иргэдийн итгэл ба цахим шүүх хуралдааны хамаарлыг тоон үзүүлэлтээр тогтмол дүгнэж байх шаардлагатай байна.

Хосолсон хуралдаан их хойшлох, тасалдахаас зайлсхийхийн тулд оновчтой, тасралтгүй ажиллагаатай технологийн платформыг шүүх ашиглах. Тодруулбал, хуульч, өмгөөлөгчид болон шүүх хуралдааны оролцогчдод хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесс, дуу, дүрсний тал дээр биш харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанарт анхаарлаа хандуулах боломжийг олгодог зохих технологийг шүүхийн захиргааны байгууллага, ажилтнууд хэрэглэх, хэвшүүлэх шаардлагатай байна. Хууль зүйн технологийн өнөөгийн дэвшлийг үл харгалзан, өмгөөлөгчгүйгээр буюу өөрийгөө төлөөлж цахим шүүх хуралдаанд оролцож буй хуульч бус хүмүүст тулгарч буй олон сорилтыг шийдэхийн тулд хууль зүйн технологи нь шударга шүүхээр шүүлгэх эрхийг дэмжсэн энгийн үг хэллэгтэй байх, үйл явцыг хялбарчлах, процессын шударга байдлыг хангах, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхэд түлхэц болохуйц байх шаардлагатай байна.

Шүүхээс баталгаажуулсан буюу зөвшөөрсөн хууль зүйн хэлмэрч, орчуулагч хангалтгүй байгаа асуудал цахим шүүх хуралдаан дээр илүү ноцтой болж байна. Цахим шүүх хуралдааны үеэр орчуулга, хэлмэрчлэх ажил удаашрах, буруу

тайлбарлахаас зайлсхийхийн тулд орчуулагч, хэлмэрч болон хэргийн оролцогч хоёрыг нэг өрөөнд байлгах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Цахим шүүх хуралдааны орчинд тулгардаг гол бэрхшээлийн нэг нь баримт бичгийг цахимаар зохион байгуулах, уялдуулах асуудал юм. Тодруулбал, цахим шүүх хуралдааны өмнө болон хуралдааны үеэр цахимаар нотлох баримт гаргах, түүнийг шинжлэн судлах, үнэлэхэд талуудын оролцоог бүрэн хангаагүй, ил тод байдал хангалтгүй явдал нь цахим шүүх хуралдааны үр нөлөөнд эргэлзэхэд хүргэж байна. Цаашид нотлох баримт, хэргийн материалыг цахимаар хуваалцах, дамжуулах технологийг шүүхийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх шаардлагатай байна. Тодруулбал, хэргийн бүх файлыг илгээх, хүлээн авах, хуваалцах, хадгалах зориулалт бүхий нэгдсэн, хүртээмжтэй платформ ашиглах нь ажил хөнгөвчлөх, ил тод байдлыг сайжруулах төдийгүй хуралдаан хойшлох явдлыг бууруулах ач холбогдолтой. Энэ хүрээнд баримт бичиг, цахим нотлох баримтын нууцлалыг хангах, түүний кибер аюулгүй байдлыг бүрэн хангах шаардлагатай.

Өөр нэг бэрхшээл бол, технологийн асуудал юм. Камерын чанар, гэрэлтүүлэг муу, интернэт холболт тогтворгүй байх асуудал гарч байна. Түүнчлэн, цахим төхөөрөмжийг ашиглаж буй жил болон төхөөрөмжийн хүртээмжээс хамааран иргэдийн цахим шүүх хуралдаанд оролцох ур чадвар ялгаатай байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан, амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур амьдралтай өрх, шилжигч өрх, хөдөөгийн/алслагдмал өрхийн хувьд гэртээ компьютертой байх явдал ховор, интернэт холболт бага, ихэвчлэн шаардлагатай үедээ утсаараа дата авч интернэт ашиглаж байгаа зэрэг нь тэдний санхүүгийн чадамжгүй байдалтай шууд хамааралтай байна. Энэ нөхцөлийг “төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрхийг хангах”-тай адилтган авч үзэж, дээрх зорилтот бүлгийн иргэдийн цахим шүүх хуралдаанд оролцох боломжийг тухайн шүүхийн тамгын газар өөрийн төсөв, технологийн нөөц, зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэж байх үүрэг хүлээлгэх шаардлагатай байна.

Монгол Улсын хувьд шударга шүүхээр шүүлгэх эрхийг цахим шүүх хуралдаанд хангасан байдлыг тоон үзүүлэлтээр хэмжээгүй бөгөөд хэрхэн хэмжих аргачлалгүй байна. Бусад улсын жишээн дээр авч үзэхэд, судалгаанд оролцогчдын 77% нь шударга шүүхээр шүүлгэх эрх цахим шүүх хуралдаанд хангагдсан гэж хариулжээ. Цахим шүүх хуралдаанд шударга шүүхээр шүүлгэх эрх илүү хангагдсан гэж үзсэн хүмүүсийн гол шалтгаан нь талууд болон өмгөөлөгчид тав тухтай, ирц сайтай (ирц бүрдэхгүй байх тохиолдол багассан), талуудын оролцоо нэмэгдсэн явдал байна. Харин интернэтэд холбогдох, шаардлагатай технологи хэрэглэх боломж хомс байдал нь цахим шүүх хуралдаанд шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилтийг бууруулах үндсэн нөхцөл болж байна. Энэ асуудал нь цаашид цахим шүүх хуралдаанд оролцох эрмэлзлийг 20% орчим бууруулах магадлалтай байна. Цаашид Монгол Улсын хувьд шударга шүүхээр шүүлгэх эрхийг цахим шүүх хуралдаанд хангасан байдлыг тоон үзүүлэлтээр аргачлалыг Шүүхийн ерөнхий зөвлөл хариуцан боловсруулах, түүний дагуу үнэлгээ хийж, цахим шүүх хуралдааны үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар тухай бүр дүгнэлт, санал бэлтгэж хэвших шаардлагатай байна.

V. НОМ ЗҮЙ

1/ Эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 1992 он, №1
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2020 он, №17
- Монгол Улсын шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль. “Төрийн мэдээлэл” эмхэтгэл, 2021 он, №05
- Засгийн газрын 2019.06.05-ны өдрийн 220 дугаар тогтоолын хавсралт “Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”
- Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн 196 дугаар тогтоолын хавсралт “Үндсэн тогтолцооны үйл ажиллагааг зохицуулах, тогтолцоо ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020.02.10-ны өдрийн 04 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Шүүхийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөгөө”
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020.11.24-ний 116 дугаар тогтоолын хавсралт “Гамшгаас хамгаалах, өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед баримтлах Эрүү, иргэн, захиргааны хэргийн хөдөлгөөний түр аргачлал”
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.02.24-ний өдрийн 39 дүгээр тогтоолын хавсралт “Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам”
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.02.24-ний өдрийн 41 дүгээр тогтоолын хавсралт “Хэргийн хөдөлгөөний нэгдсэн тогтолцоо ашиглах журам”
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022.03.31-ний өдрийн 82 дугаар тогтоолын хавсралт “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам”.
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2020.05.21-ний 61 дүгээр тушаалын хавсралт “Шүүхийн тамгын газар Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээс цахим хэлбэрээр лавлагаа, мэдээллийг авах журам”
- Үндсэн хуулийн цэцийн даргын 2020.11.19-ний өдрийн 33 дугаар тушаалын хавсралт “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хангах түр журам”,
- Үндсэн хуулийн цэцийн даргын 2021.09.06-ны өдрийн 23 дугаар тушаалын хавсралт “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн

үед Үндсэн хуулийн цэцийн дунд, их суудлын хуралдаанд маргагч талуудыг оролцуулах түр журам”

- Estonia – Code of Civil Procedure. §601. E-file proceedings information system
- Korean Law Information Center. Act on Promotion of the Digitalization of the Criminal Justice Process
- Korean Law Information Center. Act on the Use of Electronic Documents in Civil Litigations
- The Supreme People’s Court of China. Guiding Opinions of the Supreme People’s Court on Several Issues Concerning Properly Handling Civil Cases Related to COVID-19 Epidemic in Accordance with the Law (III). [2020] Fafa No.20 https://english.court.gov.cn/2021-10/23/c_761746.htm
- The Supreme People’s Court of China. Online Litigation Rules of the People’s Courts. Fa Shi [2021] No.12. May 18, 2021, and effective as of August 1, 2021) <https://english.court.gov.cn/pdf/OnlineLitigationRulesofthePeople'sCourts.docx>
- The Supreme People’s Court of China. Online Mediation Rules of the People’s Courts. Fa Shi [2021] No. 23. December 27, 2021 <https://english.court.gov.cn/pdf/OnlineMediationRulesofthePeople'sCourts.docx>
- The Supreme People’s Court of China. The Online Operation Rules of the People’s Courts. December 30, 2021 <https://english.court.gov.cn/pdf/OnlineOperationRule-softhePeople'sCourts.docx>
- Hong Kong e-Legislation. Court Proceedings (Electronic Technology) Ordinance (Cap. 638) https://www.elegislation.gov.hk/hk/cap638?xid=ID_1623986255583_317
- Hong Kong e-Legislation. Court Proceedings (Electronic Technology) (District Court Civil Proceedings) Rules (Cap. 638, section 26) (Enacting provision omitted—E.R. 1 of 2022) https://www.elegislation.gov.hk/hk/cap638C?xid=ID_1624870678856_292
- Hong Kong e-Legislation. Court Proceedings (Electronic Technology) (District Court) (Electronic Fees) Rules (Cap. 638, section 29) (Enacting provision omitted—E.R. 1 of 2022) <https://www.elegislation.gov.hk/hk/cap638E>

2/ Өгүүлэл, нийтлэл

- Changqing Shi, Tania Sourdin and Bin Li, ‘The Smart Court – A New Pathway to Justice in China?’ (2021) 12(1) International Journal for Court Administration 4. DOI: <https://doi.org/10.36745/ijca.367>
- China Justice Observer. Why Chinese Courts Promote E-Filing System? 08 Aug 2021 <https://www.chinajusticeobserver.com/a/why-chinese-courts-promote-e-filing-system>

- Civil Legal System Modernization. How Courts Embraced Technology, Met the Pandemic Challenge, and Revolutionized Their Operations. Report. December 1, 2021 <https://www.pewtrusts.org>
- Hong Kong International Arbitration Centre. Virtual Hearings at HKIAC: Services and Success Stories. 06 May 2020 <https://www.hkiac.org/news/virtual-hearings-hkiac-services-and-success-stories>
- Sparq feed. Benefits of virtual hearings | Are remote courts here to stay? <https://www.sparq.live/feed/benefits-of-virtual-hearings>
- The Supreme Court of Victoria. Virtual Hearings Glossary. May, 2020 <https://www.supremecourt.vic.gov.au/law-and-practice/virtual-hearings/virtual-hearings-glossary>
- Zuhao Wang. China's E-Justice Revolution. Published by the Bolch Judicial Institute at Duke Law. Spring 2021, Vol. 105 No. 1 <https://judicature.duke.edu/articles/chinas-e-justice-revolution/>
- Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. Цахим шүүхийн талаарх гадаадын зарим орны туршлага. “Шүүх эрх мэдэл” 2020/№1 https://www.jud-council.mn/site/news_full/10293
- いよいよはじまる裁判手続のIT化 第1部：裁判手続のIT化・Q&A 山崎雄一郎・高梨滋雄 第2部：電子証拠とメタデータの問題 櫻庭信之. LIBRA Vol.20 No.1-2 2020/1-2 https://www.toben.or.jp/message/libra/pdf/2020_0102/p04-19.pdf
- 裁判手続等のIT化検討会「裁判手続等のIT化に向けた取りまとめ – 「3つのe」の実現に向けて–」20～22頁 <https://www.kantei.go.jp/jp/singi/keizaisaisei/saiban/pdf/report.pdf>
- “Зууны мэдээ” сонин. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргаа, удирдлагын газрын Мэдээллийн технологи, хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга Э.Амарсанаагийн ярилцлага. 2021.07.06 http://www.judcouncil.mn/site/news_full/11363

3/ Тайлан

- Baker McKenzie. The Future of Disputes: Are Virtual Hearings Here To Stay? 2021 <https://www.bakermckenzie.com/-/media/files/insight/publications/2021/01/future-of-disputes-campaign-brochure.pdf>
- European Commission for the Efficiency of Justice (CEPEJ). Evaluation of judicial systems. <https://www.coe.int/en/web/cepej/cepej-work/evaluation-of-judicial-systems>
- Independent Research Institute of Mongolia (IRIM). “Qualitative Assessment of Digital Access and Skills of Vulnerable Groups”. May– August, 2021 <https://www.undp.org/mongolia/publications/qualitative-assessment-digital-access-and-skills-vulnerable-groups>

- International Bar Association. The Global Impact of the Covid-19 Pandemic on Commercial Dispute Resolution in the First Year. 2 June 2021 <https://www.ibanet.org/global-impact-covid-19-pandemic-dispute-resolution>
- International Telecommunication Union, Development Sector. Digital Skills Insights – 2021 https://academy.itu.int/sites/default/files/media2/file/21-00668_Digital-Skill-Insight-210831_CSD%20Edits%206_Accessible-HD.pdf
- The World Justice Project (WJP). Rule of Law Index 2021 <https://worldjusticeproject.org/our-work/research-and-data/wjp-rule-law-index-2021>
- Thomson Reuters Institute. The Impacts of the Covid-19 Pandemic on State & Local Courts Study 2021: A Look at Remote Hearings, Legal Technology, Case Backlogs, and Access to Justice <https://www.thomsonreuters.com/en-us/posts/legal/pandemic-impact-courts-report-2021/>
- UN E-Government Surveys. 10 July 2020 <https://publicadministration.un.org/en/Research/UN-e-Government-Surveys>
- WHO. Mongolia Situation <https://covid19.who.int/region/wpro/country/mn>
- НҮБХХ, Хараат бус судалгааны хүрээлэн (IRIM). “Зорилтот бүлгийн иргэдийн цахим ур чадварыг үнэлэх чанарын судалгааны тайлан”. 2021.09
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан – 2015-2020
- The Heritage Foundation. “2022 Index of Economic Freedom” Judicial Effectiveness: Mongolia
- Редактор Н.Эрдэнэцогт “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчим, түүний тайлбар”. Улаанбаатар, 2018. Азийн сан
- Шүүхийн ерөнхий зөвлөл. Эмхтгэсэн Т.Мэндсайхан. Шүүхийн захиргааны хөгжил. Улаанбаатар, 2018

4/ Цахим тогтолцоо

- Korea Electronic Case Filing System <https://ecfse.scourt.go.kr/ecf/ecfE00/ECFE00.jsp>
- Estonia – e-File <https://www.rik.ee/en/international/e-file>; https://e-justice.europa.eu/371/EN/service_of_documents_official_transmission_of_legal_documents?ESTONIA&member=1
- Singapore – eLitigation https://www.elitigation.sg/_layouts/IELS/HomePage/Pages/Home.aspx
- Hong Kong Judiciary portal <https://www.judwebportal.judiciary.hk/judportal-web/?lang=en>
- China Judicial Process Information Online <https://splcgk.court.gov.cn/gzfwwww/>
- China Judgments Online <https://wenshu.court.gov.cn/>

БОДЛОГЫН НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

“Цахим засаглал: Төрийн үйлчилгээ, шийдвэр гаргах үйл явц, мэдээлэл харилцааг цахимжуулах боломж ба сорилтууд” сэдэвт бодлогын судалгааны нэгдсэн зөвлөмж нь Монгол дахь Конрад-Аденауэр сан ба МУИС-ийн ШУС-ийн Улс төр судлалын тэнхимийн хамтарсан төслийн нээлтэй сонгон шалгаруулалтын үр дүнд сонгогдсон судлаач бүрийн бие даан судлан шинжилж, зөвлөх багийн зүгээс арга зүйн хувьд зөвлөн чиглүүлсэн судалгааны агуулга, үр дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Тэдгээр судалгааны дараах дэд сэдвүүдээр энэхүү нэгдсэн зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Иргэдийн цахим оролцоо, төрийн цахим үйлчилгээний өнөөгийн төлөв байдал, нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ

Хоёр. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудын нөлөөллийн шинжилгээ

Гурав. Цахим засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын хэрэгжилтийн шинжилгээ, цаашдын чиг хандлага

Дөрөв. Шударга шүүхээр шүүлгэх эрхийг цахим шүүх хуралдаанд хангах нь: Олон улсын туршлага ба Монгол улсын нөхцөл байдал

Бодлогын тодорхой судлагдахууны хүрээнд дэвшүүлсэн зөвлөмжийн нарийвчилсан агуулгыг судалгаа тус бүрээс уншиж танилцах боломжтой бөгөөд энэхүү нэгдсэн зөвлөмжөөр судалгааны дэд сэдэв бүрийн хувьд чухалчлан анхаарвал зохих зарим хэсгийг нэгтгэн илэрхийлсэн.

НЭГ. ИРГЭДИЙН ЦАХИМ ОРОЛЦОО, ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

“Иргэдийн цахим оролцоо, төрийн цахим үйлчилгээний өнөөгийн төлөв байдал, нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ” сэдэвт судалгааны ажил нь Монгол дахь иргэдийн цахим оролцооны өнөөгийн байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тоон мэдээлэлд тулгуурлан өгөгдлийн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулах зорилгоор хийгдсэн болно. Нийт 950 түүвэр бүхий асуулгын судалгааг цахим болон цаасан хэлбэрээр зохион байгуулсны үр дүнд уг судалгааны дүгнэлт гарсан бөгөөд дараах зөвлөмжийг хураангуйлан илэрхийлбэл:

- Иргэдийн цахим оролцооны үр ашигтай хэлбэрүүд болох өргөдөл, гомдол цахимаар гаргах, тухайн орон нутгийн хөгжлийн талаарх шийдвэр гаргахад цахимаар оролцох, цахим хэлэлцүүлгүүдийг тогтмол, идэвхтэй зохион байгуулах шаардлагатай байна.
- Идэвхтэй цахим оролцооны соёлыг иргэдэд төлөвшүүлэх
- Төрөөс иргэдийн хэрэгцээ шаардлага, хүлээлтэд нийцсэн цахим бүтээгдэхүүнийг бий болгох

- Төрийн байгууллагуудын албан ёсны вэб хуудасны нэгдмэл сүлжээг хөгжүүлэх
- Цахим технологийн талаарх иргэдийн мэдлэг чадварыг хөгжүүлэхийн тулд бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөр дэх холбогдох хичээлийн инноваци
- Иргэдийн эдийн засгийн нөхцөл байдал, цахим үйлчилгээг хүлээн авах боломж бололцоо зэргээс шалтгаалан төрийн цахим үйлчилгээний хүртээмжид дижитал хуваагдал үүсэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлэх, цахим засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн дэмжлэг үзүүлэх.

ХОЁР. УЛС ТӨРИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХЭД НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ СУВГУУДЫН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Нийгмийн амьдралын бүхий л хүрээн дэх тэгш оролцоо, манлайллын эрх тэгш байдлыг хангах явдал Монгол улсын хувьд төдийгүй олон улсад тулгамдаж буй энэ үед хийгдсэн “Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд нийгмийн сүлжээний сувгуудын нөлөөллийн шинжилгээ” сэдэвт судалгааны ажил нь дэлхий дахиныг хамарсан цар тахлын нөлөөгөөр эрчимжсэн цахим шилжилт ялангуяа нийгмийн сүлжээний сувгуудын идэвхтэй хэрэглээ нь улс төр дэх жендерийн тэгш бус байдлыг багасгахад хэрхэн нөлөөлж болохыг судлахад чиглэсэн болно. Нийгмийн сүлжээний сувгуудаар өрнөж буй олон талт хэлэлцүүлгүүд нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх түүнчлэн тэдний сонгогдох эрхийг хангахад эерэг нөлөө үзүүлж байна. Сонгуулийн болон улс төрийн бусад үйл ажиллагаанд нийгмийн сүлжээний сувгуудыг хэрэглэхтэй холбоотой хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эмэгтэйчүүдэд ээлтэй хэрэглээг бий болгох хэрэгтэй юм.

Эмэгтэй улс төрчид нийгмийн сүлжээний сувгуудаар өөрсдийгөө сурталчлан таниулах, сонгогч иргэдтэй тулж ажиллах, хөрөнгө босгох платформуудыг идэвхтэй ашиглах боломж өндөр байгаа нь асуулга судалгааны үр дүнгээс харагдаж байна. Иймээс тэднийг энэ чиглэлд сургаж чадавхжуулах, цахим технологи ашиглах ур чадвар нэмэгдүүлэх хялбар, өртөг багатай, хүртээмжтэй сургалт зохион байгуулах шаардлагатай.

ГУРАВ. ЦАХИМ ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ШИНЖИЛГЭЭ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

“Цахим засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын хэрэгжилтийн шинжилгээ, цаашдын чиг хандлага” судалгаагаар цахим засаглалын бодлого төлөвлөлт, эрх зүйн орчныг шинэчлэх, цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлж буй улс орнуудын

туршлага, цахим засаглал, дижитал шилжилтийн талаарх бодлогыг судлах зэрэг зорилго тавьсан. Тус судалгаанаас үе үеийн УИХ, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тооцох, үнэлгээ хийх, тэдгээр бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний давхардлыг судлах явдал дутмаг болох нь харагдаж байна. Цаашид цахим үндэстэн болох стратегийг хэрэгжүүлэхэд бусад салбарын технологийн хөгжлийг давхар тодорхойлох шаардлагатай. Дижитал шилжилтийг хурдасгах, e-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн порталын үйл ажиллагааг тогтвортой, хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг ханган хөгжүүлэхийн тулд бодлогын баримт бичгүүдийг уялдаа холбоотойгоор хяналттай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн технологийн бодлогод шинэчлэлт хийх, заавар зөвлөмж өгөх, нэр томъёо, мэдээллийн сангийн давхардлыг арилгах, цахим засгийн хөгжүүлэх чиглэлээр батлагдсан багц хуулиудыг хэрэгжүүлэхэд дагаж гарах журмуудыг боловсруулж батлах, мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хууль, бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг үнэлэх, хэрэгжилтийн хяналтын тогтолцоог Засгийн газрын бүтцийн хүрээнд бий болгох, төрийн захиргааны байгууллагад мэдээллийн технологийн бодлого, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, төрийн албан хаагчдын цахим ур чадварын үнэлгээ, програм хангамж, өгөгдлийн сан, техник тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, сул зогсолт, давхардлыг үнэлэх мэдээллийн аюулгүй байдлын аудит, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх хэрэгтэй байна. Төрийн албан хаагчдын цахим технологийн ур чадварыг дээшлүүлэхийн тулд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн албаны зөвлөл, цахим хөгжил харилцаа, холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зэрэг байгууллагууд хамтран бодлогын түвшинд хэрэгжүүлэх, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, банк санхүү, уул уурхай, эрчим хүч, нийгмийн хамгаалал, зам тээвэр, байгаль орчин зэрэг нийгэм, эдийн засгийн тэргүүлэх салбар бүрд төрийн цахим үйлчилгээний харилцан уялдааг хангах нэгдмэл бодлого, төлөвлөлт, зохион байгуулалттай хөгжүүлэхийн тулд салбар хоорондын харилцан уялдааг хангах хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

Цахим засаглалыг хөгжүүлэх төрийн бодлогын хэрэгжилтийн хяналт, хөрөнгө оруулалт, үр өгөөжийн цахим хяналтын самбар бүхий нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэх төрийн байгууллагууд дахь мэдээллийн технологийн чадварлаг хүний нөөцийг тогтвортой ажиллуулахын тулд цалин урамшуулал, нийгмийн асуудлуудыг дэмжих хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, мэдээллийн технологийн салбар дахь төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, үндэсний дижитал контентийг дэмжин хөгжүүлэх шаардлагатай байна.

ДӨРӨВ. ШУДАРГА ШҮҮХЭЭР ШҮҮЛГЭХ ЭРХИЙГ ЦАХИМ ШҮҮХ ХУРАЛДААНД ХАНГАХ НЬ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

“Шударга шүүхээр шүүлгэх эрхийг цахим шүүх хуралдаанд хангах нь: Олон улсын туршлага ба Монгол улсын нөхцөл байдал” сэдэвт судалгааны ажил нь иргэд шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангах хүрээнд шүүх хуралдааныг цахим хэлбэрээр зохион байгуулахтай холбоотой тулгамдаж буй асуудлыг тодорхойлох эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх, цахим шүүх хуралдааны хамрах хүрээ, хүртээмж, давтамжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай санал зөвлөмж боловсруулахад чиглэгдсэн. Цахим шүүх хуралдаан нь хүртээмжтэй, үр өгөөжтэй, зардал болон хугацаа хэмнэх зэрэг давуу талтай ажээ. Судалгаанаас үзэхэд цахим шүүх хуралдааны арга хэрэгслийг Монгол улсад бүрэн нэвтрүүлээгүй буюу хэрэглээгүй байна. Цахим төхөөрөмж, интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлэх тусам цахим шүүх хуралдаанд оролцох боломж нэмэгдэх, түүний үр ашигтай байдал дээшлэх боломжтой болох нь энэ судалгаанаас харагдсан. Одоогоор цахим шүүх хуралдааны зохицуулалт нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 3-р сарын 31-ний өдрийн 82 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам” -аар хязгаарлагдаж байгаа бөгөөд үүнд танхимын шүүх хуралдааны үед баримталдаг дэгийг цахим шүүх хуралдааны онцлогтой хэрхэн уялдуулах нь тодорхойгүй байна. Иймд уг журамд танхимын шүүх хуралдааны үед баримталдаг бүх дэгийг тусгаж цахим шүүх хуралдааны онцлогтой уялдуулах шаардлагатай байна.

Мөн шүүхийн төсөв, бусад санхүүжилтийн хүрээнд цахим нотлох баримтыг дэмжсэн хөрөнгө оруулах, интернэтийн холболтыг сайжруулах жамаар цахим шүүх хуралдааны хүртээмжийг нэмэгдүүлэх, цахим шүүх хуралдаанд оролцогчдод зохих зааварчилгаа өгөх, тэдэнд туслах, тэрхүү хуралдааны үр нөлөөг дээшүүлэхэд анхаарах явдал чухал болж байна. Цахим шүүх хуралдааны зохион байгуулалт нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг буруулахгүй байхад анхаарч, энэ талаар иргэдээс тогтмол асуулга авах, шүүхэд итгэх иргэдийн итгэл ба цахим шүүх хуралдааны хамааралд дүн шинжилгээ хийж байх шаардлагатай. Монгол улсад иргэд шударга шүүхээр шүүлгэх эрхийг, цахим шүүх хуралдаанд хангасан байдлыг тоон үзүүлэлтээр хэмжээгүй, хэмжих аргачлалгүй байгаа тул тийм аргачлалыг боловсруулах, түүний дагуу үнэлгээ хийх, цахим шүүх хуралдааны үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар дүгнэлт, санал бэлтгэх хэвших шаардлагатай байна.

ННА 66
ДАА 351
Ц-254



NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
DEPARTMENT OF
POLITICAL SCIENCE

ЦАХИМ ЗАСАГЛАЛ: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ,
МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААГ ЦАХИМЖУУЛАХ БОЛОМЖ БА СОРИЛТУУД

СУДАЛГААНЫ ҮР ДҮН, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

ЦАХИМ ЗАСАГЛАЛ: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ, МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦААГ ЦАХИМЖУУЛАХ БОЛОМЖ БА СОРИЛТУУД

СУДАЛГААНЫ ҮР ДҮН, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ



Монгол дахь Конрад-Аденауэр-Сан
Меру Тауэр, 8 давхар
Жамьян гүний гудамж 18-2
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар хот 14210
Монгол Улс

www.kas.mongolia
www.facebook.com/kas.mongolia
www.kas.edu.mn

978-0019-0-0079-0



9 789919 000790